МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН

НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2012

Эмхэтгэсэн: Б.Сарандэлгэр / Аргазүйч /

Улаанбаатар хот

2013 он

Өмнөх үг

Аймаг, хотын нийтийн номын сангуудын үйл ажиллагааны тайлангийн эмхэтгэл та бүхэнд 9 дахь удаагаа хүрч байна. Энэ удаагийн дугаараас эхлэн электрон хэлбэрээр хүргэдэг боллоо.

Энэхүү эмхэтгэл нь та бүхнийг бусад нийтийн номын сангийн үйл ажиллагаатай дэлгэрэнгүй танилцуулж, харилцан туршлага судлан ажил үйлчилгээндээ авч хэрэгжүүлэхэд тус дөхөм болно гэдэгт бид найдаж байна.

Та бүхнийг тайлан, судалгаагаа ирүүлж хамтран ажилласанд талархлаа илэрхийлье.

Агуулга

Өмнөх үг 2
Монгол Улсын Үндэсний Номын Сангийн 2012 оны бүтээгдэхүүн
Нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны тайлан..5
Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын төв номын сангийн 2012
оны үйл ажиллагааны болон бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний
тайлан 45
Хүүхдийн Номын Ордны 2012 он ажлын тайлан 67
Архангай аймгийн нийтийн номын сан мэдээллийн төвийн 2012 оны
жилийн ажлын тайлан 93
Баян-Өлгий аймгийн нийтийн номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 98
Баянхонгор аймгийн нийтийн номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 108
Булган аймгийн төв номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 126
Говь-Алтай аймгийн нийтийн номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 140
Говьсүмбэр аймгийн нийтийн номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 152
Дархан-Уул аймгийн төв номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 165
Дорноговь аймгийн төв номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 175
Дорнод аймгийн төв номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 185
Дундговь аймгийн төв номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 204
Завхан аймгийн төв номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 208
Орхон аймгийн номын төвийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 217
Өвөрхангай аймгийн төв номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 232

Өмнөговь аймгийн төв номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 239
Сүхбаатар аймгийн нийтийн номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 251
Сэлэнгэ аймгийн нийтийн номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 256
Төв аймгийн нийтийн номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 265
Увс аймгийн төв номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 274
Ховд аймгийн нийтийн номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 298
Хөвсгөл аймгийн нийтийн номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 305
Хэнтий аймгийн нийтийн номын сангийн 2012 онд
хийсэн ажлын тайлан 321

Монгол Улсын Үндэсний номын сангийн 2012 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны тайлан

Улаанбаатар хот. **2013.01.15.**

Бүтээгдэхүүний нэр	Нийлүүлэх бүтээгдэхүүн	Хийгдсэн ажил
Бүтээгдэхүүний анги -1 : Номын сангийн үйлчилгээ		
Бүтээгдэхүүн:1.1 Номын сангийн фондыг ном хэвлэлээр баяжуулах, техник ажиллагаанд оруулах • Фондуудад бүрдүүлэлт хийх	1.1.1.Номын худалдаа, нөхөн бүрдүүлэлт, бэлэг,солилцоогоор 3050 ш ном авах	• Шинээр 3000 ном худалдан авахаас 3109 ном худалдан авч, 104% (49.372.728₮) • Нөхөн бүрдүүлэлтээр 50 ном авахаас 67 ном авч, 134% (312.785₮) • Бэлгийн журмаар 1500 ном авахаас 2595 ном авч, 173% (33.592.790₮) • Эрдмийн зэрэг горилсон 157 диссертац, 6 хураангуйг хүлээн авч фактурлан ангилагчид шилжүүлэв. (1.616.0₮) • Төлбөрийн 1-6 дугаар фактураар 136 нэрийн 152 ширхэг 1.476.500 төгрөгийн ном хүлээн авч шилжүүлэв. **Нийт: 6086 ширхэг 86.370.803 төгрөгийн ном бүрдүүлсэн байна.** • 2012 оны монгол тогтмол хэвлэлийн захиалгыг 59 нэрийн сонин, 49 нэрийн сэтгүүлийг /нийт 108 нэр/ 4.320.054 төгрөгөөр захиалснаас гадна цахим хэлбэрээр 5 нэрийн өдөр тутмын сонинг 293.500 төгрөгөөр захиалж, 2012 оны эхний хагас жилээр орос хэл дээрх 7 нэрийн сэтгүүлийг 772.0 төгрөгөөр тус тус захиалав. (5.385.554 төгрөгийн тогтмол хэвлэл захиалсан. • Хэвлэх Үйлдвэрүүдийн Холбооны 100 жилийн ойд зориулан хэвлэх үйлдвэрүүдээс 5000 шинэ ном хэвлэлийг явуулын номын санп бэлэглэлээ.

	• Үндэсний номын сангийн захирлын 2011 оны 4 сарын 25-ны 30 дугаар тушаалаар томилогдсон төлбөр барагдуулах комисс гэрээр авсан номын төлбөрийг барагдуулах ажлыг гүйцэтгэж, нийт 53 хүнд 212 ширхэг ном дутагдсан байснаас 41 хүнээс 146 ширхэг 418.843,1 төгрөгийн номын төлбөрт 136 нэрийн 152 ширхэг 1.476.500 төгрөгийн ном хүлээн авч, төлбөрийн 1-6 дугаар фактур бичиж, фондонд шилжүүлэв. Номын төлбөрийг номыг номоор буюу нөхөн бүрдүүлэх шаардлагатай номоор орлуулан төлүүлсэн бөгөөд комиссын дэлгэрэнгүй тайланг Захиргааны зөвлөлийн хуралд илтгэж, холбогдох хавсралт бусад баримтыг шилжүүлсэн болно. • Хүүхдийн номын ордонд хадгалагдаж байсан Үндэсний номын сангийн Архив фондын орон нутгийн тогтмол хэвлэлийг татан авч, архивын номын санчид шилжүүллээ. • “Шилдэг ном-2011”-д шалгарсан 41 нэрийн 10497 номыг зохиогч, байгууллага хэвлэх үйлдвэрүүдээс хүлээн авч 21 аймаг, сумдын номын сангуудад түгээлээ. • Хэвлэлийн газар, төрийн ба төрийн бус байгууллагуудаас эрхлэн төсөл хөтөлбөрийн хүрээнд хэвлүүлсэн 2500 гаруй ном, хэвлэлийг хүлээн авч, 21 аймаг 329 сум, ЕБС, их дээд сургуулийн номын сангуудад түгээх ажлыг гүйцэтгэлээ. • Архивт шинээр 1000 нэрийн ном авч байрлуулахаас 1649 нэрийн 1718 ном хүлээн авч байрлууллаа.	
	1.1.2. 4700 ном ангилах	2477 нэрийн 5907 ном ангилав. /125%/ - Аравтын ангийн шифр зөрсөн байсан 40 номын анги, зохиогчийн тэмдэгтийг залруулж, фондод хүлээлгэн өгөв.
• Бүрдүүлэлтээр орж ирсэн номыг ангилах • Ангилсан номыг данслах • Шинээр авсан номонд техник ажиллагаа	1.1.3. Бүрдүүлсэн номыг холбогдох дансанд бүртгэх	• 4750 ном данслахаас 2506 нэрийн 6103 ширхэг номыг нэгбүрчилсэн дансанд бүртгэж, нэгдсэн бүртгэлийн 12 дэвтрийг зохих дүрэм, журмын дагуу хөтөллөө. • Фондоос татгалзалтай ирсэн 16 номыг дансны дугаарын дагуу нэгбүрчилсэн бүртгэлтэй тулгах, солилцоогоор дутагдсан 102 номын он, үнэ зэргийг нэгбүрчилсэн бүртгэлээс шүүх, тулгах бичих ажлуудыг хийв. • Бэлтгэл фондын тооллогоор дутагдсан 17.781 ширхэг номын жагсаалтаас 1988-2010 онд зарлагдсан боловч бүртгэлд тусгагдаагүй байсан 4429 ширхэг номын зарлагыг зохих баримттай тулган редакц хийж дуусгав. • Бэлтгэл фондоос захирлын зөвшөөрлийн дагуу 62 нэрийн 120ш 1.130.100 төгрөгийн үнэ бүхий номыг гарган, дансанд зохих тэмдэглэгээ хийв.

хийх	1.1.4.Бүрдүүлэн авсан номыг ажиллах	3078 нэрийн 5905 ширхэг ном ажиллав./126%/ Үүнд: • Худалдааны 1411 нэрийн 2755ш, солилцооны 309 нэрийн 351ш, бэлгийн 1559 нэрийн 2428ш, нөхөн бүрдүүлэлтийн 40 нэрийн 67ш, төлбөрийн 133 нэрийн 141ш, 158 нэрийн 163 ширхэг диссертаци, хураангуйг тус тус ажиллав.
	1.1.5. Бүрдүүлэлтээр орж ирсэн номонд 7500ш карт бичих	7500 ширхэг карт бичихээс 9572 ширхэг карт бичив. /127%/ Үүнд: • Монгол 1430 нэрийн 3385 номонд 4562ш, өрнө дахины 281 нэрийн 326 номонд 853ш, дорно дахины 120 нэрийн 141 номонд 189ш, монгол судлалын 178 нэрийн 190 номонд 586ш, архивын 1649 нэрийн 1748 номонд 3382ш картыг тус тус бичив. • Монгол номын фондод шинээр ирсэн 1430 нэрийн 3387 номын, 158 нэрийн 163 ширхэг диссертац, хураангуйн мэдээллийг компьютерт шивж, бар код наан шилжүүлж; • “Сонин сэтгүүлийн өгүүллийн номзүйн бүртгэл”-д 7 нэрийн сэтгүүлээс 2081 материал түүвэрлэн карт бичиж номзүйчид хүлээлгэж өгөв.
	1.1.6 Харилцаат номын сангуудад 300ш ном илгээж, 300ш ном, 1000ш сонин, 300ш сэтгүүл хүлээн авах	• *Гадаадын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудад илгээсэн:* ❑ 300 ном илгээхээс 5.462.040 төгрөгийн 317 ном бүрдүүлэгчээс хүлээн авч 106% • *Гадаадын номын сан эрдэм шинжилгээний байгууллагуудаас хүлээн авсан:* ❑ 300 ном хүлээн авахаас 307 нэрийн 351 ном авч 117% (6.629.020₮) ❑ 1000 сонин хүлээн авахаас 6 нэрийн 1318-ыг авч 132% (291.440₮) ❑ 300 сэтгүүл хүлээн авахаас 111 нэрийн 505-ыг авч 168% (874.320₮) Нийт 126 нэрийн 317 ширхэг 5.462.040 төгрөгийн ном илгээж, 7.794.780 төгрөгийн ном, хэвлэл хүлээн авсан.
• Бүрдүүлэлтээр орж ирсэн номонд карт бичих • Шинэ карт байрлуулах • Редакци хийх	1.1.7.Холбогдох каталогт байрлуулах карт 7500ш	• Шинээр байрлуулсан карт – 8534ш /114%/ • Картанд хийсэн редакц – 22909ш /145%/

• Фондуудад ном байрлуулах • Юнеско-ийн ном хэвлэлийг ангилах, данслах, карт бичих	1.1.8. Каталогт байрлагдсан 20000ш картанд редакци хийж 8000 ш карт хуулах	• Шинэчлэн хуулсан карт – 9341ш /117%/ • Шинэчилсэн ялгагч – 1302 ш /130%/

	1.1.10.Юнескогийн 2200 номыг ангилж, данслан ажиллах, 4400 карт бичих	• Ном ангилах, ажиллах, данслах, байрлуулах 1.Төлөвлөгөө - 2200 2.Гүйцэтгэл - 1720 3.Хувь – 78.2% • Карт бичих, байрлуулах 1.Төлөвлөгөө - 4400 2.Гүйцэтгэл – 3.Хувь – % ЮНЕСКО-гийн уншлагын танхимын ажлын үзүүлэлт 78% • Баркод 1.Төлөвлөгөө – 2200 2.Гүйцэтгэл – 1720 3.Хувь – 78.2% Юнескогийн ном хэвлэлийг НҮБ-ийн салбар байгууллагаар нь ангилан байрлуулж, техник ажиллагаа хийлээ. /Юнескогийн уншлагын танхимын номын санч нь музейн улсын тооллогод ажиллаж байгаа тул төлөвлөгөөний үзүүлэлт тасарсан болно./

Бүтээгдэхүүн: 1.2 Уншигчдад ном хэвлэлээр үйлчлэх үйлчилгээ • Фондуудаас уншлагын танхимуудад захиалгын дагуу ном хэвлэл гаргаж үйлчлэх	1.2.1.Монгол фондын номыг дотоод сүлжээгээр бусад фондын номыг захиалгын хуудсын дагуу 177000 ном, сонин, сэтгүүлийг танхимуудад гаргаж үйлчлэх	- Монгол фондын ном хэвлэлийг дотоод сүлжээгээр, бусад фондын ном хэвлэлийг захиалгын хуудсын дагуу үйлчилж, уншлагын танхимуудаар 52038 уншигчдад 157730 ном хэвлэл олгож үйлчиллээ. - Явуулын номын сангийн үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор төсөл боловсруулж, Улаанбаатар Төмөр замын газарт хүргүүлсэн. - Тайлангийн хугацаанд Багануурын нийтийн номын сан, Эрэгтэйчүүдийн хорих, 0225-р хилийн отряд, УБ хотын Хүүхдийн хорих - 401, 411-р анги, Эмэгтэйчүүдийн хорих – 407-р анги, Сэлэнгийн 0101, 0245-р анги, Алтанбулаг дахь ОУ-ын боомт, Замын-Үүдийн 0108-р анги, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв зэрэг **11 газрын** албан хаагч, хүмүүжигч шинээр ном хүргэн үйлчилж, 4800 байнгын уншигч, 16400 ирцэд 19700 орчим номоор, үйлчиллээ. - Явуулын номын санд 0303-р ангиас /101ш./, Дорноговь аймгийн Улаан-Уул сумаас ирүүлсэн 82ш ном, хэвлэлийг /вокзалаас/ мөн аймаг орон нутгийн хилийн заставуудаас ирсэн 1109ш, номыг тулгаж жагсаалтгүй 145 номонд жагсаалт хийж, Орхон аймгаас ирүүлсэн 52ш. номыг, 407-р ангийн 88ш Багануураас ирүүлсэн номыг хүлээн авч Үндсэн фондоос авсан номуудыг хүлээлгэж өгсөн. Энэ онд тус номын сан нь уншлагын танхимаар болон явуулын номын сангийн үйлчилгээгээр нийт 64038 уншигч хэрэглэгчдэд 177430 ном хэвлэлээр үйлчилсэн байна.

• Уншигчдад үйлчлэх	1.2.2. 2250 уншигчид шинээр үнэмлэх нээх • “Их уншлагын танхим”-аар 116000 ном олгох • “Эрдэм шинжилгээний уншлагын танхим”-аар 5400 уншигчдад 20000 ном олгох • “Тогтмол хэвлэлийн танхимаар 2200 уншигчдад 10000 сонин, сэтгүүл олгох • Ататуркийн уншлагын танхимаар 200 ирцэд 950 ном олгох • Солонгосын мэдээллийн төвөөр үйлчлэх • Интернэтийн үйлчилгээг уншигч, хэрэглэгчдэд хүргэх • Ном солилцоогоор 1053ш ном олгох • Ойрын фондоор 32000ш номыг уншлагын танхимуудад гаргах	• 4207 уншигчдад үнэмлэх нээв. 174% • 40993 ирцэд 87817 ном • 6952 ирцэд 21152 ном • 2694 ирцэд 21720 сонин, сэтгүүл • 455 ирцэд 753 турк ном • 610 уншигчдад 1966 ном олгож, 610 хүнд аман лавлагаа өгсөн. Нийт 224 номонд техник ажиллагаа хийсэн. Танхимын 3800 номын нэрсийн жагсаалтыг МҮНС-ийн вэб сайтад байршуулсан нь Солонгос мэдээллийн төвийн нийт номын каталогийг шууд үзэх боломжийг бүрдүүлсэн. Ном солилцоогоор 3728 ном олгож үйлчлэв. • Ойрын фондоор 25532 ном хэвлэл уншууллаа. • 758 уншигчдад интернэт үйлчилгээ үзүүллээ. • Уншигчдаас санал хүсэлт авах хайрцагийг 3 давхар, харуулын дэргэд нэмж байрлуулан, санал хүсэлтийг хүлээн авч тухай бүр арга хэмжээ авч ажиллаж байна. Уншигчдын хүсэлтээр халуун, хүйтэн цэвэр усыг 3 давхарт байнга ажиллуулж, шалгах хуудас болон захиалгын хуудсыг төлбөртэй олгохыг зогсоолоо. • Үйлчилгээний соёл, ном хэвлэлийн хүрэлцээ хангамж, номын сангийн ажиллах цагийн хуваарийн талаар 130 уншигчдаас сэтгэл ханамжийн судалгааг 2 удаа авч, үйл ажиллагаандаа тусган ажиллалаа.

• Номын сангаас зохиох соёл олон түмний ажил	1.2.3.Шинэ номын болон сэдэвчилсэн номын 25 үзэсгэлэн гаргаж, зохиолч уншигчдын уулзалт 4 удаа зохион байгуулах • “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг БСШУЯ- тай хамтран зохион байгуулах •	Тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн арга хэмжээнд зориулан **сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэнг** нийт 51 удаа 3461 номоор гаргаж сурталчиллаа. Фондын сан хөмрөгийн эргэлтийг сайжруулах, хэрэгцээт чухал сэдвүүдээр уншигчдад санамж өгөх зорилготой сэдэвчилсэн номын үзэсгэлэнг зохион байгуулж байна. Үүнд: ➢ Үндсэн хуулийн өдөрт – 52 ном ➢ Д.Сүхбаатарын мэндэлсний 119 жилийн ойд – 48 ном ➢ Багш нарын баярын өдөрт – 69 ном ➢ Сар шинийн баярт – 50 ном ➢ Олон Улсын эмэгтэйчүүдийн баярын өдөрт – 65 ном ➢ Хятад, Тайваны уран зохиолоор – 30 ном ➢ Монголын зэвсэгт хүчний баярын өдөрт /Монгол цэргийн өдөрт/ – 56 ном ➢ Монгол хүн сансарт ниссэний баярын өдөрт – 65 ном ➢ Англи хэл сурцгаая – 73 ном ➢ Гадаад хэлний сурах бичгүүд – 50 ном ➢ Дэлхийн эрүүлийг хамгаалах өдөрт – 105 ном ➢ Дэлхийн номын өдөрт - 138 ном ➢ Монголчуудын бичиг үсгийн дурсгал – 120 ном ➢ 2011 оны шилдэг номууд – 57 ном ➢ Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт – 104 ном ➢ Үндэсний их баяр наадмын өдөрт – 81 ном ➢ Монголын Залуучуудын өдөрт – 102 ном ➢ Соёл, урлагийн ажилтны өдөрт – 84 ном ➢ Улс төрийн хэлмэгдэгсдийн өдөрт – 65 ном ➢ Номын баярын өдөрт – 63 ➢ БНХАУ-ын соёлын өдрүүдэд зориулсан Хятад, Өвөр монголын зохиолчдын бүтээлийн дээжсээс – 95 ном

		➢ Зохиолч Б.Монголхүүгийн бүтээлийн үзэсгэлэн – 27 ном ➢ Байгаль орчныг хамгаалах өдөрт – 93 ном ➢ Олон Улсын оюутны өдөрт – 52 ном ➢ Герман Улсын монгол хэл дээрх орчуулгын номын үзэсгэлэн – 115 ном ➢ Яруу найрагч Ц.Хулангийн бүтээлийн үзэсгэлэн – 27 ном ➢ Нийслэлийн өдөрт – 54 ном ➢ Их эзэн Чингис хааны мэндэлсний 850 жилийн ойд – 92 ном ➢ Улс тунхагласны баярын өдөрт – 83 ном ➢ Хүний эрхийн өдөрт – 86 ном ➢ Утга зохиол судлаач, гоо зүйч С.Лувсанвандангийн 80 насны ойд – 48 ном, 21 хавтас дахь 62 сэтгүүл, 26 хавтас сонин ➢ Соёлын гавьяат зүтгэлтэн Го.Акимын бүтээлийн үзэсгэлэн – 103 ном, 9 хавтас дахь сэтгүүл **Шинэ номын үзэсгэлэн** 10 удаа нийт 638 гадаад, дотоодын номоор гаргалаа.

• Номын сангаас зохиох соёл олон түмний ажил	Соёл олон нийтийн дараах арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд: • “Монголын бэлчээрийн мал аж ахуй”- сэдэвт 20 боть эрдэм шинжилгээний бүтээлд зориулсан номын баяр 2012 оны 03-р сарын 13-ны өдөр болж өнгөрлөө. Баярын үйл ажиллагааг ХХААҮЯ, “Содпресс” ХК, МҮНС болон тус бүтээлийн редакцийн зөвлөлийн ахлагч, доктор, профессор Ц.Балхаажав нар хамтран зохион явууллаа. Арга хэмжээний хүрээнд номын зохиогч, хувь хүмүүс, монголын мал аж ахуйн талаар анхаарч, хүчин зүтгэж явдаг хүмүүст номын дээжсээс дурсгаж гардуулах ёслолын ажиллагаа боллоо. Баярын үйл ажиллагаанд хамтран ажилласан байгууллагын удирдлага, төлөөлөл зэрэг нийт 60-аад хүн оролцов. • 2012 оны 03-р сарын 29-ний өдөр “Ном уншихад хялбар боллоо” уриан дор Монголын ууган хэвлэлийн үйлдвэрийн нэг “Интерпресс” ХХК-ийн, МҮНС хамтран зохион байгуулсан “iNom” цахим номын үйлчилгээг МҮНС-тай хамтран түгээх “Үндэсний номын санд шинэ технологи нэвтэрлээ” өдөрлөгийн нээлтийн ажиллагаа боллоо. Арга хэмжээний нээлтэнд МҮНС-ийн дэд захирал Д.Бямбасүрэн, “Интер” группын удирдах зөвлөлийн гишүүн М.Баттөгс нар оролцсон бөгөөд “Интерпресс” ХХК-ийн гэрээний мэргэжилтэн Л.Нямдорж iNom.mn цахим номын үйлчилгээ, үйл ажиллагаа, уншигч хэрэглэгчид хэрхэн ашиглах талаар тодорхой танилцууллаа. • **“Үндэсний бичиг үсгийн баяр”:** “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын үйл ажиллагааг БСШУЯ, Соёл Урлагийн Хороо, Соёл урлагийн сан, Төрийн хэлний зөвлөлтэй хамтран зохион явууллаа. Баярын хүрээнд: - “Монгол бичгээ эрхэмлэгч” хувь хүн, төрийн болон төрийн бус байгууллагыг шалгаруулах арга хэмжээ, - “Монгол бичгийн албан хэрэглээг нэмэгдүүлье” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал - “Утга уянгын хур” уран бичлэгийн уралдаан - “Уран үзэгтэн” монгол бичгийн хичээнгүй бичгийн уралдаан зохион явуулах - Уран бичлэгийн үзүүлбэр - “Найман мянгат их хөлгөн судрын цоморлиг” Жадамба судар номын үзэсгэлэн - “Монголчуудын бичиг үсгийн дурсгал” сэдэвт номын үзэсгэлэнгүүд зохион байгуулснаас гадна 2011 онд шалгарсан шилдэг номуудын үзэсгэлэн - МУИС-ийн МХСС, МУБИС-ийн Багшийн сургууль болон “Хүмүүн бичиг” сонины уран бичлэгийн бүтээлийн үзэсгэлэн - Франц номын “Эрвээхэй” дэлгүүрийн бичиг хэргийн үзэсгэлэн зэрэг олон шинэлэг арга хэмжээг зохион байгуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл телевиз, радио, сонин хэвлэлүүдээр өргөн сурталчиллаа. Баярын ажиллагаанд 200 гаруй эрдэмтэн, судлаачид, оюутан залуус, хуучин бичгээ эрхэмлэн дээдэлдэг олон хүмүүс оролцлоо. - Үндэсний бичиг соёлын үзэсгэлэн зохион байгуулан сурталчлах зэрэг олон шинэлэг ажлуудыг хамарсан

- **Монгол Улсын Ерөнхийлөгч жил бүрийн 9 дүгээр сарын 3 дахь долоо хоногийн Бямба гаригийг “Номын баярын өдөр” болгон тэмдэглэх зарлиг гаргасны дагуу МҮНС энэ ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион явууллаа.**
  - **“Сэтгэл гэгээрээсэй” номын чуулган:** 2012 оны 9 дүгээр сарын 13-ны 17 цагт Монгол Улсын гавьяат эмч, доктор, профессор, дуун хөрвүүлэгч М.Шагдарсүрэнгийн “Сэтгэл гэгээрээсэй” номын чуулган МҮНС-ийн нийтийн уншлагын танхимд боллоо. “Сэтгэл гэгээрээсэй”, “Бурхан Буддагийн айлтгал”, Мэлмий нээхүйн мянган бадаг” зэрэг “30 боть бүтээлийн чуулган” цуврал бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж, уншигч судлаачдад танилцууллаа. Арга хэмжээнд төр нийгмийн зүтгэлтэн, зохиолч яруу найрагчид, уншигч, номын санч нийт 80-аад хүн оролцлоо.
  - **Уншигч-зохиолчдын уулзалт:** 2012 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр МУ-ын Ерөнхийлөгчийн нэрэмжит танхимд “Алтан гөрөөс” Олон Улсын яруу найргийн баяр”-ын уншигч зохиолчдын уулзалт болж өнгөрлөө. Уулзалтад 30-аад хүн оролцов.
- **Номын баяр:** МҮНС-ийн үйл ажиллагааг сурталчилсан “Номын баяр”-ын өдрийг Сүхбаатарын талбайд зохион байгуулан ажиллалаа. 2012 оны 09 дүгээр сарын 15-нд “Олуулаа уншъя” уриан дор болсон арга хэмжээнд баярын хүрээнд МҮНС-аас Монгол бичиг үсгийн дурсгалын өвүүдээс дээжлэн үзэсгэлэн гаргасан ба “Ардын элч” явуулын номын сан ажиллуулж 200-гаад номоор үйлчилж үзэсгэлэн зохион байгууллаа. Номын сангийн Үнэт ховор номын музей 2 өдөр уншигч, олон түмэнд нээлттэй ажиллаж 800 гаруй хүнд монгол туургатны төдийгүй дэлхийн түүхэнд чухал байр эзлэх өв үзмэрээ танилцууллаа. Номын баярын хүрээнд “Монгол номын өв соёл” эрдэм шинжилгээний хуралд МҮНС-ийн захирал Х.Чилаажав “Үндэсний номын сангийн сан хөмрөгийн гайхамшиг” сэдвээр илтгэл тавилаа.

- Явуулын номын сангийн үйлчилгээг эх үрсийн баярыг тохиолдуулан Баянзүрх дүүргийн Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төвд номын сангийн үйлчилгээг хүргэж, урлаг соёлын өдөрлөг зохион байгууллаа.

- АНУ-ын Азийн сантай хамтран Дэлхий нийтээрээ бичиг үсэг тайлагдсаны баярын өдрийг тохиолдуулан Нийслэлийн 2-р дунд сургууль дээр явуулын номын сангийн нээлттэй өдөрлөгийг зохион байгуулав. Азийн сангаас МҮНС-д 150 ширхэг ном хандивласан.

- Чингис хааны мэндэлсний 850 жилийн ойг тохиолдуулан Оюу толгой компанийн ивээн тэтгэлгээр “Монголын нууц товчоо” номын сонсдог эхийн нээлтийг зохион байгуулж, нийтийн номын сангуудад түгээх ажлыг эхлүүлсэн.

-

	• **Монгол, Хятад зохиолчдын уулзалт, уран бүтээлийн чуулган, ном хандивлах ёслол:** 2012 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын соёлын өдрүүдийн хүрээнд Монгол-Хятадын зохиолчдын форум МҮНС-ийн Ерөнхийлөгчийн нэрэмжит танхимд боллоо. Энэ үеэр Хятадын талаас “Хятадын уран зохиолын дээж” номыг МҮНС-д бэлэглэх ёслолын ажиллагаа болж, уулзалтын хүрээнд хятад, монголын зохиолчид санал сэтгэгдлээ ярьж зохиол бүтээлээсээ танилцууллаа. МҮНС-ийн талаас зочдод хятадын орчуулгын уран зохиолын номыг бэлэглэсэн бөгөөд арга хэмжээнд 40 гаруй хүн оролцлоо. Түүнчлэн “БНХАУ-ын соёлын өдрүүдэд зориулав” номын үзэсгэлэнг Хятад, Өвөр монголын зохиолчдын бүтээлүүдээр гарган сурталчиллаа. • **Шинэ номын баяр:** 2012 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр зохиолч, сэтгүүлч Б.Монголхүүгийн “Казак ардын аман билиг оршвой” хэмээх хос хэлний толь бичгийн номын нээлтийн баярын үйл ажиллагаа МҮНС-ийн Ерөнхийлөгчийн нэрэмжит эрдэм шинжилгээний уншлагын танхимд боллоо. Арга хэмжээг Баян-Өлгий аймгийн нутгийн зөвлөл, МҮНС хамтран зохион байгуулсан бөгөөд баярт УИХ-ын гишүүн А.Бакей, Ардын уран зохиолч Ш.Сүрэнжав, П.Бадарч, эрдэмтэн судлаачид С.Дулам, н.Султаан болон нутгийн зөвлөлийн гишүүд, мэргэжил нэгт нөхөд нь оролцож санал сэтгэгдлээ хуваалцлаа. Б.Монголхүүгийн уран бүтээлийн номын үзэсгэлэн гарган сурталчилсан. • **Зохиолч- уншигчдын уулзалт:** 2012 оны 10-р сарын 23-ны өдөр МҮНС-ийн нийтийн уншлагын танхимд МЗЭ болон Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, 2 удаагийн Болор цомын эзэн, яруу найрагч Цоодолын Хулантай уулзалт зохион байгуулав. Арга хэмжээнд номын сангийн уншигчид, оюутан сурагчид /мөн Утга зохиолын дээд сургууль, МУБИС, Отгонтэнгэр дээд сургуулийн оюутнууд/, номын санчид нийт 80 гаруй хүн оролцсон ба “Яруу найрагч Ц.Хулангийн шүлгийг хэн сайн унших вэ” уралдаан болж уншигч болон оролцогч хүмүүсээс эхний 3 байр, 1 хүнийг тусгай байраар шалгаруулан шагнаж урамшууллаа. Мөн Ц.Хулангийн бичиж туурвисан бүтээлээр үзэсгэлэн гаргаж сурталчлав. • Утга зохиол судлаач, гоо зүйч С.Лувсанвандангийн 80 насны ойд зориулсан арга хэмжээ: Ерөнхийлөгчийн нэрэмжит танхимд “С.Лувсанвандангийн сантай хамтран нэрт эрдэмтний амьдрал, уран бүтээлийн талаар эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа. Мөн энэ арга хэмжээний үеэр С.Лувсанвандангийн нэрэмжит “Гоо зүйн дээд шагнал” гардуулах ёслолыг зохион байгууллаа.

• **Номын сангийн соёл олон түмний ажил**	• **Соёлын гавьяат зүтгэлтэн Го.Акимын номын баяр боллоо.** 2012 оны 12-р сарын 21-ний өдөр МУ-ын Соёлын гавьяат зүтгэлтэн, Б.Ринчений нэрэмжит шагналт, сэтгүүлч, зохиолч, дуун хөрвүүлэгч Го.Акимын “Туульс хайлдаг уулс” номын баярын үйл ажиллагаа МҮНС-ийн нийтийн уншлагын танхимд боллоо. Арга хэмжээнд 70 гаруй хүн оролцсон бөгөөд Го.Акимын зохиол бүтээлээр үзэсгэлэн гаргаж сурталчлав. • БСШУЯ-ны нээлттэй хаалганы өдөр арга хэмжээний хүрээнд Сүхбаатарын талбайд номын сангаас гаргасан танилцуулга үзэсгэлэнг "Найман мянгатын цомирлог" нэртэйгээр зохион байгуулсан. Үзэсгэлэнд Монголын үндэсний номын санд хадгалагдаж буй монгол, төвд “Жадонба” судрын хувилбар эхүүдийг тайлбарын хамт байрлуулсан. **Хэвлэл мэдээллийн сурталчилгаа:** • МҮОНТ, TV5, UBS, TV9, Эх орон г.м радио, телевиз,“Өдрийн сонин”, “Үндэсний шуудан”,“Өнөөдөр”, “Үнэн” зэрэг сонин хэвлэл болон Монголын Зохиолчдын эвлэл, Улаанбаатар чуулга зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж: • Номын сангийн үнэт сан хөмрөгийн тухай • Явуулын номын сангийн үйл ажиллагаа • Үйсэн дээрх бичгийг хүлээн авах ёслолын ажиллагаа • “Бэлгийн дээд ном” арга хэмжээ, “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын нээлтийн ёслол болон бусад соёл олон нийтийн ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр тогтмол сурталчилж ажиллалаа. • Төвд номын фондын талаар 68 хүнд үзүүлж сурталчилсан ба TV9-ийн “Нар тойрсон зам” нэвтрүүлгээр ном судрын сэргээн засварлах ажиллагааны тухай, UBS, TV25, NTV телевизээр “Үлэмж цаглашгүй өв” баримтат кино, Ийгл телевизээр Явуулын номын сангийн тухай, "Номын ертөнц" нэвтрүүлгээр номын сангийн тухай ярилцлага, мэдээлэл гарлаа.. • Эх орон телевизийн “Өв соёл” нэвтрүүлэгт 2 удаа оролцож, номын сан, ном судраа сурталчилсан ярилцлага өгөв. • Үнэт ховор номын музейн танилцуулгыг жуулчны мэдээллийн төвлөрсөн лавлах http://www.touristinfocenter.mn, Нийслэлийн аялал жуулчлалын газрын http://www.touristinfocenter.mn цахим хуудаснуудад тус тус байршуулж, “Монгол орны эмхтгэл” номд оруулсан
Бүтээгдэхүүний анги -2 : Эрдэм шинжилгээ, арга зүйн удирдлага	

	2.1.1.“ Эрдмийн зөвлөл”-ийн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулж, ажиллах	- Эрдмийн зөвлөлийн жилийн ажлыг төлөвлөгөөг боловсруулан ажиллаж, гишүүдийн хурлыг 3 удаа хийлээ. Хурлаар: - Эрдмийн зөвлөлийн ажиллах төлөвлөгөөг хэлэлцэж батлах, сэргээн засварлах төслийн тухай, Ерөнхийлөгчийн танхимын үйл ажиллагааны журмын тухай, “Дэлхийн дурсамж” хөтөлбөр”-т нэр дэвшүүлэх бүтээлийг сонгох, Хосгүй үнэт зэрэглэлд бүртгүүлэх ном судрын талаар хэлэлцэж шийдвэр гаргалаа. - Эрдмийн зөвлөлийн гишүүд нь номын сангийн гар бичмэл ном судрыг хадгалах хамгаалах болон эрдэм шинжилгээ судалгааны ажилд зөвлөгөө өгөх, хамтран судалгаа хийх зэргээр байнгын холбоотой ажиллаж байна. - Герман улсын Бонны их сургууль, ШУА, Үндэсний номын сангийн гэрээний дагуу 1992, 1996 онд сэргээн засварлагдахаар явуулсан түүх, соёлын дурсгалт өв болох “Үйсэн дээрх бичиг”-ийг үнэлүүлэх, даатгалын гэрээ байгуулах ажлыг ССАЖЯ-тай хамтран хийж, гаалийн бүрдүүлэлтийг хийх, ССАЖЯ-ны комисстой хамтран хүлээн авах ажиллагааг зохион байгууллаа.
	2.1.2. Юнескогийн Монгол дахь Үндэсний Хороо, “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Үндэсний Хороотой хамтран “Баримтат өв:Бүртгэл, судалгаа, хадгалалт, хамгаалалт” төслийн хүрээнд гар бичмэл ном судрыг судалж тодорхойлох	- ШУТСан болон ЮНЕСКО-ийн Монгол дахь Үндэсний комисстой хамтран “Баримтат өв:Бүртгэл, судалгаа, хадгалалт, хамгаалалт” төслийг хэрэгжүүлж, “Дэлхийн дурсамж” хөтөлбөрт бүртгүүлэх үнэт ховор баримтат өвийг судалж, нийт 9 бүтээлийг дэвшүүлэхээр эрдэмтдийн багтай хамтран ажилллалаа.Үүнд: - Эрдэнийн товч, Есөн эрдэнийн Ганжуур, Сандуйн жүд, “Хутагт билгийн чинад хязгаарт хүрсэн найман мянгат оршвой” нэрт хөлгөн судар, Дарь эх зэрэг 9 соёлын өвийг “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн журам зааврын дагуу нэр дэвшүүлэхээр судалгааны тодорхойлолтыг бэлтгэж, англи хэлнээ хөрвүүлээд байна. - Есөн эрдэнийн Ганжуурын судалгааны тодорхойлолтыг бэлтгэж, ЮНЕСКО-ийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Үндэсний төвд илгээлээ. - Төслийн хүрээнд Үндэсний номын санд хадгалагдаж байгаа 100 соёлын өвийн каталог болон нэр дэвшигдсэн 9 бүтээлийн судалгааны товхимолыг хэвлүүлж гаргалаа.

	2.1.3.Засгийн Газрын тогтоолоор “Хосгүй үнэт өв”-д ном судрыг нэр дэвшүүлэх	• “Мэргэд гарахын орон”,”Асрагч нэртийн түүх”, “Соёмбо үсгийн итгэл”, “Эрдэнийн товч” зэрэг 10 дурсгалыг 2012 оны ЗГ-ын тогтоолоор “Хосгүй үнэт” зэрэглэлд зохих журмын дагуу тодорхойлж бүртгүүллээ. 10 дурсгалын тодорхойлолтыг зохих зааврын дагуу бичиж мэдээлэлийн санд хадгалан Соёлын өвийн төвийн мэдээллийн санд илгээлээ. • ЮНЕСКО-ийн Баримтат өвийн 20 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “МОНГОЛ ШУНХАН ДАНЖУУР” “ЛУ. АЛТАН ТОВЧ” өвүүдийн сурталчилгааны материалын эх болон танилцуулгыг бичиж, сурталчлах ажил зохион байгуулсан. • “Баримтат өв” төслийн хүрээнд Улсын хэмжээний баримтат өвийн жагсаалттай болох ажлыг хэрэгжүүлж 7 музейн 69 өвийн жагсаалт гаргасан. • Төвд номын фондод хадгалагдаж буй “Хосгүй үнэт” зэрэглэлд бүртгэгдсэн "Мэргэд гарахын орон" нэрт судрын 377 ширхэг модон барыг дугаарлан дансны дугаарыг бичиж нааж, төвд номын фондын үнэт номын ерөнхий дансанд бүртгэж дансалсан.
	2.1.4. Эртний ном судрын гэмтлийг тодорхойлж, 2013 онд сэргээн засварлах төлөвлөгөө боловсруулах	• Үнэт ховор номын фондод хадгалагдаж буй өвүүдээс яаралтай хамгаалалтанд авах, сэргээн засварлах шаардлагатай өвийн жагсаалт гаргаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулах төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. • Монгол судлал гар бичмэл фондод хадгалагдаж буй ном судраас Нэн тэргүүнд сэргээн засварлах шаардлагатай, онц ноцтой гэмтэлтэй, 39 гар бичмэл, судар ном ялган, газрын зургийг татаж, гэмтэлийг ширхэгчлэн тодорхойлуулж, тусад нь байрлуулав. • Төв номын фондоос сэргээн засварлах шаардлагатай гэмтэл ихтэй 40 ширхэг номыг шүүн авч, сэргээн засварлагч Д.Алтангэрэл, Б.Отгонтуяа нарт хүлээлгэн өгч номуудын гэмтлийг тодорхойлуулан бүртгүүлж, буцаан байрлуулсан.

	2.1.5. Автономит Монгол Улсын үеийн “Автономит Засгийг устгах цагийн бичгүүдийн хуулбар” хэмээх баримт бичгүүдийн харьцуулсан судалгааг хийх	• Богд хаанаас тулгар төр байгуулах хэрэгт онц хүчин зүтгэгсэд ба нийтэд хэшиг тараах зарлиг буулгасан хэрэг гар бичмэл бүтээлийг монгол бичгээс кирилл үсэг рүү буулгалаа. Энэ гар бичмэл нь Богд хааны үеийн урамшуулал, шагналын асуудлыг хөндсөн судалгааны ном юм. • Монголын Үндэсний номын сангийн монгол судлал, гар бичгийн фондод хадгалагдаж буй “Найман мянгат” буюу “Жадамба” судар нь гар бичмэл ба барын эхээрээ 36 төрөл байгааг судалж тогтоосон. • Зурхайн ном судрыг судалж, Монгол судлал гар бичгийн фондод хадгалагдаж буй ном судрт Эрлэг хааны төлөг ганц хувь байгааг судалж тогтоосон. • “Долоон өвгөн нэрт одны судар” хэмээх судрын харьцуулсан судалгаа хийж, дэлгэрэнгүй судалгааны тайлан бичлээ. • “Бэхар хааны түүхэнд холбогдох нэгэн баримт” эрдэм шинжилгээний өгүүллэг бичиж, Үндэсний түүхийн музейн “Нүүдэлчний өв” эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлээ.
	2.1.6. Дээрх судалгааны чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлэх	- Төрийн хэлний зөвлөлтэй хамтран “Монгол бичгийн албан хэрэглээг нэмэгдүүлье” эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгууллаа. - Мөн “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тохиолдуулан эх хэл, бичгээ сурталчлах зорилгоор Төрийн хэлний зөвлөл МУИС-ийн Монгол Хэл Соёлын сургууль, МУ-ын Боловсролын их сургууль, Монгол бичгийн “Босоо ертөнц” төв, “Хүмүүн бичиг” сонин, “Содномун” төв, “Бичиг соёл” төв, “Эрвээхэй” номын дэлгүүр зэрэг байгууллагатай хамтран “Монгол бичгээ эрхэмлэгч” хувь хүн, төрийн болон төрийн бус байгууллагыг шалгаруулж өргөмжлөл гардуулав.

Бүтээгдэхүүн: 2.2. Сургалт - арга зүйн ажил • Номын сангийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах • “Үндэсний номын санг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг дэс дараатай хийх • Улсын хэмжээний номын сангуудад мөрдөгдөх		- УИХ-ын Тамгийн газар, БСШУЯ /хуучнаар/-тай хамтран “Номын сангийн хууль”, “Үндэсний номын сангийн эрх зүйн байдлын хууль”-ийн төслийг боловсруулах ажлыг хэсэгт ажиллалаа. Хууль боловсруулах ажлын хүрээнд ХБНГУ, ОХУ-ын номын сан, Японы Парламентийн номын сан, Конгрессийн номын сангийн хуулийг орчуулсаны зэрэгцээ орон нутгийн номын сан, номын санчдаас санал авах, энэ чиглэлийн судалгаа хийх ажлуудыг хийлээ. - ССАЖЯ-аас “Номын сангийн хууль”, “Үндэсний номын сангийн эрх зүйн байдлын хууль”-ийн төслийг дахин судалж боловсруулахаар байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран ажиллалаа.
	2.2.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит уншлагын танхимын үйлчилгээний журмыг боловсруулах	Монголын Үндэсний номын сангийн эрдэм шинжилгээний танхим буюу “Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит уншлагын танхим”-ын үйлчилгээний журмыг боловсруулж мөрдөж ажиллаж байна.
	2.2.4.”Номын сангийн ном солилцооны журам”-ыг боловсруулж, батлуулах /Үндэсний номын сангийн хэмжээнд/	“Солилцоогоор ном олгох журам” боловсруулж номын сангийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн захирлаар батлуулан мөрдөж байна.

дүрэм, журмыг боловронгуй болгож үйлчилгээг сайжруулах • Аймгийн нийтийн номын сангийн үйл ажиллагааг нийтэд нээлттэй мэдээлэх, үйл ажиллагааг нь сайжруулах • Аймаг, сумдын номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, арга зүйн зөвлөлгөө өгөх, сургалт явуулах • Номын санчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхэд зориулсан гарын авлага	2.2.5. ”Газрын зургийн ном зүйн бичилт” /2011 онд боловсруулсан MNS5271:2006 Ном зүйн бичилт. Ерөнхий шаардлага MNS 5638:2006 Баримт бичиг: Аудио, видео материалын ном зүйн бичилт MNS 5639:2006 Баримт бичиг: Нотны хэвлэлийн ном зүйн бичилт /нэмэлт өөрчлөлт оруулсан/ стандартуудыг Стандарчилал Хэмжил зүйн Үндэсний төвөөр батлуулах	“MNS 6334: Газрын зургийн хэвлэл, бүтээлийн номзүйн бичилт. Ерөнхий шаардлага” шинэ стандарт Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2012 оны 11 сарын 22-ны 26 дугаар тогтоолоор улсын хэмжээнд хэрэглэх үндэсний стандартаар батлагдлаа. Боловсруулсан 3 стандарт Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2012 оны 6 сарын 27-ны 18 дугаар тогтоолоор улсын хэмжээнд хэрэглэх үндэсний стандартаар батлагдлаа. Үүнд: • MNS 5271:2012 “Номзүйн бичилт. Ерөнхий шаардлага”.-44х.; • MNS 5638:2012 “АВ материалын номзүйн бичилт”.-26х.; • MNS 5639:2012 “Нотны хэвлэлийн номзүйн бичилт”.-29х. стандартууд болно /нийт 99 хуудас/.
	2.2.6. “Дүрслэх урлагийн хэвлэлийн ном зүйн бичилт” стандарт / шинээр боловсруулах/	
	2.2.7. “Номын санчдын сургалтын танхим”-ыг түшиглэн орон нутгийн номын санчдын давтан сургалтыг зохион байгуулах	• Аймгуудын номын сангийн Мэдээллийн ажилтан, номзүйчдийн цахим сургалтын хөтөлбөрт оруулах саналыг 8 аймгаас авч, боловсруулан энэ чиглэлээр сургалт зохион явууллаа. Сургалтанд 21 аймгийн номын сангийн мэдээллийн ажилтан, номзүйчид нийт 25 хүн орлцож сертфикаттай төгссөн. • Дорнод аймаг, сумдын номын санчдын мэргэжил дээшлүүлэх сургалтанд “Номын сангийн үйл ажиллагаанд баримтлах эрх зүйн баримт”, “Фондын хадгалалт хамгаалалт, зохион байгуулалт”, “Номын сангийн анхан шатны бүртгэлүүдийг хөтлөх” гэсэн сэдвүүдээр хичээл заасан. Сургалтанд 24 номын санч оролцсон ба Сертфикат гардуулсан. .

гаргаж тараах • 2.2.11.Номын сангийн дүрэм, журмын дагуу үндсэн ажлуудтай танилцаж, арга зүйн зөвлөлгөө өгөх • Номын сангийн дүрэм, журмын дагуу зөвлөлгөө өгч үйл ажиллагааг нь сайжруулах, мэргэжлийн бус номын санчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхэд туслах	2.2.8. Ном хэвлэлийн данс бүртгэлийн дахин үнэлгээний аргачлалыг боловсруулж ажиллах	• Ном хэвлэлийн данс бүртгэлийн хөтлөлтийг сайжруулах, дахин үнэлгээг хийх бэлтгэл ажлыг хангах зорилгоор шинэчлэгдсэн дансыг хуучин данстай тулган шалгах, хуулагдсан дансны ном нэг бүрийн хуучин үнийг зохих журмын дагуу дахин үнэлэх, нэг бүрчилсэн болон нэгдсэн бүртгэлд тусгах ажлыг боловсронгуй болгож, гүйцэтгэх асуудлыг Номын сангийн мэргэжлийн зөвлөл болон Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.
	2.2.9. Аймаг, орон нутгийн 4-5 номын санд томилолтоор ажиллах	• Говь-Алтай, Хэнтий, Сүхбаатар, Говь-сүмбэр аймагт томилолтоор ажиллаж, нийтийн номын сангийн ажил байдалтай танилцлаа. Номын санч бүртэй уулзаж арга зүйн зөвлөлгөө өгч ажилласан. • Дорноговь аймгийн Төв номын сан дээр зохион байгуулсан аймаг сумдын номын санчдын сургалтанд "Номын сангийн үйл ажиллагаанд баримтлах эрх зүйн баримтууд", "Номын сангийн орчин нөхцөлд тавигдах шаардлага", "Архивын өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага" стандартын талаар хичээл заасан. • Говь-Алтай, Сүхбаатар, Говь-сүмбэр аймгийн Төв номын сангаас ирүүлсэн хичээлийн хөтөлбөрийн дагуу лекц бэлтгэж тус бүр 16 цагийн хичээл зааж дадлага хийлгэсэн.
	2.2.10. Онол- арга зүйн "Номын санч" сэтгүүлийг бэлтгэж, хэвлэн гаргах, түгээх	• "Номын санч" сэтгүүлийн 2012 оны №1,2,3,4 дугаарыг 82 онол арга зүйн материалаар, дугааруудыг бэлтгэн гаргаж, нэгдсэн захиалгын дагуу хөдөө орон нутагт хүргэлээ.

	2.2.11. Хотын болон их дээд сургуулийн номын сангийн хүсэлтийн дагуу очиж ажиллах	• Отгонтэнгэр ДС, Евро-Ази ДС, Хууль зүйн болон Хүмүүнлэгийн номын сан, Баянгол дүүргийн соёл мэдээллийн төвийн номын сан, Цахим дээд сургууль, Технологийн дээд сургууль, “Энх-Орчлон” коллеж “Монгол судлалын төв”-ийн номын сангийн ажилтай биечлэн танилцаж номын сангийн, фондын, каталогийн зохион байгуулалт, бүртгэл хөтлөх, ангилах талаар зөвлөгөө өгсөн. • Монголын номын сангуудын тухай танилцуулга бэлтгэж википедиад тавиулах зорилгоор Гадаадын зарим орны сайтаар орж туршлага судалж бүтэц гаргасан. Хүүхдийн номын ордон дээр зохион явагдсан аймгийн номын сангийн эрхлэгчдийн сургалтанд “Арга зүйн ажлын зохион байгуулалт” сэдвээр мэдээлэл хийсэн.

	2.2.12. Нийтийн болон их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын номын санчдад арга зүйн зөвлөлгөө өгөх	• Отгонтэнгэр ДС, Евро-Ази ДС, Хууль зүйн болон Хүмүүнлэгийн номын сан, Баянгол дүүргийн соёл мэдээллийн төвийн номын сан, Цахим дээд сургууль, Технологийн дээд сургууль, “Энх-Орчлон” коллеж “Монгол судлалын төв”-ийн номын сангийн ажилтай биечлэн танилцаж номын сангийн, фондын, каталогийн зохион байгуулалт, бүртгэл хөтлөх, ангилах талаар зөвлөгөө өгсөн • Соёл Урлагийн Хорооноос аймгийн номын сангийн эрхлэгчдэд зориулан явуулсан сургалтанд Эрх зүйн баримтуудын талаар мэдээлэл хийсэн. • Ховд аймгийн МСҮТ-ийн номын санч “LIB4U программ хангамжийн тухай”, Дорноговь аймгийн номзүйч, Сэлэнгэ аймгийн Орхон сумын номын санч Лхамсүрэнд, Ховд аймгийн номзүйч, Дундговь аймгийн номзүйч, Дархан-Уул аймгийн Анагаахын сургуулийн номын санч, Өмнөговь аймгийн Хилийн цэргийн 0131-р ангийн номын санч зэрэг хүмүүст мэргэжлийн зөвлөгөө өгсөн. • Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын номын санч, Мөнхцэцэгт “Номын сангийн тухай ойлголт, анхан шатны бүртгэлүүд”, МУБИС-ийн ахлах номын санч Мөнхөөд “Ном хэвлэлийг данснаас хасах журам”, Технологийн ДС-ийн номын санч Сүрэн “Анхан шатны бүртгэл хөтлөлтийн тухай”, ШШГЕГ-ын номын санч зэрэг нийт **44** хүнд мэргэжлийн зөвлөгөөг өгч ажилласан. • Номын санчид болон оюутнуудад 74 ш мэргэжлийн ном сэтгүүлээр үйлчиллээ.
Бүтээгдэхүүний анги-3: Мэдээлэл технологийн үйлчилгээ		

Бүтээгдэхүүн:3.1. Бүртгэл-мэдээллийн ажил • Гар бичмэл ном судрыг скайнердаж, дижитал хэлбэрт оруулах • Соёлын өвийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, нэгдсэн сан байгуулах • Мэдээллийн хангамж, үйлчилгээг сайжруулах, уншигчдыг мэдээллээр шуурхай хангах Электрон мэдээллийн сангуудыг бүрдүүлж, уншигч хэрэглэгчдэд шуурхай үйлчлэх	3.1.1. Монгол гар бичмэл номын олон ботит судрыг тоон хэлбэрт оруулж, DVD болон серверт хуулж, хадгалах, уншуулах	“Монгол судлалын номзүйн бүртгэл” төслийн хүрээнд Монгол судлалын, гар бичмэл ном хэвлэлийн өгөгдлийн санг бүрдүүлсэн бөгөөд энэхүү санг электрон каталогт хөрвүүлэх ажлыг хийж байна.

	3.1.2. "Үндэсний соёлын өвийн мэдээлллийг тоон ситемд оруулан хадгалах хөтөлбөр"-ийн хүрээнд үнэт ховор номын мэдээллийн санд нэмэлт мэдээллийг оруулах, архивлах	• Монгол гар бичмэл ном судрыг судлах ажлын хүрээнд тоон хэлбэрт оруулсан 636 ширхэг судрын 7 үзүүлэлтээр бүртгэж авлаа. Алтан үсгийн ганжуур, Мөнгөн үсгийн ганжуурын доторхи бурхны зургийн мэдээллийн санг бүрдүүлсэн. • "ҮЙСЭН ДЭЭРХ БИЧИГ" ДАВГА ДАРХАНЫ "АЛТАН ХҮРД" "ЛУ. АЛТАН ТОВЧ" "ЖАДАМБА" зэрэг өвүүдийн мэдээллийн санг тус тусад нь бүрдүүлж үнэлгээ болон даатгалын асуудлыг шийдвэрлүүлсэн • RCH-2 бүртгэлээс өмнөх бүртгэлүүдийг цэгцэлж дутуу байгаа өгөгдөлүүдийг нөхөн гүйцээж оруулсан. 2012 онд болох улсын тооллогонд бэлтгэх ажлыг хийж, бусад фондуудтай хамтран олон ботит ном судрын бүртгэлийг цэгцлэх санал боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна. • Улсын хэмжээнд үзэсгэлэнд тавигдах дурсгалуудын мэдээлэлийг бичих "Хөдөлгөөний карт"-ыг хөтлөх ажлыг нэвтрүүлэн ажиллаж байна. • Ганц хувь гар бичмэл ном судрын эх хувийг уншигчдад зөвхөн тоон хэлбэрээр уншуулах зорилгоор захиалгын 636 ширхэг судрыг скайнердлаа.
	3.1.3.Номын сангийн анхан шатны бүртгэлүүдийг автоматжуулах ажлыг хийж эхлэх	• "GO OK" компанитай гэрээ байгуулан ажиллаж, анхан шатны бүртгэлийг автоматжуулах ажлыг хийхээр хамтран ажиллаж байна. Номын сангийн нэгбүрчилсэн болон нэгдсэн бүртгэлийн үзүүлэлтүүд, бусад шаардлагатай мэдээлэл, ажлын даалгаврыг тус компанид гаргаж өгсөн. • Программ хангамжийг боловсруулах ажил хийгдэж байна. .
	3.1.4.1990-2010 оны тогтмол хэвлэлүүдийг цахим хэлбэрт оруулах ажлыг хийх	Мэдээлэл харилцааны системс ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж, 1990-2010 оны нийт 9 нэрийн төвийн сонин хэвлэлийг цахим хэлбэрт оруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Уг цахим санг уншигчдад toch дэлгэцээр уншуулахаар бнлтгэл ажлыг хангаж байна. Энэ ажлын хүрээнд нийт нэгж сонинг нэгжилж хавтаслах ажлыг хийлээ.

	3.1.5. Монгол ном болон гар бичмэл, монгол судлалын фондын эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлүүдийн электрон каталогийг тогтмол баяжуулах	• Монгол лам нарын төвд зохиолуудаас каталогт нийт 1694 номыг шивж, ерөнхий дансанд 2445 номыг бүртгэлээ.Компьютерийн каталогт орсон номонд 4870 ш карт бичсэн. • Монгол номын фондонд шинээр ирсэн 1972 нэрийн 2381 ном, 55 нэрийн 61 диссертац, хураангуйн мэдээллийг электрон каталогт оруулан дотоод сүлжээгээр уншигчдад үйлчилж байна. • Монгол гар бичмэл ном судрыг дижитал хэлбэрт оруулж, эрдэмтэн, судлаачдад үйлчилж байна.
Бүтээгдэхүүний анги-3: Мэдээлэл технологийн үйлчилгээ		
Бүтээгдэхүүн 3.2. Мэдээлэл – технологийн үйлчилгээг сайжруулах: Номын сангийн программ хангамжийн үйлчилгээг сайжруулахад анхаарч ажиллах Үндэсний номын сангийн интернет болон дотоод сүлжээний найдвартай	3.2.1.Unimarc форматыг дэмждэг электрон каталогжуулалтын систем нэвтрүүлж, монгол судлал, гар бичмэл номын фондын ном хэвлэлийг оруулах	- Ерөнхийлөгчийн ТГ-ын дэмжлэгтэйгээр /850 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар/ Ерөнхийлөгчийн нэрэмжит уншлагын танхимд дижитал мэдээллийн сангаар үйлчлэх системийг нэвтрүүлэх зорилгоор доорхи ажлуудыг хийлээ. Үүнд: 1. Шаардлагатай техник тоног төхөөрөмжийн судалгаа, техникийн үзүүлэлт., 2. Программ хангамжийн шаардлагыг тодорхойлох., STAR soft компанитай хамтран Unimarc форматыг дэмждэг номын сангийн электрон каталогийн программыг нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хийж дууслаа. 3.Номын сангийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор 38 хяналтын камерийг суурилуулсан. - Мэдээлэл харилцааны системс компанитай хамтран “Цахим сонин” төслийг хэрэгжүүлж, 1990-2011 оны Өнөөдөр, Өглөөний сонин, Ардын эрх, Ардчилал, Монголын мэдээ, Өдрийн сонин зэрэг 16 нэрийн 506 нэгж хавтас сонины мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээлийн сан байгууллаа. Мэдээллийн нэгдсэн санг уншигч хэрэглэгчдэд toch дэлгэцээр уншуулах бэлтгэл ажлыг хийж байна.
	3.2.2. Интерпресс компанитай хамтран цахим номын үйлчилгээг нэвтрүүлэх	Интерпресс компанитай хамтран цахим номын үйлчилгээг нэвтрүүлж, эхний ээлжинд 70 ш монгол номыг цахим хэлбэрээр уншлагын танхимуудаар үйлчилж байна.

ажиллагааг хангах,	3.3.3. Номын сангийн вэб хуудсыг тогтмол баяжуулах, YAHOO ID ашиглан лавлагаа өгч үйлчлэх	- Мэдээ мэдээлэл болон шинэ номын мэдээний 2012 оны 1-12 дугаарыг нэмж, Е-монгол номын каталог, Е-диссертацийн каталогт шинээр ирсэн номыг нэмж оруууллаа. - Номын сангийн вэб сайтад “Виртуаль лавлагааны алба” байгуулж, шинэ “Виртуаль лавлагааны албаны аргачлал”-ыг боловсруулан ажиллаж байна. “Та асуу бид хариулъя” буланг ажиллуулж, манай сайтад хандсан хэрэглэгч бүр өгөгдсөн лавлагааны архиваас хэрэгтэй мэдээллээ авах, тухайн хэрэглэгчийн асуусан асуулт хариулттайгаа хадгалагдан үлдэх үйлчилгээг үзүүлж байна.болно. 90 гаруй лавлагаанд хариу явуулаад байна. - Интерпрессийн www.Inom–ийн болон “Мөнхийн үсэг”-ийн www.bookstore–ийн нээлтийг зохион байгуулж, цахим ном хэвлэлийг сурталчилаа. - UB1617-тай цахим каталогийг сурталчлах чиглэлээр хамтран ажиллаж байгаа бөгөөд 980ш шинэ номын баазыг өгч мэдээллийн санд нь оруулаа. -Дижитал хэлбэрт орсон 18 гаруй номыг DVD-д бичин архивласан. Мөн эрдэм шинжилгээний уншлагын танхимд, дижитал хэлбэрт орсон 646 номыг уншлаганд гаргасан.
	3.2.4. Номын сангийн вэб сайтаар дамжуулан шинээр хэвлэгдэн гарсан номыг сурталчлах боломжийг хэвлэн нийтлэгчдэд бүрдүүлж ажиллах	- Үндэсний номын сангийн энэ онд худалдан авсан 1400 шинэ номын мэдээллийг сурталчиллаа. - Вэб сайтад энэ улиралд /2012 оны 1-р сарын 1-ээс 12-р сарын 17 хүртэлх/ 18323 хэрэглэгч хандсан байна. Үүнээс 89,28% нь Монгол улсаас, 11% нь Япон, Өмнөд Солонгос, Хятад, Франц, АНУ, Герман зэрэг орнуудын Киото, Сөүл, Москва, Прага , Варшав зэрэг хотуудаас хандсан байна. Нийт хэрэглэгчдийн 13522 нь шинээр хандсан байна.

	3.1.5. Сүлжээнүүд болон хэрэглээний программуудын найдвартай ажиллагааг хангах, уншигч хэрэглэгчдэд түргэн шуурхай үйлчлэх	Номын сангийн гадаад болон дотоо сүлжээний алдагдлыг засч, сүлжээний найдвартай ажиллагааг хангаж ажиллалаа. Гацсан, хэвийн ажиллагаа нь алдагдсан компьютерүүдийг засварлахын зэрэгцээ вирустсэн, системийн гэмтэл гарсан компьютерүүдийг форматлан үйлдлийн систем болон хэрэглээний программуудыг суулгалаа.
Бүтээгдэхүүний анги 4: Лавлагаа, ном зүйн үйлчилгээ		
	4.1.1. "Шинэ номын мэдээ" сэтгүүлийг сар бүр бэлтгэн гаргах, цаасан болон электрон хэлбэрээр түгээх	- "Шинэ номын мэдээ"сэтгүүлийг 1200 номоор бэлтгэн гаргаж, цаасан болон электрон хэлбэрээр түгээж байна. - Шинэ номын мэдээг электрон хэлбэрээр нийт 120 гаруй байгууллага, хувь хүнд явуулж байна. Мөн номын сангийн вэб сайтанд шинэ номын мэдээг тогтмол тавьж, сурталчилж байна.
	4.1.2. Уншигчдын дунд шинэ ном хэвлэлийг сурталчлах номын тойм яриа хийх	- Уншигчдын дунд нийт 4 удаа тойм яриа хийж, шинэ ном хэвлэлийг сурталчиллаа. - Лавлагааны фондыг нийт 20 номоор баяжуулсаны зэрэгцээ 227 уншигчдад аман лавлагаа өглөө. - Ардын уран зохиолч С.Эрдэнийн бүтээлээр, Залуу хүний уншвал зохих ном нийт 305 номоор санамж өгөх номзүй хийсэн.
	4.1.3. Шинэ номын электрон үзэсгэлэн гаргах	Байгаль хамгаалах өдөрт зориулан 88 номоор, Хүний эрхийг хамгаалах өдөрт 83 номоор тус тус шинэ номын электрон үзэсгэлэн гаргалаа.
	4.1.4. 1988-2008 он хүртэлх сонин сэтгүүлийн өгүүллийн ном зүйг үргэлжлүүлэн хийх	"Номын сангийн зөвлөл"-өөр хэлэлцэж, "Сонин сэтгүүлийн өгүүллийн ном зүй /1988-2008/" бүртгэл хийх ажлын хэсгийг байгуулж, 6126 картыг Ардын эрх, Улаан-Од, Үндэсний дэвшил, Тусгаар тогтнол, Улаанбаатарын мэдээ,Гоо марал, Номын санч, Анагаах арга билэг, Үг, Эрүүл мэнд зэрэг нийт 18 нэрийн сонин, сэтгүүлээс бичиж байрлууллаа.

	4.1.5. Албан байгууллагууд болон уншигчдын хүсэлтээр сэдэвчилсэн бичгийн лавлагааг бэлтгэх, аман лавлагаа болон бусад мэдээллийг өгч үйлчлэх	- “Монгол хэлний нэвтэрхий толь” 25-н номоор /МҮТВ-ийн захиалгаар/, “Ерөнхий сайдын номын санд худалдан авах” номын жагсаалт 672 номоор. /БСШУЯ-ны захиалгаар/, Улсын нэр томъёоны комиссоос гаргасан 1950-1989 он хүртэлх “Улсын нэр томьёоны комиссын мэдээ” хэмээх 147-н цуврал эмхэтгэлийн (Үндэсний тагнуулын академийн хүсэлтээр), “Канад” орны тухай, Уртын дууны тухай,“Б.Ринченгийн орчуулан хэвлүүлсэн бүтээл” 37 ном сонин, “Сүүлийн 3 жилд уншлаганд хамгийн их гардаг болон бага эрэлттэй номын жагсаалт” 2033 номоор, “Хүүхэд залуусын уншвал зохих ном” 100-н номоор /явуулын номын санд, “Ерөнхийлөгчийн нэрэмжит танхимд худалдан авах номын жагсаалт” 2250 номоор, Залуу хүний уншвал зохих номын жагсаалт зэрэг нийт **5238** ширхэг номоор **23** удаа сэдэвчилсэн бичгийн лавлагааг өгсөн. Мэдээллийн самбарт “Нүдний харааг хэрхэн сайжруулах вэ?”, “Монголын хамгийн хамгийн”, “Ажлын байранд хийх дасгалууд”, “Номоо зорилготойгоор сонгон авч унших нь”, “Говь Алтай аймагт чөлөөт сонголттойгоор үйлчлүүлдэг боллоо”, ”Өөдрөг явах 25 зарчим”, “Өөрийн гэсэн ажлаа хэрхэн олох вэ?”, “Үр дүнтэй яриаг хэрхэн өрнүүлэх вэ?”, “Жаргалтай гэр бүл гэдэгээ хэрхэн батлах вэ?”, “Гадаад үгийг хэрхэн тогтоох вэ?”, “Заавал унших 88 номын нэрсийн жагсаалт”, “Зохиолчдын уулзалт”, “Та эрүүл мэндийн даатгалаа төлөөд үйлчилгээ авахаа мэддэг үү? зэрэг нийт 35ш зөвлөгөө гаргасан.
	4.1.6. Монгол Улсын хуулиуд-160, тогтмол хэвлэлийн өгүүлэл-1000 карт бичиж, уншигч, хэрэглэгчдийг мэдээллээр хангах	Монгол Улсын хуулиуд-333, тогтмол хэвлэлийн өгүүлэл-1597 карт бичиж, төрөлжсөн картын санг баяжууллаа. Картын санг уншигч, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж, лавлагаа өгөхөд ашиглаж байна.
Бүтээгдэхүүний анги 5: Ном судрын хадгалалт хамгаалалт		

Бүтээгдэхүүн: 5.1. Ном хэвлэлийн хадгалалтыг сайжруулах ажил • Үнэт ховор сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах • Төвд фондын ном судрын хадгалалт хамгаалалтыг сайжруулж, судалгааны эргэлтэнд оруулах • Сан хөмрөгийн зохион байгуулалтыг тогтмол сайжруулж ажиллах • Ном хэвлэл сэлбэн засах, сэргээн засварлах Тооллогоор дутсан номын төлбөрийг барагдуулах	5.1.1. Үнэт ховор номын музейн ном судрын тооллогод бэлтгэх, улсын тооллого хийх	• Улсын тооллогын хийх салбарын сайдын тушаал болон байгууллагын захирлын тушаалаар батлагдсан 13 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комиссийг байгууллаа. • Үнэт ховор номын музейн тооллого хийх төлөвлөгөө, ажлын хуваарь болон бэлтгэл ажлыг хангаж, 2012 оны 09-р сарын 17-ний өдрөөс эхлэн улсын тооллогыг хийж эхэлсэн. • Мөн улсын тооллогын талаарх саналаа Соёлын өвийн төвд боловсруулж хүргүүлсэнийн зэрэгцээ тооллогын явцын тайланг тогтоосон хугацаанд захиргаанд тайлагнаж байна. • Тооллогын хугацаанд Алтан үсгийн ГАНЖУУР, Мөнгөн үсгийн ГАНЖУУР, Алт мөнгө хосолсон ГАНЖУУР-ын бүх боть, 9 эрдэнийн ГАНЖУУРААС 60 ботийг тоолж, хийц, чанар, ялгагдах онцлог, цаасны болон бичвэрийн хэмжээ, жин, эхлэл төгсгөлийн хуудас болон гэмтлийг нарийвчлан тодорхойлох ажлыг хийж байна.
	5.1.2. БСШУЯ, МХЕГ-тай хамтран Үндэсний номын сангийн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах ажлын төлөвлөгөөг боловсруулах	“2010-2016 онд Үндэсний номын санг хөгжүүлэх стартеги”-д үндэслэн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийлээ. Үүнд: - БСШУЯ-тай /хуучнаар/ хамтран улсын хэмжээнд мөрдөгдөх “Хосгүй үнэт, үнэт ховор ном судрыг ашиглах, хамгаалах, хадгалах журам”-ыг боловсруулан БСШУ-ны сайдын тушаалаар батлууллаа. Энэ журмын дагуу “Нэн яаралтай хамгааланд оруулах ном судрын жагсаалт”-ыг ССАЖЯ-нд гарган өгч, сэргээн засварлах ажлын санхүүжилтийг авсан. - Номын сангийн нийт 9 сан хөмрөгийн хаалга болон хонгил, мөн уншлагын танхимууд болон доод давхарт шинээр 34 ширхэг хяналтын камер суурилуулж, 24=14 гэсэн харьцаатайгаар 2 дэлгэцээр хяналт тавин ажиллаж байна. - Ном судар сэргээн засварлах лабораторийн эх суурийг тавьж, шаардлагатай багаж, хэрэгсэл,тоног төхөөрөмж авсны зэрэгцээ цаашид иж бүрэн лаборатори байгуулах зорилт тавин ажиллаж байна./Лаборатори байгуулах төслийг ССАЖЯ-нд хүргүүлсэн./ - Номын сангийн гал, усны аюулгүй байдлыг хангаж, цахилгааны болон сантехникийн засварыг хийж байна.

	5.1.3.Архив фондод илүү хувьтай номыг жагсаалтын дагуу татах, шаардлагатай фондод шилжүүлэх, нэг бүрчилсэн бүртгэлд тэмдэглэгээ хийх	Архивт илүү хувьтай байгаа 2094 ширхэг номыг тусад нь татаж байрлуулан, данснаас хасалт хийлээ. Эдгээр номыг холбогдох фондод шилжүүлэх асуудлыг "Номын сангийн мэргэжлийн зөвлөл" болон Захиргааны зөвлөлийн хурлаар оруулж, шийдвэр гаргалаа.
	5.1.4. 1921-2012 онд хэвлэгдсэн архивт байхгүй ном хэвлэлийн судалгааг хийх, нөхөн бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллах	Архивийн иж бүрэн тооллогыг хийж дууссан бөгөөд 1921-2012 онд хэвлэгдсэн архивт байхгүй ном хэвлэлийн судалгааг гаргалаа.
	5.1.5.Архив бэлтгэл фондын бүрэн тооллогыг хийх	- Архив ба бэлтгэл фондын ажил хүлээлцэх тооллого 2 сарын 16-наас 4 сарын 9-ний хооронд хийгдэж, акт ёсоор архивын 32704 номоос 32659 ном, бэлтгэл фондын 127384 ном тоологдохоос 99329 номыг тус тус хүлээн авлаа. - Бэлтгэл фондоос захирлын зөвшөөрлийн дагуу 62 нэрийн 120ш 1.130.100 төгрөгийн үнэ бүхий номыг гарган, дансанд зохих тэмдэглэгээ хийлгэв. - Архив фондод байгаа 1990 оноос өмнөх оны сэтгүүлүүдийг цэгцэлж байрлуулав. - Хүүхдийн номын ордноос ирсэн орон нутгийн 22 нэрийн 1260 нэгж сонинг хүлээн авч байрлуулав. - "Монгол улсын Үндэсний номын сангийн архив фондоос ном, хэвлэлээр үйлчлэх журам"-ыг боловсруулж, Захиргааны зөвлөлөөр батлуулан мөрдөж байна.
	5.1.6. Дорно дахины фондын бүрэн тооллогыг хийх, данс бүртгэлийг цэгцлэх	- Дорно дахины фондын 13000 орчим ном сэтгүүлийг хэл хэлээр нь (90% орчим нь хятад, үлдсэн нь вьетнам, англи, орос, солонгос хэлний номнууд байна) ялгаж цэгцэлсэн. Хятад хэлний 3996ш номыг цэгцлэн байрлууллаа. - 876ш манж номыг нэр төрөл, хэмжээ, дэвтрийн дугаараар ялгаж тус бүрт нь ялгагч хийж дэвтрийн дугаараар нь дараалуулан байрлууллаа.

	5.1.7.Тооллогын дараах төлбөрийг барагдуулах ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэх	Төлбөр барагдуулах комиссын ажлаар 1995-2011 оны хугацаанд гэрээр авсан номын төлбөрийг орлуулан төлүүлж авах ажлыг гүйцэтгэж, нийт 53 эзэнд 212 ширхэг ном байснаас 41 хүнээс 146 ширхэг 418.843,1 төгрөгийн номын төлбөрт 136 нэрийн 152 ширхэг 1.476.500 төгрөгийн ном хүлээн авч, төлбөрийн 1-6 дугаар фактур бичиж, ном ангилагчид шилжүүлэв. Комиссын дэлгэрэнгүй тайланг захиргааны зөвлөлийн хуралд илтгэж, холбогдох хавсралт бусад баримтыг шилжүүлсэн болно.
	5.1.8. Каталогт орсон Òºâä ôîíäûí 17325 íîì ñóäрыг данслах, 23100 карт хэвлэх, 3465 судрыг цэгцлэх,	- Төвд фондын 2880 ном, 377 ширхэг модон барыг ялган цэгцэлсэн. - 235 төвд ном судрыг электрон каталогит оруулж, нийт 7800 төвд ном судруудыг данслан бүртгэв. - Монгол лам нарын компьютерийн каталогт орсон номоос ерөнхий дансанд 10770 номыг бүртгэн дансалж, 12470 ширхэг карт бичиж хэвлэсэн. -Электрон каталогт орсон номын 198 файл буюу 9900 номын мэдээллийг номны хувийн дугаарын дарааллаар нэгтгэсэн. - Фондод хадгалагдаж буй "Мэргэд гарахын орон" нэрт судрын модон барыг хосгүй үнэт бүтээлд бүртгүүлэхээр дэвшүүлсэн тул 377 ширхэг бар бүрийг дугаарлан дансны дугаарыг бичиж нааж, төвд номын фондын үнэт номын ерөнхий дансанд бүртгэж дансалсан. - "Найман мянгатын цомирлог" номын үзэсгэлэнд төвд номын фондоос гарсан 9 төрлийн бар болон бичмэл Жадамба судрын 14 номыг каталогт оруулан бүртгэсэн.

<table>
<tr><td rowspan="3"></td><td>5.1.9. Фондуудын ном хэвлэлийн эмх цэгц, байрлалыг сайжруулах ажлыг тогтмол хийх</td><td>Төвд фондын 15122 номын байрыг цэгцэлж, ялгасаны зэрэгцээ 620 ном судрын баринтиг, ялгагчийг шинэчилж байрлууллаа.
• Төвд фондод хадгалагдаж буй хосгүй үнэт бүтээл Жадамба судрын 750 гаруй зэс барыг зориулалтын хайрцагт байрлуулах ажлыг хийлээ.
• 36064 гаруй гар бичмэл, барын номын байрын сунгалтыг хийж цэгцэллээ.
• Монгол номын фонд нь ном байрлуулах тавиур, байргүй болсон тул 1-р форматын 6000 орчим номыг шахан байрлуулж, шинэ ном байрлуулах тавиур бэлтгэлээ.
• Тогтмол хэвлэлийн 586 нэгж хэвлэлийн байрыг цэгцэлж, “Бодлын солбицол”, “Өдрийн сонин”, “Спортын мэдээ”, “Ардчилал”, “Таван цагираг” зэрэг нэгж сонингуудыг зөөж байрлууллаа.
• Өрнө дахины “А” фондын 67000 ш номын байрын сунгалт хийж, цэгцлэн байрлууллаа.
• 4331 манж номыг цэгцэлж байрлуулан, 1130 карт бичлээ.</td></tr>
<tr><td>5.1.10. Фондын номын санчдын “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-г дүгнэн ажиллах</td><td>Фондын номын санч бүртэй “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-г байгуулан ажиллахын зэрэгцээ Тогтмол хэвлэлийн фонд болон Архив, бэлтгэл фондын номын санчидтай шинээр гэрээ байгууллаа.</td></tr>
<tr><td>5.1.11. Засварлах номын хуудас – 4620, үдэж хавтаслах ном – 880, зориулалтын дагуу ариутгах ном - 277200ширхэг</td><td>• 3179 хуудас материалыг нааж засварлав.
• 1093 номыг үдэж хавтаслалаа.
• 535 нэгж сонин хавтаслалаа.
• 303528 номыг ариутгах ажлыг хийлээ.</td></tr>
<tr><td colspan="3">Бүтээгдэхүүний анги 6: Хүний нөөцийн удирдлагын үйлчилгээ</td></tr>
<tr><td>Бүтээгдэхүүн 6.1. Удирдлагын</td><td>6.1.1. Хөдөлмөрийн гэрээ, Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн байгуулах</td><td>Хөдөлмөрийн гэрээг ажилтан бүртэй, НББСХ болон ЗААХ-ийн 35 ажилтан, шинээр ажилд орсон 9 ажилтаны ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж мөрдөн ажиллаж байна.</td></tr>
</table>

үйлчилгээ • Удирдлагын маркетинг, менежментийг боловсронгуй болгох, байгууллагын дотоод хяналт, үнэлгээг сайжруулах • Хүний нөөцийн хангамж ашиглалтыг боловсронгуй болгох	6.1.2. Байгууллагын дотоод хяналт, зохион байгуулалтыг сайжруулах, “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг шинээр боловсруулж ажиллах	Байгууллагын дотоод хяналт, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор ажлын хэсэг байгуулан ажиллаж, “МҮНС-ийн дотоод хяналтын журам”-ыг боловсруулан НМХГ-т албан тоотоор хүргүүллээ.Сангийн яамнаас зохион байгуулсан дотоод аудит, хяналтын сургалтанд нэг ажилтныг хамруулла.
	6.1.3. Үндэсний номын сангийн орон тоог MNS5742:2007 “Номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага” стандартын дагуу боловсруулж, холбогдох байгууллагад явуулах	Үндэсний номын сангийн орон тоог MNS5742:2007 “Номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага” стандартын дагуу боловсруулж, ССАЖЯ-нд хүргүүллээ. Үндэсний номын санд одоогийн байдлаар мэргэжлийн 57 номын санч, мэргэжилтнүүд ажиллаж байгаа бөгөөд гар бичмэл сэргээн засварлагч, сан хөмрөгийн ажилтан, данс бүртгэлийн ажилтан, тооцооны нягтлан бодогч, арга зүйч, сүлжээний инженер, явуулын номын үйлчилгээний номын санч, жолооч зэрэг 20 гаруй орон тоо /стандартын дагуу/ шаардлагатай байгаа юм.
	6.1.4. Хүний нөөцийн судалгааг нарийвчлан гаргах, боловсон хүчний хангамж, чанарыг дээшлүүлэх	- Хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгааг гарган байгууллагын боловсон хүчний хангамж, чанарыг дээшлүүлэхэд онцгой анхаарч, мэрэгжлийн боловсон хүчнээр хангах бодлого баримтлан ажиллаж байна. - Шинээр ажилд орж байгаа боловсон хүчнийг мэргэжлийн ур чадвар, хэлний боловсрол, багаар ажиллах чадвар, техник технологийн мэдлэг зэрэг шалгуур үзүүлэлтээр сонгон авч байна. - Тайлангийн хугацаанд өөрийн хүсэлтээр 9 ажилтныг ажлаас чөлөөлж, 8 ажилтныг өөр ажилд шилжүүллээ. 1 ажилтанд хүүхдээ асрах чөлөө, 1 ажилтанд 2 сарын цалингүй чөлөө, 2 ажилтанд 8 хоногийн цалингүй чөлөө олгосон. 1 хүнд сонгуулийн тойрогт ажиллах сарын чөлөө олголоо.

	6.2.1. Номын сангийн ажилтнуудыг: - Мэргэжил дээшлүүлэх /номын сангийн чиглэлээр - Хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт - Гадаад хэлний сургалт - Харилцан туршлага солилцох чиглэлээрээр урт болон богино хугацаанд гадаад, дотоодод сургах	- ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр Санкт-Петербург хотын Соёл урлагийн их сургуульд Номын сангийн менежмент, автоматжуулалтын чиглэлээр магистрт - 2 ажилтан., - Финлянд улсад ОУНСХ-ны хуралд - 1 ажилтан., - Канад улсад болсон “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн олон улсын хуралд /урилгаар/ - 1 ажилтан., - Тайваны Үндэсний номын сангийн урилгаар- 1 ажилтан., - БНСУ-ын Үндэсний номын сан – 1 ажилтан - Чех улсын Үндэсний номын санд ном сэргээн засварлах чиглэлээр - 1 ажилтан., - ӨМӨЗО-ны Үндэсний номын санд туршлага солилцох – 6., - Буриадын Үндэсний номын сангийн урилгаар – 5 ажилтан., /**Гадаадад: давхардсан тоогоор - 18 ажилтан** /

	6.2.2. Номын санчдыг чадваржуулахад анхаарч, сурч боловсрох нөхцөл боломжоор хангаж ажиллах	- Юнеско, ГЁТЕ институтээс хамтран зохион байгуулсан сэргээн засварлах хөтөлбөрийн сургалтанд - 3 ажилтан., - Web design, Joomla!-ийн 2 сарын курст- 1 ажилтан., - ЗГХАА-ны сургалтанд - 3 ажилтан., - “Jet” англи хэлний дунд болон гүнзгийрүүлсэн сургалтанд - 2 ажилтан., - МУИС болон СУИС, МҮИС-ийн номын сан, удирдлагын чиглэлээр магистрт – 4 ажилтан - Архив, бичиг хэргийн мэргэжил олгох сургалтанд - 1 ажилтан - Монголын Урлагийн зөвлөл, Норвегийн элчин сайдын яамнаас зарласан “Соёл урлагийн залуу манлайлагч” тэтгэлэгт хөтөлбөрийн соёл урлагийн менежментийн мэргэшүүлэх цуврал сургалтанд - 1 ажилтан - АНУ-ын элчин сайдын яам, МУЗ-өөс хамтран зохион байгуулсан “Соёл урлаг ба Сэтгүүл зүй” сургалтанд – 1 ажилтан тус тус суралцлаа. **/Олон улсын байгууллагатай хамтарсан буюу мэргэжил дээшлүүлэх сургалтанд – 16 ажилтан/**
	6.3.3. Номын санчид, ажилчдад зориулсан төрөл бүрийн лекц, ярилцлага, мэтгэлцээнийг зохион байгуулах	- Номын санчдад зориулан “Хөдөлмөрийн шууд болон шууд бус харилцаа” /МУИС-ийн багш Б.Шүрэнцэцэг/, “Үйлчилгээний соёл”, “Белоруссийн Үндэсний номын сангийн туршлага” /Монголын консерциумын гүйцэтгэх захирал Гантулга/, “АНУ-ын их дээд сургуулийн электрон үйлчилгээ” /АНУ-ын их сургуулийн номын сангийн ажилтан Энэрэл/, “Dynate” сургалтын төвтэй хамтран “Англи хэл хэрхэн сурах вэ” зэрэг 5 удаагийн лекц, зөвлөгөө, ярилцлагыг номын санчид, ажилтнуудын дунд зохион байгууллаа. - МҮОНТ, Үндэсний Архивийн ерөнхий газартай хамтран монгол хэл бичиг, соёлоо сурталчлах “Тунгаамал” бооцоотой тэмцээнийг зохион байгуулж, тэмцээнд 1-р байр эзэллээ.

Бүтээгдэхүүний анги:7. Гадаад, дотоод хамтын ажиллагаа		
Бүтээгдэхүүн: 7.1. Гадаад хамтын ажиллагаа • • Гадаад харилцааг өргөжүүлэх	7.1.1.Гадаад орны Үндэсний номын сангууд, эрдэм шинжилгээний болон олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх Гадаадын харилцаат номын сан, олон улсын байгууллагууд	- 2012 оны 4-р сард БНЧУ-ын Үндэсний номын сантай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Уг гэрээнд заасны дагуу тус номын сангийн ном сэргээн засварлагч Б. Отгонтуяа БНЧУ-ын ҮНС-гийн ном сэргээн засварлах лабараторид 75 хоногийн хугацаатай мэргэжил дээшлүүлээд ирсэн. Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийн хүрээнд 2013 оны 4-р сард БНЧУ-ын Үндэсний номын сангийн төлөөлөгчдийг хүлээн авахаар бэлтгэл ажлын ханган ажиллаж байна. - Тайван улсын Үндэсний номын сантай 2009 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлж, хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр идэвхтэй ажиллалаа. Үүний үр дүнд Тайваны Үндэсний номын сангийн мэргэжилтнүүд ирж, хятад ном хэвлэлийг электрон каталогид оруулах ажлыг хамтран хийх асуудлыг шийдсэн бөгөөд уг ажлыг ирэх онд хийж эхлэхээр төлөвлөж байна. - БНАСАУ-ын Үндэсний Номын Сантай байгуулах хамтын ажиллагааны гэрээний эхийг англи монгол хэлээр бэлтгэн ГХЯ-нд илгээлээ.Гэрээг 2013 оны 5-р сард байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. - Тайлангийн хугацаанд Канадын номын сан, Финлянд, Тайвань, БНСУ зэрэг 6 орны Үндэсний номын санд манай номын сангийн ажилтнууд ажлын айлчлал хийлээ. - Төвд ном судрыг электрон каталогт оруулах ажлын хүрээнд АНУ-ын ACIP төсөл болон ССАЖЯ-тай хамтран гурвалсан гэрээг байгууллаа. - ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Хороо, Койка ОУБ, Тика ОУБ-уудтай төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, сайн дурын ажилтан авч ажиллуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна. Койкагийн шугамаар Солонгос мэдээллийн танхимд номын сангийн чиглэлээр сайн дурын ажилтанг 4-р улирлаас эхлэн ажиллуулж байна.

Бүтээгдэхүүн:7.2. Дотоодын хамтын ажиллагаа • Дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх	7.2.1. Төрийн, бизнесийн, соёл урлагийн, хэвлэн нийтлэлийн болон бусад ТББ-тай харилцан ашигтай хамтран ажиллана.Үүнд: • БСШУЯ • Соёл Урлагийн Хороо • Соёл Урлагийн сан • Мэдээлэл Харилцаа Холбооны газар • Номын сангууд • Соёлын дээд сургууль • Монголын Зохиолчдын Эвлэл	Ерөнхийлөгчийн Тамгийн Газраас номын сангийн үйлчилгээг автоматжуулах, аюулгүй ажиллагааг хангах, шинэ техник технологи нэвтрүүлж, Ерөнхийлөгчийн уншлагын танхимыг тохижуулах чиглэлээр, ССАЖЯ, Соёл урлагийг хөгжүүлэх сангийн дэмжлэг, санхүүжилтээр номын сангийн цахилгаан, сантехникийн засвар үйлчилгээ, ном судар сэргээн засварлах, үйлчилгээний тав тухтай орчин нөхцлийг хангах, Монголын Зохиолчдын Хороо, зохиолчидтой Явуулын номын сангийн үйлчилгээг алслагдсан дүүргийн иргэдэд хамтран хүргэх, мөн Соёмбо, Содпресс, Мөнхийн үсэг зэрэг хэвлэлийн байгууллагуудтай ном хэвлэлийг сурталчлах чиглэлээр хамтран ажиллаж тодорхой үр дүнд хүрлээ. Мөн аймгийн болон их дээд сургууль, ЕБС-ийн номын сангуудад төрийн болон төрийн бус байгууллагаас гаргасан шинэ ном хэвлэлийг хүргэх, сургалт зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгөх, Соёлын дээд сургуулийн оюутны дадлагын ажлыг удирдах, хотын номын сангуудтай хамтарсан тэмцээн уралдаан зохион байгуулах зэргээр хамтран ажиллаж байна.
Бүтээгдэхүүний анги: 8. Санхүүгийн үйлчилгээ		
Бүтээгдэхүүн: 8.1. Санхүүгийн үйлчилгээ Төсвийг оновчтой хуваарилах Санхүүгийн тайлан мэдээ гаргах Үндсэн хөрөнгийн ашиглалт	8.1.1.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах	- Тус номын сан нь Монгол улсын Нэгдсэн төсвийн тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2012 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулж ажиллалаа. Уг гэрээний дагуу 854,039.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийг зориулалтын дагуу зарцууллаа. - Тайлант хугацаанд 29,698.0 мянган төгрөгийн үндсэн болон, туслах үйл ажиллагааны орлого олж, 45,748.0 мянган төгрөгийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлжээ. - Нийт 933,927.3 мянган төгрөгийн зарлага гарснаас ажиллагсадтай холбоотой зардалд 626,323.4 мянган төгрөг, 33,997.0 мянган төгрөгийн тогтмол зардал, ажил олгогчоос бусад тэтгэмжийн зардалд 9,584.4 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

	8.1.2.Нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам зааврыг чанд мөрдөн санхүүгийн тайлан холбогдох мэдээг үнэн зөв, хугацаанд нь гаргах	- Тайлант хугацаанд Нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомжийн дагуу, НББОУСтандартад нийцүүлэн санхүүгийн бүртгэл, тайланг хийж мөн Сангийн сайдын баталсан маягтаар төсвийн гүйцэтгэлийг сар бүр гаргаж ажиллалаа.
	8.1.3.Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, эд хөрөнгийн тооллого тооцоо бүртгэлийг үнэн зөв хийх	- Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хийлээ. Шаардлага хангахаа больсон ашиглалтын хугацаа дууссан зарим эд хөрөнгийг Төрийн өмчийн хорооны шийдвэрээр акталлаа.
Бүтээгдэхүүний анги 9 : Номын сангийн орчныг сайжруулах үйлчилгээ		
Бүтээгдэхүүн: 9.1. Орчин нөхцлийг сайжруулах үйлчилгээ Номын сангийн шинэ барилгын ажлыг эхлүүлэх ажлыг түргэсгэх Нормын хувцас зөөлөн эдлэл худалдаж авах	9.1.1. Үндэсний номын сангийн шинэ барилгын , зураг, төсвийг хийлгэх, барилгын суурь тавих ажлыг хөөцөлдөх	- Ерөнхийлөгчийн Тамгийн газар, Засгийн газар, ССАЖЯ зэрэг холбогдох дээд байгууллагуудад Үндэсний номын сангийн шинэ барилгын санхүүжилтийн асуудлыг танилцуулж шийдвэрлүүллээ. - Шинэ барилга барих санхүүжилт нь 2013 оны төсөвт тусгагдсан бөгөөд ССАЖЯ-ны зөвшөөрлөөр Зураг төслийн “Эгэл” ХХК-иар барилгын эскиз төслийг хийлгэж байна. - Шинэ барилгын зураг төслийн ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн 7-р хороонд байрлах шинэ барилга болон Үндэсний номын сангийн арын талбайд барих сан хөмрөгийн өргөтгөл барилгын ажлын зургийн даалгаврыг хийж, ССАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлууллаа. - ГХЯ-ны Дипломат үйлчилгээний аж ахуйн газар, Нийслэлийн газрын албатай хамтран шинэ барилгын газрыг баталгаажуулж, талбайн эргэлтийн цэгийг тогтоох, талбайн дэвсгэр зургийг мэргэжлийн байгууллагаар гаргуулах ажлуудыг хийгээд байна.
	9.1.2. Номын сангийн барилгад урсгал засвар хийх	ССАЖЯ-ны санхүүжилтээр /250 сая төгрөг/ номын санг гал, усны аюулаас найдвартай хамгаалах зорилгоор цахилгааны иж бүрэн засвар, сантехникийн болон барилгын хэсэгчилсэн засварыг хийж байна.
	9.1.3. Номын сангийн арын талбайд машины дулаан гараaж барьж, ашиглалтанд оруулах	Номын сангийн арын талбайд 5 машины дулаан гараaж барьж ашиглалтанд орууллаа.

	9.1.4.Ажилтан, албан хаагчдыг ажлын хувцсаар хангах	НББСХ-ийн 13 ажилтан, ЗААХ-ийн үйлчилгээний ажилчдад ээлжийн ажлын хувцсыг захиалгаар хийлгэн өгсөн.
Бүтээгдэхүүний анги 10 : Нийгмийн асуудлыг сайжруулах үйлчилгээ		
Бүтээгдэхүүн:10.1. Нийгмийн халамж үйлчилгээ Номын санчдын нийгмийн асуудлыг сайжруулахад анхааран ажиллах	10.1.1. Үйлдвэрчний Эвлэлийн Хороотой хамтарсан гэрээ байгуулах, ажилтнуудын нийгмийн асуудлыг сайжруулахад хамтран ажиллах	- Номын сангийн захиргаа нь Үйлдвэрчний эвлэлийн Хороотой хамтран ажилтнуудын нийгмийн асуудал, ажил эрхлэлт, хөдөлмөр хөлс, нэмгдэл хөлс, урамшуулал, ажил амралт, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр гэрээ байгуулан ажиллаж байна. - Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн хурлыг 2 удаа хийсний зэрэгцээ эх үрсийн баяраар гишүүдээ ухамшуулах ажлыг зохион байгууллаа. - Олон Улсын Эмэгтэйчүүдийн баяр, Цэргийн баярыг тохиолдуулж байгууллагын хэмжээнд “ Эрүүл агаар - идэвхитэй хөдөлгөөн ” цасны баярыг зохион байгуулж 63 хүн оролцсон. - Номын санчид, ажилчдад биеийн тамирын чийрэгжүүлэх танхим бүхий амралтын өрөөг засварлан тохижуулах ажлыг хийлээ. - Номын санчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, баг, хамт олныг бүрэлдүүлэх зорилгоор спортын зал 15 удаа авч, ШУТИС-иас зохион байгуулсан сагс эрэгтэй, эмэгтэй баг 1-р байр, волейбол эрэгтэй баг 1-р байр, теннис эрэгтэй баг 1-р байр тус тус эзэллээ. -Хас банк болон BSB компанитай хамтран лизингээр цахилгаан хэрэгсэл худалдан авах боломжийг бүрдүүлж, 2 удаагийн борлуулалтыг байгууллага дээрээ зохион байгууллаа. - Номын сангийн орчин тойрон, эрүүл ахуйн байдлыг сайжруулахад анхаарч, нийтийн цэвэрлэгээний ажлыг 4 удаа хийж, зоорийн давхар, гадна талбайн тохижилтийг хийсэн болно. - Эрүүл ахуйн байгууллагуудаас зөвлөгөө авч, Архив, бэлтгэл зэрэг фондуудын мөөгөнцөрийг устгаж, засварлах зорилгоор “Үндэсний номын сангийн орчин, эрүүл ахуйн орчин нөхцлийг сайжруулах төсөл” боловсруулж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр ССАЖЯ-д хүргүүллээ.

	10.1.2. Номын санчдад шаардлага гарсан тохиолдолд журмын дагуу нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх	- Тус номын сан нь байгууллагын ажилтан, ажилчдын нийгмийн асуудалд анхааран ажиллаж, ар гэрт нь гачигдал гарсан 4 хүнд тэтгэмж, өндөр настны тэтгэмжийг 2 хүнд тус тус үзүүллээ. - Номын санч П.Энхээд биеийн эрүүл мэндийн байдлыг харгалзан үзэж сарын үндсэн цалингаар тэтгэлэг олгосон. - Үнэт ховор номын музейн улсын тооллогод ажиллаж буй 13 хүнд эрүүл ахуйн орчны нөхцлийн нэмэгдэл нийт 1.400.000 төгрөгийг тус тус олголоо. - Улсын хэмжээнд мөрдөгдөх стандарт, журам, төсөл хөтөлбөр нэвтрүүлсэн 16 ажилтанд мөнгөн урамшуулал олголоо. - Байгууллагын шилдэг ажилтныг шалгаруулах , дээд байгууллагын шагналд тодорхойлох зэргээр номын санчдыг урамшуулж, бүтээлч санал санаачлагыг дэмжин ажиллаж байна. Энэ онд: Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-оор 1 ажилтан, "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар 1 хүн, Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр 1 àæèëòàí, 2 ажилтан БСШУЯ-ны "Жуух бичиг"-ээр, Үндэсний номын сангийн "Шилдэг ажилтан"-аар 1 ажилтан, "Захирлын нэрэмжит шагнал"-аар 5 ажилтан тус тус шагнагдлаа. - Шагнагдсан ажилтнууд болон 2012 онд ажлын амжилтаар шалгарсан 6 ажилтныг байгууллагын дотоод журмын дагуу мөнгөн урамшууллаар тус бүр шагналаа. - Номын сангийн ажилтнуудын дунд зохион байгуулсан "Шилдэг баг" шалгаруулах болзолт уралдаанд шалгарсан 3 багийг урамшуулж, нийт 14 хүнийг Хөвсгөл далайд аялах эрхийн бичгээр шагнаж урамшууллаа.
	10.1.3. Байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан хүмүүсийг хүлээн авах, хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж байх	- Сар шинийн баяраар байгууллагын өндөр настан ахмадуудыг хүлээн авах ажлыг зохион байгуулсан. - Номын сангаас өндөр насны тэтгэвэрт гарсан 2 ажилтанд мөнгөн тусламж үзүүлсэний зэрэгцээ нэг өндөр настныг Хөдөлмөрийн түр гэрээгээр ажиллуулж байна.
	10.1.4. Ур чадварын нэмэгдлийг журмын дагуу тогтмол олгох	Зохих хууль дүрэм болон байгууллагаас гаргасан журмын дагуу 10-25 хувийн ур чадварын нэмэгдлийг нийт 26 ажилтанд олгож байна. Тус номын сангийн Захиргааны зөвлөлийн дэргэд ахлах номын санчдаас бүрдсэн ур чадварын нэмэгдэл авахаар нэр дэвшсэн номын санчдын ажлыг шалгах байнгын комисс ажиллаж байна.

	10.1.5. Номын санчдыг эмнэлгийн үзлэгт хамруулах	Нийт ажилчдыг үнэ төлбөргүйгээр Хавдар судлалын эмнэлэгт эхо, дотор, рентген, эмэгтэйчүүд, хавдар зэрэг нийт 8 чиглэлийн мэргэжлийн эмчид үзүүлж, эрүүл мэндийн үзлэгт хамруууллаа.

Дүгнэлт

1. Үндэсний номын сан нь 2012 онд Төсвийн ерөнхийлөн захирагч Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээг төлөвлөгөөт үзүүлэлт бүрээр амжилттай биелүүлж ажиллалаа.
2. 2012 он нь Үндэсний номын сангийн хувьд соёл урлагийг хөгжүүлэх шинэчлэлийн Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлж, номын сангийн өмнө хуримтлагдсан олон асуудлуудыг амжилттай шийдвэрлэсэн их ажлын жил байлаа.
3. Үндэсний номын сангийн шинэ барилгыг барих асуудалд ССАЖЯ онцгой анхаарч, хөрөнгө санхүүжилтийг 2013 оны улсын төсөвт тусгаж, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусган оруулсан нь монгол угсаатны бичиг үсгийн өв соёлоо хадгалах, хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх үйлсэд холбогдол өгөх ажил боллоо. Мөн номын сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үнэт өв соёлоо хадгалж хамгаалах, сэргээн засварлах, дэлхий дахинд сурталчлах, номын сангийн аюулгүй ажиллагааг хангаж, уншигч үйлчлүүлэгчдийн тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх, нийтийн болон их дээд сургуулийн номын санчдыг давтан сургах, номын сангийн үйлчилгээнд шинэ техник, технологи нэвтрүүлэх, гадаадын төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлүүдэд онцгой анхааран ажиллаж, тодорхой үр дүнд хүрч байна.
4.
5. Цаашид ССАЖЯ-нд уламжилж нэн тэргүүнд шийдвэрлүүлэх асуудлууд:
6.
7. 1. Шинэ барилгад шилжин орох бэлтгэл ажлыг энэ оноос эрчимтэй эхлэх ажлыг дэмжиж, “2010-2016 оны Үндэсний номын сангийн стратеги”-ийг хэрэгжүүлэхэд бүх талын туслалцаа үзүүлэх
8. 2. Цахим үйлчилгээг номын сангийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг үе шаттай эхлүүлэх
9. 3. Явуулын номын сангийн байнгын үйл ажиллагааг дэмжиж, орон тоо болон төсөв хөрөнгийг шийдвэрлэж өгөх
10. 4. Үндэсний номын сангийн орон тоог нэмэгдүүлэх, боловсон хүчнийг чадавхижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх /ялангуяа гар бичмэл ном сэргээн засварлагч болон эрдэм шинжилгээний ажилтан /номын сан судлал, эх бичиг судлаач чиглэлээр/, үйлчилгээний номын санчийн орон тоо нэн шаардлагатай байна./
11. 5. Үндэсний номын сангийн барилга болон үнэт ховор, гар бичмэл ном судрыг улсын даатгалд хамруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж өгөх
12. 6. Үндэсний номын сангийн шинэ ном, хэвлэл худалдан авах төсөв, гадаад арга хэмжээний зардал болон шуудан холбооны зардлыг нэмэгдүүлэх
13. Ном судрыг сэргээн засварлах үндэсний хэмжээний лабораторийбайгуулах ажлыг энэ онд эхлүүлэх.

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ НОМЫН САНГИЙН 2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ТАЙЛАН

2012 оны 12 дугаар сарын 07 **Улаанбаатар хот**

Нэг. БОДЛОГЫН ЗОРИЛТ

1.1. Байгууллагын тухайн жилд дэвшүүлсэн үндсэн зорилт

Монгол улсын Засгийн газар, Нийслэлийн төр захиргааны байгууллагын “Иргэдийн оролцоо-Өрхийн хөгжлийг дэмжих жил” зорилтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж номын сангаас 2012 оныг “Иргэдийн уншлагыг дэмжих жил” болгон жил, улирлын төлөвлөгөөндөө тусган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж ирлээ.

Зорилтот жилийн хүрээнд уншигч хэрэглэгчдийн дунд фондын ном хэвлэлийг сурталчлах, номын сангийн үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулах зорилгоор гэр, албан газар зөөврийн үйлчилгээг зохион байгуулж, нийслэлийн иргэдийг соён гэгээрүүлэх, тэдэнд түргэн шуурхай, соёлтой үйлчилгээ хүргэх зорилго тавин ажилласнаар номын сангаар үйлчлүүлэгчдийн тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс өссөн дүнтэй байна. Зорилтот жилийн хүрээнд хийсэн томоохон ажлуудаас заримыг дурьдвал:

1. Хан-Уул дүүргийн салбар номын санд УИХ-ын гишүүн Л.Болдын санаачлага дэмжлэгтэйгээр 135 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж засч тохижуулан **“Хүүхэд залуучуудын хөгжлийн төв”-**ийг байгууллаа.

2. Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн уншигч хэрэглэгчид, болон монголын нийт иргэд олон нийтэд зориулан сургалт, мэдээлэл сурталчилгаа соёл-танин мэдэхүйн ажил болон бүх нийтийг хамарсан арга хэмжээ, хөтөлбөрүүдийг зохион байгуулах орчин үеийн мэдээллийн технологид суурилсан, ая тухтай орчинг бүрдүүлсэн зориулалтын “**АСМТ-ийн Хөтөлбөрийн өрөө-Иргэдийн мэдээлэл сурталчилгааны танхим”-**ыг нээсэн байна. Энэхүү танхимыг байгуулахад АНУ-ын элчин сайдын яамнаас 115 мянган ам. долларын санхүүжилт хийсэн байна.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар **“Номын баярын өдөр тэмдэглэх”** болсонтой холбогдуулан анх удаа төрийн болон ТББ, олон нийтийн байгууллагаас хамтран “Олуулаа уншъя” уриан дор зохион байгуулсан өргөн хүрээтэй арга хэмжээнд номын сангаас тусгай хөтөлбөр гарган оролцсон. Үүнд:

- Төв болон салбар номын сангуудын үйл ажиллагаа, шинэлэг үйлчилгээнүүдийг иргэд олон түмэнд нээлттэй танилцуулж, тэднийг номын

сангийн уншигчаар бүртгэж номын сан номзүйн үйлчилгээнд хамруулж хэрэгцээт мэдээллээ олж авахад дэмжлэг үзүүллээ.

- Хүүхэд, залуучууд, иргэдийн дунд өөрийн номын сангийн сан хөмрөгт байгаа хэвлэмэл болон брайль, ярьдаг, дижитал буюу тоон технологид суурилсан монгол болон гадаад ном хэвлэлийн үзэсгэлэн гаргаж, ном солилцох, хандивлах, арга хэмжээг зохион байгуулсан.
- Шилдэг ном шалгаруулах, номын зохиогчийг алдаршуулах, “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж” тэмдэгтэн шалгаруулах, зохиолч уншигчдын уулзалт ярилцлага хийсэн.

4. Төв болон салбар номын сангийн хэмжээнд нийслэл хот үүсч байгуулагдсаны 373 жилийн ойг угтан нийслэлийн хүн амыг номын сангийн үйлчилгээнд хамруулах, номтой нөхөрлүүлэх зорилго бүхий “Улаанбаатарчууд уншиж байна” сэдэвт сарын аяныг уламжлал ёсоор зохион явуулж, иргэдийн ном унших идэвх сонирхлыг өрнүүллээ. Аяны хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас төв болон салбар номын сангуудад “Нүүдлийн номын сан ажиллуулах”-аар олгосон автомашинаар нийслэлийн төвөөс алслагдсан хороодын хэрэглэгчдэд үйлчилгээгээ ойртуулах үүднээс нүүдлийн номын сангийн үйлчилгээг Баянзүрх дүүргийн 20, 28 дугаар хороод болон 8 дугаар хорооны нутагт байрлах “Хүүхэд асрах төв”, Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 3 дугаар хороо, Зэвсэгт хүчний 150, 0151 дугаар анги, Сүхбаатар дүүргийн 15, 20, Чингэлтэй дүүргийн 16, Сонгинохайрхан дүүргийн 7 дугаар хороо, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хороо буюу Нисэх, Яармаг, Өлзийт хороололд хүргэж ажилласан байна. Нүүдлийн номын сангийн үйлчилгээ нь нийслэлийн хүн амд үзүүлэх номын сангийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

1.2. Нийслэлийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтод тухайн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүн

/2.7.1. Монгол улсын Соёлын тухай хууль, төрийн соёлын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ./ Тус төвлөрсөн номын сан нь Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн тодорхой заалтуудын хүрээнд уншлага үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, уншлага үйлчилгээний төлөвлөгөөт үзүүлэлтүүдийг 101,5% - 120,4%-д хүргэн, жилийн төлөвлөгөөг 100%-иар ханган биелүүлсэн байна.

/2.7.11. Алслагдсан дүүрэг, захын хороодын иргэдэд орчин үеийн программ хангамж бүхий номын сангийн үйлчилгээг ойртуулж, номын сангуудыг байгуулна./ Чингэлтэй дүүргийн Хайлааст дахь "Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих инкубатор" төвийн дэргэд 2000 гаруй номын фондтой зөөврийн номын санг ажиллуулж инкубатор төвийн бойжигчдод мэдээллийн үйлчилгээг хүргэж үйлчилсэн.

Мөн 2.7.11. заалтын хүрээнд Багахангай, Багануур, Налайх дүүргийн Соёлын ордны уншлагын танхимд интернетэд суурилсан номын сангийн КОХА программ нэвтрүүлэх ажлын хүрээнд Багануур дүүргийн номын санчдад ажлын байранд нь очиж сургалт явуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. 2012 оны 10 дугаар сараас дээрх номын сангууд өөрийн фондод байгаа номоо Коха програмын электрон каталогт оруулж эхлээд байна.

Хоёр. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Уншлага үйлчилгээний талаар

2012 оны уншлага үйлчилгээний бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

№	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	**Биелэлт**	Хувь
1	Уншигч, хэрэглэгч	60000	**75581**	126%
2	Ирэгсэд	210000	**210859**	100.4%
3	Ном олголт	585000	**503617**	86%

Эндээс харахад төлөвлөснөөс уншигч хэрэглэгч 15581-ээр, ирэгсэд 859-ээр тус тус давж биелсэн бол ном олголт 81383-аар буурсан байна.

Ном олголт өнгөрсөн жилийн мөн үеийнхээс багассан нь Хан-Уул дүүрэг дэх салбар номын сангийн үндсэн фондод ажил хүлээлцэх, Төв номын сангийн чөлөөт сонголттой фондод хяналтын тооллого хийж уншлага үйлчилгээ тодорхой хугацаагаар хийгдэхгүй байсан бодит нөхцөл байдалтай холбоотой.

Энэ оны уншлага үйлчилгээг өнгөрсөн 2011 оныхтой харьцуулбал дараах байдалтай байна.



Ном олгосон байдлыг авч үзвэл:



“Уншлагыг дэмжих жил” зорилтын хүрээнд танхимын уншлага үйлчилгээнээс гадна дараах уншлага үйлчилгээнүүдийг явуулсан. Үүнд:

- Баянзүрх дүүргийн 22, Сүхбаатар дүүргийн 19, 33, 39, 68, Сонгинохайрхан дүүргийн 92, 99, 110 дугаар цэцэрлэг, БЗД-ийн 48 дугаар сургууль, Дотоодын цэргийн 805 дугаар анги, Зэвсэгт хүчний 124, 150 дугаар анги, Хараагүйчүүдийн хөдөлмөр сургалтын төв зэрэг байгууллагуудад зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлсэн. Мөн 22, 54, 92, 99, 160, цэцэрлэгүүдэд чанга уншлага зохион байгуулан явуулсан.

- УБИС-ийн номын сан, Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн номын сан, Ярьдаг номын сан, СХД-ийн 110 дугаар цэцэрлэг, ХУД-ийн 75, 118, БЗД-ийн 48 дугаар сургуулиуд, Монгол улсын их сургууль, Орхон, Сэрүүлэг, Их засаг, Идэр зэрэг их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж, номын сан хоорондын солилцоогоор хэрэглэгчдэд үйлчилсэн байна.

- Өдөр тутмын 7 нэрийн сонин 813 удаа, цахим сонин 140 удаа уншигдсан бол интернэт үйлчилгээг 12204 уншигч хэрэглэгчдэд үзүүлсэн.

- Хүүхдийн шатар уншлагын танхимаас хүүхэд багачуудад амралт чөлөөт цагаа зөв соёлтой өнгөрүүлэх, ном уншихын зэрэгцээ шатар тоглож сурах, улмаар уралдаан тэмцээнд орж өөрийгөө хөгжүүлэх, зөв төлөвшин хүмүүжих орчин нөхцөлийг бүрдүүлсэн үйлчилгээг зохион байгуулж байгаа нь үр дүнгээ өгч байна. Тайлант хугацаанд шатар уншлагын танхимд 270 хүүхэд уншигчаар бүртгүүлж шатар тоглож сурснаар тэргүүний сайн шатарчин сурагчид олноор төрсний дотор Т.Тэнгис, П.Уганжаргал, Б.Сүрэн зэрэг хүүхдүүд дүүргийн аварга болж 1, 2 дугаар байранд шалгарсан байна. Мөн Ц.Лхагвасүрэн нь 2012 онд Дэлхийн шатрын аварга боллоо.

2.2. Фондын бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтын ажлын талаар

"Иргэдийн уншлагыг дэмжих жил" зорилтын хүрээнд Фонд бүрдүүлэлтийн ажлыг чанартай сайн зохион байгуулах үүднээс уншигч хэрэглэгчдээс авсан судалгаа, татгалзлыг үндэслэж, төсвийг оновчтой зарцуулан ажиллаж байна.

Сар бүр худалдаж авах номын төсөвтөө тохируулан фондын бүрдүүлэлт хийж, номын мөнгө шилжүүлсний дараа тухайн сарын ном бусад материалд техник ажиллагаа хийж тасаг, салбаруудаа хүлээлгэн өгч байна. Ингэснээр номыг тухай бүрд нь уншлагад шилжүүлж, ном хураагдахгүй байх үр дүнтэй ажил болж байна. Мөн өнгөрсөн онд актлагдсан 6525 тн номыг хоёрдогч түүхий эдэд тушааж, олсон 522,000 төгрөгөөр холбогдох журмыг үндэслэн эрэлт хэрэгцээтэй нөхөн бүрдүүлэлтийн 33 ширхэг ном худалдан авч номын баяжилт хийлээ.

2012 онд доорх ном хэвлэлийг бүрдүүлэн авсан байна.

д/д	Бүрдүүлэлт	Нэр төрөл	Ширхэг	Үнэ
1	Шинэ ном	270	1868	23,972,800
2	Хандив	102	724	5,209,500
3	Бэлэг	153	427	1,957,350
4	Нөхөн бүрдүүлэлт	33	33	565,235
5	Алдагдсан номын төлбөр	16	16	62701
Нийт дүн		574	3068	31,767,586

Тайлант хугацаанд 1473ш номонд техник ажиллагаа хийж, 1586ш номонд мэдрэгч ялтас нааж, 213 нэрийн 1457ш номын мэдээллийг электрон каталогт оруулан, 1586ш баркод хэвлэсэн байна. Дээрх бүрдүүлэлтээр болон бэлэг хандиваар авсан бүх номыг Олон нийтэд үйлчлэх тасаг, салбар номын сангуудад хүлээлгэн өгч уншлагад шилжүүллээ.

Ном бүрдүүлэлтийг графикаар үзүүлбэл:



DAISY студиэс харааны бэрхшээлтэй хэрэглэгчийн судалгаанд үндэслэн нийт 162 цаг 25 минутийн бичлэг бүхий 13 шинэ ном, 4 гарын авлага дижитал ярьдаг номыг бүтээсэн. Үүнд: Жюль Верн "Нууцат арал", Ц.Оюунгэрэл "Америкт суралцсан тэмдэглэл", Антони Фердинанд Оссендовский "Хүн, араатан бурхад", Цао Сюи Чинь "Улаан асрын зүүд", М.Шолохов "Дөлгөөн Дон" 2 боть, "Чойжид дагины тууж", Б.Нямаа "Арандалынхан", Х.Цэрэндорж "Дээд эрүүл мэнд", Gillom de Rubruk "Дорно этгээдэд зорчсон тэмдэглэл", "Хэрэв хараагүй хүнтэй учирвал" гэх мэт. Мөн 3 аудио номыг дижитал хэлбэрт шилжүүлж, харааны бэрхшээлтэй хүмүүсийн компьютер сурах хэрэгцээнд зориулж, Twitter буюу Жиргээний програмыг текст хэлбэрээр гарын авлага болгон гаргасан бөгөөд үүнийг дараагийн улиралд аудио хэлбэрт шилжүүлэх юм. Хоёр уншигчийн нөүтвүүк компьютерийг янзалж, хараагүй хүмүүсийн хэрэглэдэг тусгай ярьдаг програм суулгаж, интернэтэд холбон ашиглах боломжтой болгож өгсөн.

Харааны бэрхшээлтэй иргэдэд DAISY номыг гэрээр олгох үйлчилгээг яаж зохион байгуулах, ямар технологи ашиглах, хэрхэн хүртээмжтэй байлгах талаар нэлээд хугацаанд судаллаа. Мөн ярьдаг ном тоглуулагчийн судалгаа дуусгаж, тоглуулагчийн үйлдвэрлэгчтэй харилцаа тогтоолоо. Олон улсад хараагүй хүмүүст номын сангийн үйлчилгээг хүргэхдээ номын сангууд мемори карт, флаш дискний технологид суурилсан тусгай оролттой картрайдж дээр дижитал номоо гэрээр олгож байна. Ингэхдээ мөн ном сонсох тоглуулагчийг уншигчдад олгож, гэрээр ном олгох үйлчилгээг зохион байгуулдаг юм байна. Энэ нь хамгийн зөв шийдэл бөгөөд энэ хэлбэрээр харааны бэрхшээлтэй иргэдэд гэрээр ном олгох үйлчилгээг зохион байгуулах хэрэгтэй гэж үзлээ. Энэхүү шинэ үйлчилгээг зохион байгуулах бэлтгэл

ажил болгож DAISY уншлагын танхимын номын санчтай хамтран уншигчийн бүртгэлд өөрчлөлт хийж, Хараагүйчүүдийн үндэсний холбооны арга хэмжээний үеэр тус төвийн болоод гэрээр ном олгох үйлчилгээний талаар 450 ширхэг танилцуулга тараасан нь үр дүнтэй ажил болсон. Мөн EIFL-олон улсын байгууллагад төсөл дууссаны дараах 1 жилд хийсэн ажлын тайлан гаргаж өгсөн ба хэрэглэгчдийн дунд судалгаа явууллаа.

Төв болон салбар номын сангуудын урагдаж гэмтсэн нийт 1155 ширхэг ном хэвлэлийг хэвлэлтийн анхны жинхэнэ хэлбэр байдлыг алдагдуулахгүйгээр сэлбэн зассан байна. Чөлөөт сонголттой уншлагын танхимаас сэлбэн засагдсан 1139ш номонд дахин мэдрэгч ялтас наасан. Мөн Америкийн соёл мэдээллийн төвийн 13ш ном, салбар 2 дугаар номын сангийн 14ш номыг тус тус хэвлэн олшруулсан.

Энэ хугацаанд төв болон салбар номын сангийн 2011 оны сүүлчийн улирал, 2012 оны тогтмол хэвлэл болон Төрийн мэдээлэл сэтгүүлийг нийт 230 нэгж, 14 баримтыг нэгжлэн үдэж хавтасласан байна. Мөн гадны байгууллагын хүсэлтээр 5 нэрийн сонинг нэгжлэн хавтаслаж 20000 төгрөгийн орлого оруулсан ба 4300 ш уншигчийн карт, 15400 ш захилгын хуудас, 30000 ш формулярыг хэвлэн уншлага үйлчилгээнд шилжүүлсэн байна.

Сэлбэн засагч, камерын хяналтын номын санчид хамтран уншигчдын буруу хэрэглээнээс болж гэмтэж, сэлбэн засалтанд очсон номуудаар үзэсгэлэн гаргаж, уншигчдын дунд номтой зөв харьцаж хэрэглэх талаар яриа таниулга хийсэн. Төв номын сангийн чөлөөт сонголттой фондын номын тооцоог нэг бүрчилсэн бүртгэлээр гаргаж санхүүд хянуулах, хүүхдийн танхимын номыг тусад нь нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэх зэргээр фондын хадгалалт хамгаалалт, бүртгэлийг сайжруулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Тайлант хугацаанд төв номын сангийн чөлөөт сонголттой фондонд хяналтын, 2 дугаар салбар номын сангийн фондонд ажил хүлээлцэх тооллогыг тусгай аргачлалын дагуу хийж тооллогын дүнг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцсэн.

Төв номын сангийн үндсэн фондны таазнаас байнга ус алдаж улмаар фондын тааз, хана их хэмжээгээр мөөгөнцөртөх мөн цахилгааны монтажид ихээхэн гэмтлүүд гарч, фондын хадгалалт хамгаалалтын горим алдагдаж байсан учраас фондын номыг өөр фондод шилжүүлж байрлуулав.

2.3. Лавлагаа мэдээлэл, соёл танин мэдэхүйн ажлын талаар

Тайлангийн хугацаанд иргэд олон нийтэд чиглэгдсэн дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- Энэ хугацаанд тохиосон түүхэн ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэн 244 удаа, “Өрхийн хөгжлийг дэмжих жил”, “Өрхийн төсөв”, “Нийслэл хүрээ-100” сэдвүүдээр байнгын үзэсгэлэн, самбарыг 10, “Нийслэл хүрээ”, “Өрхийн төсөв”, “Хүүхдийн төлөвшил, хүмүүжил”, “Цэцэг тарьж арчлах”гэх зэрэг сэдэвчилсэн болон санамж өгөх ном зүйн бүртгэл гарын авлага 65, өнгөт болон фото мэдээллийг 15 удаа тус тус гаргаж уншигчдад сурталчилсан.

Мөн уншлагыг дэмжих жилийн хүрээнд “Номыг зөв уншихуй” хүүхдэд зориулсан унших арга барил, эрүүл ахуйн мэргэжлийн зөвлөмж самбар, товхимол, “Үйлчилгээний журам – хориглох зүйл”, “Номын бүтэц түүний хэрэглээ”, “Номын санч ба номын сан” сургалт яриа болон номын сантай танилцуулах тойрон аялал зэргийг уншигчдын дунд хийсэн нь номын сангаар үйлчлүүлэгчдийн номтой зөв харьцах, унших арга барил, соёлыг дээшлүүлсэн ажил болж чадсан.

Тайлангийн хугацаанд тохиосон түүхт ой, тэмдэглэлт үйл явдал, төр засгийн бодлого шийдвэр болон нийгмийн амьдралын тулгамдсан сэдвүүдээр уулзалт ярилцлага, сургалт семинар зэрэг соёл танин мэдэхүй олон нийтийн ажлыг зохион байгуулахад нийт **7531** гаруй уншигч хэрэглэгчид хамрагдсан байна. Үүний заримаас дурдвал:

“Нийслэл хүрээ-100” сэдэвт нэгдсэн уулзалтыг Монгол улсын Гавьяат барилгачин Я.Шархүү, Төрийн шагналт зохиолч Д.Төрбат, Монгол улсын СГЗ Ү.Хүрэлбаатар, Улаанбаатар музейн эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр нартай хийхэд 80 гаруй уншигч

“Хадгаламж таны амьдралд” уулзалтыг Хас банкны борлуулалтын менежер Байгалмаатай хийхэд 49 уншигч

“Нийгэм ба стресс” сэдэвт уулзалтыг “Өсвөр үеийнхний хөгжлийн төв” ТББ-ын сэтгэл зүйч А.Нямсүрэнтэй хийж 46 хүн

Яруу найрагч Ц.Хулантай хийсэн “Яруу найргийн тухай хамтдаа ярилцах уу” сэдэвт уран бүтээлийн уулзалтад 55 уншигч

“Үндэсний бичиг соёлын өдөр”-т зориулан Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой хамтран Төрийн шагналт, Ардын уран зохиолч Ш.Сүрэнжавтай уран бүтээлийн уулзалт зохион байгуулж, танин мэдэхүйн АХА тэмцээн зохион явуулахад 65 уншигч оролцлоо.

“Өрхийн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд нийт ажилтан албан хаагчдын дунд “Органик бүтээгдэхүүний тухай” сэдвээр “Органик Монгол” хөтөлбөрийн ерөнхий зохицуулагч Д.Ононтой уулзалт хийхэд 50 орчим хүн

Гэр бүл - хүүхэд” сэдэвт уулзалтыг Боловсрол судлалын доктор Б.Батчимэгтэй хийсэн бөгөөд 56 уншигч үйлчлүүлэгчид оролцсон.

“Өрхийн хэрэгцээнд хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарьж ургуулах нь” сэдвээр ХАА-н ухааны доктор, профессор МУ-ын Гавьяат агрономич Ш.Оросоотой уулзалт зохион байгуулахад 48 хүн хамрагдсан.

Монголын Анагаах ухааны академийн гишүүн, академич анагаах ухааны доктор, дэд профессор Ш.Болдыг урьж “Уламжлалт арга ухаанаар хэрхэн зохистой хооллож, эрүүл амьдрах вэ?” сэдэвт уулзалтыг уншигчдын дунд зохион байгуулахад 38 уншигч

Д.Нацагдоржийн нэрэмжит зохиолч Д.Цэнджав, МУСТА, жүжигчин О.Бат-Өлзийтэй нартай уран бүтээлийн уулзалт хийхэд 85 уншигч

“Динза ба түүний нөхөд” сэдэвт уулзалтыг Монголын үндэсний хүүхдийн комик цувралын зохиолч А.Дэлгэржаргалтай хийсэн ба уг уулзалтанд 48- дугаар сургуулийн 5г ангийн 34 хүүхэд, Хүүхэд асрах төвийн 9 хүүхэд оролцсон байна.

Хан-Уул дүүргийн ЕБС-ийн 30 гаруй номын санчид “Сургуулийн номын сангийн үйлчилгээний орчин үеийн чиг хандлага” сэдэвт хичээлийг БЗД дэх салбар номын сангийн эрхлэгч Г.Наранцэцэг заасан.

“Өсвөр үе, залуучуудыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт уулзалт ярилцлагыг СХД-ийн Цагдаагийн хэлтсийн ахлах байцаагч, хошууч Б.Эрдэнэчулуунтай хийхэд 60 гаруй уншигч хамрагдсан.

”Mîíãîëûí íóóö òîâ÷îî”-г хэн сайн мэдэх вэ? уран èëòãýëийн уралдаан болон “Монгол үндэстний түүх, соёл, зан заншил” сэдвийн хүрээнд ÀÕÀ òýìöýýíèéã ÅÁÑ-èéí 52 дугааð ñóðãóóëèéí 10-11 дүгээð àíãèéíхны дунд зохион байгуулахад 238 ñóðàã÷ оролцсон.

Мөн Төв номын сангийн Америкийн соёл мэдээллийн төвд уншигч хэрэглэгчдийн англи хэлний мэдлэг, сонсголын чадвараа дээшлүүлэх боломжийг олгодог тогтмол сургалт хөтөлбөрүүд болох Санхүүгийн англи хэлний сургалт, “U dream club” -ын уулзалт ярилцлага, “Америкийн тухай ярилцъя” цуврал лекц, “Кино үдэш” хөтөлбөр, “Тоглоомын өдөр”, 4H хүүхдийн хөтөлбөр, “UB English Book club” англи хэл дээр уншсан номын тухай ярилцах уулзалт ярилцлага, “Хөгжлийн төлөө хамтдаа” сургалт уулзалт зэрэг 270 удаагийн арга хэмжээнд 6600 хүн хамрагдсан байна.

2.4. Автоматжуулалт, програм хангамжийн ажлын талаар

Вэб: Нийслэлийн мэдээллийн технологийн газрын серверт байрласан Хотын төв номын сангийн вэб http://www.pl.ub.gov.mn -ийн агуулгыг шинэлэг байлгахад анхаарч ажилласан. Google Analytics програмын тусламжтайгаар вэбийн хэрэглээний үзүүлэлтийг тайлант хугацаагаар гаргахад 22703 хандагч /visitors/, 76417 хуудасны мэдээллийг үзжээ. Зураг(2.1-1)



Онлайн каталог, хэрэгчдийн хэрэглээний үзүүлэлт: http://koha.pl.ub.gov.mn -ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2011 оны оны 12 дугаар сарын 01-аас 2012 оны 12 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд 124002 хандагч /visitors/ (Зураг(2.2-1), 568290 хуудас мэдээллийг үзсэн. Хэрэглээний тоон үзүүлэлт бага байгаа шалтгаан нь номын сангийн зуны тооллого болон ээлжийн амралттай холбоотой. Нийт электрон каталогийн хэрэглэгчдийн 68,68 % нь шинээр орж байгаа хэрэглэгчид үлдсэн 31,32 % нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна. (Зураг(2.2-2)). Үүнийг улс орнуудаар ангилж үзвэл, хэрэглэгчдийн Монгол улсаас 94,56 % бусад нь дэлхийн 79 улсаас холбогдсон байна. (Зураг(2.2-3)).

Зураг(2.2-1)



Зураг(2.2-2)



Зураг(2.2-3)

Country / Territory	Visits	% Visits
1. Mongolia	165,923	94.56%
2. (not set)	2,964	1.69%
3. South Korea	1,264	0.72%
4. United States	935	0.53%
5. Russia	808	0.46%
6. China	800	0.46%
7. Japan	587	0.33%
8. Germany	245	0.14%
9. France	164	0.09%
10. Australia	162	0.09%

view full report

Интернэтийн үйлчилгээ, хэрэглээ: Тайлангийн хугацаанд интернэтийн үйлчилгээ авч байгаа Ситинэт ХХК-аас ХТНС-ийн сүлжээний хэрэглээг хянах хүсэлт гаргасны дагуу үндсэн сүлжээ болон утасгүй Интернэтийн сүлжээний хэрэглээг үзэх боломжтой болсон. Үндсэн сүлжээ болон Утасгүй интернэтийн 2 сүлжээний хооронд мэдээлэл дамжуулах эрхгүй байсныг Ситинэт ХХК -д хүсэлт гарган 2 сүлжээний хооронд мэдээлэл дамжуулах тохиргоог хийж дуусгасан. Ингэснээр утасгүй интернэт ашиглаж байгаа уншигчид номын сангийн каталогт шууд хандах эрх нээгдсэн.

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд интернэтийн татаж /download/ байгаа хурд хамгийн ихдээ 86,93Mbpsps, дунджаар 1,39 Mbps, түгээж /upload/ байгаа хурд хамгийн ихдээ 52,59Mbps, дунджаар 544,53 Kbpsps хүрсэн байна. (Зураг(2.3-1)).



Утасгүй интернэтийн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж /download/ байгаа хурд хамгийн ихдээ 48,08Mbps, дунджаар 864,79 Kbps, түгээж /upload/ байгаа хурд хамгийн ихдээ 11,70 Mbps, дунджаар 108,17 Kbps хүрсэн байна. (Зураг(2.3-2)).

Зураг(2.3-2)



Програм хангамж, Системийн болон компьютерүүдийн програм хангамж:

Цахим уншлагын танхимын компьютерүүдийн тоог 10 хүртэл нэмэгдүүлж, уншигчийн мэдээллийг Koha системийн бүртгэлтэй нэгтгэж Koha-ийн бүртгэлээр Libki програм хангамжийн тусламжтайгаар өдөрт 1 хүртэл цагаар ашиглах боломжтойгоор тохируулан үйлчилгээнд оруулсан. Хараагүй хүмүүсийн уншлагын зааланд 2, хүүхдийн уншлагын зааланд 3 компьютерүүдийг уншигч нарт зориулан тус тус байрлуулсан. Номын сангийн хэвийн найдвартай үйл ажиллагаг хангахын тулд гэрээр ном олголт, буцаалт болон залаар ном олгох үйлчилгээнүүдийг тус тус гэнэтийн саатлын үед тогтмол ажиллагаатай байлгах үүднээс нөөц төлөвлөгөөг боловсруулж холбогдох тохиргоог хийж дуусгасан.

Салбар номын сангуудын дотоод сүлжээг хийх болон Интернэтэд холбох судалгааг хийж холбогдох зардлын тооцоог гаргаж санхүүд танилцуулаад байна.

Koha програмын Ном олголт, буцаалтын модулийг туршиж эхлэх бэлтгэл ажлуудыг хийж дуусгаад байна. Төв номын санд каталогийн хайлтанд шинээр 4 компьютер байрлуулж одоогоор 8 компьютер хайлтанд ашиглах боломжтой болоод байна. Номын сангийн Каталогийн Koha програм хангамжийг 3.2.7 хувилбараас 3.8.2 болон 3.8.5 хувилбар хүртэл тус тус шинэчлэлт хийсэн. Шинэчилсэн хувилбар нь номын хавтасны зургийг оруулах шинэ боломж нээгдсэн.

Утасгүй Интернэт төхөөрөмжийг DAISY төвийн мэргэжилтний өрөөнд тохиргоо хийж хараагүй хүмүүсийн уншлагын өрөөнд Интернэт үйлчилгээ бий болгосон.

Онлайн мэдээлэл түгээлт: Номын сангийн Facebook хуудсанд цаг үеийн мэдээ мэдээллийг оруулж, иргэд, уншигчтай харилцаж байсан байдлыг дараах тоон үзүүлэлт харуулна. Нийт 1174 like дарсан давтагдахгүй хэрэглэгчтэй болж, эдгээр хэрэглэгчдийн цаад талд 308485 найзууд нь манай мэдээллийг дамжуулан харах боломжтой болжээ. [Зураг(2.5-1)].

Номын сангийн Facebook хуудсыг сүүлийн 2 сард дүгнэлт хийхэд эмэгтэй 58.6 хувь, эрэгтэйчүүд 40,9 хувийг эзэлж байгаа бөгөөд үүнээс 18-24 насныхан 68,1 хувийг эзэлж байна. [Зураг(2.5-2)]

Зураг(2.5-2)



Twitter: Жиргээ нийгмийн сүлжээгээр нийт 297 жиргээ илгээгдэж, 356 дагагчтай болсон.

Гурав. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1. Нягтлан бодох бүртгэл, санхүү, аж ахуйн талаар

Хотын төв номын санд түрээсээр байрладаг байгууллагуудтай түрээсийн болон бусад харилцагч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээгээ шинэчлэн хийж тухай бүрт нь тооцоо нийлж ажиллалаа. Мэдээ тайланг цаг тухайд нь үнэн зөв гаргаж Нийслэлийн төрийн сан, Нийслэлийн аудитын газар, Нийслэлийн соёл урлагийн газар, Нийслэлийн өмчийн харилцааны газруудад тус тус хүргүүлсэн. 2011 оны санхүүгийн тайланд "Б энд С аудит" ХХК-аас хийсэн аудитын дүгнэлт болон Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 2012 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 03/60 тоот хяналт шалгалтын удирдамжийн дагуу 2010 оны сүүлийн хагас жил, 2011 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус тус зөрчилгүй дүгнэлттэй гарлаа.

2013-2015 оны төсвийн төлөвлөгөөний төслөө хийж, БСШУЯ болон Нийслэлийн Соёл урлагийн газарт хүргүүлсэн. Мөн Өмчийн харилцааны газарт 2011 оны балансаа өгч нэгтгүүлсний дээр тус газрын өмч эзэмшүүлэх, гэрээ дүгнэх шалгалтаар "Хангалттай" үнэлгээ авсан. Улсын хэмжээнд зохион байгуулагдсан ¿íăñýí õ°ð°íã°, эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыã àæëûí 10 õîíîãò áàãòààí õèéж, Өмчийн харилцааны газартай тооцоо нийлж баталгаажуулсан.

Нийслэлийн Захирагчийн албанаас зарласан тус номын сангийн үндсэн фонд, уншлагын танхимууд, ажлын байр болон салбар номын сангуудын барилгын их засварын зураг төслийг хийх тендерт шалгарсан "Алтайн газрын хүч" ХХК-д номын сангуудын талаарх шаардлагатай бүхий л мэдээлэл, стандартуудыг танилцуулж 516,801,158 төгрөгийн засварын ажлын зураг төсвийг хийлгэлээ.

Төвлөрсөн номын сангийн хэмжээнд ажиллах Дотоод хяналт шалгалтын, Өмч хамгаалах, Үйлдэрлэлийн ослын, Ном бүрдүүлэх, Хөдөлмөрийн маргаан таслах комисс, Хөдөлмөр аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зөвлөлийг шинэчлэн байгуулав.

Сар бүрийн сүүлийн долоо хоногийн Мягмар гарагт их цэвэрлэгээг тогтмол чанартай хийж, "Хоггүй Улаанбаатар" аяныг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж байгаатай холбогдуулан төв болон салбар номын сангийн хэмжээнд бүх ажилчдыг хамарсан нийтийн их цэвэрлэгээг 4 удаа, байгууллагын гадна талын нийтийн эзэмшлийн талбай мөн ногоон байгууламжийн хогийг 7 хоног бүр цэвэрлэсэн. Мөн төв номын сангийн подвалд хуримтлагдсан байсан 4 тн гаруй хогийг цэвэрлэж ачууллаа.

Сандал ширээ эвдэрсэн гэсэн нийт 7 дуудлагаар 12 ширээнд булан тавьж бэхэлгээ хийж зассан. Мөн төв номын сангийн нийтийн 00, бусад ажилчдын 00-ийн бөглөрөл, ус алдалт зэрэг жижиг засвар үйлчилгээг тухай бүрт нь цаг алдалгүй засаж, хэвийн үйл ажиллагаанд нь оруулж байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд халуун хүйтэн усны ирэх буцах шугамууд дээр хэд хэдэн засвар үйлчилгээг хийлээ. Номын сангийн дулааны шугам дээр насос тавьж, ирэх буцах хаалт болон ЦТП-дээр байрлах хаалт, халуун хүйтэн усны шугам дээр байрлах нийт 15 хаалт сольсон. Мөн уншлагын А,Б заалууд болон бусад өрөөний нийт 25 пааруудыг шинээр сольсон байна.

Төв номын сангийн гадна талын пасадны засвар болон төв номын сангийн ном бүрдүүлэх болон компьютерийн инженерийн өрөөг засварласан.

Төв номын сангийн гаднах цэцгийн мандлыг арчилж тордон ургуулж, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн модыг засан, зүлэгжүүлэх ажлыг хийснээс гадна 100 гаруй метр ногоон байгууламжийн хашааг засаж янзлан будсан. “Болор ариусал” ХХК-тай гэрээ байгуулан, төв болон салбар номын сангийн өрөө тасалгаа, фондод хортон шавьж, ариутгал, халдваргүйтлийн хор цацуулан ариутгал хийлгэсэн.

3.2. Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар хийсэн ажил

Төрийн албан хаагчдын 2011 оны үр дүнгийн гэрээ, ажлыг дүгнэж нийт ажиллагсдын 36,5% буюу 30 хүнд ур чадварын нэмэгдэл, мөн 10 ажилтанд цалингийн шатлалыг ахиулан олгоход 18,386,210 төгрөг зарцуулсан.

Байгууллагын дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооноос номын сангийн захиргаатай байгуулсан Хамтын гэрээний дагуу 6 ажилтанд түлээ нүүрсний мөнгө 1,800,000 төгрөг, 50 нас хүрсэн 3 ажилтанд 150,000 төгрөг, шинэ байранд орсон 2 ажилтанд нийт 400,000 төгрөг, 2 ажилтны хүүхэд хурим хийхэд 200,000 төгрөг, ар гэрт нь гачигдал тохиолдсон 3 ажилтанд 708,600 төгрөг олгосон.

Сар шинийн баяраар 70 нас хүрсэн 5 ахмадад 250,000 төгрөг, Ахмадын баяраар 40 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлж, тус бүрт 50,000 төгрөг, нийт 2 сая төгрөг, тэтгэвэрт гарсан 2 ахмадад 244,600 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн.

Соёлын хуулийн дагуу мэргэжлээрээ ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан 2 хүнд нэг жилийн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж болох 8,599,728 төгрөгийг олгосон.

Төв болон салбар номын сангуудын номын санч нарт гэрээр ном олгох үйлчилгээний хураамжийн орлогоос сар бүр 12 номын санчид орлогын дүнгийн 30%-иар бодож 5,798,000 төгрөгийн урамшуулал олгож байна. Эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын 39 ажилтны 0-16 насны 58 хүүхдэд 290,000 төгрөгийн мөнгөн урамшуулал тус тус олгов.

Төв болон салбар номын сангуудын хэмжээнд болон их дээд сургуулийн номын сангуудтай хамтран спортын тэмцээн уралдааныг зохион байгуулахад 754,600 төгрөг, 15 ажилтныг Буриад улс руу аялуулахад 9,600,000 төгрөг, Төрийн албаны хуулийн дагуу 2 ажилтанд төрсөн нутагтаа амрахад ирэх очих замын зардалд 204,000 төгрөг өгсөн байна. Мөн Хамтын гэрээний дагуу 2012 оны 01 дүгээр сараас ажиллагсдын хоол унааны мөнгийг хүн тус бүрт 50,000 төгрөг болгон нэмэгдүүлэхэд 49,200,000 төгрөг зарцуулсан.

Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нийтдээ **98,585,744** төгрөг зарцуулсан байна.

3.3. Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар

Номын санчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт семинарыг сар бүрийн сүүлийн Мягмар гарагт номын сангийн дэргэдэх Мэргэжил арга зүйн зөвлөл, Номын сангуудын консерциумтай хамтран явуулдаг. Тайлант хугацаанд Номын сангийн консерциумын ажилтан Л.Гантулга, каталогч Одхүү нар Коха програмд /электрон каталогт/ ном оруулах талаар сургалт, Шинжлэх ухааны доктор Ж.Цэзэн "Гарчигийн номзүй" сэдвээр лекц сургалт явуулсан. Мөн Коха програмд /электрон каталогт/ ном оруулах талаар номын санчдад сургалт зохион байгуулав. Байгууллагын ажиллагсдаас гадна Увс, Дорнод, Сүхбаатар аймгуудын төв номын сангийн ажилтнуудтай мессенжер, имэйлээр холбогдож, мөн тус номын сантай танилцах үед нь мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч ажиллалаа.

Номын санч Г.Отгонжаргал БНСУ-ын Үндэсний номын санд мэргэжил дээшлүүлэх 6 сарын сургалтанд хамрагдлаа.

Тайлангийн хугацаанд номзүйч, бүртгэлийн номын санч, дэд захирал, ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөс гаргасан загвараар шинэчлэн боловсруулж гаргасан.

"Өрхийн хөгжлийг дэмжих жил" аяны хүрээнд нийт ажилтан албан хаагчдын дунд "Органик бүтээгдэхүүний тухай" сэдвээр Органик монгол хөтөлбөрийн ерөнхий зохицуулагч Д.Ононтой уулзалт зохион байгуулсан. Хүүхдийн баярыг тохиолдуулан хүүхдийн уншлагын танхимаас Үйлдвэрчний хороотой хамтран цэцэрлэгийн насны

хүүхдүүдийн дунд "Ойн амьтад" сэдэвт гар зургийн уралдаан, сургуулийн насны хүүхдүүдийн дунд "Миний Улаанбаатар" сэдэвт эссэ бичлэгийн уралдаан, ажилчдын хүүхдүүдийн дунд дуу шүлгийн уралдааныг зохион байгуулж байр эзлүүлэн эхний 3 байр эзэлсэн хүүдүүдэд бэлэг дурсгалын зүйл гардуулав.

Номын санчид МУИС-ийн номын сангийн – Коха програмтай болон Парламентын номын сантай тус тус танилцсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Архивын газраас хамтран 2012 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний хооронд зарласан "Баримт бичгийн стандарт" аяныг тус номын сан нь төв болоод салбар номын сангуудын хэмжээнд зохион байгуулан явууллаа. Аяны эхэнд болон төгсгөлд 2 удаа сургалт явуулж, мөн хоёр удаа шалгалт авсан. Тус шалгалтын эхнийхэд ирц 100%, сорилын голч дүн **54,5%** буюу байгууллагын голч дүнгээр **77,2** оноо буюу **"C"** үнэлгээ авсан бол аяны төгсгөлд авсан шалгалтын дүнгээр **68,6 "D"**, байгууллагын голч дүнгээр **84,3** буюу **"B"** болж түвшин ахисан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн "Монгол бичгийн албан хэрэглээг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажилтан, албан хаагчдынхаа дунд монгол бичгийн анхан шатны сургалт зохион байгуулан явуулсан.

Байгууллагын дотоодод жил бүр уламжлал болгон явуулдаг "Шилжин явах цомын тэмцээн"-ийг "Олимп хөгжил сан"-гийн цомыг аялуулах арга хэмжээтэй хамтатган, төв болон салбар номын сангуудын ажилтан албан хаагчдын дунд 2012 оны 05 дугаар сарын 19-ний өдөр спортын тэмцээнийг сагсан бөмбөг, гар бөмбөг, дартс гэсэн 3 төрлөөр зохион явуулав. Тус тэмцээний нийлбэр дүнгээр Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан хоёр дахь удаагаа цомын эзнээр шалгарсан юм. Мөн тэмцээний үеэр "Олимп хөгжил сан"- гийн хандивын хайрцгийг аялуулж, тус байгууллагын ажиллагсдын зүгээс 83,500 төгрөгийн хандивыг өгсөн байна.

3.4. Албан хэрэг хөтлөлтийн талаар

Иргэдийн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэсэн байдал: Иргэд болон ажиллагсдаас нийт 43 өргөдөл хүсэлт хүлээн авч, 100% хуулийн хугацаанд нь шийдвэрлэж эзэнд нь амаар болон утсаар мэдэгдэж ажилласан. Үүнээс 58,1% буюу 25 нь тэтгэмж, тусламж хүссэн, үлдсэн хувь нь чөлөө олгох, шилжүүлэн ажиллуулах, ажлаас чөлөөлөхийг хүссэн зэрэг бусад асуудлаар хандсан байна. Өргөдлийн 95,3% нь байгууллагын ажилтан, ахмадуудаас, 4,6% хувь нь гадны иргэдээс ирсэн архивын лавлагаа олгохыг хүссэн, уншлагын зааланд цахилгааны уртасгагч залгуур олноор тавьж өгөхийг хүссэн хүсэлт байна.

Хариутай бичгийн шийдвэрлэлт: Тайлант хугацаанд нийт 51 албан бичиг ирснээс хариу нэхсэн 23 албан бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, хариуцсан ажилтнаар шийдвэрлүүлэн, хариуг хугацаанд нь өгч, хариу нэхээгүй 28 албан бичгийн шийдвэрлэлтэд нь хяналт тавьж ажиллалаа. Улирал тутам хариутай бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээ гаргаж, шийдвэрлэгдээгүй болон шийдвэрлэлтийн шатанд байгаа албан бичгийг удирдлагад танилцуулж ажилласан. Үүнээс Нийслэлийн Архивын газрын "Байгууллагын архивын баримтыг байнгын хадгалалтад шилжүүлэх тухай", Нийслэлийн соёл урлагийн газрын "Хаяг солих тухай", Нийслэлийн мэдээллийн технологийн газрын "Цахим хуудсыг шинэчлэх тухай" албан бичгүүдийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн боловч бүрэн шийдвэрлэгдээгүй хяналтанд байна.

Дөрөв. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. Байгууллагынхаа үйл ажиллагааны үр дүнгийн талаар иргэдийн санаа бодлыг ямар арга хэлбэрээр авч, үнэлэлт дүгнэлт хийсэн байдал

Номын сангийн үйлчилгээ уншигч, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцэж буй талаар болон номын сангийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх зорилгоор санал хүсэлтийн хайрцаг, дэвтрийг танхим тус бүрээр ажиллуулж гарч буй санал бодлыг нь ажил үйлчилгээнд тусгаж ажилласан. Үйлчилгээний байгууллагын хувьд уншигч үйлчлүүлэгчдийн зан төлөв, хэрэгцээг тогтмол судлан үйлчилгээгээ зохион байгуулах нь бидний гол зорилт юм.

- Баянзүрх дүүрэг дэх номын сан: Тус салбар номын сан нь энэ улиралд 3 удаа санал асуулга явуулсан байна. Нийтийн уншлагын танхимаас 10 асуулт бүхий "Миний нүдээр-Номын сан" сэдэвт санал асуулгыг 40 уншигчийн дунд явуулсан. Судалгаанд оролцогчдын 94% нь их, дээд сургуулийн оюутан, 0,6% нь ажил эрхэлдэг, тэтгэврийн насны хүмүүс хамрагдсан байна. Санал асуулгад оролцогчдод номын сангаас зохион байгуулж байгаа уулзалт мэдээлэл, үзэсгэлэнгүүд нь цаг үеэ олсон ажил байдаг бөгөөд эерэг сэтгэгдэл төрүүлдэг байна. Оролцогчид бараг 100 хувь номын санг чөлөөт сонголттой, интернетэд холбогдсон иргэдийн чөлөөт цагийн төв байгаасай гэж хүсдэг гэсэн байна. Хүүхдийн уншлагын танхимаас 1 дүгээр улирлын уншигчдын бүтэц, ном олголтод судалгаа хийсэн байна. Уншигчдын 85 хувь нь 48 дугаар сургуулийн сурагчид бөгөөд 62% нь охидууд бөгөөд ном олголтын 81% нь уран зохиол, аман зохиолын ном байсан байна. Тус уншлагын танхимд нийслэлийн 4 дүүргийн төрийн өмчийн 16 сургууль, хувийн 8 сургуулиас ирж суудаг

байна. Номын санд хамгийн их ирж уншдаг ангийнхан 9-11 дүгээр ангийнхан байсан байна. Мөн 2 дугаар улиралд Хүүхдийн уншлагын танхимаас "Үйлчилгээний чанар" сэдэвт 10 асуулт бүхий сэтгэл ханамжийн судалгааг явуулахад 25 уншигч хамрагдсан байна. Нийт оролцогчдын 90% нь үйлчилгээнд сэтгэл хангалуун, 84% нь багшийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхээр ирдэг гэсэн бол 56% нь найзыгаа дагаж анх номын санд бүртгүүлсэн гэсэн байна. Нийт оролцогчид ширээ сандал их чимээтэй, гэрэлтүүлэг муу гэсэн байна.

Тайлант хугацаанд БЗД дэх салбар номын сангийн санал хүсэлтийн дэвтэрт 26 уншигч санал бодлоо бичсэн байна. Санал хүсэлтийн дэвтэрт хүйтний улиралд нийтийн уншлагын танхим хүйтэн учир удаан сууж ашиглах боломжгүй, хувцасны өлгүүргүй, интернет үйлчилгээ байхгүй байгааг өөрчлөх шаардлагатай гэсэн байна.

- Хан-Уул дүүрэг дэх номын сан: Санал хүсэлтийн дэвтэрт хүсэлт бичигдсэн бөгөөд шинээр гарч байгаа ном хэвлэлийг цаг тухай бүрт нь авч номын сангийн фондыг баяжуулах шаардлагатай. Тухайлбал эдийн засаг, хууль, хэлний гэх мэт салбарын ном хүрэлцдэггүй цөөн хувьтай байдаг. Нийтийн болон хүүхдийн уншлагын танхимуудыг хагас, бүтэн сайн өдрүүдэд ажиллуулах, интернет, электрон каталогтой болох талаар саналаа бичсэн байна.
- EIPL олон улсын байгууллагаас гаргасан санал асуулгыг үндэслэн Мэдээлэл боловсруулалт автоматжуулалтын тасгаас харааны бэрхшээлтэй 50 гаруй уншигч үйлчлүүлэгчдээс 14 асуулт бүхий санал асуулга авсан.

ТАЙЛАНД ӨГӨХ ҮНЭЛГЭЭ БОЛОН ЦААШИД ТАВИХ ЗОРИЛТ

2012 онд 8 чиглэлээр 58 багц ажил үйлчилгээ төлөвлөснөөс 57 ажил буюу 98,2% нь биелсэн байна. Төсөв хөрөнгөний асуудлаас хамаарч Архивын өрөөнд нягтруулсан шүүгээ авах ажил биелээгүй байна.

Цаашид шийдвэрлэх шаардлагатай дараах чухал асуудлууд байна. Үүнд:

1. Номын сангуудын барилга байгууламжид сүүлийн 30 жил барилгын ямар ч их засвар хийгдээгүй учир дээврээс байнга ус алдсаар фондын тааз хана хөгцөрч мөөгөнцөртөн, фондын хадгалалт хамгаалалтын горим алдагдан аюултай байдал үүссэн тул 2013 онд барилгын засвар хийх шаардлагатай байна.

2. Төв номын сангийн номын тавиур, уншигчийн ширээ сандлыг 32 жил ашиглаж байгаа бөгөөд одоо засвар авахгүй болтлоо эвдэрч элэгдэлд орсон тул шинээр сольж уншигч үйлчлүүлэгчдэд тав тухтай, аюулгүй орчинд үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

“ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨВ”

Уншлагын танхим

Хүүхдийн уншлагын танхим

Цахим уншлага

“АСМТ-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ӨРӨӨ-
ИРГЭДИЙН МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ ТАНХИМ”

“НҮҮДЛИЙН НОМЫН САН”

“Олуулаа уншъя”

“Багахангай, Багануур, Налайх дүүргийн Соёлын ордны уншлагын танхимд интернетэд суурилсан номын сангийн КОХА программ нэвтрүүллээ”

ХҮҮХДИЙН НОМЫН ОРДНЫ 2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Бүтээгдэхүүний анги 1. Номын сангийн үйлчилгээ			
1.1 Номын сангийн фондыг ном хэвлэлээр баяжуулах , техник ажиллагаанд оруулах			
Хийх ажил		Хийсэн ажил	Өгөх оноо
1.1.1	Фондуудад бүрдүүлэлт хийх	Нийт ХНО-ны хэмжээнд 57 сая 486 мянга 080 төгрөгний ном, хэвлэл бүрдүүлсэнээс: Улсын төсвөөс- 29 сая 966 мянга 278 төгрөгний Бэлэг хандиваар 27 сая 519 мянга 802 төгрөгний ном хэвлэл бүрдүүлсэн байна. Улсын төсвөөр бүрдүүлсэн номын тухай тодотговол: Нийт 41 фактурын 2722 ном, 54 аудио визуал материал, 14 нэрийн сонин, 6 нэрийн сэтгүүл бүрдүүллээ.	
1.1.2	Фондын бүрдүүлэлтийг бэлгийн ном хэвлэлээр баяжуулах	Нийт бэлгээр монгол болон гадаад хэл дээр 27 сая 519 мянга 802 төгрөгний ном бүрдүүлсэнээс: • Азийн сангийн “Ном хөтөлбөр”-өөс Швейцарь номын уншлагын танхим болон “Их мэдэх танхим”-д 13 фактурын 239 ш ном 47 ш аудио визуал материал бүрдүүлсэн нийт үнэ нь 3.718.400 төгрөг • Япон уншлагын танхимд 35 мянган төгрөгний 5 ном • Тайваний Үндэсний номын сангаас 2 сая 923 мянга 630 төгрөгний 216 ном - Германы Гёте Институтээс 12 сая төгрөгний 205 ном , хэвлэл - Зууны мэдээ”, ”Үндэсний шуудан”, ”Өдрийн сонин” сонин 2 хувь ”Өнөөдөр”, “Өдрийн шуудан”, ”Улаанбаатар таймс”, “Ардчилал”, “Монголын үнэн” сонины газруудаас 8 нэрийн сонин, 1 нэрийн сэтгүүлийн 822 ширхэг дугааруудыг үнэ төлбөргүйгээр бүрдүүлсэн. “Умард хөрш” сэтгүүлийн дугаар бүрээс 250 ширхэг, “Солонго”, “Тусгаар тогтнол”	

		сэтгүүлүүдийг бэлгээр бүрдүүлсэн. • Зохиогч, хэвлэлийн газруудаас 8 сая 842 мянга 772 төгрөгний ном тус тус бүрдүүлсэн байна.	
1.1.3	Бүрдүүлэлтээр орж ирсэн номыг ангилах	Шинээр ном хүлээн авсан байдал: Нийт 103 фактурын 4401 шинэ ном 110ш cd-ийг ном бүрдүүлэгчээс фактураар тулган хүлээн авлаа. Үүнийг фактураар нь авч үзвэл: - Худалдааны монгол номын 1- 38-р фактурын 2674ш ном 52ш cd - Бэлгийн монгол номын 1-38-р фактурын 1242ш ном, 3cd - Худалдааны гадаад номын 1-3-р фактурын 48ш, 2cd ном - Бэлгийн гадаад номын 1-11-р фактурын 198ш ном, 6cd - Азийн сангийн 1-13- р фактурын 239ш ном, 47cd Төлөвлөгөө Гүйцэтгэл Биелэлт 3000 4511 150,3% Танхимуудад ном хуваарилсан байдал: ХНО-ны хэмжээнд нийт 5078 ном ангилсан. Үүнээс: ГМНС-162, Тайвань уншлагын танхим -253, Япон уншлагын танхим-1200, Ном ангилагч: Бүгд 3463ш ном 57ш cd нийт 3520 ном материал ангилж нэг бүрчилсэн бүртгэл, нэгдсэн бүртгэлд бүртгэн, техник ажиллагаанд оруулж танхимуудад хуваарилсан. Монгол номын фондын хуучин ном болох Марксизм- Ленинизмийн шинжлэх ухааны 171ш номыг шинээр ангилж католог оруулахад бэлэн болгосон. Нийт 4253 ш номыг ангилсан байна.	
1.1.4	Ангилсан номыг данслах	Нийт 5626 номыг номын сангийн нэгбүрчилсэн бүртгэлд дансалсан байна. Нэгдсэн бүртгэлийн 463-531-р хэсэгт 68 фактурын 1013 төрлийн 3475ш номыг бүртгэсэн байна. Төлөвлөгөө Гүйцэтгэл Биелэлт 56 68 121,4%	

1.1.5	Шинээр авсан номонд техник ажиллагаа хийх	ХНО-ны хэмжээнд нийт 4253 номыг техник ажиллагаа хийж уншигчдын хүртээл болгосон байна. Үүнээс: Герман уншлагын танхим 162, Тайваний уншлагын танхим 253 ном аудио визуал материал. Ном ангилагч 2011 онд хүлээн авсан худалдааны гадаад номын 2-4-р фактурын 66ш ном 5 cd, 2012 оны худалдааны монгол номын 1-27-р фактурын 1914 ном 10 cd, бэлгийн монгол номын 1-38-р фактурын 1242ш ном, 3ш cd, Худалдааны гадаад номын 1-3-р фактурын 48ш ном 6cd, Бэлгийн гадаад номын 1-4-р фактурын 84ш ном, азийн сангийн 1-5- р фактурын 109ш ном, 33cd Нийт - 3463ш ном, 57cd-ийг техник ажиллагаанд оруулсан байна.	
1.1.6	Бүрдүүлэлтээр орж ирсэн номонд карт бичих	Карт хэвлэх талаар: Каталогчид нийт 2907ш каталогийн картыг мэдээллийн баазаас хэвлэн гаргажээ. Төлөвлөгөө Гүйцэтгэл Биелэлт 2600 2907 111,8% Каталогийн жижүүрт каталогчид нийт 236 удаа, үүнээс *каталогч Б.Хажидмаа* 117 удаа, *каталогч Д.Жавзанпагма* 119 удаа тус тус гарч хайлтын компьютерүүдийг ажиллахад бэлтгэх, шоголуудыг эмхлэх, каталог ашиглах, номын сангаар үйлчлүүлэх, захиалгын хуудас бичих, номоо хэрхэн хайх, сонгох талаар зөвөлгөө өгч ажиллаж байлаа. - Зарим уншигчдад унших зохиолыг нь электрон каталогоос хайлт хийж олж өгч байлаа.	
1.1.7	Шинэ карт байрлуулах	Карт байрлуулах талаар: Нийт 2241 карт байрлуулав. Үүнээс: *Үсэг дарааллын каталогт карт байрлуулах талаар:* Төлөвлөгөө Гүйцэтгэл Биелэлт 800ш 866ш 108,2% Үүнээс: Шинээр ирсэн номын *616ш* карт, хуучин карт шинэчилсэн *250ш*	

		байрлуулав. *Төрөл ангийн каталогт карт байрлуулах талаар:* Төрөл ангийн каталогт бүгд 1375ш картыг ламинатордан байрлуулав. Үүнээс шинэ номын 870ш, хуучин 505ш картыг шинэчлэн хэвлэж байрлуулав. Төлөвлөгөө Гүйцэтгэл Биелэлт 800ш 1375ш 171,8%	
1.1.8	Каталогийн редакци	Каталогт редакци хийх талаар: *Үсэг дарааллын каталогт редакци хийх талаар:* - Бичиг үсэг нь, баларч ашиглагдах боломжгүй болсон *250ш* картыг ялгаж шинэчлэн хэвлэж байрлуулав. - Карт шинэчилж хэвлэх явцад хайлтаар электрон каталогоос гарч ирэхгүй байсан 35 номыг фондоос татаж дансаар нь шүүж шалгахад 10 ш ном нь электрон каталогт байхгүй, бусад номын бичлэг алдаатай байсныг засаж зартыг хэвлэн гаргав. - Үсэг дарааллын каталогт давхар байрлуулсан картыг хасав. *Төрөл ангийн каталогт редакци хийх талаар:* - Цаасан карт хэвлэхийн өмнө шинээр оруулсан 768 нэр төрлийн номын бичлэгийг шалгаж алдааг тухай бүрд нь засаж янзлав. - Өмнө электрон каталогт ороод дахин нэмэгдэж ирсэн номын дансыг нэмэхдээ бичлэгүүдийг шалгаж алдааг засах, зарим бичилтийг нэмэх ажлуудыг хийж байлаа. - Карт байрлуулах явцдаа бичиг үсэг нь баларсан, урагдсан 600ш картыг ялган авч электрон каталогоос хайлт хийн 505 ш картыг шинэчлэн хэвлэж байрлуулав. Картыг шинэчлэх явцад 103ш ном нь хайлтаар гарч ирээгүй тул фондонд шүүж үзэхэд 23ш ном нь байсан ба 80ш ном байгаагүй тул эдийн засаг, улс төрийн 80ш номын картыг каталогоос хасалт хийв. 23ш номын алдаатай бичлэгийг засаж картыг хэвлэж гаргав. Каталогоос ямар нэгэн байдлаар алга болсон 20ш номын картыг дахин хэвлэж байрлуулав. - Карт байрлуулах явцдаа буруу байрлагдсан 25 картны байрлалыг засаж байрлуулав. - Төрөл ангийн каталогийн эдийн засаг, улс төр, утга зохиолын 103 ялгагч, шоголын 24 дугаар шинээр хийв.	

		Зураасан коджуулах талаар: Электрон каталогт оруулсан 9343 ш номын зураасан кодыг хэвлэн гаргаж ном тус бүрт наан ангилагчид хүлээлгэн өгсөн байна.	
1.1.9	Фондуудад ном байрлуулах	Монгол фонд 37000 ном байрлуулахаас 39700 ном байрлуулж төлөвлөгөөг 107 хувиар гүйцэтгэв.	
1.1.10	Хүүхдийн ном зүйн бүртгэлтэй холбогдолтой номын бүрдүүлэлтийг хийж, фондыг баяжуулах \1971- 1990 он\	1971-1990 онд хэвлэгдэсэн "Хүүхдийн уран зохиолын ном зүйн бүртгэл"-ийн материалыг online хэлбэрээр хайх боломжтойгоор өөрийн вебэд бие даасан сан үүсгэн байршуулсан. Мөн өөрийн номын сангийн архивын фондонд хадгалагдаж байгаа хүүхдийн уран зохиолын ном зүйг хийсэн.	
1.2. Уншигчдад ном хэвлэлээр үйлчлэх үйлчилгээ			
1.2.1	Фондуудаас уншлагын танхимуудад захиалгын дагуу ном, гаргаж өгөх	Монгол номын фонд 37000 ном олгохоос 39624 ном олгож төлөвлөгөөг 107 %-иар биелүүлсэн байна.	
1.2.2	• 2450 уншигчдад уншигчийн үнэмлэх нээх • • "Боловсрол хөгжил" танхимаар 26000 ирцэд 37000 ном олгох • • "Их мэдэх танхим" 4260 ирцэд 6000 ном олгох • • " Мөрөөдөл" танхим 11110 ирцэд 21850 ном олгох • • "ГМНС" уншлагаар 4500 ирцэд 8000 ном олгохЯпон номын уншлагын танхим 1750 ирцэд	• 4567 уншигчдыг шинээр бүртгэн үнэмлэх нээсэн. Төлөвлөгөө 175%-иар биелсэн. • "Боловсрол хөгжил" танхимаар 31680 ирцэд 38594 ном олгож 112,5% • "Их мэдэх" танхимаар 5582 ирцэд 11829 ном олгож 164 % • "Мөрөөдөл" танхимаар 11230 ирцэд 22060 ном олгож 101% • ГМНС-аар 5628 ирцэд 10825 ном олгож 130 % • Англи номын уншлагын танхимаар \ШСМТ\ 3680 ирцэд 6245 ном олгож 168 % • Орос номын уншлагын танхимаар 727 ирцэд 1452 ном олгож 41,5 % • Япон номын уншлагын танхимаар 1469 ирцэд 1960 ном олгож 85%	

	2250 ном олгох • Тайваний мэдээллийн төвөөр 510 уншигчид 1020 ном олгох • Монгол номын фонд 37000 ном олгож 38000 ном байрлуулах • Нийт 2236 уншигчдад шинээр үнэмлэх нээж, 49770 ирцэд 115150 ном олгож уншигчдад үйлчилнэ.	• Тайваний мэдээллийн төвөөр 860 ирцэд 1562 ном олгож 160,5% • Монгол номын фонд 39624 ном олгож 39700 ном байрлуулж 107%-иар тус тус төлөвлөгөөт ажлаа гүйцэтгэсэн. • Зөөврийн номын сангаар 6637 ирцэд 6104 ном олгож үйлчилсэн байна. Нийт 4567 уншигчдад шинээр үнэмлэх нээж 67493 ирцэд 140255 ном олгож нэгдсэн дүнгээр 118 %-иар уншлага үйлчилгээний ажил биелсэн байна. Уншлага үйлчилгээний ажлыг сайжруулах зорилгоор мөн дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд: Зөөврийн номын сан нь 2012 онд нийт 13 төвд 3547 ширхэг ном хүргэж уншигч хүүхэд багачуудтайгаа уулзаж, тэдний санал хүсэлтийг авч ирлээ. Зөөврийн номын сангийн үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор зуны 3 сард хугацаанд хүүхдийн зуслангуудтай гэрээ хийн гэрээ хийж ажиллалаа. Үүнд: Шинээр Баянзүрх дүүргийн 4-р хороонд байрлах “Мегамалл” ХХК-тай гэрээ хийлээ. Тус байгууллага нь өөрийн эзэмшлийн объектдоо “Цэц” нэртэй номын санг шинээр байгуулж Баянзүрх дүүргийн оюутан сурагч, оршин суугчдын чөлөөт цагийг зөв боловсон зохистой өнгөрүүлэхэд анхааран ажиллаж байна. Төвүүдэд алдагдсан номын жагсаалтыг гаргаж , ном төлүүлэх журмын дагуу 2 төвийн номыг төлүүллээ. Энэ жилд зөөврийн номын сан нь Зохиолч уншигчийн уулзалт 3 удаа, соёлын ажлыг Азийн сан, Япон танхимтай хамтран 3 удаа, 2 газартай шинээр гэрээ хийн үйл ажиллагаагаа идэвхтэй өргөжүүлж байна. Монгол номын фонд: Хот, аймаг, сум, сургуулийн номын сангуудад болон төрөл бүрийн арга хэмжээнүүдэд ном бэлэглэхэд 7440 ширхэгийг татаж олгосон. Хот, аймаг, сум, сургуулийн номын сангуудад тараагдаж байгаа 41 нэр төрлийн номын үлдэгдэл тоог жагсаалт, 2009-2012 онуудад тараагдсан нийт номын тоог жагсаалтаар гаргаж захиралд өгсөн. 2009-2011 онд хамгийн их уншлаганд гарсан 9 ширхэг ном татаж БСШУЯ-н шилдэг ном шалгаруулах үзэсгэлэнд гаргасан.	

		БСШУЯ-аас сургууль цэцэрлэгийн номын сангийн фондын баяжилт хийх ажлын хүрээнд 195 нэр төрлийн номыг хэвлэлийн компаниудаас хүлээн авсан. Мөрөөдөл танхим: Мөрөөдөл танхимын номын санч ажлаа хүлээлгэн өгөх болсонтой холбогдуулан тооллого хийлээ. Тооллогооор програм дээр давхар шивэгдсэн номыг каталогоос хасуулах, нэр өөр данс ижил номыг засуулах, баркод нь уншихгүй байгаа номын кодыг солиулах зэрэг тооллоготой холбоотой ажлуудыг хийж гүйцэтгэв. Мөрөөдөл танхимын фондын 10 000 номын байршлыг сэлгэн 8 тавиур ном зөөн ангилал холилдсон номыг төрөл анги, үсэг дарааллаар ялган эмхлэв. Гадаадын уран зохиол, Монголын Хүүхдийн уран зохиолын ангийн номонд үсгийн ялгагч хийв. Шинээр интернэт холболт бүхий 5 компьютер танхимд байрлуулахтай холбогдуулан бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэв. 2011 онд эмхлэгдэж цэгцлэгдээгүй хүүхдийн сонин сэтгүүлийг сэргээн засварлагчид өгөхөд бэлтгэж янзлав. Герман танхим: Шалгах хуудсаар буюу уншигчийн ирцийн урамшууллаар 5ш сэтгүүлийг уншигчиддаа бэлэглэв. Шилдэг 5 уншигчид болон хяналтын картын урамшууллаар уншигчдад гэрээр үнэ төлбөргүйгээр ном олгож байна. Хяналтын картыг шинээр 150ш хэвлэн, гэрээр ном авч буй уншигчдад өгч байна. Оны эхнээс LIB4U програмын үйлчилгээний модулыг ашиглаж эхэлсэн. Хугарч гэмтсэн 8 CD-г шинэ CD руу хуулж фондыг гүйцээсэн. 5 ш хэлний сургалтын номыг цавуутай гялгар уутаар хавтаслалаа. Тайвань танхим: Төлбөрийн номын жагсаалтыг комиссын дарга Г. Дарьсүрэнгээс хүлээн авч солилцооны дэвтрийг дахин шүүж, Монгол фондноос 2012 оны байдлаар фондонд эрэлт хэрэгцээтэй номын жагсаалтыг номын санч	

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td>Д.Энхчимэгээр гаргуулсан. Шаардлагатай үед тухайн ажилтанд дутсан номын жагсаалтыг хэвлэн гаргаж өгч байлаа. Ажилтнуудын орлуулж өгсөн ном болон фондын номонд зохих тэмдэглэгээг хийж, номыг байран дээрээс нь шалгах зэрэг ажлуудыг хийж байлаа.
ХНО-ы Үндсэн хөрөнгөнд оруулахаар Тайваниас ирсэн шинэ номын нэрийг галиглан нягтланд өглөө. Нийт 2 сая 923 мянга 630 төгрөгийн номын үнийн дүнгээр бүртгүүлэв.

Танхимын номын баяжилт нэмэгдэж байгаа тул номын тавиурын тоог нэмж 833 ш номын байрын шалгалт хийж дахин байрлуулав.
Хэлний сурах бичиг, толь бичгийн талаар 18 удаа лавлагаа өгсөн
Швейцарь танхим:
Илүү хувьтай номуудыг компьютерт шивж Европ фонд руу Мөнхцэцэг Арьяа нарын хамт зөөсөн. Номын тавиурын байрлалыг шалган эмхэлж нийт 4000 орчим номын байрыг шилжүүлэв.
Бүртгэлийн номын санч: 880 ширхэг Хяналтын хуудсыг хэвлэж захиалсан танхимуудад нь хүлээлгэн өглөө.</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>1.2.3</td>
<td>• Шинэ номын үзэсгэлэн -11 удаа
• Сэдэвчилсэн номын үзэсгэлэн-15 удаа
• Уншигчдад зориулсан цуврал лекц
• Зохиогч уншигчдын уулзалт 4 удаа
• Уншигчдын номын сангаар хэрхэн үйлчлүүлэх, номын тухай танилцуулга сургалтууд-16
• Үлгэрийн цаг -16
• Англи хэлний танхимын “Залуусын уулзалт” -10
• “Эх орон” телевизтэй хамтран “Бид номонд</td>
<td>А.Шинэ номын үзэсгэлэн: 11 удаа гаргахаас 18 удаа 551 номоор
Сэдэвчилсэн үзэсгэлэн: 15 удаа гаргахаас 21 удаа нийт 536 ширхэг ном, 76 ширхэг зургаар тус тус гаргасан байна.
<table>
<tr><th>№</th><th>Он сар өдөр</th><th>Сэдэв</th><th>Тоо. Ш.

ном/</th><th>Танхим</th></tr>
<tr><td>1</td><td>1 сарын 4</td><td>Г.Аким “Тэнгэрийн нохой” номын баярт</td><td>18 ном</td><td>БХ</td></tr>
<tr><td>2</td><td>1 сар</td><td>Динза” цуврал</td><td>10 ном</td><td>ИМ</td></tr>
<tr><td>3</td><td>2 сарын 1</td><td>“Д.Сүхбаатарын мэндэлсний 119 жилийн ойд”</td><td>14ном</td><td>БХ</td></tr>
<tr><td>4</td><td>2 сарын 7</td><td>Шинэ ном</td><td>37 ном</td><td>БХ</td></tr>
<tr><td>5</td><td>2 сар</td><td>Шинэ ном</td><td>15 ном</td><td>ИМ</td></tr>
<tr><td>6</td><td>2012.2.4-03.31.</td><td>Шинэ ном</td><td>40 ном</td><td>Тайвань</td></tr>
<tr><td>7</td><td>3 сарын 1</td><td>“Тэнгэрлэг хүүхнүүд”</td><td>34 ном</td><td>БХ</td></tr>
</table>
</td>
<td></td>
</tr>
</table>

дуртай" нэвтрүүлэг -4 удаа

- Хүн сансарт ниссэний 50 жил, Монгол хүн сансарт ниссэний 30 жилийн ойд зориулж сансрын нисэгч Ж.Гүррагчаатай уулзалт
- Олон улсын хүүхдийн номын баяр
- "Үндэсний бичиг минy" улсын 6-р уралдаан
- "Хүүхдийн баяр"
- Зугаатай зуны уншлага
- "Сайн байна уу? Ном минь
- "Р.Чойням" уран уншлагын уралдаан
- "Номын ертөнцөөр" илтгэлийн уралдаан, сургалт
- Монгол улсын тусгаар тогтнолын 100 жилийн ойд зориулсан эссэ бичлэгийн уралдаан
- Тэргүүний уншигч шалгаруулах үйл ажиллагаа

8	3 сарын 27	Шинэ ном	22 ном	БХ	
9	3 сар	Новые книги	30 ном	Орос	
10	3сарын30	"Дэлхийн хүүхдийн номын баяр"-т	53 ном	БХ	
11	3 сар	Монгол Ардын үлгэрүүд	11ш	ИМ	
12	3 сарын 30	"Путешествие по сказочной стране"	20ш ном	Орос	
13	3 сарын 30	Япон улс Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойд зориулан зургийн үзэсгэлэн гаргав.	16 ш зураг	Япон	
14	4-р сарын 1	Х.Г.Андерсений мэндэлсэний 207 жилийн ойд	149	Бүгд	
15	4 сарын 2	"2011 онд хамгийн их уншлаганд гарсан ном"	51 ш	БХ	
16	4 сарын 17	Д.Цэдэвийн эрдэм шинжилгээний хуралд	11	БХ	
17	4 сарын 26	Шинэ ном	24 ш ном	БХ	
18	2011.4 сар	Монгол-англи хэлээр гарсан үлгэр	10	ИМ	
19	2011.5 сар	Таши / австралийн хүүхдийн уран зохиол	15	ИМ	
20	5 сарын 17	То ван мэндэлсэний 215 жилийн ойд	11	БХ	
21	5 сарын 30	Хүүхдийн зохиолч Д.Батжаргалын шинэ номын баяр	7	БХ	
22	5 сарын 30	Хүүхдийн зохиолч Д.Батжаргалын уран бүтээлээр	17	Мөрөөдөл	
23	6 сарын 27	Шинэ ном	25 ш ном	БХ	
24	6 сар	Шинэ ном	48	Мөрөөдөл	
25	9сарын 03	Шинэ ном	30	БХ	
26	9 сарын9	Номын баярт	10	Япон	
27	9сарын14	"Үндэсний номын баярт" 60 хүүхдийн зураг	23		
28	10 сарын 18	Шинэ ном	35	БХ	
29	10 сарын 19	"Ч.Дагвадоржийн 70 насны ойд"	15	БХ	
30	11 сарын 9	"Японы түүх соёл"	14	Япон	
31	12 сарын 7	Шинэ ном	30	БХ	
32	12 сарын 10нд	"ХНО-ы Архивын фондонд байгаа хүүхдийн уран зохиолын 40,50-аад оны ном" "Соёл ба Хөгжил"чуулганы үзэсгэлэнд гаргасан.	43 ширхэг	Төрийн ордонд	
33	2012.9 сар	Шинэ ном	40	ИМ	
34		Шинэ номын үзэсгэлэн	110 ш	Швейцарь	
35		Шинэ ном 4 удаа	65 ш	Тайвань	
		Шинэ ном	18удаа 551 ш		

		сэдэвчилсэн	21удаа 536ш		
		зураг	2 удаа 76 ш зураг		

Соёлын ажил:

Төлөвлөгөө: 4 удаа лекц явуулах. Биелэлт: Танхимуудаар 8 удаа лекц, уулзалт ярилцлага болжээ.
Үүнд:
1. 3 сарын 3 нд "Online-аар ном унших" ярилцлагыг Швейцарь танхимд Chabla клубын хүүхдүүд явуулав. /30 хүүхэд оролцов/
2. 2012.3.14 БСШУЯ-ны мэргэжилтэн С.Болормаа, МСХ-ны тэргүүн С.Сэлэнгэ нарыг урин "Элсэлтийн Ерөнхий Шалгалтанд юуг анхаарах вэ? " Амжилтанд хүрэхүй" сэдэвт лекц уншуулав. Лекц "Боловсрол хөгжил" танхимд болж 200 гаруй хүүхэд хамруулав.

3.2012.05.30 Тайвань танхимд БСШУЯ-ны Мэргэжлийн боловсролын Гадаадад болон гадаадаас суралцагчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Шинэбаярыг урьж "Монгол Улсын Засгийн газрын гадаадад суралцах тэтгэлэгт хэрхэн хамрагдах" сэдэвт лекцийг зохион явуулав. Лекцэнд "Болор" дунд сургуулийн төгсөх ангийн сурагчид, Хөгжлийн инженерчлэгч клубын идэвхтэн гишүүд, ХНО-ы уншигчид оролцов.
4. 2012.05 сард Швейцарийн мэргэжилтэн Анита хүүхдүүдтэй уулзаж ярилцав.
5. 2012.10.03 нд "Германы баярын өдрүүд" сэдвээр зохион 18-р сургуулийн герман хэлний багш Г.Алтантуул,Германы сайн дурын ажилтан Лена Павловский нартай нээлттэй лекц зохион явуулав.
6. 10-р сарын 10-нд "Унших арга барилын тухай" МУИС-ийн герман хэлний магистр багш М.Одонтуяатай нээлттэй лекц зохион байгууллаа
7. 2012.10. 26. "Герман дахь монгол судлал" МУИС-ийн герман хэлний багш др. Проф. Г.Лувсантай нээлттэй лекц зохион байгууллаа

8.2012.11.08 " Тэтгэлгээр хэрхэн суралцах вэ?" лекцийг МСХ-ны тэргүүн Сэлэнгэ Боловсрол Хөгжил танхимын ажилтан Адьяа нар зохион байгууллаа.

В. Төлөвлөгөө: 8 удаагийн үзүүлэн таниулах сургалтыг Эцэг эхэд зориулан
Биелэлт: . Үүнд: Эцэг эхэд зориулан 8 удаагийн сургалтанд 257 эцэг эх оролцов.

Бүтээгдэхүүний анги 2: Мэдээлэл технологийн үйлчилгээ			
2.1. Мэдээллийн хангамжийг сайжруулах			
2.1.1	ХНО-ны вебийг сайжруулан мэдээ мэдээллээр баяжуулах 	*Web: Web-ийн чиглэлээр:* -ХНО-ны вэб сайтад цаг үеийн холбогдолтой шинэ материалуудаар байнга баяжилт хийсэн. -Вэбэд тавигдах том хэмжээний материал бэлтгэхэд Агуулга удирдлагын системд хэрхэн бүтээхийг судлан мэдэж “Монголын хүүхдийн уран зохиолын номзүй” 1921-1940: 1941-1970 онуудын бүртгэлээр, өгөгдлийн санг шинэчлэлт сайжруулалт хийж байрлуулсан. -Вэбийн бүтцэд орох нэмэлтүүдийг судалж улмаар ХНО-ны вэб сайтад зураг болон текст, график материалыг оруулж, боловсруулах “JCE Administration” нэмэлт эдиторийг нэвтрүүлсэн. -Интернэтийн орчинд олон нийттэй харьцах боломж гаргасан нэмэлт болон вэб сайтын харагдах хэлбэрийг өөрчлөхөд Мэдээллийн дэлгэрэнгүй хураангуйлж үзүүлэх нэмэлт үйлчилгээг вэб сайтад нэвтрүүллээ. -Койка байгууллагын шугамаар ирж ажилласан Юу Ми-тай хамтран ажиллахдаа 5-6 удаа Энхчимэгийн хамт програмчлалийн талаар сургалт авч үүний дунд Excel болон бусад баримтуудаар MySQL өгөгдлийн санг бүрдүүлэх арга дадлагыг эзэмшлээ. -Олон улсын хүүхдийн дижитал номын сангийн вэб материалаас 2 төрлийн “Read.mn” CD, DVD бүтээх ажлыг хийж гүйцээсэн.	
2.1.2	Вэбэд өөрчлөгдсөн материалаар сан бий болгож offline хэлбэрээр хадгалах	• ХНО-оос эрхлэн гаргасан Монголын хүүхдийн уран зохиолын ном зүйн нэгдсэн мэдээллийн сангийн online, offline хэлбэрийг бий болгосон. 	

2.1.3	Дотоод болон интернэтийн сүлжээг сааталгүй найдвартай ажиллагаатай байлгах 	Номын сангийн автоматжуулалтын талаар дараах ажлыг гүйцэтгэлээ. -ХНО-нд нийлүүлэгдсэн техник тоног төхөөрөмжийн санхүүжилттэй болон уншигч үйлчилгээний хэрэгцээ шаардлагатай холбогдон гарсан 2 сервер бүхий 3 дэд сүлжээнээс бүрдэх 2 шинэ сүлжээний топологийг зохион гаргаж дуусгав. -2 шинэ сүлжээний болон сервер өрөөний мантажийн механик ажлуудыг дуусгаж гүйцэтгэв. -ХНО-ны сүлжээ шинэчлэлийн чиглэлээр 4 байгууллагын 6 мэргэжилтэнгээс зөвлөгөө авч ажилласан. /консерцумын захирал Гантулга, Wolves-ын Ганхуяг, Гантулга, Magicnet-ийн инженер, Topica –ийн 2 инженер/ -БШУЯ-ны төслийн болон Koica төслийн санхүүжилтээр нийлүүлэгдсэн 19ш компьютеруудын байрлал хувиарлалтыг гаргаж танхимуудад хүлээлгэн өгч ашиглалтанд оруулав. -Интернэт провайдер “MagicNet” компанитай интернэт хурд нэмэгдүүлэх болон IP хаяг авахаар тохиролцож хамтран ажиллав. -ХНО-д шинээр хийгдэж буй камер хяналтын сүлжээн мантажийн /сүлжээний сервер, терминал сервер, 8 цэг/ нийт 10 кабель татах ажлыг дуусгаж, камер суурилуулж “everfocus” болон “PowerFocus” програмуудыг туршин ажлуулж 5 камер ашиглалтанд оруулав. -2 цэгт шинээр n-Computing системийг суурилуулах ажлыг хийж гүйцэтгэв. -ХНО-ны компьютерийн дотоод сүлжээний найдвартай байдлыг тайлангийн хугацаанд хангаж ажиллахдаа удаа дараагийн тасалдлыг арилгасан. -Тайлангийн хугацаанд техник тоног төхөөрөмжүүдэд 6 удаагийн эвдрэл гарсаныг засварласан. 	
		-Каталогийн хайлтанд зориулсан n+Computing төхөөрөмжийн нийлүүлэгчтэй	

2.1.4	WEB-д электрон каталогийг нэвтрүүлэх ба бусад үйлчилгээнүүдийг бий болгох боломжуудыг судалж нэвтрүүлэх	хамтран 2 удаа засварлуулж улмаар өөрийн байгууллагын мэдэлд авсан. -LIB4U Net програмын баазыг улирал бүрд нөөцөлж хадгалсан. /4-р улирлынх 2012-12-18-нд 9,32GB/ -Шинэ серверт LIB4U Net програм болон номын каталогын өгөгдлийн баазыг Wolves-оор суулгуулан шинэчлэв. -Сүлжээний “Microtek 1200” роутерийн тохируулгыг Topica–ын мэргэжилтнүүдээр тохируулуулж ашиглалтанд оруулав. -ХНО-ны мэдээллийн аюулгүй байдлыг хангахад вирусын эсрэг Kaspersky Open Space Security програмыг захиалж улмаар ажиллагсдын компьютерт суулган ашиглуулж байв.	
2.1.5	“LIB-4” программын дагуу номыг электрон каталогт оруулах	• Нийт 4936 номыг электрон каталогт оруулсан.	
		2.2 Арга зүйн ажил	
2.2.1	ЕБС- ийн номын сангуудад арга зүйн зөвлөгөө өгөх	Номын санчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх: Нийт 78 номын санчид хамрагдлаа. Үүнээс: ➢ Аргазүйч Л.Батболор ЕБС-ийн 48 номын санчдад арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Төлөвлөгөө Биелэлт Гүйцэтгэл 45 48 106,6% Хот хөдөөгийн дараах 11 номын санчид өөрсдөө ирж арга зүйн зөвлөгөө авчээ. БГД-ийн Оюуны ундраа цогцолбор сургуулийн номын санч Х.Баянлиг, 113-р сургуулийн номын санч П.Нандин-Эрдэнэ, 19-р сургуулийн номын санч Э.Дэлгэрцэцэг, ХУД-ийн 10-р сургуулийн номын санч Ц,Золжаргал, СХД-ийн 104-р сургуулийн номын санч Д. Цэцэгмаа, Баянзүрх дүүргийн “Цэц” хүүхэд залуучуудын номын сангийн номын санч Н.Баасансүрэн, Төв аймгийн “Хүмүүн” цогцолбор ахлах сургуулийн номын санч Т.Тунсаг, “Ирээдүй” цогцолбор 2-р бага сургууль Г.Шийлэгдамба, “Бага нуур дүүрэг Л.Наранцэцэг, 96-р сургуулийн номын санч С.Наранцэцэг, Нийслэлийн боловсролын газрын номын санч Б.Байгалмаа нар биечлэн ирж арга зүйн зөвлөгөө авлаа. Мөн нийт 37 сургуулиудын номын сангийн үйл ажиллагаатай аргазүйч биечлэн очиж танилцан заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Үүнд: - Хан-уул дүүргийн 115, 63, 32, 18, 41, 59	

		- БЗД-ийн 84,14, 53, Амгалан цогцолбор, 87, 44, 21, 109 - ЧД-ийн 72, 117, 61, 24, 50 - БГД-ийн 113, 38, ”Монгени” цогцолбор, 70, 13, 47, 20, 40, 28, 38, 19 - СБД-ийн 31, 35, 58, 6, 11, 71, 2 сургуулиуд хамрагдлаа. Ажил мэргэжил нэгт буриад улсын хүүхдийн номын сангийн ажилчдыг танхимуудын үйл ажиллагаатай танилцуулаа. Мөн нийслэлийн 25-р цэцэрлэгийн бяцхан уншигчид, нийслэлийн 97-р сургуулийн 1б ангийн сурагчдыг танхимын үйл ажиллагаатай танилцуулж заавар зөвлөгөө өгч ажиллав. Номзүйч С.Тунгалаг лавлагаа номзүйн болон мэргэжил арга зүйн зөвлөгөөг нийт 28 хүнд өгөв. Төлөвлөгөө Биелэлт Гүйцэтгэл 22 28 127,2% Үүнд: Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын сургуулийн номын санч, Газарчин ДС-ийн номын санч, СХД-ийн Оюуны өргөө цогцолборын номын санчид, Соёл эрдэм дээд сургуулийн номын санч, 50, 52-р сургуулийн номын санч, СБС-ийн 2 оюутан, Дорнод, Өвөрхангай, Ховд аймгийн номын санчдад ДАА, лавлагаа мэдээллийн ажил, номзүйн жагсаалт хэрхэн гаргах, тоон номын сангийн хадгалалт, хамгаалалт хамгийн их уншигдаж буй ном, каталогийг хэрхэн ашиглах, нэгдсэн бүртгэл хөтлөлт, соёлын олон нийтийн ажлын талаар хөдөө орон нутгийн номын санчид болон хамтран ажилладаг байгууллагуудын ажилтнуудад биечлэн, e-mail хаягаар, утсаар нийт 28 удаа өгсөн. Хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг мэргэжил арга зүйн зөвлөгөөг 2 номын санчид өгөв. Үүнд: Замын –Үүд сумын сургуулийн номын санч Б.Ганцэцэг ур чадварын нэмэгдэл хэрхэн авах талаар зөвлөгөө авсан бөгөөд ХНО-ны ур чадварын нэмэгдэл авах журмыг электрон шуудангаар илгээлээ. Мөн Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын номын санч Герман танхимын хэвлэмэл бус материалын чөлөөт сонголттой биечлэн танилцаж, зөвлөгөө авлаа. Танхимын номын санчдад заавар зөвлөгөө өгөх Төлөвлөгөө Биелэлт Гүйцэтгэл	

		4 4 100% Орос уншлагын танхимын номын санчийг 23-р сургуулийн орос хэлний тэнхмийн багштай холбож өгч танхимын үйл ажиллагаа болон цаашид хийх ажлын талаар харилцан ярилцсан. Мөн орос хэлний сургалттай ЕБС-ийн жагсаалтыг бэлтгэж цаашид төлөвлөгөө гарган хамтран ажиллах болно. "Тайвань" уншлагын танхимын номын санчтай танхимын номын талаар харилцан ярилцаж зөвлөгөө өгөв. Тус танхимын номын санчид хоёр удаа зөвлөгөө өгсөн. "Боловсрол хөгжил" танхимын номын санчдад танхимаас зохиож болох соёл олон нийтийн ажлын талаар харилцан ярилцлаа.	
2.2.2	Сургалт семинар зохион байгуулах	Сургалт семинар зохион байгуулах талаар: Төлөвлөгөө Биелэлт Гүйцэтгэл 6 8 133% 2012.01-23-28 "ЕБС-ийн номын сан нь сургуулийн мэдээллийн төв болох нь" сэдэвт анхан шатны мэдлэг олгох модуль сургалтанд Хөвсгөл аймгийн сургуулийн номын санчид оролцлоо. Сургалтанд нийт -9 номын санч хамрагдсан. 2012. Сургалт семинарыг ЕБС-ийн номын санчдад төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зохион байгууллаа. БЗД-ийн сургуулийн номын санчид нь дүүргийн сургуулийн номын санчдын дунд спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулж номын санчид идэвхтэй оролцлоо. Спортын уралдаан тэмцээнийг гар бөмбөг, ширээний теннис гэсэн 2 төрлөөр зохион явуулж байр эзлүүлэв. Тэмцээнд 5 баг болон номын санчид оролцсноос 1-р байр ХУД-ийн номын санчид орж шилжин явах цом, алтан медаль, 2-р байр БЗД-ийн номын санчид мөнгөн медаль өргөмжлөл, 3-р байр СБД-ийн номын санчид хүрэл медаль, өргөмжлөлөөр шагнагдлаа. 2012.2.6-10-нд ЕБС-ийн номын санчдад 5 хоногийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд нийслэлийн 86, 112, 4, 117, 111, СХД-ийн Ирээдүй цогцолбор 2-р бага сургууль, 81, 78, 77, Утга зохиол нийгмийн ажилтан сургуулийн номын санчид хамрагдлаа. Сургалтын хөтөлбөр боловсруулах, сертификатын эхийг бэлтгэх, сургалтын өрөө бэлтгэх зэрэг бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэлээ. 2012.4.20 Нийслэлийн ЕБС-ийн номын санчдад төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зохион байгууллаа. Тус сургалтаар номын санчдын цалин болон нийгмийн асуудлын талаар санал бодлоо солилцсон. Дүүрэг тус бүрээрээ	

		номын санчид харилцан ярилцаж дээд байгууллагад уламжлах гарын үсэг бүхий санал хүсэлтийг бичгээр бэлтгэж өглөө. Нийт- 65 сургуулийн номын санчид оролцлоо. 2012.5.25 “Номыг ариутгах нь” сэдвээр ном сэргээн засварлагч Эрдэнэцэцэгтэй хамтран сургалт явууллаа. Номын санчид сурах бичгээ хураан авч байгаа энэ үед номын ариутгалыг хэрхэн хийх талаар заавар зөвлөгөө өгсөн сургалт боллоо.Нийт -25 номын санч оролцов. 2012.09.26 Баянзүрх дүүргийн 97-р сургуулийн номын санч Н.Долгормаатай хамтран БЗД-ийн номын санчдад ажил мэргэжлийн уулзалтыг зохиож харилцан ярилцаж санал бодлоо солилцсон. Нийт 16 номын санч оролцлоо. 2012.10.12 Сургуулийн номын санчдын өдрийг угтаж СБД-ийн 2-р сургуулийн уншлагын танхимын нээлт болж тус үйл ажиллагаанд ХНО-ны захирал Д.Оюунбилэг, Ном зүйч С.Тунгалаг, Арга зүйч Л.Батболор, дүүргийн номын санчид оролцож харилцан туршлага судлаж хамтарч ажиллалаа. Нийт 55 сургуулийн номын санч оролцов. 2012.10.26 Сургуулийн номын санчдын өдрийг угтаж СБД-ийн номын санчидтай хамтран “ЕБС-ийн номын сангийн өнөөгийн байдал цаашдын чиг хандлага” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. “ЕБС-ийн номын сангийн өнөөгийн байдал цаашдын чиг хандлага”” сэдвээр номын санчдын дунд эссэ бичлэгийн уралдааныг зарлаж 19 эссээ ирүүлснээс хамгийн шилдэг бичсэн 5 эссэ бичлэгийг шалгаруулж номын санчдыг шагнаж урамшуулсан. Тус сургалтаар ЕБС-ийн номын санчдын тулгамдсан асуудлын талаар баримт бичиг боловсруулж номын санчдын гарын үсэг бүхий материалыг нэгтэн БШУЯ-ны сайд Л.Гантөмөрт өгсөн. 2012.11.19-22 “ЕБС-ийн номын сан нь сургуулийн мэдээллийн төв болох нь“ сэдэвт анхан шатны мэдлэг олгох модуль сургалтанд Хөвсгөл аймгийн сургуулийн 13 номын санчид хамрагдан оролцлоо. - Модул сургалтын сургалт явуулах эрхийн гэрчилгээний хугацаа дууссан тул дахин хугацааг 1 жилээр сунгуулах ажлаар СБД-ийн халамж үйлчилгээний хэлтэс, Халамж үйлчилгээний газарт сургалтын тайлан болон сургалтын хугацаа сунгуулах хүсэлт албан бичиг зэргийг төлөвлөн дээрх газруудад хүргэж өгч сургалтын гэрчилгээг сунгуулсан болно.	
		<u>Аргачлал боловсруулах</u>: Төлөвлөгөө Биелэлт Гүйцэтгэл 8 10 125% - Сургалтын хөтөлбөр	

2.2.3	Аргачлал боловсруулах	- “Хэн хамгийн сайн ном сурталчлах вэ?” уралдааны удирдамж - ЕБС-ийн номын сангийн тулгамдсан асуудал эрдэм шинжилгээний өгүүлэл - Номын сангийн хөмрөгийг хүлээлцэх - Номын сангийн хөмрөгийн номыг цэвэрлэх зөвлөмж - ХНО-ны 2003-2011 оны үйл ажиллагааны стастистик үзүүлэлт - Олон улсын номын санчдын өдөрт зохион байгуулах хэлэлцүүлгийн удирдамж - “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” шалгаруулах сүлд модны наадмын удирдамж - “ЕБС-ийн номын сангийн өнөөгийн байдал” - Чанга уншлага явуулах хөтөлбөр - Гэр бүлийн уншлагыг зохион байгуулах хөтөлбөр зэрэг материалыг боловсрууллаа. Номзүйч С.Тунгалаг: - “Хүүхдийн уншлагыг удирдахуй” нэртэй ном бэлтгэн хэвлэлтэнд өгөхөд бэлэн болгоод байна. - СДС-ийн 3 оюутны дадлага хийх хуваарь гаргаж, дадлагыг удирдан ажилласан. - Чанга уншлага явуулах аргачлал, хөтөлбөрийг боловсруулж гаргасан. - Хэлтсийн эрхлэгч нартай номын санчийн ёс зүйн дүрмийг хэлэлцэж, саналаа солилцон зарим өөрчлөлтийг тусгуулсан. Байгууллагын цахим хуудсыг мэдээ мэдээллээр хангах: Байгууллага динамик вебтэй болсонтой холбогдуулан нийт номын санчид цахим хуудсанд мэдээ, мэдээлэлээр хангах үүрэг хүлээснээр энэ жилийн хувьд байгууллагын вэб хуудасны хувьд нилээд ахиц дэвшил гарсан. Нийт 57 мэдээ мэдээлэл, 94 ширхэг зураг оруулжээ. Үүнээс: Аргазүйч Л.Батболор нийт 10, ном зүйч С.Тунгалаг 8, Ном бүрдүүлэгч Ч.Энхтуяа 2, Сэргээн засварлагч Б.Эрдэнэцэцэг 1, Номын санч Энхчимэг вэбд танхимуудын 94 ширхэг зураг, 7 мэдээлэл, Боловсрол хөгжлийн уншлагын танхим 10, Япон танхим -5, Тайвань танхим -3, Мөрөөдөл танхим-4, Герман танхим-7 материал тус тус оруулжээ.	

2.2.4	Шинэ номын мэдээ гаргах	Шинэ номын мэдээ Төлөвлөгөө: Гүйцэтгэл: Биелэлт: 4 4 100% Бүх уншлагын танхимуудын 336 шинэ номоор мэдээллийг гаргаж уншигчдын хүртээл болсон. Номзүйн жагсаалт, мэдээллийн талаар: Нийт 14 жагсаалт гаргасан. Төлөвлөгөө: Гүйцэтгэл: Биелэлт: 12 14 116% - “ХНО хэвлэлийн хуудаснаа” ном зүйн жагсаалтанд 2012 онд хэвлэгдсэн 7 материалыг бүрэн эхээр нь, - Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн зохиолч, орчуулагч Г. Акимын уран бүтээлийн номзүй, - 2009-2011 онуудад хамгийн их уншигдсан номын жагсаалт, - Олон улсын хүүхдийн номын баярт зориулсан номзүй, - Монголд хэвлэгдэж буй хүүхдийн тогтмол хэвлэлийн жагсаалт, - Д. Цэдэвийн уран бүтээлийн номзүй, - То ван судлалын номзүй, - Соёлын гавьяат зүтгэлтэн Ч. Дагвадоржийн 70 насны ойд зориулсан уран бүтээлийн ном зүй, - Монгол ардын үлгэрийн номзүйн жагсаалт нийт 14 жагсаалт гаргасан. Номзүйн лавлагаа мэдээллийн хүрээнд: Бүх шинжлэх ухааны төрлөөр 1595 лавлагааг амаар болон бичгээр өгсөн. Төлөвлөгөө: Гүйцэтгэл: Биелэлт: 1560 1595 102% MCS компаний тухай, Бага ангийн сурагчдын дуу хөгжмийн хичээлийн програм, Англи улсын тухай, Царцааны тухай, Төрийн алба хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох тухай, 100000 айлыг орон сууцжуулах үндэсний хөтөлбөрийг бүрэн эхээр, Ятга хөгжмийн үүсэл, Оросын холбооны улсын гавьяат сэтгүүлч Людмилад Хүүхдийн номын ордны тухай материал болон өөрийн хэвлүүлсэн материалыг нь шүүж цахим шуудангаар 5 удаа, Хүүхэд хэрхэн үрчилж авах тухай, Бүх нийтийн витаминжуулалтын аяны тухай,	

		"Вагнер Ази" компаний тухай, ТББ байгуулах үе шат, Ц. Дамдинсүрэнгийн түүвэр зохиолын эмхтгэгчийн овог, Айраг хэрхэн хийх арга, "Нарны бүжиг", "Мөөгхөн", "Хүүхэд нас", "Хүүхэд бидний найз" хүүхдийн 5 дуу зэрэг лавлагааг 1-3 хоног хайлт хийж бичгээр өгсөн. ХНО-ны үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах талаар: Телевизээр 18, радиод 6, сонинд 10 мэдээллийг : Захирал Д.Оюунбилэг: Телевизэд 6 удаа, сонинд 2 удаа, радиод 4 удаа Хэлтсийн эрхлэгч С.Тунгалаг: Телевизэд 2, радиод 1, сонинд 3 удаа Ном бүрдүүлэгч Ч.Энхтуяа: Телевизэд 1 удаа Номын санч Б.Баярмаа : Телевизэд 2 удаа, Номын санч Н.Адъяа :Телевизэд 2 удаа Хэлтсийн эрхлэгч Г.Дарьсүрэн Телевизэд 4 удаа, радиод 1 , сонинд 5 удаа Хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг Телевизэд 1 удаа Ш.Оюунцэцэг: сонинд 1 удаа тус тус мэдээлэл ярилцлага өгсөн байна. Мөн хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг Улаанбаатар Такси компаны 10 таксинд байгууллагын сурталчилгааны материалыг байршуулах талаар ярилцаж, сурталчилгааны материалын эхийг бэлтгүүлэн 3 сарын турш сурталчилгааг байрлуулав. ХНО-ы үйл ажиллагаатай дэлгэрэнгүй танилцсан байгууллага хамт олон: 2012 онд ХНО -ы үйл ажиллагаатай ЕБ-ын 12 сургуулийн хамт олон /зуун билэг, Гёте, 93, 24, 2, 1 р ангийн 60 орчим, 97 сургуулийн 5 ангийн сурагчид, 14-р сургуулийн 5-р ангийн 18 сурагч,багш эцэг эхчүүдэд, Сурагчдын холбооны сурагчид, Номч, Улаанбаатар дунд сур, Орчлон сур, 56 р цэцэрлэг, 74-р цэцэрлэг, 18 р цэцэрлэг,9 р цэцэрлэг, 25-р цэцэрлэгийн эцэг эх, "Кингс-Кидс" сургуулийн 16 сурагчид, "Галакси" сургуулийн 16 сурагч ирж / МУБИС-ын Дүрслэг Урлаг Технологийн сургуулийн II курсын 11оюутан багшийн хамт, Дархан –Уул аймгийн сургуулийн номын санчид, Япон танхимтай Япон улсын элчин сайдын яамны хоёрдугаар нарийн бичгийн дарга Аояма Дайсүкэ, Буриад улсын номын санчид, "Хөгжлийг инженерчлэх" клубын гишүүд, Дархан Уул аймаг, Эрдэнэтийн номын санчид, 6-р сарын 6-нд Дорнод аймгийн 14 номын санчид тус тус танилцсан байна.	
2.2.5	"Номын санч" сэтгүүлд 3-аас доошгүй материал	Номын санч сэтгүүлд материал бэлтгэх: Арга зүйч Л.Батболор "Номын санч" сэтгүүлийн 2012 оны дугаар бүрт ХНО-ны мэдээ мэдээллийг нэгтгэж бэлтгэсэн. Үүнд: ЕБС-ийн номын сангийн өнөөгийн байдал, Номын сангаас хүүхэдтэй ажиллах ажил, ХНО-ны	

	нийтлүүлэх	танхимаас зохион явуулсан соёл олон нийтийн ажлууд, номын санчдын бэлтгэсэн онолын материалууд болно. Номзүйч С.Тунгалаг хүүхдийн ном уншлагын талаар 4 , захирал Д.Оюунбилэг 1, ном бүрдүүлэгч Ч.Энхтуяа 1 материал, номын санч Д.Алимаа Тайвань уншлагын танхимд зохиогдсон ажлын талаарх мэдээллийг тус тус бэлдэж нийтлүүлсэн байна. Мөн захирал Д.Оюунбилэг “Соёл ба хөгжил” сэдэвт Соёлын чуулганы эмхтгэлд материал өгч нийтлүүлжээ.	
Бүтээгдэхүүний анги 3. Ном хэвлэлийн хадгалалт хамгаалалт			
3.1	Ном хэвлэл сэлбэн засах	Сэргээн засварлагч Ном: Нийт 550 ширхэг ном , баримтыг сэргээн засварлаж үдэв . Төлөвлөгөө Гүйцэтгэл Хувь 550 ш 553 ш 100,5% Сонин: 79 хавтас сонинг нэг бүрчлэн шигшин, үдэж хавтаслав. Мөн даалимбаар шил наав. Төлөвлөгөө Гүйцэтгэл Хувь 78 хавтас 81 хавтас 103,8%	
3.2	Ном хэвлэл сэргээн засварлах, сэлбэн засах тухай сургалт зохион байгуулах	Ном хэвлэлийг сэргээн засварлах сургалт арга зүйн хүрээнд: 01.25-нд “Ном сэргээн засварлах” талаар онол практик хосолсон сургалт явуулав. 06.14-нд Төв аймгийн “Хүмүүнлэг цогцолбор” сургуулийн ахлах номын санчид ном, цаас сэргээн засварлах, ариутгах хичээл заав. 11.22-нд Хөвсгөл аймгийн ЕБС-н номын санч нарт цаас сэргээн засварлах, цавуу цаасны бүтэцийн талаар сургалт явуулав.	
Бүтээгдэхүүний анги 4 : Удирдлагын үйлчилгээ			
4.1 Хүний нөөцийн удирдлагын үйлчилгээ			
4.1.1	Байгууллагын дотоод журам бусад хууль эрхийн актын	• Байгууллагын ажилтан албан хаагч бүрийн үр дүнгийн гэрээг дүгнэж, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн хийв.	

	хэрэгжилтэнд хяналт тавих	• Байгууллагын “Ур чадварын нэмэгдэл олгох журам”-ын дагуу нийт 28 ажилтан албан хаагчдад 1-6 сарын хугацаатай ур чадварын нэмэгдэл олгов. • “ХНО-ны номын санчийн ёс зүйн дүрэм”-ийг боловсруулан батлуулахаар удирдлагад өгсөн. • Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газрын албан тоотын дагуу байгууллагын хүрээнд мөрдөх “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”–ыг боловсруулан гаргаж 2-р сараас эхлэн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих 5 хүний бүрэлдэхүүнтэй “Дотоод хяналт шалгалтын комисс”-ыг томилон ажиллуулж байна. Комиссын гишүүдийн тайланг үндэслэн Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтэст “Байгууллагын дотоод хяналт”-ын чиглэлээр эхний хагас жилд хийсэн ажлын тайланг нэгтгэн электрон шуудангаар болон албан бичгээр хүргүүлсэн. • 2012 оны 6-р сарын 25-нд 2013 оны төсвийн төслийн “Нэмэлт буюу цар хүрээ нь өргөжсөн үйл ажиллагаа” бүлэгт байгууллагын төсвийн төлөвлөлтөнд тусгах саналыг ХНО-д шаардлагатай байгаа орон тоо, ХНО-д шаардагдаж буй зарим зардлын талаар яаманд хүргүүлсэн. • 2012 оны 8 дугаар сарын 28-нд Засгийн Газрын мөрийн хөтөлбөрт оруулах саналыг “Хүүхдийн Номын Ордны барилга байгууламжийн тухай” санал боловсруулан ССАЖЯ-нд хүргүүлэв. • Хүүхдийн уншлагыг дэмжих ажлын хүрээнд ССАЖЯ-нд үйл ажиллагааны төсөл боловсруулан оруулж “Их мэдэх” танхим болон ном сэлбэн засах үйл ажиллагаанд шаардлагатай материалуудыг бүрдүүллээ. Мөн ном уншлагын талаар гарын авлага, номын хавчуургыг хэвлүүлээд байна.	
4.1.2	Байгууллагын дотоод журам бусад хууль эрхийн актын хэрэгжилтэнд хяналт тавих	• УИХ, Засгийн Газрын шийдвэр, БСШУ, ССАЖ-ын сайдын тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж ирлээ. • Захирал Д.Оюунбилэг МХЕГ- ын гэрээт байцаагчийн үүрэгт ажлын дагуу Герман улсад сэргээн засварлагдаад ирсэн “үйсэн дээрх бичиг” хүлээн авч акт үйлдэн зохих бичиг баримтыг бүрдүүлэн актыг ССАЖЯ, МУҮНС,МХЕГ-дад хүргүүлэв. Мөн МУҮНС-ийн “Ховор үнэт номын фондын тооллогын хяналтын байцаагчаар ажиллаж байна.	

		• Захирал Д.Оюунбилэг БШУ-ны сайдын тушаалаар их дээд сургуулиудыг атестачлах комисст орж ажиллаж 2 удаа нийт 9 сургууль дээр ажилласан. • БСШУ-ны сайдын тушаалаар арга зүйч Л.Батболор их дээд сургуулиуд дээр Боловсролын магадлан итгэмжлэлийн шинжээчээр ажилласан. • 2012 оны Хүний нөөцийн болон цалингийн нэмэгдлийн шинэчилсэн судалгааг гарган Соёл Урлагийн Хорооны Хүний нөөцийн мэргэжилтэнд өгсөн. Мөн байгууллагын Хүний нөөцийн шинэчилсэн судалгааг гаргасан.	
4.2 Ажилтан, албан хаагчдыг сургалт			
4.2.1	Номын санчдын мэргэжлийг дээшлүүлэх давтан сургалтанд хамруулах	СУИС-ийн СДС-ийн номын санч - Мэдээллийн ажилтаны Баклаварын зэргийн зайны сургалтанд Мөрөөдөл танхимын номын санч Батцэцэг, Япон танхимын номын санч Арьяа нар суралцаж төгслөө -1-р сарын 9нөөс 13-нд Хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг, номзүйч С.Тунгалаг нар “Монгол Улс, эдийн засаг, соёл-2012”, 1-р сарын 19-20нд “Удирдлагын менежмент, соёл урлагийн байгууллагын санхүүжилт, худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалт” сэдэвт сургалт семинар\ Байгууллагын зардлаар \ -2-р сарын 1-3 нд Сангийн яамны худалдан авах ажиллагааны бодлогын газраас зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” 3 хоногийн сургалтанд номзүйч С.Тунгалаг, аргазүйч Л.Батболор, Компьютерийн инженер Б.Сүхбаатар нар оролцсон. \ Байгууллагын зардлаар \ -2-р сарын 1- нд хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг байгууллагын номын санчдын хүрээнд “Мэдээллийн сан дахь мэдээллийн чанарыг сайжруулах, өргөтгөх нь“ сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаарх зарим мэдээллийг ажилтнуудад өгч, хэлэлцүүлгийн материалыг номын санчиддаа электрон шуудангаар илгээв. -5-р сарын 1-11нд ном сэргээн засварлагч Б.Эрдэнэцэцэг Гёте институт, ЮНЕСКО хамтарсан “Цаасан баримт өвийг хадгалж, хамгаалах” сэдэвт IV сургалт, 10.22-10-31нд сэдэвт V дах удаагийн сургалтанд хамрагдлаа. -5-р сарын 10- нд Хотын төв номын сандНомын сангийн консерциумаас зохион байгуулсан каталогч Энэрэлийн “Koha” программийн хичээлд ном ангилагч С.Адъяаням, номзүйч С.Тунгалаг, каталогч Б.Хажидмаа, каталогч Д.Жавзанпагма нар оролцлоо.	

		-12.06-нд Чанга уншлага хэрхэн явуулах талаар найруулагч Алтан-Очир багшийн лекцэнд нийт ажилтнууд хамрагдлаа. -2012. 12.15-нд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хүүхдийн төлөө үндэсний төвөөс Төрийн ордонд зохион байгуулсан “Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын шинэчлэлд хамдаа“ үндэсний чуулганд нийт 12 ажилтан оролцсон. - 2012- 12.12-14 “Соёл ба Хөгжил” чуулганд захирал Д.Оюунбилэг ,инженер Б.Сүхбаатар, номын санч Энхчимэг нар оролцов. Чуулганы үеэр зохион байгуулагдсан үзэсгэлэнд байгууллагаа танилцуулсан болно.	
4.2.2	Ажилтан албан хаагчдыг баг болгон ажиллуулж үйлчилгээний соёлын талаар лекц бэлдүүлэх, ярилцлага зохион байгуулах,бусад ажлууд	Энэ онд манай хамт олон дараах ажлуудыг хамтын хүчээр хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. 2012 оны 2 сард “Бэлгийн дээд бэлэг-ном “ 3 өдрийн номын худалдаа гаргах арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд нийт 12 хэвлэлийн газар, ном борлуулагчид оролцсон болно. 2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 156 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2012 оны 9 дугаар сарын 15-нд болсон “Олуулаа уншъя” өдөрлөгт оролцож байгууллагаа сурталчилав. Энэ ажлын хүрээнд 1,4 тэрбум төгрөгний өртөг бүхий номыг улсын хэмжээний 21 аймаг 326 сум, 614 сургууль,734 сургуульд савлаж, хувиарлах ажлыг хийж гүйцэтгэсэн. 3. 5 дугаар сарын 11 –нд болсон “Хүүхдийн байгууллагуудыг сурталчлах өдөр”, 5 дугаар сарын 16-нд БСШУЯ-ны “Нээлттэй хаалганы өдөр”-өөр талбай дээр үзэсгэлэн зохион байгуулж байгууллага сурталчлах үйл ажиллагаанд оролцов. 4. ССАЖЯ-наас 12 сард сумдын номын сангийн фондын баяжилтанд зориулан хувиарлагдсан 14520 номыг савлаж хүлээлгэн өгөх ажлыг хийж гүйцэтгэсэн. 5. Жил бүр уламжлал болон номын санчдын дунд зохион байгуулагддаг спортын тэмцээнд 1 дүгээр байранд шалгарч цом, мөнгөн шагналаар шагнуулсан.	
Бүтээгдэхүүний анги 5. Гадаад харилцаа			
5.1	Гадаад харилцааг өргөтгөн Олон улсын номын сангийн холбооны үйл ажиллагаанд	Олон улсын номын сангийн холбоотой байнга хамтран ажиллаж гишүүнчлэлийн татвараа цаг тухайд нь өгч, хэрэгцээт материалуудаа авч өөрсдийн үйл ажиллагаанд ашиглаж байна. Энэ оны хувьд захирал	

	идэвхитэй оролцох	Д.Оюунбилэг Финлянд улсад болсон Олон улсын номын санчдын хуралд оролцсон болно.	
5.2	Гадаад харилцааг тогтмолжуулах	Энэ онд хамтран ажиллаж байсан байгууллагуудтайгаа нягт хамтран ажиллаж ирлээ. -Гетё институтээс Герман уншлагын танхимд уншигчдад зориулан Wi-Fi орчин бүрдүүлэх боломжоор хanган Rooter, нэг бүр нь 1699000 төгрөгний үнэ бүхий 2 компьютер хүлээлгэн өглөө. Танхимын үйл ажиллагааны хүрээнд Гёте-Институтийн төлөөлөгчийн газартай утсаар болон электрон шуудангаар харилцаж ирлээ. - Чехийн элчин сайдын яамтай хамтран Чехийн номын үзэсгэлэнг 3-27-ноос 4 дүгээр сарын 15 дуустал зохион байгуулсан. - Монголд Япон улсаас сууж буй ЭСЯ-ны 2 дугаар нарийн бичгийн дарга Аояма Дайсүкэ Хүүхдийн номын ордны Япон танхимын үйл ажиллагаатай танилцсан. - Японы хүүхдийн номын сангийн төлөөлөгчид ирж ХНО-той танилцаж Монголын хүүхдийн зохиолчидтой уулзалт хийсэн. - 5 сарын 11 нд Америкийн номын сангийн ажилтан Энэрэл, David Kadas нар уулзан бага насны хүүхдийг номонд татах талаар санал бодлоо солилцлоо. - 2012 оны 4 сарын 26 нд Оросын Буриадын 8 номын санчид ХНО- ны үйл ажиллагаатай танилцсан. - Өвөрмонголын өөртөө засах орны зохиолч Ш. Өлзийбагана ХНО-ны уншигчдад зориулан “Хөх хадны цуурай” номоо бэлэглэж тус номын сангийн үйл ажиллагаатай танилцав.	
5.3	Монголд ажиллаж байгаа олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах	• Азийн сангийн “Ном хөтөлбөр”-өөс Швейцарь номын уншлагын танхим болон “Их мэдэх танхим”-д 13 фактурын 239 ш ном 47 ш аудио визуал материал бүрдүүлсэн нийт үнэ нь 3718400төгрөг • Японы Фукуй аймгийн Ротари клубээс 35 мянган төгрөгний 5 ном • Гетё институтээс 12 сая төгрөгний 205 ном • Тайваний Үндэсний номын сангаас 2 сая 923 мянга 630 төгрөгний 216 ном тус тус хандивласан. .	
5.4	Солонгосын Хүүхдийн номын сангуудтай холбоо тогтоон	Койка байгууллагын сайн дурын ажилтан Юу-Ми вэбийн бүтцэнд орох нэмэлтүүдийг хэрхэн бүрдүүлэх, оруулах арга ажиллагааны талаар	

	хамтран ажиллах	сургалтыг явуулсан.	
Бүтээгдэхүүний анги 6. Санхүүгийн үйлчилгээ			
6.1	Төсвийг оновчтой зарцуулах	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулан ажилласан.Төсвийн орлого, зарлагын мэдээг дараа сарын 2-ны дотор төрийн санд өгч, байгууллагын өөрийн орлогыг төрийн сангийн дансанд тушааж байна.	
6.2	Санхүүгийн тайлан мэдээ гаргах	Нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам зааврыг чанд мөрдөн санхүүгийн тайлан мэдээг тухай бүр нь холбогдох газруудад нь өгч ажиллаж байна. 2012 оны татварын тайланг татварын байцаагчид өгч хянуулсан.	
6.3	Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах	Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, эд хөрөнгийн тооллого тооцоо бүртгэлийг үнэн зөв хийж ирлээ. Байгууллага Койка байгууллагаас төслөөр өгсөн 37 ширхэг 23 сая 966 мянга 504 төгрөгний техник хэрэгслэл, БСШУЯ-наас хөрөнгө оруулалтаар ирсэн 16 ширхэг 10 сая төгрөгний компьютер, номын тавиур, хувилагч машин , төсвөөр болон бэлэг хандиваар орж ирсэн ном техник тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөндөө тусган ажиллаж байна. Тооллого 2012 оны 12 сарын 5-наас 20-ны хооронд 14 хоног “Номын төлбөрийг барагдуулах комисс” ажиллаж номын төлбөрийг барагдуулж номыг ижил номоор нь эсвэл фондод хэрэгцээтэй байгаа номоор төлүүллээ. СТӨ-ний болон байгууллагын эд хогшлын тооллогыг 3 удаа хийж зохих журмын дагуу хүлээлцэн эд хариуцагчийн картыг бичин гарын үсэг зуруулан баталгаажуулсан.	
Бүтээгдэхүүний анги 7 : Номын сангийн орчныг сайжруулах үйлчилгээ			
7.1	Урсгал засвар хийх	Энэ онд захирлын өрөөнд урсгал засвар хийж тохижуулсан. Мөн танхимуудын гэрэлтүүлэгийн асуудлыг анхааран цаг тухайд нь сольж шинэчлэж байлаа. “Их мэдэх” танхимын паарыг байгууллагаас, өлгүүрийн хэсгийн паарыг СТӨ-ны хөрөнгөөр шинэчилсэн.	
7.2	Зөөлөн эдлэл худалдаж авах	Хөдөлмөр хөнгөвчлөх, аюулгүй байдал , ариун цэвэр хангах зорилгоор сар бүр ариун цэврийн материалуудыг ажилтан албан хаагчдад олгож байна. “Их мэдэх” танхим болон захирлын өрөөний хөшиг шинэчилсэн. 1 давхарт	

		LED телевизор, ажилчдад 6 ус буцалгагч шинээр авч өгсөн.	
		Бүтээгдэхүүний анги 8. Нийгмийн асуудал	
8.1	Нийгмийн халамж үйлчилгээ	• Зун хамт олноороо Завхан аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудаар явж амарсан. • Хүүхдийн номын ордны нийт 32 ажилтан, албан хаагчид 2012 онд нэг хүний /330000/ төгрөгөөр бодож Урамшуулалд нийт 10560000 / арван сая таван зуун жаран мянган төгрөг/ олгосон. • Ур чадварын нэмэгдлийг нийт 1-6 сарын хугацаанд 28 ажилтанд олгосон байна. • 22 хүнд 1730546 төгрөгөөр шагнаж урамшуулсан. \ ЕБС-ийн 7 номын санч, Юми, Үндэсний бичиг үсгийн баяраар 8 хүн \ • Байгууллагын дотоод журмын дагуу 17 хүнд 1824020 төгрөгний буцалтгүй тэтгэмж олгосон байна. • Энэ жил номын санч И.Пүрэвбат Булган аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр хэлтсийн эрхлэгч Г.Дарьсүрэн хүүхдийн зохиолчдын “Пэн” төвийн мөнгөн шагналаар шагнагдсан. • Цагаан сар, ахмадын өдрүүдээр номын сангийн ахмад ажилтнуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр байгууллагын хүүхдүүдэд бэлэг өгсөн.	

АРХАНГАЙ АЙМГИЙН НОМЫН САН МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН 2012 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2012-12-21 ДУГААР № ЭРДЭНЭБУЛГАН СУМ.

Аймгийн нийтийн номын сан-Ìýäýýëëèéí ò°â нь аймгийн нийт иргэдийг мэдээлэлээр хангах,соёлын үнэт зүйл ном хэвлэлийг хадаглах,хамгаалах,уламжилт өв соёлыг түгээн дэлгэрүүлэх,сурталчилах,дэлхий нийтийн жишигт нийцсэн орчин үеийн мэдээллийн технилоготой “Олон нийтийн мэдээллийн төв”-ийг бий болгож орчин үеийн үйлчилгээг ашиглан мэдээллийн чөлөөт урсгалыг хөгжүүлэн хүн амын ном,хэвлэл, мэдээллийн хангамжийг сайжруулахыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.Дээрхи эрхэм зорилгоо биелүүлэхээр дараах ажлуудыг 2012 онд хийж гүйцэтгэлээ.Үүнд:

1.Уншлага үйлчилгээний талаар

Номын сан –мэдээллийн төв нь насанд хүрэгчдийн болон хүүхдийн óíøëàãûí òàíõèì,зөөврийн эомын сангийн үйлчилгээ,гэрээр ном олгох үйлчилгээ болон бусад үйлчилгээний хэлбэрүүдээр нийт 8100 ирэгсдэд 61688 ширхэг ном хэвлэлээр үйлчилсэн байна. Үүнээс зөөврийн номын сангийн үйлчилгээг Аймгийн ЗДТГ,Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Прокурор, Мэргэжлийн Хяналтын Газар, Хүүхдийн Төлөө Хэлтэс, Татварын газар, Боловсрол Соёлын Газар, аймгийн Иргэдийн хурал, Монгол банк зэрэг байгууллагуудад хүргэн нийт 101 уншигч шинээр бүртгэж 251 ирэгсэдэд,6542 ширхэг номоор,гэрээр ном олгох үйлчилгээгээр Эрдэнэбулган сумын 1,2-р багийн 120 ирэгсдэд 1560 ширхэг ном,хэвлэл,мэдээллээр тус тус үйлчилжээ. Насанд хүрэгчдийн уншлагын танхим, хүүхдийн номын сангийн уншлагын танхимуудад ирсэн шинэ номыг электрон каталогит бүртгэсэн бөгөөд номны бар кодыг наан,үсэг дараалын болон төрөл ангийн катологит байрлууллаа.Санал хүсэлтийн дэвтэрийг тогтмол ажлуулж уншигчдын хүсэлтийг хүлээн авч боломжтой зарим асуудлыг цаг тухай бүрт нь шийдвэрлэж ирлээ.

2.Номын мэдээлэл суртчилгааны талаар

Уншлагын танхим,болон зохион байгуулж буй Соёл олон түмний ажлуудтай холбогдуулан шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг тогтмол гаргасан байна.Үүнд: *Шинэ ном *, *Үлгэрийн ертөнцөөр аялацгаая*, *Монгол ардын аман зохиолын дээжээс*, *Гадаадын хүүхдийн сонгодог зохиолын дээжис* цуврал, *Дэлхийн хүүхдийн шилмэл зохиолын эрдэнэсийн сан* цуврал ном, *Сурах бичиг, сургалтын гарын авлага* зэрэг шинэ номын болон сэдэвчилсэн үзэсгэлэнг давтагдсан тоогоор 23 удаа гаргаж уншигчдад хүргэлээ.

Зая бандида Лувсанпринлэйн мэлмий гийсний 370 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан *ИХ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭГЧ ЛУВСАНПРИНЛЭЙ* эрдэм шинжилгээний бага хурлын үеэр Зая бандида гэгээнтнүүдийн түүх, намтар, бүтээл туурвилыг харуулсан судар ном, орчин үеийн түүхэн роман, Заяын Гэсэрийн 4 боть номоор мөн*Үндэсний бичиг үсгийн баяр*-ын арга хэмжээний үеэр өндөр

настан Т. Ядамсүрэнгийн *Дорно дахины анагаах ухаан, шашин, түүх*-ийн холбогдолтой хуучны болон ховор номын үзэсгэлэн, ахмад багш С. Очирпүрэв, М. Нацаг-Юм нарын хувийн ховор ном, судраас дээжлэн нийт 60 гаруй ном, судраар үзэсгэлэн гаргаж нийтэд сурталчиллаа. Аймгийн *Тамир* телевизийн *Номын ертөнц* нэвтрүүлэгт *Миний номын сан* буланг шинээр нээн ажиллуулж 7 зочин урьж оролцуулсан. *Номын ертөнц* нэвтрүүлгийн *Шинэ номын танилцуулга* булангаар 7 удаа шинэ номын сурталчилгаа хийсэн.*Архангайн толь* сонинд *Номын ертөнц* булан шинээр нээж 8 номын тайлбар хийж иргэд, уншигчдад сурталчилсан.

3.Соёл Олон Түмний Ажлын талаар

Номын сан мэдээллийн төв нь дараах СОТА-уудыг зохион байгууллаа.Үүнд:
Маргааш шиг хайр богино өгүүллэгийн уралдаан

2-р сарын 14-ны өдөр. Гэгээн хайрын өдөрт зориулж *Маргааш шиг хайр* сэдэвт хайрын богино өгүүллэгийн уралдааныг зохион байгууллаа. Оюутан, сурагчдын чөлөөт цагийг оюунлаг өнгөрүүлэх, тэдний уран зохиолын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх, бичих ур чадварыг сайжруулах зорилгоор Эрдэнэбулган сумын ЕБС-иудын 11-р ангийн сурагчид, МСҮТ, их, дээд сургуулийн оюутнуудын дунд 2 үе шаттайгаар зохион байгууллаа.

Уралдаанд нийт 25 авьяаслаг оролцогч бичлэг, сэтгэлгээний ур чадвараараа өрсөлдсөнөөс тэргүүн байрыг БС-ийн 4а ангийн оюутан А. Нанжид *Гаргүй хүүхэлдэй* өгүүллэгээр, дэд байрыг БС-ийн 3а ангийн оюутан Н. Донжалам *Маргааш шиг хайр*, өгүүллэгээр, 3-р байрыг БС-ийн 4а ангийн оюутан А. Уранцэцэг *Өглөө бүхэнд хайр байгаасай* өгүүллэгээр тус бүр ээлж өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнагдсан ба шүүгчдээр СГЗ, зохиолч сэтгүүлч Г. Жамц, аймгийн Утга Зохиолын Нэгдлийн дарга Г. Ганбаатар, УБИС-ийн харьяа Архангай аймаг дахь Багшийн сургуулийн монгол хэл-уран зохиолын багш Д.Чимэгбаатар нар ажилласан байна.Мөн тэмцээнд оролцсон нийт оролцогч, хөгжөөн дэмжигчдийг цаасан сарнай, шоколадаар урамшууллаа.
Ном-Миний найз 2 сарын аян
МБСГ-ийн харьяа Архангай аймаг дахь Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв, Номын сан-Мэдээллийн төвтэй хамтран жил бүр уламжлал болгон зохион байгууллаг аяны хүрээнд дараах 3 ажлыг зохион байгууллаа. Үүнд:
А. *ЧИНГИСИЙН МОНГОЛ* яруу найргийн тэмцээн
3-р сарын 21-ний өдөр. Оюутан, сурагчидын эх оронч үзлийг төлөвшүүлэх, уран зохиолын сэтгэлгээг хөгжүүлэх, бичих ур чадварыг сайжруулах зорилгоор 3-р сарын 21-ний өдөр буюу Дэлхийн яруу найргийн өдөр, Ардын уран зохиолч Дэндэвийн Пүрэвдоржийн *Чингис* шүлэг зохиогдсоны 50 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан оюутан, сурагчдын дунд *Чингисийн Монгол* сэдвийн яруу найргийн тэмцээнийг зохион явуулсан бөгөөд Тэргүүн байрыг БС-ийн 4а ангийн оюутан О. Нямдорж *Эх орон таныгаа би дуулна* шүлгээр, дэд байрыг БС-ийн 4а ангийн оюутан Д. Мөнхцэцэг *Үнэн…үнэн* шүлгээр, 3-р байрыг БС-ийн 3а ангийн оюутан О. Төгсжаргал *Чингисийн Монгол* шүлгээр, тусгай байрыг

Хүмүүн цогцолбор III сургуулийн 11б ангийн сурагч Ш. Ганзориг *Монгол хэл бичиг мину* шүлгээр тус бүр ээлж өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнагдлаа.
Тэмцээний шүүгчээр зохиолч, сэтгүүлч С. Бараанасан, аймгийн БСГ-ын мэргэжилтэн Н. Энхгэрэл, БС-ийн 4-р курсийн оюутан, яруу найрагч А. Нанжид нар ажиллаа.
Б. "ХАНГАЙН ХӨГЖИЛ БИДНЭЭС" сэдэвт дэвжээ тэмцээн
4-р сарын 6-ны өдөр. Оюутан, сурагчдын авьяас чадварыг нээх, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх, орон нутгийн хөгжилд тэдний дуу хоолойг нэгтгэх зорилгоор их, дээд сургууль, МСҮТ-ийн оюутнууд, ЕБС-ийн ахлах бүлгийн сурагчдын дунд *Хангайн хөгжил биднээс* дэвжээ тэмцээнийг зохион байгууллаа.
Тэргүүн байрыг МБСГ-ийн харьяа Архангай аймаг дахь Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн *MGL* баг, дэд байрыг *Хүмүүн* цогцолбор III сургуулийн *Ирээдүй* баг, гутгаар байрыг мөн МСҮТ-ийн *Ирээдүйн ээзд* баг ээлж өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналаар шагнагдлаа. Оролцогч багууд мэндчилгээ, чөлөөт сэтгэлгээ, бидний хит, гэрийн даалгавар, асуулт хариулт зэрэг төрлүүдээр өрсөлдөж, эх нутгийн хөгжлийн төлөө дуу хоолой, үзэл бодлоо илэрхийлж байлаа.
В. "Үндэсний бичиг үсгийн баяр"-ын арга хэмжээ
5-р сарын 5-ны өдөр. Халхын Зая бандида С. Лувсанпринлэйн мэлмий гийсний 370 жилийн ойг 2012 онд тэмдэглэхтэй холбогдуулан энэ жилийн "Монголын үндэсний бичиг үсгийн баяр"-ыг их хутагтын нэрэмжит болгон *Монгол бичгийн үндэсний хөтөлбөр*-ийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд үндэсний хэл, бичиг үсэг, түүнтэй холбоотой уламжлалт соёлын өвийг судлах, сурталчилах, хойч үедээ заах өвлүүлэх, хэл, бичиг үсгийн үнэт дурсгалуудтай танилцуулах, хадгалж хамгаалах, уншигчдын хүртээл болгох, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд аймгийн хэмжээнд зохион байгууллаа.

Энэхүү арга хэмжээний үеэр *Зөв сайхан бичигтэн* , *Уран бичлэг*, *Түргэн уншлага*-ын уралдаануудыг зохион байгууллаа. Мөн МУЭ-ийн шагналт, зураач Ц. Бямбажавын *Мөнх тэнгэрийн бичиг* сэдэвт уран бичлэгийн бүтээлийн үзэсгэлэн, аймгийн Музейн монгол үндэсний уламжлалт бичгийн хэрэгсэл, өндөр настан Т. Ядамсүрэнгийн *Дорно дахины анагаах ухаан, шашин, түүх*-ийн холбогдолтой хуучны болон ховор номын үзэсгэлэн, ахмад багш С. Очирпүрэв, М. Нацаг-Юм нарын хувийн ховор ном, судрын дээжээс үзэсгэлэн гаргаж нийтэд сурталчиллаа.

Нийт 118 оролцогчоос *Зөв сайхан бичигтэн*-ний төрөлд 51, *Уран бичлэг*-ийн төрөлд 22, *Түргэн уншлага*-ын төрөлд 45 оролцогч мэдлэг, ур чадвараа сорьсноос насанд хүрэгчдын *Зөв сайхан бичигтэн* уралдаанд тэргүүн байрыг Хайрхан сумын багш О. Чулуунбаатар, дэд байрыг *Хүмүүн* I сургуулийн багш Л. Буяннэмэх , гутгаар байрыг БС-ийн МХУЗ-ын 1а ангийн оюутан Д. Баасанжав, ЕБС-ийн сурагчдын дундах *Зөв сайхан бичигтэн* уралдаанд тэргүүн байрыг *Хүмүүн* I сургуулийн сурагч Чанцалдулам, дэд байрыг *Хүмүүн* I сургуулийн сурагч Наранцэцэг, гутгаар байрыг Хайрхан сумын 12 жилийн сургалттай дунд сургуулийн 9-р ангийн сурагч Т. Жавзанпагма , насанд хүрэгчдын *Түргэн уншлага*-ын уралдаанд тэргүүн байрыг ХТХ-ийн мэргэжилтэн Д. Орхонтуул , дэд байрыг *Хүмүүн* I сургуулийн багш Ц. Булган, ЕБС-ийн сурагчдын дундах *Түргэн уншлага*-ын уралдаан тэргүүн байрыг Хүмүүн III сургуулийн 8а ангийн сурагч П.

Амгаланбаяр, дэд байрыг Хайрхан сумын 9-р ангийн сурагч Б. Мандахзаяа, 3-р байрыг Хайрхан сумын дунд сургуулийн 9-р ангийн сурагч Х. Энхзул, нийтийн дундах *Уран бичлэг*-ийн уралдаанд тэргүүн байрыг Эрдэнэмандал сумын багш Золбаяр, дэд байрыг БС-ийн 4-р курсийн оюутан Г. Ганжавхлан, гутгаар байрыг *Хүмүүн* III сургуулийн 9-р ангийн сурагч Б. Мөнхчимэг нар тус бүр ээлж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Түргэн уншлага, *Зөв сайхан бичигтэн* уралдааны шүүгчдийн бүрэлдэхүүнд БСГ-ийн мэргэжилтэн Н. Энхгэрэл, МУЭ-ийн шагналт, зураач Ц. Бямбажав, БС-ийн монгол хэл-уран зохиолын багш Нэргүйцэцэг, Мөнхтуяа, *Хүмүүн* цогцолбор III сургуулийн багш Уранчимэг нар ажиллалаа. *Уран бичлэг*-ийн уралдааны шүүгчээр МУЭ-ийн шагналт, зураач Ц. Бямбажав, аймгийн Зураач Урчуудын Холбооны тэргүүн Ё. Батбаяр нар ажиллалаа.

АХА тэмцээн.

4-р сарын 30-ны өдөр. МУ-ын Засгийн газрын *Цагдаа - Олон нийтийн хамтын ажиллагаа* хөтөлбөрийг сурталчилах 2 сарын аяны хүрээнд аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн Газрын нийт бие бүрэлдэхүүний дунд архи, тамхины холбогдолтой болон хууль эрх зүйн асуулт, хариултын уралдаант цэнгээнт АХА тэмцээнийг Хэв журмын тасагтай хамтран зохион байгуулав. Тэмцээнд нийт 60 гаруй цагдаагийн ажилтан, албан хаагчид оролцож оюуны чадвараа сорьсноос 1-р байрыг Эрүүгийн төлөөлөгч Галбадрах, 2-р байрыг Хэв журмын тасгийн ахлах байцаагч Мөнх-Очир, 3-р байрыг Эрүүгийн төлөөлөгч Н. Бадамдоо нар тус бүр ээлж дурсамж, цалингийн 20%,10%, 5%-ийн нэмэгдлээр шагнагдлаа. дэд дарга Цагдаагийн газрын Алдрын танхимд зохион байгуулав.

АХА тэмцээн.5-р сарын 19-ны өдөр. ЕБС-ийн бага бүлгийн төгсөлтийн баярт зориулан *Хүмүүн* цогцолбор I сургуулийн Даваасүрэн багштай 5б ангийн 38 хүүхдийг хамруулсан танин мэдэхүйн АХА тэмцээнийг зохион байгууллаа. Тэдний нас, сэтгэхүйн онцлогт тохирсон 221 танин мэдэхүй, IQ сорилын асуулт, хариулт бэлтгэн зохион байгууллаа. АХА тэмцээний ялагчаар тус ангийн сурагч Ж. Анхбаяр тодорч бусдыгаа манлайллаа.

Тэмцээнийг *Хүмүүн* цогцолбор I сургуулийн биеийн тамирын зааланд зохион байгуулав.

АХА тэмцээн.

6-р сарын 1-ний өдөр. Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан 11-14 насны хүүхдүүдийг хамарсан *Өсвөр насны өртөө*-г хариуцан ажиллаж тэдний нас, 333 асуулт шинээр боловсруулж, уралдаант АХА тэмцээнийг зохион байгуулан, 100 гаруй хүүхдийг хамруулж, хүүхэд бүрийг урамшуулсан ба тэмцээнд эхний 3 байр эзлүүлж бэлэг, номоор шагналаа.

9-р сарын 16-ний өдөр. МУ-ын Ерөнхийлөгчийн *Номын баярын өдөр

тэмдэглэх тухай* 158 зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутагт *Номын баярын өдөр*-ийг Дэмид жанжны талбайд зохион байгууллаа.Номын баярын өдрөөр номын үзэсгэлэн, номын худалдаа, номын хандив, номын солилцоо зэрэг олон ажлуудыг зохион байгуулж,”Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэг”-ний болзол хангасан уншигчид,ЕБС-н номын санчдыг шагнаж урамшуулсан ба ЕБС,Цэцэрлэг,Сумын номын сангуудад номын хандивыг хүргэлээ.Мөн БСШУЯ-наас өгсөн явууллын номын сангийн фургон машинаар Ихтамир ,Цэнхэр

,Эрдэнэмандал сумуудад “Номын баярын өдөр*-ийг тэмдэглэх арга хэмжээг зохион байгуулан явуулын номын сангийн үйлчилгээг хүргэлээ.Жилдээ 13 удаа СГМС-ны ажлуудыг зохион байгуулан явуулж нийт 4000 гаруй уншигчид хамрагдсан байна.

4.Номын фондын баяжилт хадгалалт
хамгаалалтын талаар.

2011 онд захиалсан тогтмол хэвлэлийн үдэж хавтаслан сонин сэтгүүлийн дансанд бүртгэн үндсэн фондод авлаа.Ажиллагсдын ажил дүгнэх үзүүлэлт ,үр дүнгийн гэрээнд тусгагдсаны дагуу нийт урагдаж гэмтсэн 3500 ширхэг номонд сэлбэн засалт хийж уншлага үйлчилгээнд ашиглаж байна. Мөн аймгийн төв номын санд 6500,0 төгрөгийн 535 ширхэг ном хэвлэлээр,сумын номын сангийн фондыг 1920 ширхэг 33,593,766 төгрөгийн,ЕБС-н номын санд 1164 ширхэг 19,637,150 төгрөгийн,Цэцэрлэгүүдэд 570 ширхэг 7,213,960 төгрөгийн номоор тустус баяжилт хийсэн байна.Батцэнгэл,Эрдэнэмандал,Төвшрүүлэх,Цэцэрлэг,Чулуут сумуудад тус бүр 6 ширээ,12 сандал 846,000 төгрөгийн нийт 4,230,000 төгрөгийн 30 ширээ,60 сандал,бүх суманд 18 ширхэг 11,070,00 төгрөгийн,аймгийн нийтийн номын санд 10 ширхэг 7,380,00 комьютерийг хүргүүллээ.

Шинээр авсан номуудыг техник ажиллагааг хийн дансанд авч электрон катологит оруулан уншигчдын хүртээл болголоо. Номын сангийн нэг бүрчилсэн бүртгэлийн 16 ширхэг дансыг шинээр хуулж дууссан байна.

Сумдын болон ЕБС-н номын санчдын сургалт семинарыг 2012 оны 04-р сарын 19-20 ны өдрүүдэд “Орчин үеийн номын сангийн үйлчилгээ,түүний хүртээмж” сэдэвт сургалтыг зохион байгуулан Улаанбаатар хотоос Соёл Урлагийн Хорооны номын сангийн асуудал хариуцсан мэргэжилэн Б.Ариунаа,Монголын номын сангийн консорциумын гүйцэтгэх захирал Л.Гантулга нарыг оролцуулан хичээл заалгасан бөгөөд нийт 40 гаруй номын санчдыг оролцуулсан байна.

Бусад зүйлийн талаар.

Номын сангийн ажиллагсдын 2011 оны үр дүнгийн гэрээг дүгнэж зарим ажилтанг шагнаж урамшууллаа.Мөн ажиллагсдын ажил дүгнэх үзүүлэлтийн дагуу ажлыг нь дүгнэж 1135.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалин, 1000,0 мянган төгрөгийн тэтгэмж урамшуулал олгосон байна. 2012 оны 04-р сарын 09-11-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо Монгол Улсын Үндэсний номын сан дээр зохион байгуулагдсан *Номын сан-мэдээллийн технологи* сэдэвт мэргэжил дээшлүүлэх 3 хоногийн сургалтанд номын санч А.Ундармааг,Хүүхдийн Төлөө Төв дээр зохион явуулсан “Гэр бүлийн харилцаа”сэдэвт сургалтанд А.Ундармаа,Ё.Алтантариа,Л.Өсөхбаяр нарыг,ССАЖЯ-с зохион явуулсан “Цахим номын сангийн үйлчилгээ” сургалтанд Цэцэрлэг,Булган сумын соёлын төвийн номын санчдыг,мөн “Соёл ба хөгжил”олон улсын соёлын чуулганд оролцлоо. Өдөр бүр номын сангийн орчмын 50 метр дахь газрыг тогтмол цэвэрлэн Бүх нийтийн хог цэвэрлэгээ,хотын өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд хуваариласан газруудыг цэвэрлэн хогийг хаясан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04-р сарын 14-ны өдрийн 63 тоот зарлигийг хэрэгжүүлэх “Бүх нийтээр мод тарих өдөр”-өөр Бөхбилэгтийн саданд 6 шар хуайс мод тарилаа. БСШУЯ-наас сумдын соёлын төвийн номын санд хувиарласан комьютерийг сумын номын сангуудад хүргүүллээ.Мөн оны сүүлээр ССАЖЯ-наас сумын номын сангуудад

хүргүүлсэн 19 ширхэг 13,531,015 төгрөгийн комьютер,756 ширхэг 15,272,460 төгрөгийн ном Аймгийн төв номын санд нийт 13.816.000 төгрөгийн 80 ширээ,160 сандалыг хүлээн аваад байна.

Номын сангийн үйл ажиллагаатай холбогдолтой эрх зүйн баримт бичгүүдийг хулдаасан хэвлэлээр хийн уншигчдад сурталчилж байгаа бөгөөд "Нээлттэй хаалга"-ны өдрийг тогтмол хийж ирсэн. Номын сан – мэдээллийн төвийн барилга баригдаж байгаа ба ,шинээр барих Хүүхдийн номын ордон-сургалт мэдээллэлийн төвийн зургийн төсвийн ажил дуусаж тендер зарлагдаж барилгын суурийн ажил хийгдсэн байна. Батлагдсан төсвийг хуваарийн дагуу зарцуулан байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахад шаардлагатай зардалд зарцуулж өр авлагагүй ажиллаа.

БАЯН- ӨЛГИЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2012 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Эрхэм зорилго:

Аймгийн нийтийн номын сан нь хүн төрөлхтний оюуны үнэт өв болсон ном, хэвлэлийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх, номын сангийн үйлчилгээг орчин үеийн дэвшилтэт арга хэлбэрээр баяжуулж, уншигч бүрт хэрэгцээ шаардлагыг нь хангахуйц хүссэн мэдээллийг хүргэх зорилготой ажиллаж байна.

Монгол Улсын соёлын тухай хууль, төрөөс баримтлах Соёлын бодлого, бусад хууль эрх зүй, Монгол Улсын Засгийн Газар болон Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрүүд, бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ, номын санг хөгжүүлэх стратегийн төлөвлөгөө болон дэвшүүлсэн зорилго зорилтоо биелүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллаж ирлээ.

Удирдлага, бүтэц зохион байгуулалт, дотоод ажил

- Монгол Улсын төр засаг, орон нутгийн төр захиргааны байгууллагаас номын санг хөгжүүлэх талаар гаргасан хууль тогтоомж, эрх зүйн бусад актыг хэрэгжүүлэхэд номын сангийн менежментийн бодлогын хүрээнд үйл ажиллагаагаа өргөжүүлэн хүртээмжтэй явуулж, хүний нөөцийн чадвахийг нэмэгдүүлэх замаар нийгэм хувь хүний хэрэгцээтэй ном хэвлэл мэдээллээр фондоо бүрдүүлэн үйлчилгээ үзүүлж байна.
- Манай номын сангийн шинээр баригдаж байгаа барилга нь 2007 онд эхэлж 2011 онд 300.0 сая төгрөгний санхүүжилт хийгдсэн. Одоогоор тус номын сан нь 70% гүйцэтгэлтэй баригдаж байгаа ба барилга материалын үнэ

нэмэгдсэнтэй холбоотой 225,0 сая төгрөгний төсөв дутуугаас болж зогсонгуй байдалтай тул Аймгийн Засаг даргад албан бичиг оруулж, мөн Сангийн сайд, БСШУ-ны сайд нарт аймгийн Засаг даргаар уламжлуулж албан бичиг явуулсан.

- Байгууллагын дотоод хяналт шинжилгээ үнэлгээг боловсронгуй болгох, ажилчин албан хаагчдын өдөр бүр хийх ажлыг эрчимжүүлэх номын санчдын ажлын норм хэмжээг биелүүлж ажилласан тухай улирал, хагас, бүтэн жилээр хийх хяналт шинжилгээ үнэлгээний төлөвлөгөө боловсруулж, 1,2,3,4 улиралд хийж гүйцэтгэсэн ажилд үнэлгээ өгч ажиллав.

- 2012 онд 106730.3 сая төгрөгний төсөв, аймгийн нөөц хөрөнгөөс 5 000 000 төгрөг авч, бүтэн жилд 111639800 төгрөгний төсөвийг үзүүлэлт бүрээр нь зарцуулсан.
- Удаан хугацаагаар эмчилгээнд явсан, ар гэрийн гашигдалтай ажилчдыг байгууллагын зүгээс анхаарч нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгож байна.
- Номын сангийн MNS 5742:2007 стандартыг хангахгүй байранд тогтмол хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна.
- Энэ жилд номын сангийн фондод 774 ширхэг номыг 4.834.620 төгрөгөөр худалдан авч, 489 ширхэг 4,588,700 төгрөгний номыг хандиваар авч, 46 төрлийн сонин сэтгүүлийг 502,400 төгрөгөөр тус тус захиалан уншуулж байна.
- Номын сангийн дотоод журмыг бүх ажилчдын хурлаар батлан мөрдөж ажиллаж байна.
- Соёл Урлагийн Хорооноос хандивын журмаар өгсөн 5 ширхэг компьютерийг авч, дотоод сүлжээнд холбогдож, LIB 4U программаар уншлагын танхим, гэрээр ном олгох тасаг, үндсэн фондын номыг электрон каталогт нэгэн зэрэг оруулж цаасан каталогийг хамт бичиж, ангиллын дагуу байрлуулж байна.
- Соёл, Спорт, Аялал жуулчлалын яамнаас хөрөнгө оруулалтаар 60 ширхэг уншигчийн ширээ, 120 ширхэг сандал, 20 ширхэг номын тавиурыг авч, уншигчдын ая тухтай байдлыг ханган ажиллаж байна.
- Манай номын сан номын сангийн стандартын дагуу фондонд **86641** ширхэг ном хэвлэлтэй орчин үеийн электрон каталогт орсон дотоод сүлжээнд холбогдсон, нутгийн хүн ам ихтэй төв газраас алслагдсан өвөрмөц хэллэгтэй аймаг тул номын сангийн бүх ажиллах ёстой номын сангийн стандартын дагуу орон тооны жишигт хүрэхгүй байна.

- Иймд манай номын сан ашигалалтанд орох гэж байгаа тул номын сангийн стандартын дагуу ажиллах ёстой 21 хүний орон тоог нэмж өгөхийг хүсэж байна.
- Төвийн болон сумдын номын сангуудын хоорондын ном солилцооны гэрээ байгуулан өөрийн фондонд байхгүй ховор номыг солилцооны журмаар олж, уншигчдын санал хүсэлтийг барагдуулсан.
- Аймгийн хэмжээний арга зүйн төвийн үүрэгээ гүйцэтгэх зорилгоор Алтай, Буянт, Сагсай, Толбо, Цагааннуур, Ногооннуур, Баяннуур, Алтанцөгц, Бугат, Дэлүүн сумдын соелын төвийн номын сан болон сургуулийн номын сангуудад удирдамжийн дагуу газар дээр очиж танилцаж арга зүйн зөвлөлгөө өгсөн.

  Үүнд:
- Алтай сумын номын санч Жанботад «Уншигчидтай ажиллах ажил»,
- Буянт сумын номын санч Аққу, сургуулийн номын санч Цагаанмөөгд нэгдсэн бүртгэлийн хөтлөлтийн тухай,
- Толбо сумын санч Ботагүл, сургуулийн номын санч Нуржанд «Номын сан ном зүйн ангилал»
- Ногооннуур сумын номын санч Ермекболд «өдөр тутмын бүртгэлийн хөтлөлтийн тухай»
- Цагааннуур сумын номын санч Амандах-д «Номын сангийн тайлан тооцоо»

Цагааннуур номын санд дээр нь очиж ажиллагаатай танилцаж нь

сумын газар үйл байгаа

- Алтанцөгц сумын И.Саулешт салбар нүүдлийн номын санг яаж ажиллуулах тухай арга зүйн зөвлөлгөө өгч ажиллав.

Алтанцөгц сумын номынсангийн уншлагынзаал

- Манай аймгаас төрөн гарсан БНМАУ-ын баатар Икей, Хөдөлмөрийн баатар Ж.Серикбай, М.Ахаан, А.Зайтин, Х.Солтан зэрэг алдартангуудын намтар ном зүй хийж уншигчдад хүртээл болгосон.
- Сонин сэтгүүлээс «Хууль таны мэдлэгт » сэдэвтэй картын сан,
- «Ногоочдад зөвлөлгөө» сэдэвтэй картын сан,
- «Хүүхдийн хүмүүжил» нэртэй картын санг тус тус бичэж уншигчдын хүртээл болгосон.
- Монгол улсын стандарт «Архив номын сангийн өв соёлыг хадгалж хамгаалах стандарт «MNS-11799-2007-г» хэрэгжүүлэн үндсэн фондын 20%, ГНО танхимын 50% , уншлагын танхимын 40% номыг сэргээн засварлаж, 6000 ширхэг номыг сэлбэн зассан.
- Фондын эргэлтийг сайжруулах зорилгоор Алтанцөгц, Алтай, Баяннуур, Дэлүүн, Улаанхус, Цэнгэл, Сагсай сумдад салбар, нүүдлийн номын санг тогтмол ажиллуулж номыг улиралд нэг удаа сольж ажиллуулж байна.

2.**Уншлага үйлчилгээ.**

Энэ жилд 3859 уншигчдад шинээр карт нээж, 18870 ирэгсэдэд 50550 ш ном олгон уншуулж, аймгийн албан байгууллага, сургууль, сумдад салбар болон нүүдлийн номын санг тогтмол ажиллуулж, бага насны хүүхдүүдийг ном унших сонирхолтой болгох зорилгоор янз бүрийн зурагт хуудас, дүрийн тоглолт, бага хурал, бод сэтгэ, үлгэрийн ертөнцөөр аялцгаая нэртэй бяцхан ном хийж сурталчилснаар сурагчдыг номын сангийн байнгын уншигч болгосон байна.

- Өөрийн орлого болох 50 000 төгрөгийг жигд биелүүлсэн.

- Насанд хүрэгчдийн уншлагын танхимаас 1023 уншигчдад шинээр карт нээж, 4499 ирэгсдэд 10003 ширхэг ном сонин сэтгүүлийг уншуулсан.
- Гэрээр ном олгох танхимаас 894 уншигчдад карт нээж, 5956 ирэгсэдэд 11006 ширхэг ном хэвлэл уншуулж байна.
- Хүүхдийн танхимаас 1942 уншигчдад карт нээж, 8415 ирэгсэдэд соёлтой чанартай үйлчилж, 28728 ширхэг ном хэвлэлийг танхимаар, салбар, нүүдэлээр уншуулсан байна.
- Халамж, Татварын хэлтэс, Хэвлэл мэдээллийн газар, ШШГА, МХГ, Цагуур зэрэг байгууллагуудад нүүдлийн номын сан ажиллуулж байна.
- Хүүхдийн сонирхлын дагуу 2 төрлийн дугуйланг хүүхдүүдийн дунд явуулж байна.

Үүнд:

- «Ном бол миний үнэнч нөхөр мөн» сэдэвт бяцхан ном хийж сурах дугуйлан.
- «Уран зураг миний бүтээл» сэдэвт дугуйлангуудыг байнга явуулж байна.
- Гэрээр ном олгох танхим, уншлагын танхимуудын номын санч нар лавлагааны дэвтэр, татгалзлын карт ажиллуулж, уншигчдын захиалсан лавласан ном хэвлэлийг цаг алдалгүй олж өгч байна.
- Соёлын өвийг хамгаалах хуулийг хэрэгжүүлхэд үнэт ховор номын бүртгэлд 8 номыг бүртгэв.

3.Соёл олон түмний ажил

Уншигчдыг сурч боловсроход нь ном хэвлэл, мэдээ мэдээллийг түгээх, түргэн шуурхай, шинэлэг хэлбэрээр сурталчлах зорилгоор бүх номын санчдын бүтээгдхүүний гэрээнд тусгагдсан ажлуудыг хийлээ.

Үүнд:

- Аймгийн хэмжээнд зохион байгуулж явуулсан «Нээлттэй хаалганы» өдөрлөгт 260ш номоор үзэсгэлэн гаргаж, номын сангаас эхний 5 сард явуулсан соел олон түмний ажилуудын плакат гаргаж сурталчилсан.
- Наурызын баярт зориулж «Казак үндэсний ёс заншил» нэртэй эвхмэл самбар гарган уншигчдад сурталчилав.
- Багш нарын баярыг тохиолдуулан «Ұстаз ұлағаты» нэртэй уншигчдын бага хурал явуулав.
- «Жас әдебиетшілер жаңғыры» нэртэй уран уншлагын тэмцээн явуулсан.
- 1-р бага сургуулийн Ахсауле багштай 4а ангийн сурагчдын дунд «Казак ертегілері» үлгэрийн номноос тойм яриа.

- 2-р ахлах сургуулийн 5б ангийн сурагчдын дунд «Уран уншигч» сэдэвт шүлгийн уралдаан.

- 4-р ахлах сургуулийн 5-р ангиудын дунд «Хан мен үш ұры» номноос чанга уншлага.
- ОУЭ-ийн баярт зориулж баярыг угтаж 6-р ахлах сургуулийн 7-р ангиудын дунд «Анам менің аяулым» сэдэвт уншигч сурагчдын өөрөө зохиосон шүлгийн уран уншлагын уралдаан.
- 4-р ахлах сургуулийн 5а ангийн сурагчид уншигчдын дунд «Казак ертегілері» номноос «Тентек балапан» сэдэвт дүрийн тоглолт хийж сонирхуулав.
- 2-р ахлах сургуулийн 7-р ангиудын дунд «Монголын ХУЗ-ын дээж 1ботї номноос тойм яриа хийв.

Түүхт ой баярын өдөрүүдэд номын үзэсгэлэн байнга гаргаж, шинэ номын үзэсгэлэн, сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж ажилласан.

- Шинэ номын үзэсгэлэн 40 ш номоор
- Усан луу жилийн Цагаан сарын баярт зориулж «Монголын зан үйлс» сэдэвт номын үзэсгэлэн,
- ОУЭ-ийн баярыг угтаж «Анам менің аяулым» сэдэвт номын үзэсгэлэн,
- Наурызын баярыг угтаж «Армысың ару көктем» сэдэвт номын үзэсгэлэн,
- Инээдмийн өдөрт зориулж «Күлкі көңіл ашар» сэдэвт номын үзэсгэлэн,
- Ургацын баярт зориулж «Ургацын далай» сэдэвт 35 ш номоор тустус номын сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж ажилласан.
- Бага ангийн сурагчдын сонирхолын дагуу «Англи хэл бидний хэрэглээ» сэдэвт номын үзэсгэлэн,
- Хүүхдийн баярыг угтаж 11-р цэцэрлэгийн хүүхдүүдийг дунд амьтадын зурагтай номноос «Амьтад бидний алжал тайлах ертөнц мөн» сэдвэт номын үзэсгэлэн,
- Бага ангийн сурагчдын дунд хаврын шалгалтыг угтаж «IQ-гээ хөгжүүлье» сэдэвт үзэсгэлэнгүүдийг тус тус гаргаж уншигчдад сонирхуулав.
- Хүүхдийн баярыг тохиолдуулан 11-р цэцэрлэгийн багш Алмагүлтэй хамтран хүүхдүүдийн дунд бүжгийн уралдаан явуулж, үзэсгэлэн гаргаж эцэг эхэд нь сонирхуулав.
- Шинэ хичээлийн жилд зориулан «Шинэ хичээлийн жилд амжилт хүсье» сэдэвт чөлөөт сонголтын үзэсгэлэн.
- Ерөнхийлөгчийн 158-р зарлигийн 2-р ахлах сургуулийн талбайд «Номтой нөхөрлөё» сэдэвт үзэсгэлэнгийг сурагчидад сурталчилав.
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 09-р сарын 12-ны өдрийн А-16 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн дунд ном бэлэглэж, хандивлах, солилцох, ном унших аяныг хэрэгжүүлэх зоилгоор төлөвлөгөө боловсруулан захиралд баталгаажуулан ажиллав.

Үүнд:

- Номын сангийн бүх номын санчид жишиг сум Увс аймгийн Ховд сумын соёлын төвийн болон сургуулийн номын санд газар дээр нь очиж танилцаж, туршлага солилцож, Өлгийн зарим зохиолчдын номнуудыг бэлэглэх ажлыг зохион байгуулав.

- 4-р ахлах суруулийн номын санчтай хамтарч сурагчдын дунд «Ойлан тап» сэдэвтэй уралдаан зохион байгуулж, шинэ номын үзэсгэлэн гаргаж уншигчдад сурталчилав.

- «Тэргүүний уншигч- Нацагдорж тэмдэгтэн»-ийг бага, өсвөр насныханы дунд сүүлийн 2 жилийн турш ном уншсан ба болзолыг хангасан уншигчдыг Уншлагын танхим, ГНОТанхим, Хүүхдийн танхимуудаас тус тус шалгаруулав.

  Үүнд: Уншлагын танхимаас ХИС-ын Баян-Өлгий аймаг дахь салбар сургуулийн оюутан Камесхан Алтынай, 3-р ахлах сургуулийн 11-р ангийн сурагч Мауазыр овогтой Ардах.

Гэрээр ном олгох танхимаас ХИС-ын Баян-Өлгий аймаг дахь салбар сургуулийн оюутан Топаан овогтой Бижамал.

Хүүхдийн танхимаас Серикбол овогтой Еркежан, Бектемир овогтой Марита нар тус тус шалгаруулав.

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны 09-р сарын 12-ны өдрийн А-16 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн дунд ном бэлэглэж, хандивлах, солилцох, ном унших аяныг хэрэгжүүлэх зорилгоор ард иргэд, байгууллагуудын дунд уралдаан зарлаж, аймгийн бүх 42 албан байгууллагуудад албан тоот-ыг удирдамжтай хамт хүргүүлж, радио, FM-ээр сурталчилав.

Үүнд:

- Хувьдаа хамгийн олон шилдэг номтой, хувийн номын сантай айл өрх шалгаруулсан.



1-р байрыг 5-р багийн иргэн О.Хабсатар,

2-р байрыг 3-р багийн иргэн М. Амантай багш,

3-р байрыг имам М.Азатханнар тус тус байр эзлэж, «Өргөмжлөл» мөнгөн шагналаар шагнав.

- «Ном дор мөргөмүү» сэдэвтэй шүлгийн уралдааныг бүх албан байгууллага болон сургуулиудын дунд 2 шатаар явуулав.

Насанд хүрэгчдийн дунд 1-р байрыг Цагуурын бичиг хэргийн ажилтан Цэцгээ,

2-р байрыг уншигч Р.Әбижат, 3-р байрыг МСҮТ-ын багш Инабат,

сурагчдын дунд 1-р ахлах сургуулийн сурагч Толхын нар тус тус байр эзлэж, «Өргөмжлөл» мөнгөн шагналаар шагнан урамшуулав.

- «Аха» тэмцээнийг зохиолчдын намтар, уран бүтээлээр 10-11-р ангийн сурагчдын дунд сургууль тус бүрээр 2-3 сурагчыг хамруулж зохион байгуулав.
- Тэмцээнд «Бастама» ахлах сургуулийн 10-р ангийн сурагч Бекберди овогтой Алтантанаа түрүүлж «Өргөмжлөл» мөнгөн шагнал авсан.
- Хамгийн ховор, олдоц муутай эрэлт хэрэгцээтэй номтой хувь хүнийг сурталчилж шагнасан.
- 1-р байрыг «Капитрон» банкны ажилтан Асхар эзлэж, «Өргөмжлөл» үнэ бүхий зүйлээр шагнан урамшуулав.

- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 09-р сарын 12-ны өдрийн А-16 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн дунд ном бэлэглэж, хандивлах, солилцох, ном унших аяны дүгнэлтийг 10-р сарын 19-ний өдөр аймгийн төв номын санд шинэ номын үзэсгэлэн гаргаж, ном

солилцож, бэлэглэж, дээрхи уралдаанд идвэх зүтгэл гаргасан уншигчдад шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулав.

5. Цаашид хийх ажил

- Номын сангийн MNS 5742:2007 стандартын дагуу дутуу байгаа 7 орон тоог нэмж өгөхийг хүсэж холбогдох газарт албан бичиг явуулсан боловч биелэлээ олоогүй.
- Интернэтэд холбогдох хүчин чадалтай 5 ширхэг компьютер, принтер, скайнер канон зэрэг орчин үеийн тоног төхөөрөмж шаардлагатай байна.
- Мөн энэ жил шинэ байранд орох тул стандартыг хангасан номын тавиур, соронзон хаалга, үзэсгэлэнгийн тавиур, номын санчдын ажлын ширээ г.м тоног төхөөрөмжүүд шаардлагатай байна.
- Төвийн номын санчид УБ-хотод очиж сургалт семинард оролцох, сургалтын зардлыг жилийн төсөвт суулгаж өгөх тухай санал болгож байна.

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2012 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2012 оны 12 дугаар сарын 15 Дуурсах

1.Номын сангийн үйлчилгээ

-Лавлагаа арга зүй, ном зүйн ажил

Тайлангийн хугацаанд 2012 онд 225 уншигчдад цахим лавлагааг өгч, цахим программд бүртгэн, 23 уншигчдад цаасан каталог ашиглах талаар, 28 уншигчдад электрон каталог ашиглах талаар заавар зөвлөгөө өгч, орон нутгийн ном зүйн бүртгэлийн 2 дахь хэвлэлд нийт 378 зохиол бүтээлийг хамруулан оршил, хүний нэрийн хэлхээс, бүртгэн мэдээллэх ном зүйн бүртгэл гаргаж, уншигчдаас саналын хайрцагаар номын санчдын ёс зүйтэй холбоотой 8 санал хүсэлт ирснийг удирдлагад танилцуулан холбогдох хүмүүст нь хэлж анхааруулан тухай бүр шийдвэрлэж ажиллалаа.

Номын сан, ном зүйн ангилал өөрчлөгдсөнтэй холбогдуулан 1800 номын цаасан каталогийг шинэчлэн нааж, төрөл анги, үсэг дараалын А-Т хүртэл үсгийн каталогийг каталогт байрлуулан ялгагчуудыг шинээр хийлээ. Ерөнхий боловсролын сургуулиудын 8 багшийн магистр хамгаалсан материалыг хувилан магистрын материалаар лавлагааны фондыг баяжуулж, материалыг хувилахад 18.900 төгрөг зарцууллаа.

Үндэсний номын сангийн 2011 оны 05 сарын 11-ний 132 тоот албан бичиг, аймгийн Иргэдийн хурлын тогтоол, аймгийн Нийтийн номын сангийн захирлын 2012 оны 04 сарын 18-ны дугаар 27 тушаал, орон нутгийн Өмчийн албаны зөвшөөрлийг үндэслэн 4771 ширхэг ном, 97 ширхэг сонин, 2 ширхэг сэтгүүлийг акталж үнэ бууруулан зарж 301800 төгрөг олж, үлдсэн ном, сонинг 2 дах түүхий эд болгон ашигласан.

Удирдамж боловсруулан удирдамжийн дагуу аймгийн төвийн ЕБС-ийн 1,2-р сургууль, Япон сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн номын сангуудын ажил байдалтай танилцаж, арга зүйн зөвлөгөө өгч хяналт үнэлгээ шинжилгээ хийн, илтгэх хуудсыг бичин,2012 оны 12 сарын 03-07-ны өдрүүдэд захирал Б.Түвшинчимэг, мэдээллийн ажилтан М.Мөнхдалай, номын санч Ц.Сарантуяа, номын санч Б.Должин, Фондоч Я.Гэрэлтуяа, үйлчлэгч А.Уранчимэг нар хамтран Өлзийт сумын сум, сургуулийн номын санд ажиллаа. Үүнд номын сангийн фондын зохион байгуулалт, данс бүртгэлийг шинэчлэн, сумын номын сангийн 1200 ном, сургуулийн номын сангийн 1500 номыг дахин дансалж, данслагдаагүй номуудыг номын сан ном зүйн шинэ ангиллаар ангилж, цаашид хийх ажлын заавар зөвлөгөөг өгч ажилласан.

Фондын ажил

Засгийн Газрын 140-р тогтоолоор жил бүр шалгаруулдаг “Шилдэг ном-2011”-ээр шалгарсан 90 ширхэг 565.688 төгрөгний ном, БСШУЯ, Хүүхдийн номын ордон, Азийн сан, Нээлттэй нийгэм форумаас бэлгээр аймаг, сумын нийтийн номын сан, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт 160 нэр төрлийн 5491 ширхэг, 71.068.555 төгрөгийн ном, Соёл урлаг хөгжүүлэх сангийн төсвөөр 19 сумын номын санд 14.469.930 төгрөгийн 29 нэр төрлийн 684 ширхэг номоор сумдын номын сангийн фондыг баяжуулж, номыг дансанд бичин техник ажиллагааг хийн электрон каталогт оруулж, тасаг нэгжүүдэд хуваарилан уншигчдад үйлчилж байна.

Номын сангийн номын фондыг худалдаагаар 414 ширхэг, 6.592.000 төгрөгний номоор, бэлэг хандиваар 313 ширхэг 3.993.398 төгрөгний ном, хэвлэл, цахим материалаар 4 удаа бүрдүүлж, ангилалтын дагуу тавиурт байрлуулж, улирал бүр 8 нэр төрлийн сонин сэтгүүлийг захиалж, 408.000 төгрөг зарцуулж уншигчдад чөлөөт сонголтоор үйлчилгээ явуулсан.

Фонднoос түр шилжүүлгээр нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхим, гэрээр ном олгох тасгаар 3029 номоор үйлчилж, буцааж аван фондонд байрлуулан, номын санд шинээр ирсэн уран зохиол, хүүхдийн зохиол, лавлагааны болон бусад салбарын номоор шинэ номын мэдээ товхимол 4 удаа гаргалаа.

Номын сан хоорондын ном солилцооны гэрээг МСҮТ, “Номгон”, “Эрдэм”, “Номундалай” ахлах сургуулиудын номын сангуудтай гэрээ хийж явуулын номын сангаар 4 удаа 30 номоор үйлчилжээ.

Фондын номын ээлжит тооллогыг аймгийн Нийтийн номын сангийн захирлын 2012 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн дугаар 11 тушаалаар тооллогын комиссыг томилж тооллогын комиссын дарга ном зүйч Б.Түвшинчимэг, гишүүд фондоч Я.Гэрэлтуяа нар 4-5-р саруудад хийж, дутсан номын өр авлагыг барагдууллаа.

Номын фонд, гэрээр ном олгох тасаг, “Их мэдэх” хүүхдийн уншлагын танхимаас ном сэргээн засварлах лаборатор, ном сэргээн засварлах цүнхний тусламжтайгаар 3300 номыг сэргээн засварлаж, “Хэн намайг ийм болгов”, “Хэн намайг усанд оруулав” үзэсгэлэнг 3 удаа 66 урагдаж гэмтсэн номоор гаргаж, фондын хуучин дансыг шинэчилсэн данстай тулгах ажлыг эхлүүлж, номын сангийн шинэчилсэн монгол номын 18 данс, Орос, Англи номын 2, нийт 20 дансыг тэмдэг дарж гарын үсгээр баталгаажууллаа.

Ховор 55 номоор музей байгуулж, бүртгэл мэдээллийн санд Монгол ганжуур, монгол данжуур, монголын бурхан шашны урлаг 2 боть нийт 4 ном бүртгэв.

Номын фонд, гэрээр ном олгох тасаг, Хүүхдийн уншлагын танхимаас шинэ номын үзэсгэлэнг 8 удаа 213 ном, эрүүл мэнд гоо сайхан, бизнес эдийн засаг, Монгол бичгийн хишиг өдөр, Хүүхэд жаргалант ирээдүй, Хичээлийн шинэ жил, Монгол үндэсний утга соёлын өв, сэдэвчилсэн үзэсгэлэнг 8 удаа 269 номоор гаргаж нийт 837 хүнд сурталчлав.

Уншигчдын эрэлт хэрэгцээг судалж, татгалзлын бүртгэлд 35 номыг бүртгэн татгалзлыг шинэ ном авах захиалганд оруулснаар 15 нэр төрлийн номоор уншигчдын эрэлт хэрэгцээг хангасан. 2012 оны сонин хэвлэлийг сар бүр нэгжлэн үдэж хавтаслан нэгбүрчилсэн бүртгэлд бүртгэн, фондонд байрлууллаа.

Электрон каталогт 12000 ном оруулахаас 11220 ном оруулж, бар код, формуляр, цаасан каталогийг хэвлэн, оруулсан номуудын бар кодыг нэг бүрчилсэн бүртгэлээ.

Уншигчдад үйлчлэх үйлчилгээ

Байнгын 3800 уншигчдад цахим үнэмлэх нээхээс 4031 уншигчдад цахим үнэмлэх нээж, ирцээр 20000 уншигчдад үйлчлэхээс 29025 уншигчдад үйлчилж, 55000 ном олгохоос 53685 ном олгож, уншигчдын төлөвлөгөө 97,6 - 105,1 хувиар биелэгдэж, "Их мэдэх" хүүхдийн уншлагын танхим, нийтийн уншлагын танхимаас 400 уншигчдад электрон үйлчилгээгээр үйлчлэхээс 415 уншигчдад үйлчилж,электрон үйлчилгээнд Цэргийн 339-р анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, ЕБС-ийн сурагчид, МСҮТ-ийн оюутнууд идэвхтэй үйлчлүүлж, хүүхдийн уншлагын танхимд ашиглагдаж байгаа 2ш компьютерт 237ш цахим номыг суулган цахим үйлчилгээгээр уншигчдад үйлчиллээ.



Уншигчдад үйлчилсэн график

Соёл олон түмний ажил: Тайлангийн хугацаанд 12 соёл танин мэдэхүйн ажил зохион байгуулж, нийт 1250 хүнийг хамруулжээ. Үүнд: Ч.Лхамсүрэнгийн нэрэмжит "Хүрэн морь" яруу найргийн наадмыг "Нийгмийн хөгжлийн хэлтэс" Утга зохиолын нэгдэл, АННС, Баянхонгор таймс, Хөгжлийн төв ТҮ-10 зэрэг байгууллага хамтран "Хонгор нутгийн яруу найрагчдын дунд зохион явууллаа. Яруу найргийн

наадамд 70 гаруй яруу найрагчид хурд авъяасаа уралдуулж 1-5 байр эзэлж “Хүрэл цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдаж “Нийгмийн хөгжлийн хэлтэс, АННС 50000 төгрөгөөр нийт шагналын санд 247500 төгрөгөөр ивээн тэтгэж явууллаа.

Ч. Лхамсүрэнгийн Хүрэн морь” яруу найргийн наадмын оролцогчид

“Хүрэн морь” яруу найргийн наадмын тэргүүн байрны шагналтнууд

ЕБС, МСҮТ-ийн 14-18 насны уншлага үйлчилгээнд идэвхтэй оролцдог уншигчдыг БСШУ-ны сайдын 2006 оны 6 сарын 8-ны өдрийн 211-р тушаалын “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” шалгаруулах болзлын дагуу 7 сурагчийг 10 үзүүлэлтээр шалгаруулллаа.

Сурган хүмүүжүүлэх ухааны доктор, Гавьяат багш Ш.Чимгээгийн нэрэмжит 2012 оны “Ном эрдэм” 13 дахь удаагийн аяны нээлтийн ажиллагааг 1 сарын 11-ны өдөр зохион байгуулж, болзлыг шинээр боловсруулан 19 сумын сургууль, цэцэрлэгүүд, аймгийн төвийн ЕБС, Их дээд сургууль, цэцэрлэгүүдэд тараан, аяны үйл ажиллагааг 3 сарын турш зохион байгуулан явууллаа. Ном эрдэм аяны оролцогчид өмнөх оныхоос 10% -иар /4180/ өссөн байна. “Номын зууч” явуулын номын сангийн журам, шалгаруулах болзолыг боловсруулан, үйлчилгээг төрийн болон төрийн бус байгуулага, багийн төвүүдээр графкийн дагуу 58 байгуулагын 1304 ажилчин, албан хаагчдад 2466 номоор явуулын номын сангийн үйлчилгээг хүргэлээ.

Аяны хугацаанд шинээр “Номын зууч” бүлгийн явуулын номын сангийн санал сэтгэгдэлийн дэвтэр аялуулж 41 байгууллагын саналыг бичүүллээ. Аяны материалыг 4 сарын 10-15 хооронд хүлээн авч шалгуур үзүүлэлтийн дагуу шилдэгүүдээ шалгаруулан, “Ном эрдэм” аяны тайлан, “Номын зууч” бүлгийн тайланг нэгтгэн,хаалтын ажиллагааг 5 сард зохион байгуулж 450 гаруй уншигчид оролцож “Номын зууч”, ” Ном уншлага” номинациар шилдэг багш, сурагч, номын санч, сургалтын менежер, шилдэг байгууллага, номын зуучийн хүүхдүүдийг шалгаруулж,шагналыг гардуулсан.

Үндэсний бичиг үсгийн баярт зориулан “Монгол бичиг сайхан бичиг” уралдааныг ЕБС-ийн 7-р ангийнхны дунд зохион явуулж уралдаанд нийт 28 сурагч идэвхтэй оролцсоноос 1-р байрт Номгон ахлах сургуулийн сурагч 7а ангийн сурагч Нандинцэцэг, 2-р байрт Эрдэнэмандал ахлах сургуулийн 7б ангийн сурагч Гэндэн, 3-р байрт Эрдэм ахлах сургуулийн сурагч Э.Санжаа, тусгай байрт Эрдэм ахлах сургуулийн 7д ангийн сурагч Чимиддорж, Номундалай цогцолбор сургуулийн сурагч Б.Анужин нар тус тус шалгарлаа. Шагналын санд 10.000 төгрөг зарцуулсан.

“Номонд мэргэн" дугуйланг ЕБС-ийн 7-р ангийн 14 хүүхэдтэй байгуулж, дугуйлангийн хүүхдүүдэд номын сангийн үйл ажиллагаа, тасаг нэгжийн үйл ажиллагаатай танилцуулан, дугуйлангийн хүүхдүүдийг “Ном эрдэм аяны үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулан, тасгийн ном сэргээн засварлах, электрон каталоит орсон номонд бар код наах, формуляр хийх, цаасан каталогийг хайчлах зэрэг ажлуудыг хийхэд дадлагшуулан ажилласан. Мөн захирал Мянган дугуйлангийн хүүхдүүдэд “Номын ертөнц “ хүүхэд илтгэлийг тавьсан.

“Олон улсын номын баяр”-т зориулж Үлгэрийн их хаан Дани улсын их зохиолч Х.К.Андерсены мэндэлсэний 207 жилийн ойн хүрээнд “Андерсены үлгэрийг хэн сайн мэдэх вэ?” уралдааныг зохион явуулж, Х.К. Андерсены түүх намтар, зохиол бүтээлээр үзэсгэлэн гаргаж 38 уншигчдад суртчиллаа. Тэмцээнд Номгон ахлах сургуулийн “Шинэ үе” баг, Эрдэнэмандал ахлах сургуулийн “Үлгэр амилуулагч” баг, Эрдэм ахлах сургуулийн “Тугалган цэрэг ба ямх охин” багууд 4 үе шаттайгаар амжилттай оролцож Эрдэм ахлах сургуулийн “Тугалган цэрэг ба ямх охин” баг бусдаасаа тэргүүлж дурсгалын зүйлээр шагнууллаа. Шагналын санд 14.500 төгрөг зарцуулсан.

Интернэт мэдээллийн танхим, хүүхдийн уншлагын танхимаас хамтран Номгон ахлах сургуулийн 4е, 4б ангийн нийт 47 сурагчдын дунд “Номын амт зугаацсан уншлага”-ыг 3 үе шаттайгаар зохион явуулж, 4б ангийн Сувд ахлагчтай баг тэргүүлж, дурсгалын зүйлээр шагнууллаа. Шагналын санд 10.000 төгрөг зарцуулсан.

Аймаг орон нутгаас төрөн гарсан зохиолчдын зохиол бүтээлийг сурталчилах, танин мэдүүлэх зорилготой “Алтан агшин” зохиогч уншигчдын уулзалтыг

удирдамж, хөтөлбөрийн хүрээнд зохион явуулж, зохиолчид оролцон хүүхэд багачууд, ард иргэдэд зохиол бүтээлээсээ танилцуулж нийт 350 гаруй уншигчид оролцлоо. Уулзалтын үйл ажиллагаанд МСҮТ-ийн Дорж багштай цахилгааны анги 40000 төгрөгөөр ивээн тэтгэж нийт 55000 төгрөг зарцуулсан.

Жил бүр БСГ-тай хамтран уламжлал болгон зохион байгуулдаг “Үлгэрээ амилуулсан багачууд” олимпиадыг зохион байгуулж, аймгийн төвийн нийт 9 цэцэрлэгийн 27 хүүхэд оролцсоноос 4-р цэцэрлэгийн “Одхон” баг түрүүллээ. Шагналын санд 45.500 төгрөг зарцуулсан.

Хүүхдийн төлөө хэлтэстэй хамтран “Үлгэрч багачууд” уралдааныг удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд зохион байгуулж, Баянцагаан, Шинэжинст, Баянговь, Баян-Өндөр, Баянлиг зэрэг 5 сум, аймгийн төвийн нийт 20 хүүхэд оролцсоноос Шинэжинст сумын н.Сувд-Эрдэнэ 1-р байрт орсон. Шагналын санд 48.000 төгрөг зарцуулсан.

Ш.Нацагдорж, С.Эрдэнийн зохиолын сэдвээр СД-д бэлтгэж 339-р ангийн байлдагч, албан хаагчид, ЕБС-ийн сурагчид, МСҮТ-ийн оюутан, номын санч нарт дэлгэцээр 120 уншигчдад үзүүлж суртчиллаа. Суртчилгааны үеэр 30 хүний бүрэлдэхүүнтэй "Аха" тэмцээн явуулж ялагч цэргийн ангийн дэслэгч Б.Очирхүү Номундалай цогцолбор сургуулийн 10-р ангийн сурагч А.Билгүүн, Б.Пүрэвсүрэн нарт дурсамж, дурсгалын зүйлийг гардуулж өглөө.

Мэдээллийн үйлчилгээ

Байгууллагын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, 16 компьютерийн дотоод сүлжээг тохируулан рэсэнт, депрамэнт, клийнап хийж вирусийн програмийн аптетийг тухай бүр татаж, хэвийн үйл ажиллагааг хангалаа. Компьютеруудын вирусыг 62 удаа устган форматлаж, компьютерийн системийн доголдлыг засан, программ хангамжийн аюулгүй байдлыг хангаж, номын сангийн цогц программыг гадны халдлага, эрсдэлээс хамгаалж электрон каталогт орсон 38651 номыг CD-д хуулж хамгаалсан.

Интернэтийг шилэн кабельд холбох ажил миком компанаас болж хойшлогдсон боловч интернэтийн хурдыг 1mb болгож тохиргоог тохируулж уншигчдад үнэ төлбөргүй үйлчилж, электрон цахим үйлчилгээ, программ, ном хэвлэл, CD, DVD, мэдээлэл хангамжийн зохиогчийн эрхийн хуулийн дагуу хамгаалсан. Электрон каталогт орсон 38615 номыг интернэтэд байрлуулж, байгууллагын вэб сайтыг боловсронгуй болгон байгууллага, нэгж тасгийн шинэ мэдээ мэдээллийн модулаар баяжуулж, шинэ номын мэдээг улирал болгон байрлуулж, амжилтын буланг шинээр нээн байрлуулан мэдээллээр баяжууллаа.

Хараагүй иргэдэд зориулсан DAISY буюу ярьдаг номын булангаар 10 хүнд, интернэтээр 703 хүнд үйлчилж, 16 хүнд и-мэйл хаяг нээж үйлчилжээ.

Мэдээллийн самбарт “Монгол Троллейбус угсрах үйлдвэртэй боллоо”, ”Италид суралцацгаая боловсролын өдөрлөг боллоо”, “Дэлхийд хосгүй морин хуурын хөшөө”, “Авто замын осол бууруулах радар бүтээжээ”, “МУИС-ыг Судалгааны их сургууль болгоно”, зэрэг 42 сэдвээр 7 хоног бүр мэдээллийн самбарт мэдээлэл гаргаж, нэгтгэн товхимол болгон, урсдаг LED самбарт 34 мэдээлэл бэлтгэн уншигчдад хүргэлээ.

“AutoCad”-ын тухай ойлголт, 2012 онд шинээр ирсэн номуудаар “Шинэ номын мэдээ” гэсэн сэдвүүдээр товхимолууд 4 удаа бэлтгэн гаргаж, “Дэлхийн хамгийн алдартай 10 номын сан” гэсэн слайд бэлтгэн, мөн “Мэдээллийн технологи”, “Монгол үндэсний язгуур урлаг” гэсэн сэдвээр моувий мэйкер бэлтгэж CD дээр бичиж гаргалаа.

Удирдлагын үйлчилгээ

Соёлын талаарх төрийн бодлого, номын сангийн хөгжлийн бодлого, хууль тогтоол, тушаал, албан даалгавар, дүрэм, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж, биелэлтийг хангаж ажиллан, Соёлын тухай хуулийн 17.1-д соёлын үйл ажиллагааг хууль тогтоомж, мэргэжлийн ур чадвар үйлчилгээний өндөр түвшинд явуулж, соёлын өвийн тухай хуулийн 1.2-т номын санд хадгалагдаж байгаа соёлын өвөөр үйлчлэх, сурталчилах, судалгаа шинжилгээ

хийх, зориулалтаар ашиглахдаа гэмтээх, үрэгдүүлэхийг хориглосон заалтыг хэрэгжүүлж, номын сангийн ном хэвлэлийг сэргээн засварлах, номонд соронзон ялтас наах зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ.

Байгууллагын тулгамдсан асуудлаар БСШУЯ-ны Соёл урлагийн газар, Монгол үндэсний номын сан, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Орон нутгийн өмчийн алба, Газрын алба, “Чандмань” хувьцаат компани, Стандартчилал хэмжил зүйн газар, Хөх бүрдний эх ХХК, -д санал боловсруулан албан бичгээр хүргүүлж шийдвэр гаргуулан зохион байгуулж хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолын Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн 2.2-г үндэслэн номын сангийн захирлын 2011 оны 1-р сарын 11-ны тушаалаар хамт олны саналыг авч баталсан “Ёс зүйн дүрэм”-г хэрэгжүүлэн ил тод байрлуулан сахилга хариуцлага тооцож 2 ажилтанд ажлын байрны тодорхойлолтын чиг үүргээ биелүүлэх, ёс зүйтэй ажиллах талаар зөвлөж цаашид арга хэмжээ авах талаар анхааруулж ажилласан.

Аймгийн засаг даргын 2008-2012 оны мөрийн хөтөлбөрийн 4 заалтыг заалт бүрээр хэрэгжүүлж, хэрэгжилтийг Боловсрол соёлын газарт гаргаж өгсөн ба Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд электрон каталогт ном оруулах асуудал 93,5 хувьтай хэрэгжсэн.

Байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгавар хэрэгжиж ирсэнч хугацаандаа хэрэгждэггүй дутагдал байгааг цаашид нийт ажилчид анхаарах, байгууллагын зорилго зорилтыг хэрэгжүүлэхэд байгууллага, хувь хүмүүс сар жилээр ажлаа төлөвлөж, хамт олны хурлаар тайлагнаж дүгнүүлдэгч үйлчилгээний ажилчид төлөвлөсөн төлөвлөгөөгүй ажилладаг дутагдал байсаар байна. Захиргааны зөвлөлийн шийдвэр, байгууллагын дотоод журам, Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль, бусад хууль эрх зүйн хүрээнд ажилчид, ахмад настнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, бусад олон нийтийн арга хэмжээ, тэмцээн уралдаан, чөлөөт амралтанд 2.249.998 төгрөг зарцууллаа.

Архив номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага MNS ISO11799:2007, номын сангийн орчин нөхцөл үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS 5742:2007 стандартыг ханган номын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч номын сангийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад агааржуулалт ажиллахгүй байгаа нь уншигчид, ажилчдын эрүүл мэндэд сөрөг үр дагавар гарч ажлын байрны эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Байгууллагын 9 ажилтантай үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээний сунгалтыг хийж, Боловсрол соёлын газрын даргатай 2012 оны бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээг баталгаажуулан, байгууллагын жилийн болон сарын төлөвлөгөөг хамт олны хурлаар хэлэлцүүлэн батлуулж,сарын ажлын төлөвлөгөөний биелэлт, тайланг гаргаж хамт олонд танилцуулан дүгнэн ярилцаж санал бодлоо солилцдог.

Байгууллагын батлагдсан 100,722.2 төсвийг төсвийн хуваарийн дагуу зориулалтаар зарцуулж, төсвийн ил тод байдлыг ханган сар бүрийн эрхийн хүсэлтийг ажилчдад танилцуулан ажилчдын саналыг авч зарцуулан өр, авлагагүй ажиллан, сар бүрийн төсвийн талаар самбар гарган ажилчид, ард иргэдэд мэдээллэн ажиллаж, санхүүгийн үйл ажиллагаанд Олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн хууль, орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэн хяналт тавьж ажилласан.

Сургалт семинар: Мэргэжлийн ур чадвартай боловсон хүчнээр хангагдаж, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд байгууллагын захиргаанаас байнга анхаарч ажиллалаа.Захирал М.Мянган Улаанбаатар хотод 2012 оны 02 сарын 13-15-ны өдрүүдэд Монгол улсын Үндэсний номын санд 3 хоногийн сургалтанд хамрагдаж, 03 сарын 01,02-ны өдрүүдэд орон нутгийн 28 номын санчдад Боловсрол Соёлын газар, Аймгийн музейтэй хамтран “Номын сангийн бодлого хэрэгжилт, менежмент технологийн шинэчлэл” сургалтыг зохион байгуулж ,БСШУЯ-наас аймгийн мэргэжлийн урлагийн байгууллагууд, сумдын номын сангуудад хандиваар өгсөн компьютерүүдийг гардуулах ажлыг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд Аймгийн ИТХ-ын дарга Г.Батжаргал, БСГ-ын дарга Ж.Энхбаяр нар урилгаар оролцсон. Мөн сумдын номын сангуудад Ш,Лувсанвандангийн 12 боть ном,”Сталин ба Монгол”,” Хотын үлгэр”, хөдөөгийн боловсролыг дэмжих хөтөлбөрийн цахим номын CD- г тараасан.

МУ-ын Үндэсний номын сангаас зохион байгуулсан “Номын сан мэдээллийн технолог” сэдэвт сургалтанд мэдээллийн ажилтан М.Мөнхдалай, ном зүйч

Б.Түвшинчимэг нар 04/09-11-ны өдрүүдэд оролцож, мэдлэг боловсролоо дээшлүүлэн, сургалтын талаар ажилчдад сургалт явууллаа. Ном зүйч Б.Түвшинчимэг, ноын санч Ц.Сарантуяа нар хамтран Япон сургуулийн 7-р ангийн 20 сурагчдыг хамруулан “Харилцааны соёл” сэдвээр сургалт явуулж сургалтын төгсгөлд бататгах тест бөглүүлэн санал асуулга авлаа. Сургалт, томилолтын зардалд 1.713.650 төгрөг зарцуулсан.

Хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2009-2012 оны эхний улиралд хийгдсэн ажлуудыг фото зургаар баталгаажуулан, Хүүхдийн төлөө хэлтсийн мэргэжилтэн н.Оюунсүрэнд и-мэйлээр явуулж, хөтөлбөрийн хүрээнд дааж авсан 3 хүүхдийн ах ИЗИС-ийн номын санч Э. Даваадалайд номын сангийн анхан шатны мэдлэг олгон, цахим номын сангийн үйлчилгээ, танин мэдэхүйн ажил, Lid 4U цогц программын талаар мэдээлэл өгч сертификат олголоо.

“Угийн бичиг хөтлөх” сургалтыг нийтийн уншлагын танхимд 40 хүний бүрэлдэхүүнтэй зохион явууллаа. Сургалтанд 10, 11-р ангийн сурагчид оролцсон.

“Архи тамхи таны амьдралд хор нөлөөтэй” лекцийг ЕБС-ийн сурагчид, МСҮТ-ийн оюутнуудад Хууль зүйн хэлтэсээс Сарангэрэл, Мөнхтуяа нар ирж 40 гаруй уншигчдад мэдээлэл хийж, гарын авлага тараасан.

“Угийн бичгийг судлах нь” түүх соёлын сургалт 2 удаа явуулахад ахмад уран бүтээлч МУСТА- Ч.Доржсэмбээ оролцож, ЕБС-ийн сурагчид, МСҮТ-ийн оюутан, номын санчдад Угийн бичгийн түүх, ач холбогдолын талаар лекц уншсан. Лекцийн талаарх гарын авлагыг CD-д бэлтгэн Нийтийн уншлагын танхимд зохион явууллаа. Лекцэнд нийт 80 уншигч оролцсон.

Үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан “Үндэсний язгуур урлагийг хөгжүүлэх нь” сургалтанд МСҮТ, “Номгон”, “Эрдэм”, “Эрдэнэмандал” ахлах сургуулиудаас нийт 45 оюутан, сурагчдыг хамрууллаа. Сургалтыг нээж Аймгийн нийтийн номын сангийн захирал М. Мянган үг хэлэв. Морин хуурын домог түүхийн талаар номын санч Б. Должин, морин хуурын бүтэц, цуур хөгжим, уртын дууны төрөл, нутгийн аялгуу, хөөмэйн урлагийн талаар Эрдэм ахлах сургуулийн дуу хөгжмийн багш н.Бүрэнтогтох, Бий биелгээний тухай өндөр настан бий биелээч Ч. Доржсэмбээ нар хичээл зааж асуулт, хариулт чөлөөт ярилцлага өрнүүллээ.

Мэдээллийн ажилтан М.Мөнхдалай иргэний нийгмийн байгууллагуудын анхдугаар чуулганд Аймагаа төлөөлж 9 төлөөлөгчийн хамт оролцлоо.

Байгууллагын захирал 2012 оны 12 сарын 12-14-ны өдрүүдэд Улаанбаатар хотод “Соёл ба хөгжил” Олон улсын чуулганд оролцож, ССАЖ-аас хөрөнгө оруулалтаар өгсөн 30 ширхэг номын тавиур,том канонийг авчирлаа.

Номын сангийн орчныг сайжруулах үйлчилгээ

Цэвэрлэгээ үйлчилгээ. Ажлын цагийг баримтлан цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, чийгшүүлэх зорилгоор нэгж тасагт түмпэнд ус хийж тавин өдөр бүр сольж, байгууллагын 25 цэцгийг өнжөөд услан арчилж ургуулж байна.

Байгууллагын их цэвэрлэгээг сар бүр номын санчидтай хамтран хийж, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллах ёстой ч тогтмол хийгдэхгүй байгаа нь уншигчдад ая тухтай нөхцөл бүрдүүлэхэд дутагдалтай байна.

Харуул хамгаалалт. Байгууллага объектыг ажлын байрны тодорхойлолтонд заасан чиг үүрэг үйл ажиллагааны шаардлагад нийцүүлэн төлөвлөж, төлөвлөсөн ажлаа хийж гүйцэтгэлээ. Харуул хамгаалалтын хуулийн дагуу хөрөнгө объектыг харж хамгаалан, жижүүрийн дэвтэрт жижүүрт гарсан

өдрийн ажлыг тэмдэглэн эд хөрөнгийн бүртгэлд байх эд хөрөнгө, өрөөнүүдийн лац, ломбо бүрэн бүтэн эсэхийг нэгбүрчилэн шалгаж тэмдэглэн танилцуулж ирлээ. 2012 онд 91 удаагийн гараагаар 2184 цаг харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэв. Байгууллагын цахилгаан сантехникийн аюулгүй байдалд хяналт тавьж шаардлагатай үед трубаг солих болон зохих арга хэмжээг авч ажиллалаа.

Байгууллагын захиргаанаас өгсөн үүрэг даалгаварыг цаг тухайд биелүүлж, нийтийн эзэмшил талбай, шат, довжоог цэвэрлэж ажилласан.

Архив, бичиг хэргийн ажил

Тайлангийн хугацаанд байгууллагын захиргаанаас гаргасан нийт 39 тушаал, захиргааны зөвлөлийн 13 хурал, шуурхай мэдээллийн 43 хурлын тэмдэглэлийг түргэн шуурхай цаг тухайд нь стандартын түвшинд шивэн удирдлагаар хянуулан ажиллаж, байгууллагад ирсэн бичиг 76 байснаас хариутай бичиг 38 байсны хариуг хугацаанд нь шийдвэрлэж байгууллагаас бусад албан байгууллагуудад 61 бичгийг төлөвлөн явуулсан байна.

Байгууллагын бичиг хэргийн ажилд хэрэглэгддэг боловсруулсан нийлсэн дардас, ирсэн бичгийн дардас, хуулбар үнэн дардас, нүүр дардсыг өдөр тутмын бичиг хэргийн үйл ажиллагаандаа хэрэглэж, хурлын тэмдэглэл, даргын тушаал, том, жижиг албан тоотыг зөв зарцуулан, үрэгдүүлсэн тохиолдолд тухай бүр төлөн ажиллалаа.

Байгууллагын архивыг цахим, нөхөн бүрдүүлэлт хийхэд 06 сарын 27-оос 07 сарын 22-ны өдөр хүртэлх хугацаанд аймгийн архивын тасагт ажиллаж архивт хадгалагдаж байсан 2001, 2002 оны байнга хадгалах баримтуудыг нэгбүрчилэн дугаарлаж, скайнердан архивын “Organization” программд оруулж аймгийн Архивын тасагт цаасан болон цахим хувиар хүлээлгэн өгсөн ба бичиг хэргийн компьютерт архивын программ суулгаснаар байгууллагын архив цахимжсан. Үүнд 2001 оны байнга хадгалах 10 ширхэг, 2002 оны байнга хадгалах 12 ширхэг цаасан баримтыг программд орууллаа. Мөн түр хадгалах 2001 оны 10 ширхэг, 2002 оны 10 ширхэг, түр-70 жил хадгалах 2001, 2002 оны тус бүр 1 ширхэг баримтыг байгууллагын архивт хадгалж байна.

Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын 101 бичиг баримтыг бичиг баримт нягтлан шалгах комисстой хамтран жилээр боловсруулан гаргалаа.

Архивын тасгаас зохион байгуулсан “Байгууллагын архив, бичиг хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, ажилчдын ур чадварыг сайжруулах нь” сургалтанд Б.Түвшинчимэг, бичиг хэргийн ажилтан О.Байгал нар хамрагдаж бичиг хэргийн

компьютерт монгол бичгийн фонд суулгаж программ дээр ажиллах дадлага хийлээ.

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг бүртгэн шийдвэрлэхэд, ажилчдаас нийт 11 өргөдөл ирсэнийг тухай бүр бүртгэн удирдлагад танилцуулан шийдвэрлэсэн хариуг амаар болон бичгээр өгч ажиллаа.

Няравын ажил

Байгууллагын 1-5 сарын орлого, зарлага, шаардах, сар, улиралын тайлан, бараа материалын тайланг номын санч, нярав Б.Должин гаргаж, цалин болон бусад гүйлгээг цаг тухайд нь хийж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн дагуу ажиллаж байна.

Няравын ажлыг 06 сарын 06-нд номын санч, нярав Б.Должингоос хүлээн авч, байгууллагын үндсэн хөрөнгө 323 ширхэг 47.448.287 төгрөг, бичиг хэргийн 37357 ширхэг 1.079.362.94 төгрөг, аж ахуйд 629 ширхэг 2.292.207 төгрөгийн хөрөнгийг тоолон хүлээн авлаа. Ажил хүлээлцэх тооллогын комиссын даргаар фондоч Я. Гэрэлтуяа, гишүүнээр мэдээллийн ажилтан М. Мөнхдалай нар ажилласан.

Байгууллагын 6-12-р сарын бараа материалын тайланг гарган байгууллагуудаас авсан бараа материалын нэхэмжлэх, зарлагын баримтыг нягтланд өгч төлбөрийг хугацаанд нь барагдуулж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн дагуу ажиллаж, цалингийн картанд ажилчдын цалинг бичиж тухай бүр гарын үсэг зуруулж баталгаажууллаа.

Аймгийн Архивын тасгаас 24500 төгрөгийн санхүүгийн тэмдэг 9 сард захиалан авч, нягтлан бодогчийн эд аж ахуйн бүртгэлд бүртгэлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11, 70 дугаар зүйл, Засгийн газрын 2012 оны 01 дүгээр албан даалгавар, Төрийн өмчийн хорооны 2012 оны 46 дугаар тогтоол, байгууллагын захирлын 2012 оны 05 сарын 07-ны өдрийн 17 тоот тушаалыг тус тус үндэслэн 2012 оны 05 сарын 07-10-ны өдрүүдэд орон нутгийн өмчийн тооллогыг хийхэд тооллогын комиссын даргаар ном зүйч Б.Түвшинчимэг, гишүүдээр нярав, бичиг хэргийн ажилтан О.Байгал, номын санч Ц.Сарантуяа нар ажиллаж тооллогын акт дүгнэлтийг гарган, байгууллагын захиргааны зөвлөлд танилцуулж тооллогын дүн мэдээг орон нутгийн Өмчийн албанд хүргүүллээ.

Бүтээлч ажил

Лавлагаа арга зүйн танхимаас танхимын номуудад үсгийн ялгагч, хувцасны өлгүүр, урагдаж гэмтсэн номыг нөхөн бүрдүүлэх, магистрын материалын фонд

бүрдүүлэх, орон нутгийн болон аймгийн төвийн номын сангуудад арга зүйн зөвлөгөө өгсөн, сургалт семинарт хамрагдсан графикийг гаргаж, стикер хэвлэлээр хийлгэн танхимд байрлуулж, сумдын номын сангийн 2011 оны тайлан, Баянхонгор аймгийн нийтийн номын сангийн 2008-2012 оны тайлан, нийтийн номын сангийн 2007-2009 оны танилцуулгыг нэгтгэн товхимол болгож гаргасан ба Хүүхдийн уншлагын танхимд үлгэрийн 12 баатарууд, уншигчдад зориулсан 28 санамж, лавлагаа аргазүйн тасаг, интернэтийн танхим, хүүхдийн уншлагын танхимд “Үлэмжийн чанар”, “Төрийн дуулал”-ыг стикерээр хийж уншигчдад сурталчиллаа.

Хүүхдийн уншлагын танхимаас хүүхдүүдэд зориулж сар бүр шинэ бүтээлч ажил санаачлан хийлээ. Танхимдаа Монгол ёс заншил сэдэвтэй буланг байгуулж, булангийн хаягийг монгол бичгээр бичиж,хувцасны өлгүүр,цагийн хуваарь, гарын авлага хийх зэрэг олон бүтээлч ажлуудыг хийжээ.

Фонд гэрээр ном олгох тасгаас хөдөө аж ахуй, анагаахын номуудыг нарийвчилсан ангиллаар байрлуулах, 2009-2011 оны тогтмол хэвлэлийг шинэчилсэн бүртгэлд бичин дансалж, фондонд байрлуулан, 1-р улиралд ирсэн шинэ номоор мэдээ гаргах, эхний улиралд ирсэн шинэ ном ашиглалтын судалгаа, мөн фонд ашиглалтын судалгааг энэ оны эхний 5 сарын байдлаар гаргах, ховор номын музей үзмэрийн танхим байгуулах, 22 ховор номонд товч анатацийг бичих зэрэг бүтээлч ажлуудыг хийлээ.

Нийтийн уншлагын танхимаас ”Номын зууч” явуулын номын сангийн үйлчилгээний аялан явах санал сэтгэгдлийн дэвтэр, зохиолч С.Эрдэнэ, хөгжмийн зохиолч, Л.Галмандахын уран бүтээлүүдээр электрон мэдээлэл бэлтгэх, Д.Нацагдоржийн зохиолоор CD, Нийтийн номын сангийн ёс зүйн дүрмээр самбар хийлгэх, “Морин хуурын үүсэл хөгжил”, “Угийн бичиг” уншигчдад зориулсан гарын авлага, CD, Номын өдөрлөгийн фото самбар, ”Хүүхдэдээ хайртай хүн бүрт зориулав” гарын авлага, Ном эрдэм аяны 9-н номинаци, Д.Нацагдорж дүр тэмдэгт шалгарсан 2007-2011 оны судалгаа, Ном эрдэм аяны 2000-2011 оны уншигчдын 12 жилийн судалгаа, Хонгор нутгийн шилдэг дуучдын CD, Ч.Лхамсүрэнгийн “Хүрэн морь” яруу найргийн наадмын шалгарсан яруу найрагчдын гарын авлага зэргийг хийлээ.

Интернэт мэдээллийн танхимаас хүүхдийн уншлагын танхимтай хамтран зугаацсан уншлага, фондны 21 ховор номоор танилцуулга альбом, мэдээллийн самбарын мэдээллүүдийг нэгтгэн товхимол, дэлхийн шилдэг 10 номын сан CD, Монгол ардын уртын дуу CD-г бэлтгэж гаргалаа.

Бичиг хэргийн ажилтан ажилчдын нормын хувцасны загвар гаргаж өрөөндөө хувцасны өлгүүр хийж, албан тасалгааг цэцэгжүүлэх ажил зохион байгуулж 2 ширхэг цэцгийн сав авч 14000 төгрөг зарцуулсан, "ховор номын музей"-н хаяг хийхэд 1000 төгрөг, архи тамхины хор нөлөөг сурталчилсан самбар гаргаж, "Харилцаа ба эерэг сэтгэлгээ" сэдвээр ажилчдад сургалт явуулж үүнтэй холбоотой онцлог үгийг жаазлан коридорт байрлуулсан гэх мэт олон ажлуудыг хийлээ.

Үйлчлэгч хогийн савны 50 ширхэг уут, жижүүр хүүхдийн уншлагын танхимын шалыг паркетлах, амралтын өрөөний цонхонд хаалт хийх, ховор номын музейд номын хорго 6 ширхэгийг хийсэн, дотоод сүлжээний утас далдалж зассан, байгууллагын нэгж тасгууд, коридорт шатсан гэрлүүдийг сольж засварласан зэрэг ажлуудыг хийсэн ба байгууллагаас 1.906.000 төгрөг зарцуулсан.

Төлөвлөгөөнөөс бусад ажил

"Цэвэр орчин бүрдүүлэгч байгууллага, хамт олон шалгаруулах аян"-ны хүрээнд хамт олноороо их цэвэрлэгээ хийн, аяны хүрээнд аялж буй дэвтрийг хөтөлж, альбомд зургийг хийн дараагийн байгууллагад хүлээлгэн өгсөн. Монголын багш нарын 46 дахь жилийн хүрээнд зохион байгуулагдсан шагай шүүрэх тэмцээн, аймгийн Музейгээс зохион байгуулсан "Хот доторх аялал" явган аялал, аймгийн Онцгой байдлын газраас ирсэн албан тоотын дагуу төлөвлөгөө гарган, газар хөдлөлт гамшиг болох үед авах арга хэмжээний талаар сургалтанд хамрагдаж, хүн бүр аранз бэлтгэн шалгуулсан.

Жил бүр соёл урлагийн байгууллагын дунд уламжлал болгон зохион байгуулдаг гар бөмбөгийн бооцоот тэмцээнд амжилттай оролцож, багаараа 2-р байр эзэллээ. Байгууллагын үйл ажиллагаа, хамт олноо суртчилсан 2 ширхэг самбар, "Тунгалаг төсөв" аяны хүрээнд төсвийн мэдээллийн самбар зэргийг шинээр хийн коридорт байрлуулсан.

"Албан тасалгаагаа цэцгээр чимэе" цэцэг тарих аяныг ногоон орчин бүрдүүлэх зорилгоор хамт олны дунд зохион байгуулахад нийт ажилтнууд идэвхтэй оролцож албан тасалгааны цэцгийн тоо, нэр төрөл нэмэгдэж, хамгийн гоё цэцгийн эзнээр үйлчлэгч А.Уранчимэг, хамгийн гоё цэцгийн савны эзнээр бичиг хэргийн ажилтан О.Байгал нар шалгарлаа.

"Бүх нийтийн хөдөлмөрийн өдөр"-өөр нийтийн эзэмшил газрыг цэвэрлэж, 05 сарын 12-ны бүх нийтийн мод тарих өдрийн хүрээнд хамт олноороо байгууллагын орчныг цэвэрлэн гадаах талбайд 2 кг зүлэгний үр суулгаж 40000 төгрөг зарцууллаа.

“Нийгмийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөг”-өөр байгууллагаа суртчилах ажлыг зохион байгуулж, Баганат талбайд лавлагааны фондын 20 ном, Баянхонгор фондын 25 ном, 2012 онд шинээр ирсэн 37 ном, үнэт ховор 30 ном, нийт 152 номоор үзэсгэлэн гаргаж, 100 гаруй ард иргэдэд суртчилан, байгууллагын танилцуулга 30 ширхэгийг хийн ард иргэдэд тараасан. Үүнд үйл ажиллагааны талаар иргэдээс санал асуулга авахад оролцогчдын 99,9 % нь номын сангаар үйлчлүүлдэг гэсэн дүгнэлт гаржээ. Өдөрлөгийн үеэр 50 хүнийг оролцуулсан танин мэдэхүйн АХА тэмцээнийг зохион байгуулахад АЗДТГ-ын архивын ажилтан н.Энхбаатар тэргүүллээ.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр “Хүүхэд бүр гэр бүлдээ жаргалтай” уриан дор Аймгийн Музей, Голомт банк, Хүүхдийн төлөө хэлтэстэй хамтран “Боролдой “ хотхоны арга хэмжээг зохион байгуулах удирдамж, хөтөлбөрийг боловсруулан, хөтөлбөрийн дагуу хүүхдүүдийн дунд шагай шүүрэх, оньсон тоглоом, зүйр цэцэн үг, оньсого таах тэмцээнүүдийг зохион явууллаа. Арга хэмжээнд нийт 350 гаруй хүүхэд багачууд оролцсон.

Улаанбаатар хотод томилолтоор ажиллаж, БСШУЯ-аас хөрөнгө оруулалтаар өгсөн Фургон машиныг авчирах бичиг баримтыг бүрдүүлэн, яамнаас бэлгээр сум сургууль, цэцэрлэгүүдэд өгч байгаа 3712 ширхэг номыг хүлээн авч, Сүхбаатарын талбай дээр Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Олуулаа уншъя” арга хэмжээ, СХУ-ны доктор Ш.Чимгээгийн нэрэмжит “Ном эрдэм “аяны шилдэг бүтээлээр үзэсгэлэн гаргах ажилд 5 хүн оролцсон.

“Олуулаа уншъя” номын өдөрлөгийн нээлт Сүхбаатарын талбайд

Баянхонгор аймагт “Олуулаа уншъя” номын өдөрлөгийг мөн зохион байгуулж аймгийн Засаг дарга Д.Амарсанаа, Боловсрол соёлын газрын дарга Ж.Энхбаяр, соёл хариуцсан түшмэл н.Очирбат, мэргэжилтэн Ц.Амгалан, ахмад

уран бүтээлч МУСТА Ч.Доржсэмбээ, цэцэрлэгийн эрхлэгчид, ЕБС-ийн сурагчид, МСҮТ-ийн оюутнууд, номын санчид оролцлоо.

Өдөрлөгийн үеэр Д.Нацагдорж тэргүүний уншигч хүүхдээр “Эрдэнэмандал” ахлах сургуулийн 11д ангийн сурагч М.Төрмөнх шалгарч Засаг дарга Д.Амарсанаа шагналыг гардуулсан. Аймгийн сургууль, цэцэрлэгүүдэд хандив бэлгийн номын дээжийг гардууллаа. Мөн “АХА” тэмцээнийг зохион явуулж Эрдэнэмандал ахлах сургуулийн 11-р ангийн сурагч н.Сувдмаа тэргүүлж Нийтийн номын сангийн дурсгалын зүйлээр шагнагдлаа.

Хангайн сумууд Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут зэрэг сумдаар тойрч, БСШУЯ-аас бэлгээр өгсөн номуудыг сум, сургуулийн номын сангууд, цэцэрлэгүүдэд хуваарийн дагуу хүлээлгэн өгч, номын сангуудын ажил байдалтай танилцан арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.

Аймгийн Засаг даргын 4 жилийн мөрийн хөтөлбөрт орсон ажлуудын фото самбарыг хэвлэлийн газраар хийлгэн, Соёл урлагийн байгууллагуудын нээлттэй 7 хоногийн ажлын төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу ажиллан биелэлтийг гаргасан.

Байгууллагаас зохион байгуулсан “Хэн нь авхаалжтай вэ” хөгжөөнт тэмцээнд хамт олноороо идэвхитэй оролцлоо.

“Хүүхэд бүрт тэгш боломж” төслийн багаас 2012 оны 11-р сарын 30-ны өдөр “Сайн санааны өглөг” 1 өдрийн аяныг зохион явуулж 20 нэр төрлийн эд материалыг Хүүхдийн төлөө хэлтэст тайлангийн хамт хүргэлээ.

“Аймгийн нийтийн номын сангийн дүрэм”, БСШУЯ-ны сайдын “Алдагдсан буюу гэмтээгдсэн ном хэвлэлийг төлүүлэх журам”, “Зөөврийн номын сан ажилуулах аргачилал”, “Номын сангийн үйлчилгээг автоматжуулахад баримтлах

зөвлөмж", "Архи тамхи шинэ үеийн сонголт биш", самбаруудыг стикерээр хийлгэж коридорт байрлуулсан.

Дүгнэлт

Тайлангийн хугацаанд байгууллагын жилийн төлөвлөсөн 59 ажлаас 53 ажил биелэгдэж, 6 ажил хагас биелэгдэж, 94,9 хувьтай биелэгдлээ.

Үйлчилгээний хүрээ хүртээмж нэмэгдэж, ажлын чанар үр дүн дээшилсэн нь номын санчдын ажлын үр дүн, өдөр тутмын үйл ажиллагаа үнэ төлбөргүй болж, автоматчлагдсанаар уншигчдад хөнгөн шуурхай үйлчлэх боломж бүрдэж, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл, ая тухтай орчин бүрдсэн нь урд онуудаас ахиц дэвшил гарсан.

БУЛГАН АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2012 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2012.12.31

Уншлага үйлчилгээ:

2012 онд номын сан нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхим, гэрээр ном олгох, салбар номын сан гэсэн 4 танхимаар нийт 2725 уншигч, 21831 ирэгсэдэд 41050 ном хэвлэл олгож үйлчилсэн байна.

Нүүдлийн номын сангаар 653 уншигч, 3825 ирэгсэдэд 9189 ном олгож үйлчилсэн байна. Нүүдлийн буюу явуулын номын сангийн үйлчилгээгээр Булган сумын төвийн алслагдсан баг хороодод хүрч ажиллах зорилгоор 7 сарын 23-аас 8 сарын 31 хүртэлх хугацаанд 6 багийн өрхийн эмнэлэгүүд дээр хуваарь гаргаж ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан цахим номыг салбар номын сан дээр ажиллуулж байна.

Баяннуур, Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Гурванбулаг, Могод, Рашаант, Баян-Агт, сумдад нүүдлийн номын санг байршуулан ажиллаж байна. Байгууллагууд дээр нүүдэл зөөврийн номын санг тогтмол ажиллуулж хэвшээд байна.

Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 43 удаа 2150 номоор гаргасан байна

Фонд баяжилт хөрөнгө оруулалт:

БСШУЯ-ны "Шилдэг ном 2012" сонгон шалгаруулалтаар шалгарсан 1.575 төгрөгний ном, бэлгийн 446.7 төгрөгний, худалдаагаар 4.328.8 мянган төгрөгний нийтдээ 5.940.6 мянган төгрөгний номоор фондоо баяжууллаа. Нийт 195 нэр төрлийн, 670 ширхэг, 6,424,1 төгрөгний ном хэвлэлээр номын фонд баяжигдлаа.

Хөрөнгө оруулалтаар БСШУЯ-наас 3.075.0 мянган төгрөгний үнэ бүхий 5 компьютер, 320.0 мянган төгрөгний принтерийг хүлээн авч мэдээллийн танхим, хүүхдийн уншлагын танхим, нийтийн уншлагын танхимд тус бүр нэг нэгийг байршуулж уншигч иргэдсэдэд цахим номоор үйлчилж, интернэтэд орж мэдээ мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Мөн 12 сард БСШУЯ-наас 5.39.583 төгрөгний үнэ бүхий 20 ширхэг сүүлийн үеийн номын төмөр тавиур, 1.350.000 төгрөгний хувилагч, 6.336.0 төгрөгний 160 сандал, 7.480.0 төгрөгний 80 ширээг хөрөнгө оруулалтаар авлаа. 11.394.539 төгрөгний үнэ бүхий 16 компьютерийг сум бүрт нэгийг, 12.739.050 төгрөгний 630 ширхэг номыг яамнаас ирүүлсэн хуваарийн дагуу сумдад хувиарллаа.

9 сард БСШУЯ-наас "Шилдэг ном 2012" сонгон шалгаруулалтаар ирсэн номнуудыг АТНС дараах газруудад ирсэн хуваарийн дагуу хүргэлээ. Булган аймгийн хэмжээнд 24 цэцэрлэгт 827 ширхэг 5,6 сая төгрөгний ном, 22 сургуульд сургуулийн номын санд 1544 ширхэг, 13,9 сая төгрөгний ном, 15 сумын нийтийн номын санд 2126 ширхэг 27,8 сая төгрөгний номыг номын санчид болон цэцэрлэгийн эрхлэгчид хүлээлгэн өглөө.

Соёл олон нийтийн ажил

Жилд дунджаар 47 соёл олон түмний ажил зохион байгуулж давхардсан тоогоор 2200 хүн хамрагдсан байна.

Үндэсний бичиг соёлын өдрийг угтан Булган сумын байгууллагуудын ажилтан албан хаагчдын дунд монгол бичгийн мэдлэг, чадварыг сорих, харилцан туршлага солилцох, үндэсний бичгээрээ бахархах үзэл төлөвшүүлэх зорилгоор "ҮНДЭСНИЙ БИЧИГ-БИДНИЙ БАХАРХАЛ" уралдааныг Боловсрол Соёлын Газар, Булган сумын Соёлын төвтэй хамтран зохион байгууллаа. Тэмцээнд Эрүүл

мэндийн газар, Онцгой байдлын газар, ХААТМС, Шүүх, Спортын дунд сургуулийн ажилтан албан хаагчдын багууд оролцсоноос Шүүхийн ажиллагсадын баг түрүүлж, эрүүл мэндийн газар дэд байр, онцгой байдлын газар гурав дугаар эзэллээ. Энэ өдөрлөгийн үеэр хуучин монгол бичгээр хэвлэгдсэн номын үзэсгэлэнг 58 номоор гаргаж мөн багуудын гэрийн даалгаварт хийлгэсэн монгол бичгээр бичсэн бүтээлийг дэлгэн үзэгчдэд толилууллаа.

Монгол улсын засгийн газраас 2012 оныг “Өрхийн хөгжлийг дэмжих жил”, Аймгийн ИТХ-аас “Өрх гэр бүлийн хөгжил”-ийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан үр хүүхдээ багаас нь номонд дуртай болгох, ном унших хүсэл сонирхлыг төрүүлэх, номыг хайрлах сэтгэлгээнд сургах, номоор дамжуулан амьдралын арга ухааныг олж авахад өв тэгш хүмүүжил олгох зорилгоор “Гэр бүлээрээ ном унших хөдөлгөөн” өрнүүлж “Оюунлаг гэр бүл” шалгаруулах 3 сарын аян, байгууллагууд дээр ном уншлагын 14 хоногийн аянг хуваарь гарган зохион байгуулах зэрэг ажлуудыг өргөн хүрээнд явууллаа.

Аймгийн цагдаагийн хэлтэс, аймаг, сумын тамгын газар түүний хэлтэс, агентлагууд, ус цаг уурын газар, газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, шүүх, прокурор, спортын дунд сургууль зэрэг газруудад “Ном уншлагын 14 хоногийн аян” зохион байгуулж тухайн аяны хүрээнд шинэ номын үзэсгэлэн, байгууллага дээр нь ажиллагсадынх нь дунд АХА тэмцээн явуулж, номын сангийн Lib 4u программын тухай танилцуулага хийж, сэтгэл ханамжийн судалгаа авч, угийн бичиг хөтлөх сургалтыг Монгол Улсын Гавъяат багш Ш.Шийтэртэй хамтран зохион байгууллаа. Сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчдын ихэнх нь угийн бичгийн сургалтыг онцлон сайшаасан байлаа.

6 сарын 1-нд олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхэд даам, шатарын тэмцээн, гар зургийн уралдаан, “АХА” тэмцээн, хүүхдүүдийн дунд азын сугалаа, хүүхдийн номын үзэсгэлэнг 60 гаруй номоор гаргаж, иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлуудыг зохион байгуулсан. Даамны тэмцээн, азын сугалааг номын санч Т.Мөнгөнтуяа, шатрын тэмцээнийг номын санч Г.Эрдэнэчимэг, “АХА” тэмцээнийг мэдээллийн ажилтан Г.Энхбилэг, фондоч Эрдэнэбулган нар хөтлөн явуулж түрүүлсэн хүүдүүдэд шагнал урамшил, бэлэг дурсгалын зүйл гардуулсан.

Мөн цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд зохион байгуулсан “Миний хайртай үлгэрийн баатрууд” дүрийн тоглолтын тэргүүн байранд шалгарсан 7-р цэцэрлэгийн бяцхан хүүхдүүдийн тоглолтыг сонирхуулан цом, дурсамж, шагналыг гардууллаа.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Ц.Чинбатын шүлгийг хэн сайн унших вэ?” тэмцээнийг сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд зохион байгуулж 3-р цэцэрлэгийн....

Энэ жил Монгол улсын ерөнхийлөгч номын баярыг “Олуулаа уншъя” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх зарлиг гаргасны дагуу 9 сард номын баярыг өргөн хүрээнд тэмдэглэсэн. Энэ номын баярт бүх сум, сургуулийн номын санчид оролцсон нь онцлог байлаа. Баярын үеэр Булган нутгийн яруу найрагч зохиолч

Бат-Очир, Чинбат, Отгонсувд нарын шинэ номын баярыг Булган сумын соёлын төвтэй хамтран зохион байгуулж, Булган нутгийн зохиолч Дагвадоржийн хувийн номын сангаас номын үзэсгэлэн гаргалаа. Номын худалдаахантай хамтарч номын үзэсгэлэн худалдаа хийсэн. БСШУЯ-наас сумдад хувиарласан номын дээжээс сумын номын санчдад гардуулсан.



Булган сумын 2-р багийн Ууганболдын гэр бүл “Оюунлаг гэр бүл”-ээр шалгарлаа.

Хүүхдийн Төлөө Хэлтэс, Булган сумын соёлын төв, хүүхдийн зохиолч Ж.Дашдондогтой хамтран уншигч хүүхдүүд багачуудтай уулзалт ярилцлага зохион явуулсан. Энэ үеэр Ж.Дашдондог зохиолчийн зохиосон номын үзэсгэлэнг гаргалаа.

“Болор цом”-ын эзэн яруу найрагч, “Монголын философичдийн хүрээлэн“-ийн тэргүүлэгч гишүүн, Дэлхийн яруу найрагчдын холбооны байнгын гишүүн Д.Урианхайн “Инээд шиг хуучин хүний амьдралд” шүлэг нь Ази тивээс анх удаа “Дэлхийн нэг шүлгийн ном”-нд багтсан. Энэ номын баярт зохиолчын өөрийнх нь ном бүтээлээр номын үзэсгэлэн гаргаж, уншигчдын уулзалт зохион байгуулж хүндэтгэл үзүүлсэн.



“Иргэдийг сонсох өдөр” буюу “Байгууллагын нээлттэй хаалганы өдөр”-өөр хийх ажлын төлөвлөгөө гарган түүний дагуу байгууллага дээрээ:

- ✓ Уншигч хүүхдүүдийн дунд ардын аман зохиолоос тэмцээн явуулсан. Тэмцээнд 1-р 11 жилийн 9-р ангийн сурагчид 4 баг болж оролцсон. Ийм тэмцээнд тэдэнд сонирхолтой байсан төдийгүй хоорондоо маш өрсөлдөөнтэй, хөгжилтэй байдлаар оролцож байлаа. Энэхүү тэмцээнийг явуулсанаас хойш тэр 9-р ангийн сурагчид байнга ангиараа номын санд ирж суудаг болсон нь тэмцээний ач холбогдол, үр дүн байлаа.

- ✓ Номын сангийн ойрын болон үндсэн фондуудаар танилцах аялал зохион байгуулахад аялалд оролцсон хүүхдүүд тэр бүр номын сангийн фондод ордоггүй болохоор үзээд дуу алдан гайхаж сэтгэл өндөр байлаа. Цаашид ийм ажлыг өргөн хүрээнд зохион явуулж байх нь номын санд ирэгсэдийн нэмэгдүүлэх,сонирхолыг татах, уншигч иргэдийн номын сангийн үйл ажиллагааны талаарх ойлголт илүү их болно гэсэн сэтгэгдэл үлдлээ.
- ✓ Идэвхтэн уншигч Баясгаланг урьж уншигч хүүхдүүдтэй чөлөөт ярилцлага уулзалт хийх ажлуудыг зохион байгуулсан. Энэхүү ярилцлагыг хийхэд хүүхдүүд өөрсдийгөө танилцуулж, авъяасаа үзүүлж, өөрийн зохиосон шүлгээ уншиж, дуртай зүйлээрээ чөлөөтэй ярилцаж байлаа. Уулзалт ярилцлага албан бус чөлөөтэй байсан нь хүүхдүүдэд ойр байж чадлаа.

Спорын ордонд болсон байгууллагуудын “Иргэдийг сонсох өдөр” арга хэмжээнд АТНС-аас шинэ номын дээжээс 153 ном, 8 ширхэг ховор номын үзэсгэлэн гаргаж 180-аад иргэд үзэж сонирхон.

“Номын сангийн үйлчилгээ” сэдэвт 5 асуулгатай санал асуулга явуулж 90 нээлттэй саналын хуудасаар санал авлаа. Үүнээс: 2 хуудас хүчингүй болсон.

1. АТНС-гийн ерөнхий үйлчилгээ ямар байна вэ? гэсэн асуултанд
   90% сайн, 10% дунд
2. Номын хүрэлцээ хангамж ямар байна вэ?
   65% сайн, 33% дунд, 2% муу
3. Номын сангийн үйлчилгээнд анхаарах зүйл байна уу?
   - Гэрэлтүүлэг 20
   - Цагийн хуваарь 16
   - Компьютер техник хангамж 25
   - Халаалт дулаан 30
   - Бусад 12
4. Номын санчдын зан харилцаанд үнэлгээ өгнө үү?
   90% сайн, 10% дунд
5. Таны хүсч байгаа номын сангийн үйлчилгээ?
   Орчин үеийн бэстселлэр номнуудаар фондоо баяжуулах, дулаан саруул орчинг бий болгож, багтаамжаа нэмэгдүүлэх, заалаа томсгох зэрэг асуудлуудыг илүү их тавьсан байна.

Сургалт сурталчилгаа:

9 сарын 12-14-ны өдрүүдэд Улаанбаатар хотод Үндэсний төв номын сан дээр болсон номын сангийн автоматжуулалтын талаарх сургалтанд 2 номын санч, архив бичиг хэргийн сургалтанд 1 номын санч сууж мэргэшилээ дээшлүүлсэн.

9 сарын 27-нд Волвес компанийн программист Гантулгын урьж “Номын сангийн автоматжуулалт” мөн Lib 4U програмын тухайсургалтыг төв орон нутгийн номын санчдад зохион байгууллаа.

Дээрх сургалтанд 16 сумын номын санч, 18 сургуулийн номын санч, МСҮТ, ХААТМС-ын 2 номын санч хамрагдлаа.

11 сарын 2-3 нд Эрдэнэт хотод болсон “Хүүхэд ном-цахим уншлага” сэдэвт сургалтанд бусад номын санчид оролцсон. Эрдэнэт хотын Номын ордоноор орж тэдний үйл ажиллагаатай танилцан туршлага судлан авууштай санааг ажил хэрэгтээ тусган ажиллаж байна.

12 сард Соёл урлагийн их сургуулийн харъяа Соёлын сургууль дээр болсон “Сумдын номын сангийн мэргэжлийн боловсон хүчний хангамжийг сайжруулах, мэргэжил дээшлүүлэх Могод сумын номын санч хамрагдсан.

“Номын сангийн салбарын бодлого, хэрэгжилт болон менежмент, технологийн шинэчлэл” сургалтанд орон нутгийн бүх номын санчид хамрагдсан.

Байгууллагын сахиулыг харуул хамгаалалтын сургалтанд сургаж мэргэшүүлсэн.

Соёлын байгууллагын удирдах ажилтны семнар, Боловсрол, Соёлын салбарын удирдах ажилтан нягтлан бодогч нарын сургалт, сэдэвт сургалт семнарт байгууллагын ерөнхий менежер хамрагдсан байна.

Булганы мэдээ сонинд 5 мэдээ, МОНЦАМЭ сонинд 4 удаа, Булган телевизийн урсдаг зараар 7 хоног зар явуулж, УБ хотын ТМ телевизээр 2 удаа номын сангийн үйл ажиллагааг сурталчилсан.

Байгууллагын цаг үеийн үйл ажиллагааг сурталчилах, мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргэх зорилгоор байгууллага дээрээ урсдаг зар авч ажиллуулж байна.

АТНС-аас сум, сургуулийн номын санг мэдээлэл арга зүйгээр хангах ажлын хүрээнд Хишиг-Өндөр, Гурван булаг, Рашаант, Баяннуур, Бүрэгхангай сумдад нүүдлийн номын сан ажиллуулж, Баяннуур, Бүрэгхангай сумын номын санч нарт газар дээр нь очиж заавар зөвөлгөө өглөө. Номын санчдад зөвлөмж, гарын авлага 4 удаа хүргүүлсэн.



ЕБС-ын 5,8,9-р ангийн сурагчдын дунд анги тус бүрээр нь ангилан ардын аман зохиолын 5 төрлөөр тэмцээн зохион явууллаа. Ингэж анги тус бүрээр тэмцээн зохион байгуулах нь хүүхдэд хүрэх хүртээмж нь илүү, хүүхэд бүрийн оролцоо нэмэгдэх, тэмцээн явуулах заал талбай хүрэлцээтэй зэрэг давуу талтай байна.

Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу,“Олуулаа уншъя” аян, БШУ-ны яамнаас гаргасан “Ном хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд, хүүхэд залуусын, ном унших сонирхол төрүүлэх, номтой нөхөрлөх, бүтээлчээр унших арга зүйг эзэмшүүлэх, дэмжих, хүүхэд бүр уншсан номоо тэмдэглэл хөтөлдөг болох, номын сангаар үйлчлүүлэгчдийг нэмэгдүүлэх зорилгоор “Номын анд” 14 хоногийн уншлагын аянг ЕБС-ийн 7-11 ангийн сурагчид, Спортын дунд сургууль, МСҮТөв, ХААТМС-ын сурагчдын дунд тусгай удирдамж гарган 2012 оны 11 сарын 27-оос, 12 сарын 14-ний өдрүүдэд Аймгийн төв номын сан, 1-р 11 жилийн сургуультай хамтран зохион байгууллаа.

Тус аяны хүрээнд:

- Сурагчдыг уншсан номын тэмдэглэл хөтлүүлэх /хүүхэд бүрийг/
- Монгол ардын аман зохиолоор тэмцээн зохион байгуулах /анги бүрээр нь тусгайлан/
- Хувийн номын сантай хүүхдүүдийг сурталчилах
- Уншсан номныхоо тухай бусаддаа ярьж өгөх /уншлагын танхимд тусгай цагийн хуваарь гарган/
- “Номч анги” шалгаруулах зэрэг ажлуудыг зохион байгуулж явууллаа.

Энэ хугацаанд 188 уншигч, 1106 ирэгсэдэд, 2190 ном олголсон байна.

Номын сандирж байгаа сурагчдын 80% нь уншсан номын тэмдэглэлээ хөтөлдөг болсон.

Сурагчдын тэмдэглэл хөтөлсөн дэвтэрүүдээр нийтийн уншлагын танхимд үзэсгэлэн гаргалаа.

Уншлагын зааланд 5 дахь өдөр бүрийн 16 цагаас 18 цагийн хооронд уншсан номынхоо тухай ярилцах цагийг уншигчдад зориулан гаргаж 63 хүүхэд оролцон уншсан номынхоо тухай ярьж өглөө. Тэдгээрээс сурагч Б.Ишдоржийн ярьсан “Унагаа зуусан хулан” ном хүүхэд бүрийн сонирхол маш их сонирхолтой байлаа.

Монгол ардын аман зохиолыг сурталчилах, хүүхэд багачуудыг ардын аман зохиолоо сайн мэддэг, дуртай болгох, сонирхолыг төрүүлэх зорилгоор оньсого таалцах, түргэн хэллэг, хэлц үг, зүйр цэцэн үгийг хэн олныг мэдэх вэ?, ертөнцийн гуравыг хэлэх /өөрсдийн сэтгэхүйгээр зохиох/ тэмцээнүүдийг 8-р ангийн сурагчдын дунд зохион явууллаа.Энэ тэмцээнд 1,2-р 11 жилийн 8-р ангийн сурагчдын төлөөлөл нэг ангиас 1 сурагч баг болон оролцож 1-р 11 жилийн сургуулийн “Хурц-Од” баг түрүүллээ.

Хүүхдүүдийн хувийн номын санг сурталчилж уншлагын зааланд байрлах номын тавиурт байрлуулж үзэсгэлэн гаргасан. Номын сангийн уншлагын заалаар 1-р 11 жилийн 9 В ангийн сурагч Ж.Номин-Эрдэнэ 21 ном, 2-р 11-н жилийн 10 3 ангийн сурагч У.Пүрэвням 24, 1-р 11-н жилийн 9 А ангийн сурагч О.Хулан 25 ном, 9а ангийн сурагч Б.Цахиуртөмөр,О.Хулан, Б.Баттулга, А.Олзмөнх нар өөрийн

номын сангаа сургууль дээрээ найзууддаа үзүүлсэн нь сурагчдын сонирхлыг татсан үйл ажиллагаа болов. Сурагч А.Олзмөнхийн “Чингис хаан” 20 цуврал ном сурагчдад тун их таалагдаж Олзоо ч номынхоо тухай найзууддаа дуртайяа тайлбарлан ярьж өглөө.

“Номч анги”-аар 1-р 11 жилийн сургуулийн Буянбат багштай 9 Б анги шалгарлаа.

“Номын анд” аянд 1-р сургуулийн 9 а, 9 б ангиуд бусдаасаа илүү идэвхтэй оролцсоныг онцлон хэлэх хэрэгтэй.

Тэргүүн байранд: 9 Б ангийн сурагч Б.Ишдорж шалгарч “Нацагдорж” тэмдэг, өргөмжлөл, ном

2-р байранд: 9 А ангийн сурагч Г.Ариунзаяа шалгарч “Нацагдорж” тэмдэг, өргөмжлөл, ном

3-р байранд: 9 А ангийн сурагч Ц.Доржханд шалгарч өргөмжлөл, ном

Тусгай байранд: 8 Б ангийн сурагч П.Амарцэнд шалгарч өргөмжлөл, номоор тус тус шагнууллаа.

Сурагчдын хөтөлсөн тэмдэглэлүүдээс:



Хүүхдүүдийн хувийн номын санг сурталчилсан талаар:



Уншсан номынхоо талаар бусаддаа ярьж байгаа нь:

"Номч ангиар шалгарсан 9 Б ангийнхан ангидаа шагналаа гардан авлаа:



Тэргүүлсэн сурагчид:

Номын санчдын нийгмийн асуудлыг сайжруулах талаар:

Байгууллагын дотоод журмын заасны дагуу 4 хүнд 350.0 төгрөгний тэтгэмж, 2012 оны үр дүнгийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж 70%-иас 1 сарын цалингаар, байгууллагын аварга ажилтан шалгаруулж, өргөмжлөл, тууз, 100.0 төгрөгөөр шагнаж урамшууллаа.

Бүх ажиллагсадыг эрүүл мэндийг үзлэгт хамруулсан. Чөлөөт цаг болон үдийн цайны цагаар биеийн чилээгээ гаргах, алжаал тайлах жижиг оврийн массажны хэрэгсэлүүдийг авсан.

Ажиллагсад болон уншигч иргэсэдийг цаг үеийн мэдээ мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх зорилгоор байгууллагын кордиорт 32 инчийн зурагт авч байрлуулсан.

Ажиллагсадын алжаалыг тайлан, сэтгэл сэргээх зориолгоор Орхон аймгийн номын санчдын хамт байгалийн үзэсгэлэнт газар Бүрэгхангай сумын нутагт орших “Бодь мод”-онд очсон. 2 байгууллагын номын санчдын дунд нөхөрсөг тэмцээн зохион байгуулсан.

Бусад:

Номын фондын хадгалалт хамгаалалтанд анхааран хортон шавж устгалыг жилд 2 удаа хийсэн. Их цэвэрлэгээг улиралд 1 удаа хийж байна.

Номзүйчийн өрөөг тусгайлан гаргаж засвар хийж тохижуулсан мөн нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхимуудыг тохижуулсан. Нийтийн уншлагын танхимд загасны аквариум байрлуулсан.

Бүх номын санчид Орхон аймгийн Номын төвийн ажил байдалтай танилцан, ажлын туршлага солилцсон.

Үндсэн фондод хадгалагдаж байгаа тогтмол хэвлэл, хуучин монгол бичгээр бичигдсэн номуудыг 100% электрон каталогт оруулсан.

Уншлагын заал танхимууд урагдаж гэмтэж уншлагад гарах боломжгүй болсон 350 гаруй номыг өөрсдийн нөөц бололцоогоор засаж сэлбэсэн байна. Нийтийн уншлагын танхимын дэргэд “Ном эмчлэх клуб” ажиллуулж байна.

2012 онд хийсэн шинэлэг ажлууд:

- Нийтийн уншлагын зааланд “Уншигчтай дотно харилцах дэвтэр”-ийг санаачлан нээн ажиллуулж байна. Энэ нь уншигч ирэгсэд хэлж чадахгүй байгаа зүйлээ бичиж үлдээх, хариултыг номын санч дэвтэртээ бичиж үлдээх гээд санал сэтгэгдэлээ хуваалцахад илүү нээлттэй ажил болсон.
- Хүүхдүүдийн ном унших сонирхолыг төрүүлэх, урам зориг өгөх зорилгоор анх удаа “Номч анги”-ийг шалгаруулла.
- Уншлагын заалнуудад 7 хоног бүр хамгийн их уншигдсан ном, хамгийн их ном уншсан уншигчийг шалгаруулж сурталчилж байна.

- “Номын баяр”-ыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, шинэ номын баяр тэмдэглэсэн.
- Анх удаа “Оюунлаг гэр бүл”-ийг шалгаруулсан
- Хувийн номын сантай уншигчдын номын санг сурталчилах ажлыг зохион байгуулсан.
- Монгол ардын тоглоом наадгай, ардын аман зохиолыг сурталчилах, хүүхэд багачуудыг татан оролцуулах ажлыг өргөн хүрээнд зохион байгуулсан
- Зуны явуулын номын санг баг хороодод ажиллуулсан
- Цахим номын үйлчилгээг шинээр нэвтрүүлж ажиллуулж байна
- Нийтийн уншлагын танхимд 5 дахь өдөр бүрийн 16-18 цагийн хооронд уншигч хүүхдүүдийн дунд “Уншсан номынхоо тухай ярья” чөлөөт ярилцлагын цагтай болсон уншигч хүүхэд багачуудын сонирхолыг татсан ажил болоод байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд хүүхэд бүр уншсан номынхоо тэмдэглэл хөтлөх хөдөлгөөн өрнүүлсэн. /тэмдэглэл хөтлөх арга зүйн зөвлөмж өгсөн/
- Угийн бичиг хөтлөх сургалтыг Ц.Шийтэр багштай хамтран байгууллага бүр дээр зохион байгууллаа.
- Орхон аймгийн номын санчидтай нөхөрсөг тэмцээн зохион байгуулсан.
- Байгууллага дээрээ цаг үеийн мэдээ мэдээлэл түгээх зорилгоор урсдаг зар болон зурагтыг байршуулан ажиллуулж байна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
2012 ОНЫ ТАЙЛАН

2012.12.03 Алтай хот.

1. Удирдлага зохион байгуулалтын талаар:

Боловсрол соёлын газрын даргатай байгуулсан Менежерийн бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх гэрээг үндэслэн Говь-Алтай аймгийн Нийтийн номын сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг зорилтуудыг ханган биелүүлэх зорилгоор баталгаажуулан ажиллаа.

Аймгийн нийтийн номын сан нь Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжууд, УИХ, Засгийн газар, БСШУЯ-ны сайдын тушаал СУБГЗ-ын заавар, зөвлөмжүүдэд үндэслэн өөрийн үйл ажиллагааг зохион байгуулж ирлээ.

Орон тоо бүтэц зохион байгуулалтын хувьд 12 орон тоотойгоор үйл ажиллагаа явагдаж байна. Жилийн болон улирлын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг зорилтуудыг ханган биелүүлэх зорилгоор ажлын зохион байгуулалтыг сайжруулж ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулж бүтээгдэхүүн нийлүүлэлтийг ханган биелүүлэх үр дүнгийн гэрээг байгуулж ажиллаа.

2. Номын сангийн үйлчилгээний талаар:

2012 онд 1800 øинэ уншигч бүртгэн 20.000 ирцэд 40.000 ширхэг ном тогтмол хэвлэл олгож, уншигчдын карт формулярыг хөтлөн чөлөөт сонголтоор болон захиалгын хуудсаар фондоос үйлчиллээ. Зөөврийн номын сангаар Хас банк, Хадгаламж банк, АДБАЧуулга, ОНСМузей, Хүүхдийн төлөө хэлтэс, Улсын тэргүүний 1-р цэцэрлэг, Их буудал ХХК, Ажийн гэрэл ХХК эмийн сан,МСҮТ зэрэг 15 байгууллагатай гэрээ хийн ажиллууж, 1000 ирцэд 3000 ном олгож үйлчилсэн байна.

Фондын нөхөн бүрдүүлэлт хийх, номын хүртээмжийг нэмэгдүүлэх, уншигчдад шинэ мэдээллийг хүргэх зорилгоор шинэ áîëîí хандивààð èðñýí 816 ø номыг дансанд авч техник ажиллагаа хийж фонд тасгуудад хувиарлан фондоо баяжууллаа. Íомын хүртээмжийг нэмэгдүүлэх, уншигчдад шинэ мэдээллийг хүргэх зорилгоор лавлагаа болон олшруулсан материал бэлтгэн үйлчиллээ.

14-25 нэр төрлийн тогтмол хэвлэл захиалан нэгж ном болгон үйлчилгээнд гаргалаа. Уншигчдын эрэлт хэрэгцээг ханган шинэ мэдээ мэдээллээр түргэн шуурхай үйлчлэх

зорилгоор аман болон бичгийн лавлагаа 400 өгч1000 ширхэг ном сэлбэн засварлан уншигчдад хүргэж үйлчиллээ.

3. Сургалт семинарын талаар:

Соёл урлагийн хорооноос Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү эдийн засгийн сайдын 2002 оны 377/388 хамтарсан тушаалаар батлагдсан " Соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах санхүүжүүлэх журам"-ын дагуу 2012 оны 2 сарын 13-наас 15-ны өдрүүдэд Аймгийн төв номын сангуудын удирдлагуудад зориулсан "Номын сангийн салбарын бодлого, хэрэгжилт болон менежмент, технологийн шинэчлэл сэдэвт сургалт семинарт эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч Д.Ундармаа удирдамж хөтөлбөрийн дагуу оролцлоо.

Мөн 2012 оны 03 сард ОБХ-ийн 4-р салааны захирагч Онцгой байдлын дэслэгч Ц.Амарсанаа гал түймрийн тухай ойлголт, гал гарсан үед авч хэрэгжүүлэх яаралтай ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гамшгийн байдлын талаар сургалт хичээл зохион явуулж ажилчид бүрэн хамрагдлаа.

Ажилчид сургалтан дээр

4 сарын 03-05-нд Хүн судлалын үндэсний төвийн захирал, биологийн шинжлэх ухааны профессор, ШУ-ны гавьяат зүтгэлтэн Жамъяангийн Батсуурь "Угийн бичгийн" сургалт зохион явуулж 6 номын санч хамрагдсан.

Угийн бичгийн сургалтан дээр

4 сарын 09-11-ны өдрүүдэд Монголын Үндэсний номын сангаас “Номын сан-Мэдээллийн технологи” сэдэвт сургалтанд номын сангийн номзүйч Б.Одсурмаа, мэдээллийн ажилтан Б.Оюун нар хөтөлбөрийн дагуу хамрагдлаа.”Хөдөө орон нутгийн номын санчдын чадавхийг бэхжүүлэх нь”сургалтыг 7-2-6-ны хооронд Үндэсний Номын сантай хамтран зохион байгуулж МҮНС-н ахлах мэргэжилтэн Б.Энхжаргалыг урьж авчран аймгийн хэмжээний сум сургуулийн нийт 40-н номын санч хамрагдсан ба мөн Тайшир сумын соёлын төвийн номын сан дээр үзүүлэх сургалтыг зохион явуулав.

Номын санчид сургалтан дээр

ССАЖЯ-наас 2012-12-р сарын 3-7-ны өдрүүдэд зохион явуулж буй “Номын сан ба шинэчлэл”сэдэвт сургалтанд номын санч Г.Энхцэцэг хамрагдав.

“Шинэчлэлийн Засгийн газрын бодлого, Соёл урлаг” сэдэвт сургалт семинар

Төрийн ордонд “Соёл ба хөгжил” олон улсын хурал

4. Мэдээлэл сурталчилгааны талаар:

Шинэ номын мэдээ -6, “Үлгэрийн ертөнцөөр аялцгаая”, “Морь сонирхогчид” санамж өгөх номзүйн бүртгэл - г гарган 2012 оны 3 сарын 15-19-нд насанд хүрэгчдийн уншлагын танхимд шинэ номын үзэсгэлэн, 4-р сард ”Үлгэрийн ертөнцөөр” сэдэвчилсэн үзэсгэлэн, 5-р сард М.Цэдэндоржийн мэндэлсний 80-н жилийн ойд зориулан 1 сарын аян зарлаж түүний уран бүтээлээр сэдэвчилсэн үзэсгэлэн 5-р сард “Бичиг соёлын хишиг өдрөөр” ховор номын үзэсгэлэн” 6-р сард,“Хүүхдийн номын үзэсгэлэн худалдаа” 9-р сард ,”Алтай түншлэл 2012” үзэсгэлэн”,10-р сард ”Нээлттэй хаалганы өдрөөр” шинэ номын үзэсгэлэн,11-р сард Монгол бахархлын өдрөөр “Чингис хаан” номын сэдэвчилсэн үзэсгэлэн, “Мэдэхэд илүүдэхгүй” лавлагааны материал бэлтгэн уншигчдын эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна.Нийтийн номын сангийн Blog нээж шинэ мэдээ мэдээллээр баяжуулж байна.Фондын 40000 номын электрон каталогийг хэвлэж зураасан код нааж, үсэг дараалын дагуу байрлуулж дууслаа.

1. 12 жилийн 2-р сургуулийн Д.Алтанцэцэг багштай 5-в ангийн сурагчдын дунд “Хэн олон ном унших вэ” сарын аян зохион байгуулж 5-в ангийн сурагч Лхамноржин тэргүүллээ.
2. 2. ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Ч.Лодойдамбын “Надад мөсөн чихэр гуйгаарай ээжээ” зохиолоор 8-а ангийн сурагчдын дунд 3 сарын 1-7-ны хооронд гар зургийн уралдаан зарлаж тус ангийн сурагч Сумъяа 1-р байр, Нямжаргал 2-р байр,

Гүндэгмаа 3-р байр тус тус эзэллээ. Тус ангийн сурагчид энэ зохиолоор дүрийн тоглолт бэлтгэн амжилттай оролцлоо.

Дүрийн тоглолтын хэсгээс

4 сарын 10-23-ны хооронд 12 жилийн 2-р сургуулийн багш сурагчидтай хамтран Д.Дашдондогийн "Долоон бөхтэй" тэмээ зохиолоор гар зургийн уралдаан, дүрийн тоглолтыг зохион байгуулж, 5-в анги тэргүүн байр эзэллээ. Мөн Нацагдорж тэмдгийн болзол хангасан 5-г ангийн сурагч Б.Дамдин, 5-в ангийн сурагч Ц.Оюунзул, 4-а ангийн сурагч
Э.Баасандаш, 5-в ангийн сурагч Б.Балжинням нарт тэргүүний уншигчийн тэмдэг үнэмлэхийг гардуулж өглөө.

" Нацагдорж" тэмдэгтэн тэргүүний уншигчид

5 сарын 22-нд Д.Лхагвасүрэнгийн " Дүрсгүй буд" зохиолоор 12 жилийн 2-р сургуулийн 6-р ангийн сурагчдын дунд дүрийн тоглолт, гар зургийн уралдаан

зохион явуулж уг дүрийн тоглолтогд Д.Алтанцэцэг багштай 6-б анги тэргүүн байр , гар зургийн уралдааны тэргүүн байрыг 6- в ангийн сурагч М.Нямсүрэн , дэд байрыг 6-а ангийн сурагч Э.Рэгжийбуу нар тус тус эзэлсэн.

Дүрийн тоглолтын хэсгээс

3. Соёлын гавъяат зүтгэлтэн ардын уран зохиолч Тангадын Галсангийн 80 жилийн ойд зориулж Монгол ёс заншлын тухай "Мэдэхгүй хангал үг, Мэдүүштэй монгол үг " номоор МСҮТ-ийн сурагчдын дунд соёл танин мэдэхүйн ажил зохион явуулж 80 гаруй уншигч сурагчдыг хамруулж хүнсний 1-р дамжааны сурагч А.Алзагүй тэргүүн байр, хүнсний 2-р дамжааны сурагч О.Цэнд 2-р байр, хүнсний 2-р дамжааны сурагч О.Ижилцэцэг 3-р байрыг тус тус эзэлж дурсамж, мөнгөн шагнал гардан авлаа.
4. 2012 оны 05 сарын 04-нд Үндэсний бичиг үсгийн баяраар насанд хүрэгчдийн дунд " Монгол бичиг-бидний бичиг" сэдэвт сайхан бичгийн уралдааныг Есөнбулаг сумын нийт албан байгууллагуудын ажилчдын дунд амжилттай зохион явууллаа. Уг уралдаанд 30-д бүтээл ирснээс 1-р байрыг Аймгийн ЗДТГ-ын ажилтан Р.Цэнд-Аюуш , 2-р байрыг ЭМШУИС-ийн салбар сургууль АУК-ийн номын санч Т.Анхцэцэг, 3-р байрыг ОНСМузейн сан хөмрөгийн эрхлэгч Б.Сарангэрэл , тусгай байрыг Аймгийн Хүүхдийн төлөө хэлтсийн мэргэжилтэн Б.Батбаяр, аймгийн Шүүхийн шүүгч Э.Золбадрах нар эзэлж дурсамж,дурсгалын зүйл,мөнгөн шагналаар шагнагдлаа. Мөн 2011 оны сайхан бичлэгийн улсын уралдааны тэргүүн байрын шагналт "Алтай –Улиастай" ТӨХК-ий ажилтан Б.Жигжээ, 2009 оны сайхан бичгийн уралдааны тэргүүн байрын шагналт МСҮТ-ийн англи хэлний багш Ч.Нарантуяа нар өөрсдийн монгол бичгээр бичсэн бүтээлийн үзэсгэлэн, номын сангийн фондын ховор ном судар, уйгаржин монгол бичгээр бичигдсэн номын

үзэсгэлэн, уран таталган, эвхмэл бичгээр бичсэн бүтээлийн үзэсгэлэн гаргаж уншигч иргэдэд сурталчилсан.

3. Үндэсний бичиг үсгийн баярын талаар “Алтай хөгжил” ,”Говийн мэдээ” сонинуудад мэдээлэл нийтлүүлсэн.

Үндэсний бичиг үсгийн баяраар

М.Анхцэцэг Б.Батбаяр нарт шагнал гардуулж байгаа нь

Монгол бичгийн номын болон ховор номын үзэсгэлэн

5.Эх үрсийн баяраар Жанчив баатарын талбайд хүүхдийн уран зохиолын номоор үзэсгэлэн гаргаж, номын үзэсгэлэн худалдаа зохион байгуулаа.

Талбай дээр

3.

Хүүхдийн номын үзэсгэлэн

Монгол улсын ерөнхийлөгчийн зарилгаар номын баярыг тэмдэглэв

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга,Боловсрол Соёлын газрын дарга нар номын баярыг үйл ажиллагааг нээв

Тунгалаг Тамир зохиолын хэсгээс

Цахим номын үйлчилгээ

Байгууллагын “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж фондын шинэ номоор үзэсгэлэн гаргаж иргэдэд үйлчилж байгууллагын үйл ажиллагааг сурталчиллаа.

Номын үзэсгэлэн

Монгол бахархлын өдрөөр

“Чингис хаан” номын үзэсгэлэн

Бар код наасан хүүхдийн болон гэрээр ном олгох тасгийн номууд

Катологижуулалт , шинэ байрлуулсан каталоги

4.Засвар үйлчилгээ

Бохирын шугамыг засварлаж 00-г ашиглалтанд оруулла. Дотор вистуль, гэрээр ном олгох тасгийн бүрэн засварыг хийв.



Вистуль,гэрээр ном олгох тасгийн шалнууд /засварын дараа/

Мөн хүүхдийн заал,аргазүйчдын өрөөний засвар,гадна талын засваруудыг хийж гүйцэтгэв.



Вистуль,мэдээллийн ажилтны өрөө /засварласны дараа/

Хүүхдийн уншлагын танхим,гэрээр ном олгох тасаг/засварын дараа

5. Яам-ны хөрөнгө оруулалтаар:

Фондын номын тавиурыг шинэчиллээ



Комьпютер, принтер, канон шинээр өгсөн

Яамнаас нүүдлийн номын сангийн үйл ажиллагаа явуулах зорилгоор УАЗ пургон машин, 5 комьпютер, принтер, канон өгсөн нь бидний үйл ажиллаанд их дэмжлэг туслалцаа болж байна.

Байгууллагын гадна цэцгийн мандал хийж шинээр 2 мод нэмж тарив. БСШУЯ-наас хандивын болон шилдэг номуудыг хүлээн авч аймгийн нийт сум,сургуулиуд, соёлын төвийн номын сангууд,цэцэрлэгүүдэд хуваарийн дагуу хүлээлгэн өгч фонд баяжилт хийв.

4. **Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар:**

Байгууллагын дотоод журмыг шинэчлэн баталж, 7-р заалтад оруулснаар Монголын уламжлалт цагаан сарын баяраар 2кг цагаан тос, 5кг сүү, Олон улсын эмэгтэйчүүдийн баяраар ажилтан бүрт 10,000 төгрөг, Эх үрсийн баяраар ажилтан

бүрийн хүүхдэд бэлэг гардуулан өгч байгууллага дээр хүлээн авч тараг сүү өгч уралдаан явуулж шагнаж урамшууллаа.

Мөн ажилчдад зайлшгүй гачигдал гарсан үед өргөдлийг үндэслэн байгууллагын төсвийн тэтгэмж урамшуулалын сангаас гарган нэг удаагийн тусламжийг олгож ирлээ. 11 сард байгууллагын бүх ажилчдыг мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамруулан ажилласан. 12 сард ажилчдад нэг удаагийн буцалтгүй тусламж болгон 110.000 төгрөг, хоолны мөнгийг өдрийн 10.000 төгрөгөөр тооцон олголоо. Үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж 100%-А үнэлгээ авсан мэдээллийн ажилтан Б.Оюун, үйлчлэгч Х.Цогзолмаа нарт 1 сарын урамшилт цалингаар, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж 95%-А үнэлгээ авсан номзүйч Б.Одсурмаа, харуул Ш.Оюунцэцэг нарт урамшилт цалинг 40%-иар, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж 93%-А үнэлгээ авсан номын санч С.Цэрэнпил, Г.Энхцэцэг, харуул Д.Мандахзул, Б.Дашжаргал нарт урамшилт цалинг 30%-иар, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж 90%-А үнэлгээ авсан номын санч Э.Оюунгэрэл, харуул Н.Бямбажаргал нарт 20%-иар урамшилт цалинг тус тус олголоо. Харуул Н.Бямбажаргалын хүү 2-р сургуулийн 1-б ангийн сурагч Вангүр нь зүрхний булчингийн хэсгийн цоорхой, зүрхний гажиг оноштой бөгөөд сүүлийн үед эрүүл мэндийн байдал зовиуртай болж үнэтэй эм тариа байнга хэрэглэж байгаа ба нарийн мэргэжлийн эмч нарын шийдвэрээр “Монголдоо хагалгаа хийх боломжгүй АНУ болон Канад улсад хийгдэнэ” гэсэн хариу гарсан бөгөөд гадаад явж эмчилгээ хийлгэхэд нь 80 сая төгрөг шаардлагатай байгаа учраас 6 сард өргөдлийг хүлээн авч байгууллагын тусламж 50,000 төгрөг, 12 сард буцалтгүй тусламж болгон 300.000 төгрөгийг тус тус тусламж болгон өгч сэтгэл санааны дэмжлэг үзүүлж шаардлагатай үед цалингүй чөлөө олгон ажиллаж байна.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Уншлага үйлчилгээ:

Үйлчилгээндээ байнгын 1066 уншигч 15.053 ирэгсэд Нийт 16119 уншигчдад 18470 ширхэг ном хэвлэл олгож үйлчиллээ.

Өмнөх оныхоос уншигч 59%-иар өссөн.

Гэрээр ном олгох үйлчилгээ:

- Гэрээр ном олгох журмын дагуу 2613 уншигчдад 6234 ширхэг ном олгож үйлчилсэн.
- Ном олголт 7%-иар өссөн.
- ЕБС-ийн бага ангийн сурагчдад долоо хоног бүрийн мягмар, пүрэв гаригийн 1000- 1200, 1400-1700 цагийн хооронд уншлагын цаг гарган номоор үйлчиллээ.
- Уншлаганд:
- 2012.01.17, 19, 24, 26 –нд Сүмбэр сумын 1-р сургуулийн 1-р ангийн 4 бүлгийн 120,
- 2012.02. 14, 16, 21-нд 2-р ангийн 3 бүлгийн 89 ,
- 2012.03. 06, 13, 22- нд 3-р ангийн 3 бүлгийн 84,
- 2012.04 10, 19, 24, 26-нд Сүмбэр сумын 2-р сургуулийн 1-р ангийн 3 бүлгийн 96,
- 2012.05.03, 08, 17, 22-нд 2012.09.11-нд Сүмбэр сумын 2-р сургуулийн 2,3-р ангийн 86
- СӨБ –ын 2-р цэцэрлэгийн бэлтгэл Б бүлгийн 32
- 2012.09.18 –нд СӨБ –ын 1-р цэцэрлэгийн бэлтгэл Б бүлгийн 27
- 2012. 09. 20, 25, 27, 10.04, 11, 18, 23-нд Сүмбэр сумын 1-р сургуулийн 4, 5-р ангийн 6 бүлгийн 138
- 2012.11. 06, 08, 27, Сүмбэр сумын 2-р сургуулийн 4, 5-р ангийн 4 бүлгийн 78, сурагчдад номыг уншуулж харилцан ярилцлаа.Үүнд:

1-3-р ангийнханд

- Динза, Аалз шувуу хоёр
- үнэгний санаа Монгол ардын үлгэр
- Сэцэн хатны үлгэр
- Насретин хожа

- ❖ Ухаант туулай
- ❖ Орос ардын үлгэр
- ❖ Тогоруу
- ❖ Алтангаа
- ❖ 4-5-р ангийханд

Алмаазан хүү 1.2.3 боть

- ❖ Хүүхдийн монголын уран зохиолын дээж
- ❖ Сэцэн хатны үлгэð
- ❖ Хун шувуу
- ❖ Чингис хаан
- ❖ Аавын цээжит чулуут
- ❖ Эхийн санаа үрд үрийн санаа ууланд
- ❖ Хүүхдийн Монголын уран зохиолын дээж

ЕБС-ийн бага ангийн сурагчид
болон СӨБ-ийн хүүхдүүдэд тод уншлагыг 9 удаа зохион байгуулж, 28 бүлгийн 750 сурагч хамрагдсан

Зөөврийн номын үйлчилгээ:

1,2,3-р багийн хөгжлийн бэрхшээлтэй судалгааг СЗДТГ- тай хамтран судалгаа гаргасан.Үүнээс:

1-р багийн 32

2-р багийн 32

3-р багийн 15

 Хөгжлийн бэрхшээлтэй 79 хүнд карт нээж, 19 удаа 502 ширхэг номоор үйлчилсэн.
 6 байгууллагын 48 ажилтанд 13 удаа 305 ширхэг номоор,
Хөдөөгийн 4, 5, 6 -р багийн иргэдэд 5 удаа 187 уншигчдад 568 номоор тус тус хүргэсэн.
Үүнд:

1. Сүмбэр сумын 4-р багт 2012 оны 4-р сарын 04нд
2. Сүмбэр сумын 5-р багт 2012оны 4-р сарын 05нд
3. Сүмбэр сумын 6-р багт 2012оны 4-р сарын 06нд
4. Баян тал сумын өдөрлөгт 2012 оны
5. Сүмбэр сумын 5-р багт 2012оны 10-р сарын 20нд тус тус зөөврийн номын үйлчилгээг хүргэсэн.

Номын фонд баяжилт , номонд хийх технник ажиллагааны талаар:

Номын фондын сан хөмрөгийг Нийт 230 нэр төрлийн 594 ширхэг 6.268.566 төгрөгийн номоор баяжуулсан.
Үүнээс:
Төсвийн хөрөнгөөр: 103 нэр төрлийн 333 ширхэг 3.423.070 төгрөгийн,
Хандиваар: 127 нэр төрлийн 261 ширхэг 2.615.496 төгрөгийн номоор
2012 оны 01, 03, 05, 06,07,10, 11, 12-р саруудад шинээр ирсэн 169 нэр төрлийн 497 ширхэг номыг шинжлэх ухааны ангилалаар ангилж, электрон катологит оруулж үйлчилгээнд гаргахад хяналт тавьж ажилласан.

Шинээр ирсэн 497 ширхэг номонд 8 удаа техник ажиллагааг хийж, шинжлэх ухааны салбарын дагуу ном зүйн ангилалаар ангиласан
Сэргээн засварлахаар номын жагсаалт хөтөлж, 107 ширхэг ном төлөвлөсөн.
Хөнгөн гэмтэлтэй 103 ширхэг номыг сэргээн засварлаж уншлаганд гаргасан
2012 оны 6 нэр төрлийн сонин сэтгүүлийг дугаараар нь тулган улирлаар нь үдэж хавтаслаж, уншлаганд гаргасан. өмнөх оныхоос сонин сэтгүүл 4 нэр төрлөөр нэмэгдсэн
Ном зүйн ажлын талаар:
/Access программыг ашиглан уншигчдын лавлагааг цахим хэлбэрээр бүртгэж байна. Мөн
/Access программд өгүүллийн картын санг 4 удаа
- Чингис хааны тухай
- Танин мэдэхүй зэрэг сэдвээр материал цуглуулан мэдээллийн бааз үүсгэн бүртгэж, Лавлагаа ном зүйн ажилд мэдээллийн технолгийг нэвтрүүлсэн.

Өгүүллийн картын санг 4 удаа 115 ширхэгээр нэмэгдүүлсэн.
Орон нутгийн картын санг:
- Утга зохиолын эвлэлийн шагналт Яруу найрагч Р.Батжаргалын бүтээлүүдийг ном, сонин сэтгүүлд хэвлэгдсэн материалыг цуглуулж 156 ширхэг картын сан хийлээ.
- Сэдэвчилсэн болон орон нутгийн картын санг зохион байгуулсан.
- Орон нутгийн холбогдолтой ном зохиол, мэдээллийг цуглуулж ном зүй гаргахаар материал цуглуулан бэлтгэж байна.

Намтар ном зүй
- Р.Ганбатын 8 боть зохиолоор
- Дамдины Пүрэвийн 12 зохиол бүтээлээр
- Д.Намдагийн уран бүтээлээр

Санамж өгөх ном зүй
- “Урлаг” –ийн холбогдолтой 84 ширхэг ном зохиолоор
- “Танин мэдэхүйн” талаар та юу унших вэ
- Хуулийн талаар та юу унших вэ
- Таны хэлний боловсролд
- Эдийн засаг маркетинг менежмент сэдэвээр та юу унших вэ
- Бурхан шашин зурхайн холбогдолтой ном зохиолууд
- Түүхийн холбогдолтой ном зохиолууд
- Танин мэдэхүйн холбогдолтой 54 ширхэг номоор
- Хүүхдийн уран зохиолын 367 ширхэг номоор
- Гүн ухааны 55 ширхэг номоор
- “Монгол ёс заншил” зэрэг сэдвүүдээр намтар болон санамж өгөх ном зүйн бүртгэл хийж, лавлагаа мэдээллийн санг нэмэгдүүлсэн.

2011-2012 онд шинээр ирсэн 446 ширхэг номыг шинжлэх ухааны ангилал, ном зүйн бичилтээр бичиж
- шинэ номын мэдээг 8 удаа бэлтгэн гаргасан.
- Шинэ номын танилцуулгыг 1удаа 15 ширхэг номоор 50 ширхэгийг өнгөтөөр хэвлэн гаргасан.
- “Ном зүйн бүтэц”
- “Номын сан дахь Лавлагаа мэдээлэл номзүй” сэдвээр гарын авлагыг 2 удаа бэлтгэн сум болон сургуулийн номын санг мэргэжил арга зүйн гарын авлагаар хангаж зөвлөгөө өгч ажилласан.

Номын үзэсгэлэн мэдээлэл сурталчилгаа:

Шинэ номын үзэсгэлэнг 8 удаа, сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 24 удаа нийт 32 удаа 983 ширхэг номоор гаргасан.
Нийт 1445 уншигч хамрагдсанаас шинэ номын үзэсгэлэнд 520 уншигч, сэдэвчилсэн номын үзэсгэлэнд 925 уншигч хамрагдсан.
Иргэдийн гар дээр байгаа ховор ном судрыг бүртгэх ажлыг зохион байгуулсан.
Ч. Сосорбурамын гар дээр байгаа 100 гаруй жилийн түүхтэй 3 үе дамжсан Жадамба гэдэг гар бичмэлийг бүртгэн авсан.
Мөн байгууллагын үйл ажиллагааны танилцуулга, боршур, мал аж ахуйн фермер, малчдад өгөх зөвөлгөө зэрэг гарын авлага номнуудыг тарааж өгсөн.
Байгууллагаас зохион байгуулж буй соёл олон түмний ажил, шинэ номын мэдээ байгууллагын үйл ажиллагааг аймгийн холбооны сувгаар болон чойрын толь сонин, боржигин нутаг FM-ээр Нийт 25 удаа сурталчилсан.Үүнээс:

- FM, радио болон телевизээр сурталчилсан тоо- 6
- Сонин сэтгүүл бусад хэвлэлээр сурталчилсан тоо- 8
- Вэб сайтаар сурталчилсан тоо - 11
- Шинэ номын мэдээ, танилцуулгыг 50 ширхэгийг өнгөтөөр хэвлэн гаргаж тараасан.

Сүмбэр, Баянтал суманд зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдөрлөгөөр үйл ажиллагааг сурталчилсан.
Үндэсний дата төвд хүсэлт гарган Цахим хуудас байршуулах үйлчилгээний гэрээ байгуулан Вэб сайт хийлгэсэн.
Мэдээлэл сурталчилгааг явуулсаны үр дүнд уншигчдын ирц сайжирсанаас гадна хамтран ажиллах байгууллагын тоо нэмэгдэж байна.
Соёл олон түмний ажил :
Хичээнгүй цэвэр бичигтэн
4-р сарын 16 нд Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэгч номинацын хүрээнд монгол бичгийн хичээнгүй цэвэр бичигтэн шалгаруулах уралдаанд нийт 84

сурагч, 2 то

м хүн оролцлоо.
Илтгэлийн уралдаан
4-р сарын 18 нд Номын гайхамшиг 2012 илтгэлийн уралдааныг зохион байгуулав. Илтгэлийн уралдааныг энэ жил анх зохион явуулж байгаа бөгөөд өсвөр насны ангилалд 3 сургуулийн нийт 9 сурагч, насанд хүрэгчдийн ангилалд 2 хүн оролцов.
Үүнээс:
Өсвөр насны ангилалд:
Тэргүүн байр: 1-р сургуулийн ангийн сурагч Б.Марал
Дэд байр: 2-р сургуулийн 10б ангийн сурагч Т.Мөнгөнтуул
Гутгаар байр: 2-р сургуулийн 10б ангийн сурагч Ш.Алтансувд эзлэв.

Насанд хүрэгчдийн ангилалд:

Тэргүүн байр: 1-р сургуулийн багш Л.Лоохууз

Дэд байр: Боржигон өв музейн ЭШАжилтан Г.Баасансүрэн

эзлэв.

“Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэгч”

номинац ын хүрээнд бичгийн хичээнгүй цэвэр бичигтэн шалгаруулах уралдаанд нийт 54 уншигч оролцлоо.Үүнээс Тэргүүн байрыг 5-р сургуулийн багш Ч.Туул Дэд байрыг 2-р сургуулийн сурагч А.Золжаргал нар эзэллээ.

Оюунлаг хамт олон шалгаруулах төрөлд

Тэргүүн байр: П.Батцацрал багштай 1-р сургуулийн 2а ангийн хамт олон

Дэд байр: Ч.Дарьзав багштай 2-р сургуулийн 3б ангийн хамт олон эзэллээ.Ном-Эрдэм аяны хаалтын үйл ажиллагаанд Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Х.Баяржаргал, Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Сүхбаатар, аймгийн утга зохиолын салбарын удирдах зөвлөлийн дарга Б.Энхтөр нар хүрэлцэн ирж номинацуудыг шалгаруулж шагнал гардуулав

Тэргүүний уншигч номинацийн хүрээнд: Бага насны ангилалд:

Тэргүүн байр: О.Баярчимэг

Дэд байр: Б.Учралбаяр

Гутгаар байр: Т.Маралмаа

Өсвөр насны ангилалд: Тэргүүн байр

А.Даваасүрэн

Насанд хүрэгчдийн ангилалд

Тэргүүн байр Ж.Отгонтөгс

Дэд байр Б.Сувдшүрэн

Ном эрдэм аяны хүрээнд: “Тэргүүний уншигч” шалгаруулах номын маргаан мэтгэлцээнийг 5-р сарын 7 нд хамгийн олон ном уншсан уншигчдын дунд зохион байгууллаа.

2012 оны 05-р сарын 19-нд аймгийн утга зохиолын салбартай хамтран Яруу найрагч Б.Энхтөр, Б.Батбаясгалан, нарын шинэ номын нээлт хийв.
Номын нээлтэнд манай аймгийн яруу найрагчид хүрэлцэн ирсэнээс гадна УБ хотоос Монголын зохиолчдын эвлэлийн шагналт яруу найрагч, зохиолч П.Батнайрамдал, яруу найрагч О.Цэнд-Аюуш, МЗХорооны яруу найрагч Минжинсайхан зэрэг хүндтэй олон зохиолч, яруу найрагчид хүрэлцэн ирэв.

Ирсэн зочдод шинэ номын дээжээсээ гардуулав.

“Номын баяр” арга хэмжээ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 8 дугаар сарын 24-ний өдөр “Номын баярын өдөр тэмдэглэх тухай” 158 дугаар зарлигийг соёрхон батлаж, жил бүрийн 9 сарын гурав дахь долоо хоногт өргөнөөр ёслон тэмдэглэхээр болсон. Энэ ажлын хүрээнд Сургууль, анги, хамт олон, хүүхэд, залуучууд ард иргэдийн ном унших сонирхолыг төрүүлэх, өргөнөөр оролцуулах номын үзэсгэлэн, номын худалдаа,

ном солилцох, бэлэглэх, хандивлах, тэргүүний уншигчдийг тодруулах, орон нутгийн зохиолчдын гарын үсэгтэй номын үзэсгэлэн, уламжлалаа сэргээж, **“НОМЫН САЙН НӨХӨР”** тэмдэгтэнг олноор төрүүлэх, номын баярын өдөр бүх нийтээр ном эрдмийг сурталчлахаар 9 сарын 21 өдөр Аймгийн Засаг даргын тамгийн газар, Боловсрол, соёлын газар, Нийтийн номын сан, Соёлын төвүүд хамтран **“Номын баярын өдөр”-**ийг хамтран зохион байгууллаа̀.

Уг арга хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулиуд, Цэцэрлэгүүд, Соёлын байгууллагууд, Иргэд, эцэг, эхчүүд, Төрийн болон төрийн бус байгууллагууд илдэвхитэй сайн оролцож 400 гаруй хүн хамрагдсан.

Номын баярын өдрөөр дараах арга хэмжээнүүд зохион байгуулагдсан. **Үүнд:**

1. Номын баярын өдрийн нээлтийн арга хэмжээ, урлагийн тоглолт зохион байгуулсан.
2. Аймгийн номын санд нүүдлийн номын сангийн автомашин гардуулсан.

1. Тэргүүний уншигч Д.Нацагдоржийн тэмдэгтний нийт 8 сурагч шалгаруулан шагнал гардуулсан. 1-р сургуулийн 10 а ангийн сурагч Б.Цэндсүрэн 119 ном уншсан. 2-р сургуулийн 4б ангийн сурагч Б.Одмаа 118 ном уншсан. 3-р сургуулийн 8а ангийн сурагч Б.Итгэлт 183 ном уншсан. 4-р сургуулийн 9а ангийн сурагч Б.Бямбаням 125 ном уншсан. 5-р сургуулийн сурагч Ч.Буянбадрал 140 ном уншсан. Аймгийн нийтийн номын сангийн уншигч 1-р сургуулийн 4а ангийн

сурагч Л.Мөнхзаяа, 2-р сургуулийн сурагч М.Ариунтуул нар 152 ширхэг ном тус тус уншиж тэргүүний уншигч тэмдэгээр шагнагдсан.

Сургууль, цэцэрлэгүүд, соёлын төвүүдийн номын санд номын баяжилт хийж ном хандивласан. Сургууль, цэцэрлэгүүд, соёлын төвүүдийн номын санд болон ЕБС-ийн 1,2,3,4,5,-р суруулиудад нийт 185 төрлийн 3.146.975 төгрөгийн ном, 1,2,3,4,5,-р цэцэрлэгүүдэд нийт 105 төрлийн 1.500.000 төгрөгийн ном, Соёлын төвүүдэд 139 төрлийн 1.800.000 төгрөгийн номыг тус тус хандивласан.

1. Номын бэлэгтэй тэмцээн /АХА, хөгжөөнт тэмцээн, шүлгийн уралдаан/ СӨБ-ийн хүүхдүүдийн дунд шүлгийн уралдаан зохион байгуулж оролцсон нийт хүүхдүүдэд ном бэлэглэсэн. АХА тэмцээнд нийт 60 гаруй сурагчид оролцож 2-р сургуулийн 11а ангийн сурагч Мөнгөнбаяр түрүүлж ном дурсгалын зүйлээр шагнагдсан.

Шинэ номын болон уйгаржин монгол бичгийн номын үзэсгэлэн

Номын худалдаа /шилдэг номын уралдаанд шалгарсан шинэ ном болон ЕБС-ийн сурах бичиг/

1. Ном солилцох- ЕБС-ийн сурагчид өөрийн уншсан номоо бусадтайгаа солилцон уншсан.

2. АЗДТГ нийтийн номын санд ном бэлэглэсэн. Ном бэлэглэх – номын баярт идэвхитэй оролцсон иргэдэд шинэ номын дээжисээс бэлэглэсэн
3. “Утгын сүүн эгшиглэн” ахмад яруу найрагчдын тэмцээнийг 10 сарын 12-нд Утга зохиолын нэгдэлтэй хамтран зохион байгууллаа. Уг уралдаанд 15 ахмад өөрийн зохиосон шүлгээ уншиж, Тэргүүн байрыг 5-р сургуулийн багш Н.Баттөмөр, Дэд байрыг Дөш нар эзэлсэн.

Сургалт

Сумдын болон сургуулийн номын сангуудын номын санч нарт 2 удаа сургалт зохион байгуулж, номын санчдын чадавхийг дээшлүүлсэн.

Үндэсний ном сангийн Ахлах арга зүйч.докторант Б.Энхжаргал багш хичээл зааж, арга зүйн зөвлөгөө өгсөн.

- Номын сангийн үйл ажиллагаанд баримтлах эрх зүйн баримтууд /стандарт/
- Номын сан, ном зүйн ангилал /дадлагатай/
- Фондын бүтэц, зохион байгуулалт
- Номын сангийн автожуулалт, программ хангамж
- Лавлагаа ном зүйн ажилд мэдээллийн технологийг нэвтрүүлэх,
- / Access / программд ном зүйн бүртгэл, картын санг бүртгэх
- Ном сэлбэн засах зэрэг сэдвээр хичээл зааж, арга зүйн зөвлөгөө өгсөн.

Нийт төвийн болон сум, сургуулийн нийт 13 номын санч

ха

мрагдсан.



Цахим номын үйлчилгээ:

Цахим номын үйлчилгээгээр 804 хүнд үйлчилсэн байна.
Цахим номын фондыг:

- 237 ширхэг монгол,
- 4 ширхэг англи орчуулгын

12 төрлийн номоор баяжуулсан.

Интернэт мэдээллийн үйлчилгээ:

Интернэт мэдээллийн үйлчилгээгээр 1211 хүнд үйлчилсэн.
Номын сангийн үйлчилгээг автоматжуулан байгууллагын үйлчилгээний 7-н компьютерийг дотоод сүлжээнд холбосон.
. Интернэтийн үйлчилгээнд нэмж 2 ширхэг компьютер холбон нийт 5 компьютерээр интернэтийн үйлчилгээ үзүүлж байна.
Байгууллагын үйл ажиллагааг сурталчилах зорилгоор Вэб сайт нээсэн.
Вэб сайтанд :
Байгууллагын танилцуулга, үйлчилгээ, шинэ номын мэдээ, соёл олон түмний ажил, цахим ном, мэдээ мэдээлэл зэргийг байршуулсан.
Хэвлэн олшруулах, канон, скайнердах, зэрэг нэмэлт үйлчилгээнүүдийг үзүүлсэн.
уншигчдын хэрэгцээт мэдээллийг интернэтээс татах, хэрэгцээт мэдээллийг олж мэдээллийн самбарт байрлуулсан.

ДАРХАН -УУЛ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ТАЙЛАН

Дархан сум 2012.12.10

Эрхэм зорилго: Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг аймаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд, номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, уншигч бие даан боловсрол эзэмших, номын санг иргэдийн мэдээллийн төв болон хөгжүүлэхэд оршино.

Нэг. Удирдлагын менежментийн талаар.

Дархан-уул аймгийн Төв номын сан нь ТБУС-ийн тухай хууль, орон нутгийн засаг захиргаанаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

2012 онд Аймгийн төв номын сан нь 15 ажиллагсадтай, харъяа 1 салбар номын сантай орон нутгийн уншигч иргэдэд үйлчлэв.

Номын сангийн нийт жилийн төсөв 120110.6 мян. төгрөг батлагдсанаас
- Цалин хөлс 84653.2
- НДШ бусад тэтгэвэр тэтгэмж 9311.9
- Ном авах зардал 5000.0
- Бараа үйлчилгээний бусад зардал 24645.5
- өөрийн үйл ажиллагааны орлого 50.0 төгрөг батлагдаж зарцуулагдав.

Байгууллагын ашигтай үйл ажиллагааны орлого 2621.7 мян. төгрөгний ашигтай ажилласан байна.

Аймгийн төв номын сан нь “2009-2012 онд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр”-өө боловсруулж, номын сангийн хэтийн зорилго, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүнгээ тодорхойлон ажиллаж байна. Номын сангийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд удирдлагын менежментийн үйл ажиллагаа нь:
- Номын сангийн материаллаг баазыг бэхжүүлэх
- Номын санд мэдээллийн технологи нэвтрүүлэх
- Олон нийттэй харилцах харилцааг өргөжүүлэх
- Уншлага- үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх
- Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэгдэж байна.

Аймгийн Төв номын сангийн дэргэд БСШУ- ны сайдын 2001 оны 180-р тушаал /Номын сангийн үйл ажиллагаанд олон улсын ДДС ангилал нэвтрүүлэх тухай/, 2005 оны 441-р тушаал / номын сангийн данс, маягт шинэчлэн батлах тухай/, Сангийн сайд, БСШУ-ны сайдын хамтарсан 357/406 тоот тушаал /Ном хэвлэлийг дахин үнэлэх тухай/-ыг хэрэгжүүлэх, номын сангийн цахим програм “Lib-4U”-д ном хэвлэлийн бүтээгдэхүүн, каталогийг цахим хэлбэрт оруулах “Ажлын хэсэг” байгуулагдан 5469 нэр төрлийн 12095 боть номыг бүрэн техник ажиллагаа хийн, нэгбүрчилсэн бүртгэлд бүртгэж, цахим хэлбэрийн каталогтой болгон уншигчдад ашиглуулж байна.

Аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд Аймгийн төв номын сан, музей, хүүхдийн номын ордны үйл ажиллагааг нийтийн хүртээл болгох зорилготой “Нээлттэй хаалга”-ны өдрийг “ Дархан-50” цогцолборт зохион байгууллаа.

“Нээлттэй хаалга”-ны өдрөөр дараахь арга хэмжээнүүд боллоо. Үүнд:
Төв номын сангийн үйл ажиллагааны танилцуулга. Үүнд:

- ✓ Номын сангийн дэргэдэх Дэлхийн банкны мэдээллийн төвийн үйл ажиллагаа
- ✓ Номын сангийн дэргэдэх МННХ /Соросын сан/-н ивээн тэтгэлэгээр байгуулагдсан Боловсролын Зөвлөгөө Мэдээллийн Төвийн /БЗМТ/ үйл ажиллагаа
- ✓ Төв номын сангийн веб сайтын танилцуулга
- ✓ Номын сангийн lib-4U програмын танилцуулга
- ✓ Цахим номын сангийн танилцуулга
- ✓ Шинэ номын үзэсгэлэн
- ✓ Дэлхийн банк, БЗМТөвийн мэдээллийн материал тараах
- ✓ Соёл олон түмний ажлын үзэсгэлэн

Аймгийн төв номын сангийн www.darlib.mn веб сайт, http://darkhan-library.blogspot.com/ блог дээр номын сангийн үйл ажиллагаа, шинэ номын мэдээ, аймаг, орон нутгийн холбогдолтой 239 мэдээ, мэдээллийг тавьж 26325 хүн хандан мэдээлэл авсан байна.

Гадаадын их, дээд сургууль, TOEFL-ийн шалгалтын талаар мэдээлэл авах, гадаад, дотоодын их дээд сургуульд онлайнаар бүртгүүлэх, хууль эрх зүйн актууд болон бусад сонирхсон сэдвүүдээр эрэл хайлт хийж 839 хүн интернетээр үйлчлүүлсэн байна.

Интернетийн үйлчилгээг ашиглан Дэлхийн банк, Америкийн боловсролын байгууллага, АНУ-ын ЭСЯам, УБ хотын Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв, БСШУЯам, Үндэсний номын сан, бусад аймгуудын номын сантай хамтран ажиллаж үйл ажиллагаагаа явуулж байна.

ОХУ-ын Москва, Иркутск, Улан-Үдэ хотын номын сангийн төлөөлөгчдийг өөрийн ном сан дээр хүлээн авч “Номын сангийн өнөөгийн хөгжил” сэдэвт уулзалт-ярилцлага зохион байгуулж, харилцан туршлага солилцов.

Аймаг байгуулагдсан өдрөөр соёл урлагийн байгууллагад он удаан жил номын санч Да. Сарантуяа “МУСТАжилтан” цол тэмдэгээр, номын санч С.Нэргүй Аймгийн дээд шагнал “Найрамдлын Дархан” медалиар шагнагдав.

Хоёр. Номын сангийн уншлага үйлчилгээний талаар

2012 онд:

- Байнгын уншигч	3869
- Ирэгсэд	56778
- Ном олголт	94043

- Номын сан нь уншлага үйлчилгээндээ ном хэвлэлээ тогтмол сурталчилж, шинэ номын мэдээллийн сангаар үйлчлэх, ном хэвлэлийн тойм, ашигтай зөвлөмж материалуудыг хувилж уншигчдын хүртээл болгох, эрэл хэрэгцээг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

- 2012 онд Төв номын сангийн үйл ажиллагаатай танилцуулах, хүүхэд багачуудыг номтой ойртон нөхөрлүүлэх, үйлчилгээний хүрээг өргөтгөх зорилгоор цэцэрлэгийн болон ЕБС-ын бага ангийн 634 хүүхдэд үнэ төлбөргүй карт нээж, ном хэвлэл олгож үйлчилсэн байна. Мөн зөөврийн номын сангаар ШШГЕГазрын харъяа 435-р анги, ОИЦ сургуулийн сурагчид, 1,15-р сургууль, 1,18,15,23-р цэцэрлэгийн хүүхдүүдэд өөрийн фондын болон МҮНСангаас зохион байгуулж буй “Ардын элч” явуулын номын сангийн 1200 ном олгож үйлчилсэн байна.

- Уншигч хэрэглэгчдийн оюуны эрэлт хэрэгцээг хангах тэднийг номын сантай нөхөрлүүлэх, ном хэвлэлээс өөрсдийн хэрэгцээтэй мэдээллийг авч сурахад нь

туслах зорилгоор урилгат уншлагыг ОИЦ, “Од” цогцолбор 15, 16-р сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж 418 сурагчид хамрагдан 500 гаруй ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр үйлчлүүллээ.

- Номын баяраар “Тэргүүний уншигч Д.Нацагдорж” тэмдэгтний болзолыг хангасан ОИЦ сургуулийн сурагч 18-р сургуулийн сурагч Ч.Эрдэнэчимэг, ШУТИС-ийн оюутан Б.Балжинням нарын сурагчдыг шагнаж урамшуулав.

Аймгийн Төв номын сангаар үйлчлүүлж байгаа уншигчдын 40 гаруй хувь нь ЕБС-ийн сурагчид, 60-аад хувь нь их, дээд сургуулийн оюутнууд, насанд хүрэгсэд, өндөр настнууд байна. Нийт ном олголтын 60-80 хувийг нийгэм, улс төр, эдийн засаг, хууль эрх зүй, гадаад хэл, уран зохиолын номнууд, 20-иод хувийг тогтмол хэвлэл эзэлж байна.

Төв номын сан нь 40 гаруй нэр төрлийн цахим хэвлэлийн бүтээгдхүүнтэй болж байна. Үүнд:

- Монгол улсын хуулийн сан
- Монголын зохиолчдын шилдэг 50 бүтээлийг нэгтгэсэн цахим номын сан
- Монголын Үндэсний номзүйн бүртгэл мэдээллийн сан
- Анагаах ухааны номын сангийн эрдэм шинжилгээний бүтээлүүд
- Монголын нууц товчоо г.м.

Гурав. Номын сангийн фонд, номзүйн лавлагаа мэдээлэл, каталог зохион байгуулалтын ажлын талаар

Төв номын сангийн фондын зохион байгуулалт, бүрдүүлэлт, номзүйн мэдээлэл, каталог картын санг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, уншигчдын хэрэгцээ шаардлагыг хангахуйц шинэ ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр фондоо баяжуулж байна.

- Аймгийн Төв номын сан нь БСШУ-ны сайдын 2001 оны 180, 2005 оны 441-р тушаал, “Аймгийн төв номын сангийн хөгжлийн хөтөлбөр” /2009-2012/ -ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 8660 нэр төрлийн 26313 боть ном хэвлэлийн бүтээгдэхүүн номын сангийн анхан шатны шинэчилсэн бүртгэлд бүртгэгдэж, олон улсын DDC ангиллаар ангилалагдсан байна. Үүнээс 2012 оны байдлаар 5469 нэр төрлийн 12095 боть ном номын сангийн Lib-4U програмд цахим хэлбэрт шилжив. Мөн номын санд нийтдээ 1550 гаруй цаасан каталог шинээр бичигдэж, уншигчдын хэрэгцээнд ашиглагдаж байна.

Төв номын сан нь 2012 онд 5885.385 мян. төгрөгний 525 боть ном хэвлэлийн бүтээгдэхүүн авч фондоо баяжуулан уншигч олны хүртээл болголоо

Төв номын сан нь 2012 онд шинээр ирсэн 525 боть номын агуулгын тайлбартай бүртгэлийг гарган, мөн товч агуулгатай нь номын сангийн веб сайтад байршуулан уншигчдын хэрэгцээ шаардлагыг ханган ажиллаж байна.

2012 онд 543 уншигчдад амаар болон утсаар лавлагаа өгч 118 татгалзал бүртгэгдэж 30 татгалзлыг барагдуулсан байна.

Урагдаж гэмтсэн 9545 номыг сэлбэн засварлаж, тогтмол хэвлэлийг сар улирлаар нь боть болгон үдэж хавтаслан уншигчдын хүртээл болгов.

Дөрөв. Номын сангийн СОТАжлын талаар

Аймгийн төв номын сан нь 2012 онд хүүхэд залуусыг номтой нөхөрлүүлэх, тэдний чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, таних мэдэхүй, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд зориулсан соёл олон түмний ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- ”Дэлхийн номын өдөр”-ийг Аймгийн ЗДТГазар, БСГазар, ХНОрдон, “Номын ундраа” номын дэлгүүр, Дархан их дэлгүүр, Монголын зохиолчдын эвлэлийн Дархан-Уул аймаг дахь салбар хамтран зохион байгууллаа.

“Дэлхийн номын өдөр”-ийн арга хэмжээнд Аймгийн Засаг дарга Эрдэнэбат, ИТХ-ын дарга Л.Гүнчин, БСГазрын дарга Батжаргал, УГЗүтгэлтэн, зохиолч Одончимэд нар оролцож. баяр хүргэж, үг хэллээ.

Энэ арга хэмжээний үеэр дараах ажлууд зохион байгуулагдав.

- ЕБС-ийн 1-5 ангийнхны дунд “Үлгэрийн баатрыг хэн сайн зурах вэ?” зургийн уралдаанд 200 гаруй хүүхэд хамрагдлаа. 22, 15, 16, 4 дүгээр сургуулиуд сайн зохион байгуулж олон хүүхэд хамрагдлаа.
- Цэцэрлэгийн ахлах ангийн хүүхдүүдийн дунд “ Үлгэрийн баатрууд амилсан нь” сэдэвт “Хэн хамгийн гоё үлгэрийн баатрын хувцастай вэ” уралдааныг зохион байгуулж 80 гаруй хүүхэд оролцов. 4, 5 дугаар цэцэрлэгүүд, эцэг, эхчүүд хувиараа маш идэвхитэй оролцлоо.
- Танин мэдэхүйн “АХА” тэмцээнийг ЕБС-ийн “Од”, 15, 16 дугаар сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж амжилттай боллоо.
- Нийт оролцогчдын дунд “Ном таны бодлоор” 4 мөртийн уралдаан зохиогдож 100 гаруй хүн амжилттай оролцлоо.
- Энэ арга хэмжээний үеэр МЗЭ-ийн гишүүн М.Уянсүх өөрийн шинэ номын хуримаа хийлээ.

“Дэлхийн номын өдөр”-ийн арга хэмжээнд УИХ-ын гишүүн Сүхбаатар, УГЗүтгэлтэн Одончимэд, “Соён гэгээрүүлэгч” телевиз оролцлоо.

Мөн УБ хотоос зохиолч Шүүдэрцэцэг өөрийн номоо 20 хувийн хөнгөлөлттэй, гарын үсэгтэй худалдаа, “Шилдэг цуврал” номын худалдаа, “Багшгүйгээр англи хэл сурцгаая”, “Энерги” цуврал номын зохиогчийн номын худалдаа, “Эрдэм” номын дэлгүүр, Дарханы зохиолчид хөнгөлөлттэй, гарын үсэгтэй худалдаа, хуучин ховор номын худалдаа, “Номын ундраа” дэлгүүрийн бэлэгтэй худалдаа зохион байгуулагдлаа.

Дархан-Уул аймгийн БСГазрын мэргэжилтэн Эрхэмсайханы “Эх сайхан монгол бичиг минү”, Аймгийн төв номын сан, ХНОрдон номын үзэсгэлэн гаргаж ном хэвлэлээ сурталчиллаа.

Дээрхи арга хэмжээнд “Залуучууд” театрын дэргэдэх “Дионис” драмын дугуйлангийн сурагчид, “Хүслийн шувуухай” чуулгын сурагчид тоглолтоо хийлээ.

- Жил бүрийн тавдугаар сарын эхний ням гаригийг “Үндэсний бичиг соёлын өдөр” хэмээн тунхагласан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 тоот зарлигийг үндэслэн Дархан-Уул аймгийн төв номын сан, Хүүхдийн номын ордон, “Иргэний боловсролын төв”, “Номын ундраа” дэлгүүр, “Дархан Элит” 22 дугаар сургууль, “Цайхун” 28 дугаар сургууль хамтран Үндэсний бичиг үсгийн баярыг 5 дугаар сарын 11нд тэмдэглэн өнгөрүүллээ. Энэ арга хэмжээний үеэр дараахь арга хэмжээ зохион байгуулагдав. Үүнд:

- 9-11 дүгээр ангийн сурагчдын дунд “Монгол бичиг бидний үндэсний бахархал” эсээ бичлэгийн уралдаан, үзэсгэлэн
- 7-8 дугаар ангийн сурагчдын дунд “Хурдан уншлагын уралдаан”
- Нийт оролцогчдын дунд “Уран бичлэгийн уралдаан”
- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын удирдлага, ажилтнуудын дунд “Миний нэрийн хуудас” сэдэвт уран бичлэгийн уралдаан зохион байгуулагдав.

Мөн энэ арга хэмжээний үеэр:

- “Ном дор мөргөмү” монгол бичгийн номын үзэсгэлэн, шинэ номын үзэсгэлэн худалдаа
- Монгол бичгийн уран бичлэг, бичгийн хэрэгслийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдав.

“Монгол бичгийг дээдлэгч” байгууллага хамт олноор “Од” цогцолбор сургууль шалгарч батламж гардан авлаа.

“Үндэсний бичиг үсгийн баяр”-т “Од” цогцолбор, 18, 15, 8, 22, 28 дугаар сургуулиуд багш, сурагчидаа сайн зохион байгуулж, идэвхитэй оролцлоо.

- Дархан-Уул аймгийн төв номын сан, Хүүхдийн номын ордон, “Номын ундраа” номын дэлгүүр, “Мөнхийн үсэг” хэвлэлийн газрууд хамтран Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд номын баярын өдөрлөгийг “Найрамдал” талбайд 9-р сарын 19-ний өдөр 11-17 цагт зохион байгууллаа.

Өдөрлөгийг Монгол улсын Ерөнхийлөгчийн “Номын баярын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай зарлигийг хөтлөгч Ганчимэг уншсанаар эхэлж, Аймгийн ИТХ-ын дарга Л.Гүнчин, Төв номын сангийн захирал С.Лхамсүрэн нар нээж үг хэллээ.

Өдөрлөгийн нээлтэнд “Уран зохиолын баатрууд амилсан нь” 200 гаруй хүүхэд оролцсон багт наадмын жагсаал явагдав.

Өдөрлөгийн үеэр “Тэргүүний уншигч Д.Нацагдорж” тэмдэгийн болзол хангасан 18-р сургуулийн сурагч Ч.Эрдэнэчимэг, ШУТИС-ийн оюутан Б.Балжинням нарт шагналыг захирал С.Лхамсүрэн, ХНО-ын захирал Мөнхбаатар нар гардуулан өглөө.

Өдөрлөгийн арга хэмжээнд “Залуучууд” театрын уран бүтээлчид оролцлоо.

Мөн БСШУЯамны хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймгийн ХНО, сум, төрийн өмчийн ЕБС, цэцэрлэгүүдэд хувиарлагдан ирсэн 172 нэр төрлийн 1458 боть 24363678 төгрөгний номыг гардуулан өглөө.

Өдөрлөгийн үеэр Төв номын сан, ХНО, сургууль, цэцэрлэгүүд шинэ номын болон бүтээлийн үзэсгэлэн гаргаж, номын худалдаа ажиллаа. Мөн хэвлэл мэдээллийн бүх байгууллагууд оролцож ярилцлага авав.

Өдөрлөгийн арга хэмжээнд нийт 600 гаруй хүн оролцож төв номын сан, хүүхдийн номын ордон, сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаатай танилцлаа.

- Дархан-Уул аймгийн төв номын сан, Хүүхдийн номын ордон, Аймгийн музей, “Залуучууд” театр хамтран “Их хотын баяр” нээлттэй хаалганы өдрийг 9-р сарын 22-ний өдөр 10-17 цагт зохион байгууллаа.

Нээлттэй хаалганы өдрөөр дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулав.

1. Шинэ номын үзэсгэлэн 100 гаруй номоор
2. Гадаадад сурах асуудлаар зөвлөлгөө өгөх төвийн номын үзэсгэлэн 150 гаруй номоор
3. Уран бичлэгийн номын үзэсгэлэн 20 гаруй
4. Нүүдлийн номын сангийн үзэсгэлэн 50 гаруй номоор
5. Номын сангаас зохион байгуулсан соёл олон түмний ажлын материалын үзэсгэлэн 30 гаруй бүтээлээр
6. Төв номын сангийн үйл ажиллагааг харуулсан зурагт самбар
7. Нээлттэй хаалганы өдөрт оролцогсдод 50 хувийн хөнгөлөлттэй уншигчийн карт 70 гаруй хүнд нээсэн
8. Гадаадад сурах асуудлаар зөвлөлгөө өгөх 170 гаруй хүнд өгөв.

Нээлттэй хаалганы өдрийн арга хэмжээг Аймгийн орлогч дарга н.Батсүх

нээж,БСГазрын мэргэжилтэн Дашзэвэг, Нийгмийн хөгжлийн хэлтэсийн мэргэжилтэн Баяржаргал, номын сангийн захирал С.Лхамсүрэн, музейн захирал Болорсүх нар оролцлоо.

Нээлттэй хаалганы өдрийн үеэр номын санч С.Нэргүй "Найрамдлын Дархан" тэмдэгээр шагнагдав.

Аймгийн орлогч дарга н.Батсүх Аймгийн соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж заавар, зөвлөмж өглөө.

Нээлттэй хаалганы өдөрт нийт 500 гаруй хүн оролцож Аймгийн төв номын сан, Хүүхдийн номын ордон, Аймгийн музейн үзвэр, үзэсгэлэн, үйл ажиллагаатай танилцаж, мэдээлэл авлаа.

- "Номтой нөхөрлөе" аяны хүрээнд Сумын ЗДТГазар, аймгийн БСГазартай хамтран ЕБС-ийн сурагчдын дунд "Оюуны лянхуа" яруу найргийн наадмыг зохион байгуулж 80 гаруй багш сурагчид оролцлоо.

"Ухаарал хайрласан шүлэг", "Урагшлах замд ухаан нэмэх", жил бүр МҮОНТ-ээс жил бүр зохион явуулдаг "Ижийдээ захидал бичээрэй" уралдаанд оролцогсдын бүтээлээр "Залуус дүү нартаа" сэдэвт эчнээ уншигчдын бага хурлыг 1,4,26 дүгээр сургуулийн сурагчид, ШШГГазрын харъяа 445, 435 дугаар хорих ангийн хүмүүжигчдийн дунд тус тус зохион явуулж 150 гаруй хүн хамрагдлаа.

- Номын сантай танилцах өдөрлөгийг 1,12,15,21-р цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж 250 гаруй хүүхэд хамрагдлаа.

- 21-р цэцэрлэгийн бэлтгэл болон ахлах ангийн хүүхдүүдэд "Бэлэн амт хулгана", " Заан оготно хоёр" номоор чанга уншлага хийж 250 хүүхэд хамрагдлаа.

- "Монгол ёс заншил" сэдвээр 18-р цэцэрлэгийн багш ажилчдын дунд АХА тэмцээн зохион байгуулж 36 хүн хамрагдав.

- Аймгийн ЕБС-ын албан бус сургалтын багш нартай хамтран ажиллаж холимог бүлгийн 60 сурагчийг гомын сангийн уншигчаар бүртгэн авч номын сантай танилцах аялал зохион байгуулж, Д.Гармаагийн "Хөгжөөнтэй туужууд", Түмэнжаргалын "Гэмшил", "Сургамжит өгүүллэгүүд" зэрэг номоор чанга уншлага, тойм яриа хийлээ. Мөн 15-р сургуулийн холимог бүлгийн 6 сурагчийг номын сангийн туслагч сурагч болгон хамтран ажиллаж байна.

- Түүхт ой, тэмдэглэлт өдрүүд, соёл олон түмний ажлын хүрээнд сэдэвчилсэн номын үзэсгэлэн 28 удаа 1166 боть номоор, шинэ номын үзэсгэлэн 10 удаа 525 боть номоор тус тус гарган өөрийн фондын номоо сурталчилсан байна.

ТҮ-9 болон орон нутгийн телевиз, радио, сонингоор өөрийн үйл ажиллагааг 12 удаа сурталчиллаа.

Тав. Сургалт-семинар аргазүйн ажлын талаар

2012 онд номын сангийн ажилтнууд дараах сургалтуудад хамрагдлаа. Үүнд:

- Аймгийн төв номын сангийн удирдлагуудад зориулсан "Номын сангийн салбарын бодлого, хэрэгжилт болон менежмент, технологийн шинэчлэл" сэдэвт 3 өдрийн сургалтанд Улаанбаатар хотод ахлах номын санч Ч.Бадамцэцэг оролцлоо.

Сургалт-семенарын төгсгөлд аймаг, сумдын нийтийн номын санд хөрөнгө оруулалтаар олгох компьютерүүдийг хуваарийн дагуу өгөх ажил БСШУЯ дээр зохион байгуулагдлаа. Энэ хуваарийн дагуу Аймгийн төв номын санд 5, Хүүхдийн номын ордонд 5, сумдын соёлын төвүүдийн номын санд тус бүр 1 компьютер хуваарлагдан ирснийг гардуулан өгч, орон нутгийн радио, телевизээр сурталчиллаа.

- УБ хотноо 2010 оны 3-р сарын 9-10-ны хооронд зохион байгуулагдсан "Иргэний нийгмийн үзэл баримтлал" үндэсний чуулганд Дархан-Уул аймгаас 10 төлөөлөгч оролцлоо. Төв номын сангийн дэргэдэх БЗМТөвийн зохицуулагч Г.Нямцэнд Дархан-Уул аймгийн иргэний нийгмийн зөвлөлийн гишүүдтэй хамт оролцоод ирлээ.

- Аймгийн ҮЭХолбооны II бүгд хуралдаан болж, номын сангийн ҮЭХорооны дарга Ч.Бадамцэцэг, тэргүүлэгч гишүүн Г.Нямцэнд нар оролцлоо. II бүгд хуралдаанаар “Аймгийн ҮЭХолбооны 2011 онд хийсэн ажил”, “Аймгийн ҮЭХолбооны 2012 онд хийх ажлын төлөвлөгөө”-г танилцуулж, төсвийн ажилтнуудын нийгмийн халамж, цалин хөлсний талаар ярилцлаа.

- Гадаад уншлагын танхимын номын санч Г.Нямцэнд нь Дархан-Уул аймгийн ШУТИС-д БСШУСайдын 2001 оны 45 тоот тушаалаар батлагдсан “Сургах зүйн боловсрол” курсэд суралцаж “Дээд боловсролын сургалтын байгууллагад багшлах эрх”-ийн үнэмлэх авлаа.

- Номын санч Н.Норжмаа УБ хотноо “Номын сан- мэдээллийн технологи” сэдэвт мэргэжил дээшлүүлэх сургалтанд 4 дүгээр сарын 9-11 нд хамрагдан оролцлоо.

-УБ хотын соёлын дээд сургуулийн номын сангийн ангийн бакалаврын “Онлайн” сургалтанд 2 хүн суралцаж байна.

Зургаа. Шинэлэг үйлчилгээ- бүтээлч ажил.

Төв номын сангийн дэргэдэх Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв /БЗМТ/ нь Соросын сан, АНУ-ын ЭСЯамнаас зарлагддаг :

- “Тэтгэлэгийн хөтөлбөр”,
- “Магистрийн тэтгэлэгт хөтөлбөр”,
- “Болгар дахь Америкийн их сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”,
- “Оюутан солилцооны хөтөлбөр”,
- “Англи хэлний багш нарын хөтөлбөр”
- “Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрүүд”
- “USAP-ийн тэтгэлэгт хөтөлбөр”-үүдийг ЕБС-ийн сурагчид, их, дээд сургуулийн багш, оюутнууд, эдийн засгийн мэргэжилтнүүдэд сурталчлан 23 удаа лекц зохион байгуулж 1200 хүн хамрагдсанаар:
- Болгар дахь Америкийн их сургуульд 29 сурагч шалгалт өгч 2 сурагч Англи хэлний 3 дугаар түвшний сургалтанд, 1 сурагч 1 дүгээр түвшний сургалтанд тус тус тэнцэн суралцах урилга авч, Дархан-Уул аймгаас 2012 онд 5 сурагч Англи хэлний 1 дүгээр түвшний сургалтанд сурч байна.

-Оюутан, сурагчдыг гадаадад сурах асуудлаар мэдлэгтэй болгох зорилгоор

“Болгар дахь Америкийн их сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”, “АНУ-ын их дээд сургууль,коллежид суралцуулах тэтгэлэгт хөтөлбөр USAP-2013” сэдэвт уулзалт, ярилцлагыг ЕБ-ийн 21,19,1,4 дүгээр сургууль, ХААИС, Дархан дээд сургууль зэрэг газруудад зохион байгуулж 519 оюутан, сурагчид хамрагдлаа.

- Аймгийн ЗДТГазар, аймаг, сумдын ИТХ, ТББ-тай хамтран төр, олон нийт, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, мэдлэг олгох “Мониторинг, байгууллагын нийгмийн хариуцлага”, “Иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлал”, “Төр-ТББ-ын түншлэл” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг 5 удаа зохион байгуулж 170 хүн оролцов.

- 2012 онд БЗМТ нь англи хэлний анхан, дунд, гүнзгий шатны болон TOEFL-ийн сургалтыг 11 удаа явуулж 112 оюутан, сурагчид хамрагджээ.

-Төв номын сангийн дэргэдэх БЗМТөв нь орон нутагт оюутан сурагчдаас түвшин тогтоох шалгалтыг 436, Pre TOEFL-ийн шалгатыг 318 хүүхдээс авлаа.

- БЗМТөв нь Дэлхийн банк, ННФорум, тэтгэлэгт хөтөлбөрүүдийн талаар:

-ганцаарчилсан зөвлөгөө	517
- группын зөвлөгөө	677
- Утсаар	513

- Email хаягаар 1519 удаа тус тус зөвлөлгөө өгч ажилласан байна.

- Сурагчид, оюутны англи хэлний мэдлэг эзэмшүүлэх зорилгоор гадаад хэлний санй дурын ажилтан Патриктай хамтран англи хэлний ярианы клубыг 22 удаа зохион байгуулж 280 хүн хамрагдлаа.

Долоо. Бусад ажлын талаар

Аймгийн Төв номын сан нь 2012 онд үйл ажиллагаагаа сурталчлах, орчноо тохижуулах, ажилтнууд, уншигч-хэрэглэгчдийн ая тухтай орчинг бүрдүүлэх дараахи ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Номын сангийн интернетийн хурдыг нэмэгдүүлэх, уншигч хэрэглэгчдийн үйлчилгээг хурдасгах зорилгоор шилэн кабель тавиуллаа.
- Номын сангийн вэб сайт болон блогт шинэ мэдээ мэдээллийг байнга баяжуулан тавьж байна.
- Байгууллагын гадна орчинг тохижуулах, ногоон байгууламжийг бий болгох зорилгоор 2 мод тарьж, 5 бут арчилж, 5 тасалгааны, 11 цэцгийн мандалд цэцэг тарьж ургууллаа.
- Хуучин Дарханы салбар номын сан, Дэвшил дэх архивын фонд, төв салбарт 3674.0 мян. төгрөгний урсгал засвар хийсэн.

Найм. Цаашид тавих зорилт.

Аймгийн төв номын сан нь “Номын сангийн хөгжлийн хөтөлбөр”-т тусгасан зорилтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх,

“ Номын сангийн анхан шатны бүртгэл маягтыг шинэчлэх тухай” БСШУ-ны сайдын 441, 180, Сангийн сайд, БСШУ-ын сайдын хамтарсан 357/406 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд анхан шинэчилсэн маягтыг хөтлөх, ном хэвлэлээ дахин үнэлэх, олон улсын ДДС ангиллаар ангилах ажлыг үргэлжлүүлэх,

Номын сангийн програмд монгол фондын номыг оруулж бүрэн дуусгах.

Аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд “Нээлтэй хаалга”-ны өдрийг “Дархан-50” цогцолборт зохион байгуулж үйл ажиллагаагаа сурталчилав.

Аймгийн ЗДТГ, БСГ, ХНО, “Номын ундраа” дэлгүүр, ДИД, МЗЭ-ийн Дархан-Уул аймаг дахь салбартай хамтран “ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР”-ийг анх удаа тэмдэглэж, “Үлгэрийн баатрууд амилсан нь”, “Хамгийн гое хувцастай үлгэрийн баатар”, “АХА”, “Ном таны бодлоор” дөрвөн мөртийн уралдаан, МЗЭ-ийн гишүүн М.Уянсүхийн шинэ “НОМЫН ХУРИМ”, УБ, Дарханы номын худалдаа ажиллаа.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 тоот зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХНО, “Иргэний боловсролын Төв”, “Дархан Элит”, “Цайхун”, “Турк сургууль”, “Номын ундраа” дэлгүүртэй хамтран “ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛЫН ӨДӨР”-ийг тэмдэглэн өнгөрүүллээ. “Монгол бичиг бидний үндэсний бахархал” эссэ бичлэг, “хурдан уншлага”, “Уран бичлэг”, “Миний нэрийн хуудас” уран бичлэгийн уралдаан зохион байгууллаа.

ТНС-гийн номын санчид БСШУЯ, МУЗГ, МҮЭ, ШУТИС, Соёлын дээд сургуулиас зохион байгуулсан сургалтанд 6 хүн хамрагдлаа. БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар ТНС, ХНО, сумдуудын Соёлын төв, театр, музейд тус бүр 1 компьютер олгосныг гардуулан өглөө.

“НОМЫН БАЯР ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ТУХАЙ” Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлыг ХНО, “Мөнхийн үсэг”, “Номын ундраа”, дэлгүүртэй хамтран ”Найрамдал” талбайд зохион байгууллаа. “Уран зохиолын баатрууд амилсан нь багт наадмын жагсаал, номын худалдаа, номын үзэсгэлэн, уран бүтээлчдийн тоглолт боллоо. БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар сум, сургууль, цэцэрлэгүүдэд хувиарлагдан ирсэн 172 нэр төрлийн 1458 боть 24.3 сая төгрөгийн ном, Төв номын сан, ХНО-д 24.0 сая/төгрөгний фургон машиныг гардуулан өгч, 600 гаруй хүн оролцов.

“Их хотын баяр” нээлттэй хаалганы өдрийг ХНО, Музей, “Залуучууд” театртай хамтран зохион байгууллаа. Нээлттэй хаалганы үеэр номын үзэсгэлэн, 50%-ийн хөнгөлттэй карт нээх зэргээр үйлчилж 500 гаруй хүн оролцов.

“Болгар дахь Америкийн Их сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”-т 13 сурагч онлайнаар өргөдлийн маягт бөглөж, 29 сурагч TOEFL-ын шалгалт өгч, Турк сургуулийн 11-р ангийн сурагч Солонго, ОИЦ сургуулийн 11-р ангийн сурагч Идэрмөнх нар нь Англи хэлний 3-р түвшний сургалтанд, ОИЦ сургуулийн 11-р ангийн сурагч Дөлгөөнмандах нь Англи хэлний 1-р түвшний сургалтанд тус тус суралцах урилга авч, 2012 онд Дархан-Уул аймгаас 5 сурагч Болгар дахь Америкийн Их сургуулийн хэлний курст амжилттай суралцаж байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2012 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2013.01.28

“Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага”,”Архив , номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага” стандартуудын шаардлагын түвшинг хангах, сумдын номын санг шаардлагатай байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрмжөөр хангах, номын санчдын мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, Номын сангийн үйл ажиллагаанд CDIS/ISIS программ нэвтрүүлэх ажлын бэлтгэлийг хангах зэрэг зорилт тавин дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Байгууллагын удирдлага зохион байгуулалт, дотоод ажлын талаар

1. Аймгийн Засаг даргатай байгуулсан Байгууллагын ерөнхий менежерийн 2011 оны үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүгнүүлж, 86,0 оноо авч “ Сайн” гэсэн үнэлгээ авсан болно.
2. Аймгийн Төв номын сангийн 2011 онд хийсэн ажлын тайланг БСШУЯ-ны сайдын 2008.12.24-ний өдрийн 154 тоот тушаалын хавсралт “ Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх үнэлэх журам” –ын дагуу 20 үзүүлэлтээр боловсруулан 8 хуудас, Су -10, Су -5 Су -3 мэдээг 4 хуудас , Аймгийн Засаг даргатай байгуулсан Байгууллагын ерөнхий менежерийн 2011 оны үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 8 хуудас тус тус бичиж, аймгийн ЗДТГ,БСГазарт 2012 оны 01 сарын 15 –ны дотор хугацаанд нь хүргүүлсэн.
3. Дорноговь аймгийн “Dornogovi.gov.mn” сайтад Аймгийн Төв номын сангийн тухай Вэб сайтын 4 хуудас электрон эх материалыг бэлтгэж байрлуулсан.
4. “Аймгийн Төв номын сангийн төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм” –д нэмэлт оруулах талаар хамт олны хурлаар хэлэлцэн баталж, самбарт томоор ил бичиж хадан мөрдөн ажиллаж биелэлтийг хагас бүтэн жилээр дүгнэж байна.
5. Улсын Мэргэжлийн хяналтын 2009 оны шалгалтын мөрөөр авах арга хэмжээний талаар стандарт хэрэгжүүлэх ажлын 2012 -2016 оны төлөвлөгөөг

боловсруулан баталж, төлөвлөгөөнд тусгагдсан доорх ажлууд хийж эхлээд байна.

Үүнд:

- Аймгийн Төв номын сангийн үндсэн болон хүүхдийн, гэрээр ном олгох фондуудын дулааныг +18 +_2, чийгшилийг 55+_5%, цонхнуудыг хар хөшигтэй болгон нарны гэрлээс хамгаалж, галын аюулгүй байдлыг хангах үүднээс 50 м2 талбайд нэг гал унтраагуур, өрөө тасалгаа бүрд нэг галын унтраагууртай болгон, гэрэл чийдэнгүүдийг номын тавиур, шкаф баримт, ном хэвлэлийн гадаргуугаас 0,5 метрээс багагүй зайд байрлуулан стандартыг ханган ажиллаж байна.
- Номын сангийн дотоод хяналт шалгалтын ажилтнаар номын санч Д.Алтанчимэгийг томилон, дотоод хяналтын журам боловсруулан мөрдөн ажиллаж, тайланг улирал ирүүлэн ажиллаж байна.
- Үндсэн болон ГНО тасаг, Хүүхдийн, хэвлэлийн фондын нэг бүрчилсэн бүртгэл , ерөнхий дансны товъёог хийсэн..
- “**Ном хэвлэлийн байгууллагад мөрдөх үндэсний стандартын эмхтгэл”.**2007он . номыг уншиж судлан өөрийн ажилдаа өдөр тутам мөрдөгдөх стандартуудын жагсаалт, гарын авлага хийж, номын сангийн үйл ажиллагаандаа өдөр тутам мөрдөж бүрэн хэрэгжүүлэх
- **“Номын сангийн анхан шатны бүртгэлүүд, хөтлөх аргачлал”.** 2006 он. номыг уншиж судлан өөрийн ажилдаа өдөр тутам хөтлөгддөг анхан шатны бүртгэлүүдийн жагсаалт, гарын авлага хийж, номын сангийн үйл ажиллагаандаа өдөр тутам үнэн зөв бүрэн гүйцэт хөтөлж хэрэгжүүлэх
- **Номын сангийн үйл ажиллагаанд баримтлах эрх зүйн баримт бичгүүд”**. 2011он. номыг уншиж судлан өөрийн ажилдаа өдөр тутам хэрэглэгддэг хууль, тогтоол, журам дүрмүүдийн жагсаалт, гарын авлага хийж, номын сангийн үйл ажиллагаандаа өдөр тутам мөрдөж хэрэгжүүлэх

6. Стандарт шаардлагыг хангаж ажиллах, орчин үед номын санд мэдээлэл технологийг хэрхэн нэвтрүүлэх, үйл ажиллагааг автоматжуулах, электрон каталогижуулах асуудлыг онол, практиктай нь хослуулан ажилдаа хэрэгжүүлэх зорилгоор аймгийн төв номын сангаас зохион байгуулсан ”Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах стандарт, шаардлага”, “Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага” сэдэвт сургалтанд 20 номын санч, “Компьютерийн анхан шатны сургалт”-д 10 сумын номын санч, “Номын сангийн CDS/ISIS программ-Электрон каталогжуулалт” сэдэвт сургалтанд сумын 12 номын санч,” Номын сангийн CDS/ISIS программд ном оруулах нэгдсэн журам”, “Ном сэлбэн засалт” зэрэг сэдэвт сургалтанд 7 номын санч оролцсон.

7. Улаанбаатар хотод болсон “Номын сан-Мэдээллийн технологи” сэдэвт сургалтанд 5 номын санч, “Номын сангийн шинэчлэл” сэдэвт сургалтанд 2 сумын номын санч хамрагдсан.

Эдгээр 7 удаагийн сургалтад нийт давхардсан тоогоор 63 номын санч оролцож, мэргэжил, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байна. Сургалтанд амжилттай оролцсон сумдын номын санч нарт Аймгийн Төв номын сангийн захирал Л.Цэнд-Аюуш сертификат гардуулсан.

8. Мөн сургалтын үеэр БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар аймгийн төвийн болон 12 сумын номын санд электрон катологийн үйлчилгээ нэвтрүүлэх зориулалт бүхий 12.3 сая төгрөгний 20 ширхэг компьютер олгосон байна. Аймгийн Төв номын сангаас 12 сумын номын сангийн компьютерт электрон катологийн хайлтын " Номын сангийн CDS/ISIS программ"-ыг үнэгүй суулган өгч , сумдын номын санч нар 5 хоногийн дадлага хийсэн. Мөн энэ үеэр аймгийн төв номын сангийн мэргэжлийн номын санч нар хичээл зааж өөрийн хариуцсан сумдын номын санч нарт заах арга зүйн зөвлөгөөг өгсөн.
9. Эрдэнэ, Айраг, Даланжаргалан, Олон-Овоо сумын номын сангийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн
10. Улаанбаатар хотод Соёлын дээд сургуулийн номын сангийн Бакалаврын зэргийн зайн ангид онлайн интернэтээр 3 номын санч суралцаж мэргэжлийн зэргээ ахиулж байна.
11. БСШУЯ –ны хөрөнгө оруулалтаар олгосон шилдэг шинэ номуудыг манай аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа 14 сумын номын сан, ЕБС-ийн 19 номын сан, 22 цэцэрлэгийн номын санд хуваарилсан нийт 42.7 сая төгрөгний 3550 ширхэг шинэ ном хэвлэлийг аймгийн төв номын сан өөрсдийн хүчээр нэгдсэн журмаар татан авчирч, хуваарилж, номын сангуудад хүргүүлсэн .

Үүнд:

14 сумын номын санд 25,8 сая төгрөгний 1749 ш, ЕБС-ийн 19 номын санд 11,8 сая төгрөгний 1213ш, 22 цэцэрлэгийн номын санд 5,1 сая төгрөгний 588 ш шинэ ном хэвлэлийг хуваарилж , падаан баримт бичиж нэг бүрчлэн хүлээлгэн өгсөн.

12. Мөн Аймгийн ИТХ –аас 14 сумдын болон ЕБС –ийн 19 номын санд хандивласан "Дорноговь аймгийн зохиолчдын цоморлог" - ном 67 ширхэгийг нэгдсэн журмаар хуваарилж хүлээлгэн өгсөн.
13. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2001 оны 180 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Номын сангийн нэгдсэн сүлжээг бий болгоход зориулан ЮНЕСКО-гоос эрхлэн гаргасан CDS/ISIS программыг номын сангийн үйл ажиллагаанд 2010 оны 05 сарын 01 –ний өдрөөс эхлэн нэвтрүүлж, Үндсэн болон ГНО тасаг, Хүүхдийн, хэвлэлийн фондын 7290 гаруй ном хэвлэлд электрон каталог бичиж, Гэрээр ном олгох тасагт электрон каталогийн үйлчилгээ шинээр нээж, номын фондоос уншигчид өөрийн хэрэгцээт унших номоо электрон катаологаас хайлт хийн ашиглаж байна.
14. Уншигчдын дунд зохион байгуулсан уралдаан тэмцээнд идэвхитэй оролцсон болон тэргүүний уншигч анги хамт олон, тэргүүний хувь хүмүүсийн шагналд 160000 төгрөг, Цагаан сар, эмэгтэйчүүдийн баяр, эх үрсийн баярын арга хэмжээ, өндөр настанд олгосон буцалтгүй тусламж, ажилчдын хүүхдүүдийн бэлэгт бүгд 182000 төгрөг зарцуулсан болно.
15. Аймгийн хэмжээнд зохион байгуулж байгаа арга хэмжээ, уралдаан тэмцээнд манай байгууллагын хамт олон амжилттай оролцож, эмэгтэйчүүдийн баг гар бөмбөгийн тэмцээнд багаараа хүрэл медаль, "Удирдах ажилтан – спорт" гар бөмбөгийн тэмцээний хүрэл медаль, мэдээллийн ажилтан Э.Цэндсүрэн шатрын тэмцээнд алтан медаль-2, мөнгөн медаль-1, номын санч Г.Цэндсүрэн теннисний ганцаарчилсан төрлөөр алтан медаль тус тус хүртэж, спортын өндөр амжилт гаргалаа.

.

16. Байгууллагын эрхэлсэн ажилдаа амжилт гарган 2012 оны Үр дүнгийн гэрээгээ сайн биелүүлсэн 8 албан хаагч, ажилтан 1,2 сая төгрөгний мөнгөн урамшил олгосон.

Хоёр. Уншлага үйлчилгээний 2012 оны тоон үзүүлэлтүүд

Номын санчийн нэр	Уншигч	Иргэсэд	Ном олголт, лавлагаа, мэдээ-лэл	Орлого	Сэргээн Засварлалт	Каталог, картын сан	Лавлагаа- ном зүйн тоо	СОНА-д хамрагдсан хүний тоо
Гансүрэн	500	5320	8741	250.0	200	Э.к -532	21	2105
Эрдэнэтуяа	=	602	698	162.9	187	Э.к-547 Ц.к-177	712	199
Баттогтох	355	5046	6124	355.0	79	Э.к -300	54	1289
Алтанчимэг	424	2812	3719	297.1	296	Э.к-1559 Ц.к-199	66	1228
Г.Цэндсүрэн	=	=	2450	=	300	Э.к -3617	110	120
Э.Цэндсүрэн	=	1600	1600	426.5	19	Э.к -609	20	230
Батчимэг	224	3346	3929	Бч.83.0 Бб.128.2	=	Э.к -126	19	=

Бүгд	1503	18726	27261	1702,7	1081	Э.К - 7290 Ц.К -376	1002	5171

НОМЫН ФОНДУУДЫН 2012 ОНЫ ТООН МЭДЭЭ

2012.12.31-ны байдлаар:

Фондын нэр	2011 оны эцсийн үлдэгдэл		2012 онд шинээр авсан		2012,12,31-ны байдлаар эцсийн үлдэгдэл	
	Номын тоо	Үнийн дүн	Номын тоо	Үнийн дүн	Номын тоо	Үнийн дүн
Үндсэн фонд	29136	29346,9	382	4622,1	29518	33969,0
ГНО фонд	12133	17218,2	261	3008,3	12394	20226,5
Хүүхдийн фонд	15782	7704,5	258	1594,7	16040	9299,2
Хэвлэлийн фонд	958	1342,1	22	201,5	980	1543,6
БҮГД ДҮН	58009	55611,7	923	9426,6	58932	65038,3

Гурав.Уншлага үйлчилгээ, номын фонд, сурталчилгааны талаар

17. Танхим, тасгуудын уншлага үйлчилгээг батлагдсан цагийн хуваарь журмын дагуу хүргэж, 1503 уншигчдын бүртгэлийг шинэчлэн 18726 ирэгсэд, үйлчлүүлэгчдэд , 27261 ширхэг ном , хэвлэл лавлагаа- мэдээлэл олгож үйлчилсэн. Гэрээр олгосон номыг гэр бүл хамт олны хүртээл болгох, уншигч, ном олголтыг нэмэгдүүлэх зорилгоор нэг уншигчийн авсан номыг тухайн гэр бүл, анги хамт олноороо унших, утсаар хугацааг сунгуулах болон урамшуулалт үйлчилгээ зэрэг шинэлэг үйлчилгээг нэвтрүүлж эхлээд байна.
18. Хүүхдийн уншланын танхимаас уншигчдын ном унших идэвхийг өрнүүлэх, Тэргүүний уншигчийг шалгаруулах, алдаршуулах , нийтэд сурталчлах зорилгоор “ 2012 оны Тэргүүний уншигч “ шалгаруулах уралдааныг зарлан дүгнэхэд 12 жилийн 1-р сургуулийн 4-д ангийн С.Цолмон багштай хамт олон, 12 жилийн 2-р сургуулийн 5-а ангийн Г.Саранцэцэг багштай хамт олон , 12 жилийн 2-р сургуулийн 4в ангийн сурагч Б.Уянгатөгөлдөр, 12 1-12 жилийн сургуулийн сурагч М.Баяртогтох, А.Зул, Л.Мөнхбаясгалан нарыг “Д.Нацагдорж тэргүүний уншигч” анги, тэргүүний уншигчаар шалгаруулан шагналыг аймгийн засаг дарга П.Ганхуяг гардуулсан.
19. Хүүхдийн уншлагын танхим, Цахим номын сантай хамтран 1-12 жилийн 1 –г ангийн 25 хүүхдүүдийн дунд Эрхий мэргэн”, “Жаран хөлт” гэсэн үлгэрүүдийг сонсгож ,“ Хэн олон Үлгэрийн баатар мэдэх вэ”, “Эрхийн мэргэн гэж хэн бэ” гэсэн асуулт хариултын тэмцээн бяцхан хүүхдүүдийнхээ дунд явуулж эхний 3 хүүхэд шалгаруулж, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулж, фото зурагжуулсан. ГНО хамтран шинэ номын үзэсгэлэн гаргаж телевизийн бичлэг

хийлгэж, НБ-хэлтэс Мөнхцэцэгийг урин оролцуулан, аймгийн вэб сайтад мэдээлэл өгсөн

20. Хүүхдийн танхимаас “Хүүхдийн үлгэрийн ном” зөөврийн номын санг 2, 4, 9 –р цэцэрлэг, мөн 1,5,3-р сургуулиудад 6 удаа аялуулж , 376 нэр төрлийн давхардсан тоогоор 3465 ширхэг номоор 1030 хүүхэд багачуудад үйлчилсэн.

21. Аймгийн ЗДТГ –ын вестюльд “Шинэ ном -2012” номын зөөврийн үзэсгэлэнг аймгийн төвийн агентлэг, төсөвт байгууллагын дарга нарын мэдээлэлийн цагаар гаргаж сурталчилсан нь шинэлэг ажил болж төрийн албан хагчдаас өндөр үнэлгээ авсан.

22. Аймгийн Төв номын сан Юнескогийн байгууллагын “Номын сангийн CDS/ISIS программ “- электрон каталогийн хайлтын программыг нэвтрүүлж , Үндсэн фонд, Гэрээр ном олгох тасаг, хүүхдийн номын фондуудын номонд бүгд 7290 гаруй электрон каталог бичиж, Гэрээр ном олгох тасгийн номын фондоос уншигчид өөрийн хэрэгцээт унших номоо электрон кататологаас хайлт хийн ажшиглаж байна.

23. Гэрээр ном олгох тасгаас Уншилтаараа тэргүүлж буй ном шалгаруулалтыг уншигчдын уншсан номнуудаас хийж С.Мэйер “Хиртэлт”, “Үүрийн гэгээ”, Ц.Оюунгэрэл “Миний ажлын ноу-хау”, “Сургамжит өгүүллэгүүд” зэрэг 20 гаруй ном шалгарч уншигчдад номын тухай мэдээллийг хүргэж сурталчилсан

24. Уншлагын танхимаас Гэгээн Валентиний өдөрт зориулан “хайрын зууч” шүлгийн уралдааныг уншлагын танхимдаа тэр өдөр ирсэн уншигчдын дунд зохион явуулсан. Энэхүү шүлгийн тэмцээнд нийт 15 хүүхэд оролцсоноос 1- байранд 2-11жилийн 11-в ангийн сурагч Ч.Батзаяа “Хайрын зууч” шүлгээрээ эзэлсэн. 2-р байранд МСҮТ-ийн сурагч Ч.Цэцэгсүрэн, мөн нэг тусгай байрыг 2-11 жилийн 10-б ангийн сурагч Бадамханд шалгарч өргөмжлөл дурсгалын зүйлээр шагнуулсан. ЕБС-ийн 2-11 жилийн 7-д ангийн 32 сурагчдын дунд “Равжаа хутагтыг

25. Уншлагын танхимаас Цагдаагийн байгууллагатай хамтран гадуур хараа хяналтанд байдаг 10 хүүхдийг авчирч карт нээлгүүлсэн. ЕБС-ийн 1-11 жилийн Алтантуяа багштай 7-в анги болон 2-11жилийн 7-д анги, мөн 2-11 жилийн 8в ангийн хамт олонд урилга өгч номын сандаа урьж анги хамт олноороо 7 хоногийн нэг өдөр тогтмол ирж уншлагын танхимаар үйлчлүүлдэг болсон. Нийт гурван ангийн 75 хүүхэд хамрагдсан.

17. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны “ Номын баяр өдөр тэмдэглэх тухай” 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, ном хэвлэл сурталчлах, номын өв санг арвижуулах, хүүхэд залуучуудыг ном эрдмийг хүндэтгэн дээдлэн нандигнан хайрлаж, эрхэмлэн уншдаг ариун ёс уламжлалаа сэргээн хөгжүүлэх, өвлүүлэх зорилгоор “Эрхэм баян –Эрдэм ном” номын баярын хүрээнд дараах ажлуудыг хийсэн болно. Үүнд :

- Шинэ Дорноговь” хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд гарсан Дорноговь аймгийн албан байгууллага, иргэд, зохиолчид, уран бүтээлчдийн 2009-2012 онд эрхлэн хэвлүүлж гаргасан “Эрхэм дээд –Эрдэм ном” шинэ номын үзэсгэлэн

- “Шилдэг оюуны хандивлагч” сарын аян
- “Нацагдорж” тэмдэгтэн тэргүүний уншигч шалгаруулах уралдаан
- Иргэдийн гар дээр байгаа ховор хуучин , судар шастир, ном зохиол, хувийн номын цуглуулгын “ Миний номын сан” үзэсгэлэн
- Сумдын номын сангийн үзэсгэлэн
- Номын худалдаа

18. Аймгийн Төв номын сангийн захиргаанаас “Эрхэм дээд- эрдэм ном “ номын баярыг угтан “ Ном хандивлагч” сарын аян зарлан дүгнэж, “ Оюун хандивлагч” өргөмжлөлөөр номын сангийн сан хөмрөгт өөрийн оюуны өв сангийн дээж ном хэвлэлээ хандивласан Равжаа музейн захирал З.Алтангэрэл, Монгол улсын Гавъяат жүжигчин Л.Буянхишиг, ахмад зохиолч Ш.Доржбал нарыг, “Ном хандивлагч” талархалын бичгээр ахмад барилгачин Д.Сэдээ, Аудитор Я.Төмөрмөнх, ЭМГ –ын дарга Г.Энхцэцэг нарын 9 хүнийг шагнаж урамшуулан алдаршуулж сурталчилсан.
19. Мөн номын баяраар 9 тэргүүний уншигчийг шалгаруулан “Д.Нацагдорж” тэмдэг, үнэмлэх олгож , үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулсан . Үүнд: 12 æèëëèéí 1-р сургуулийн 11б ангийн сурагч Т.Бүжмаа, ЭМШУИС-ийн оюутан

Д.Тодгэрэл, “Чандмань илч“ ХХК –ны ажилчин М.Гантулга нарын .. 9 хүнийг шалгарсуулсан.

20. Мөн Монгол Улсын баатар Дашийн Данзанваанчигийн Гэрэлт хөшөөний нээлтийн ажиллагаанд идэвхитэй оролцож , хүндэтгэл үзүүлж, манай аймгийн Төв номын сангийн тулгын чулууг тавьсан номын сангийн анхны дарга- ахмад номын санч Улсын баатар Д.Данзанваанчигийн үйл хэрэгийг мөнхлөн 2018 онд болох түүний 100 жилийн ойг угтаж, аймгийн Төв номын сангаа Улсын баатар Д.Данзанваанчигийн нэрэмжит 5 давхар орчин үеийн шинэ номын сангийн барилгатай болох санаачилгыг дэвшүүлсэн
21. ШИНЭ ДОРНОГОВЬ” хөгжлийн хөтөлбөрт “Аймаг, сумын номын санг түшиглэн “Иргэдийн хөгжлийн төв” –ийг байгуулан иргэдийг мэдээлэл солилцох, интернэт ашиглах, сургалтанд хамрагдах боломжийг бүрдүүлнэ” хэмээх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Төв номын сангийн “Иргэдийн хөгжил төв”-өөс 2012 онд аймгийн хэмжээний бүх сумдын номын санчдыг хамруулан ”Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах стандарт, шаардлага”, “Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага”, “Компьютерийн анхан шатны сургалт”, “Номын сангийн CDS/ISIS программ-Электрон каталогжуулалт”, “Номын сан-Мэдээллийн технологи”, “Номын сангийн шинэчлэл” зэрэг сэдвүүдээр мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг 5 удаа амжилттай зохион байгууллаа.
22.
23. Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компаниа сольж өндөр хурдтай мөртлөө хямд интернэттэй болсон. Wireless router тавьснаар уншигч, үйчлүүлэгч нар цагийн хязгааргүйгээр нэтэд орж мэдээлэл авах боломж бүрдсэн. Дотоод сүлжээний кабель, толгой авч нийт 6 тасагруу 300 м дотоод сүлжээ татан, тохиргоо хийснээр байгууллагын хэмжээний бүх компьютер интернэтэд холбогдлоо. Ингэснээр хоорондоо дотоод сүлжээгээр холбогдож, хэрэгцээт файлаг мэссэнжэр болон дотоод сүлжээгээр солилцон, ажлын бүтээмж, хурд дээшилсэн.
24. Ном зүйч Эрдэнэтуяатай хамтран *Гэгээн хайр*, *Цагаан сар* *1970-1990 оны сэтгүүлээр аялъя* гэх мэт сэдвээр үзэсгэлэн гаргасан. Нийт 30 ш ном, 10-аад сэтгүүл гаргасан. Мөн үзэсгэлэнгийн үеэр АХА, Та та тунга, Хайрын 4 мөртийн тэмцээн зохиож, шагналт байрны оролцогчдод интернэтээр үйлчлүүлэх эрх гардууллаа.
25. Иргэдийн хөгжил төвөөр 2202 гаруй үйлчлүүлэгч үйлчүүлж, 360,0 мян. төг оруулсан.
26. Уншлага үйлчилгээнд гарч байгаа номын ашиглалт, хугацаанд хяналт тавьж нэг номыг олон уншигчийн хүртээл болгох талаар таниулга хийж, ном ашиглах талаар 80 гаруй номонд санамж нааж, 1081 ширхэг номыг нааж сэлбэн, оёж үдсэн.
27. Шинээр худалдан авсан 400 ш номыг үдэж нуруулдаж оёж хуудсыг салж унахааргүй болгож бэхэлсэн. Хэвлэлийн фондын 161 сонинг цагаан өнгийн материалаар нуруулдаж, он дугаар, нуруунд нь нааж, буцаан тавиур дээр оны дараалаар байрлуулав Өв санг хадгалж хамгаалах ажлын хүрээнд: 161ширхэг сонинг нуруулдаж сэлбэн засалт хийсэн.
28. Аймгийн Төв номын сангийн стандартыг хэрэгжүүлэх ажлын 2012 – 2016 оны хэтийн төлөвлөгөөг боловсруулан баталж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэж байна
29. Аймгийн Төв номын сангийн үндсэн болон хүүхдийн, гэрээр ном олгох фондуудын дулааныг +18 +_2, чийгшилийг 55+_5%, цонхнуудыг хар хөшигтэй болгон нарны гэрлээс хамгаалж, галын аюулгүй байдлыг хангах үүднээс 50 м2 талбайд нэг гал унтраагуур, өрөө тасалгаа бүрд нэг галын унтраагуууртай

болгон, гэрэл чийдэнгүүдийг номын тавиур, шкаф баримт, ном хэвлэлийн гадаргуугаас 0,5 метрээс багагүй зайд байрлуулан стандартыг хангаж ажиллаж байна.

30. Номын сангийн стандарт шаардлагыг хангаж ажиллах, орчин үед номын санд мэдээлэл технологийг хэрхэн нэвтрүүлэх, үйл ажиллагааг автоматжуулах, электрон каталогижуулах асуудлыг онол, практиктай нь хослуулан ажилдаа хэрэгжүүлэх зорилгоор 2012 онд аймгийн хэмжээний бүх сумдын номын санчдыг хамруулан "Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах стандарт, шаардлага", "Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага", "Компьютерийн анхан шатны сургалт", "Номын сангийн CDS/ISIS программ-Электрон каталогжуулалт", "Номын сан-Мэдээллийн технологи", "Номын сангийн шинэчлэл" зэрэг сэдвүүдээр мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг аймгийн Төв номын сан дээр 5 удаа амжилттай зохион байгуулж, сургалтанд амжилттай оролцсон сумдын номын санч нарт Аймгийн Төв номын сангийн захирал Л.Цэнд-Аюуш сертификат гардууллаа.
31. Мөн сургалтын үеэр БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар аймгийн төвийн болон 12 сумын номын санд электрон катологийн үйлчилгээ нэвтрүүлэх зориулалт бүхий 12.3 сая төгрөгний 20 ширхэг компьютер олгосон байна. Аймгийн Төв номын сангаас 12 сумын номын сангийн компьютерт электрон катологийн хайлтын " Номын сангийн CDS/ISIS программ"-ыг үнэгүй суулган өгч , сумдын номын санч нар 5 хоногийн дадлага хийсэн. Мөн энэ үеэр аймгийн төв номын сангийн мэргэжлийн номын санч нар хичээл зааж өөрийн хариуцсан сумдын номын санч нарт заах арга зүйн зөвлөгөөг өгсөн.
32. Аймгийн Төв номын сан 2012 онд шèíýýð 923 øèðõýã, 9.4 сая òºãðºãíèé íîì хэвлэлээр ôîíäîî áàÿæóóëñàí. / Íèéò 2012 îíû 12 ñàðûí 31-íèé áàéäëààð 58932 øèðõýã, 65.0 сая òºãрөгíèé íîìòîé áîëñîí./ . Уншигчдын санал судалгааг авч тэдний унших дуртай 12 нэр төрлийн төгрөгний сонин сэтгүүлүүд захиалж иргэд уншигчдад үйлчилж байна. Үүнд: Зууны мэдээ, Өдрийн сонин, Төрийн мэдээлэл, Хүмүүс сонин, номын санч сэтгүүл … гэх мэт.
33. "Эрхэм баян – Эрдэм ном" номын баярыг угтаж, иргэд уншигчдын дунд "Номын санд ном хэвлэл хандивлах сарын аян" зохион байгуулснаар манай фондод байхгүй аймгийн зохиолчдын сүүлийн 5 жилд шинээр хэвлэгдэн гарсан 75 нэр төрлийн ном хэвлэлийг иргэд хандивлаж, номын фондын баяжилт нэмэгдсэн.
34. БСШУЯ –ны хөрөнгө оруулалтаар манай аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа 14 сумын номын сан, ЕБС-ийн 19 номын сан, 22 цэцэрлэгийн номын санд хуваарилсан нийт 42.7 сая төгрөгний 3550 ширхэг шинэ ном хэвлэлийг аймгийн төв номын сан өөрсдийн хүчээр нэгдсэн журмаар татан авчирч, хуваарилж хүргэсэн . ҮҮНД:

   14 сумын номын санд 25,8 сая төгрөгний 1749 ш, ЕБС-ийн 19 номын санд 11,8 сая төгрөгний 1213ш, 22 цэцэрлэгийн номын санд 5,1 сая төгрөгний 588 ш шинэ ном хэвлэлийг хуваарилж , падаан баримт бичиж нэг бүрчлэн хүлээлгэн өгсөн.
35. Мөн Аймгийн ИТХ –аас 14 сумдын болон ЕБС –ийн 19 номын санд хандивласан "Дорноговь аймгийн зохиолчдын цоморлог" - ном 67 ширхэгийг нэгдсэн журмаар хуваарилж хүлээлгэн өгсөн.

Дөрөв. Бусад ажлын талаар

1. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого олдог ажилтнуудыг Баасан гариг бүрт тогтмол хугацаанд орлого төвлөрүүлж , сард 2 удаа тооцоо нийлж , акт үйлдэж гарын үсэг зуруулан санхүүгийн баримтад хавсарган

ажилласнаар танхим, тасгуудын төлбөрт үйлчилгээнд 2012 онд 1.3 сая төгрөгний орлого оруулж , орлогын төлөвлөгөөг 260 % -иар биелүүлсэн.

2. Байгууллагын 2012 оны батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулж, өр авлага гаргаагүй.
3. Байгууллагын 2012 оны архив бичиг хэргийг цэгцэлж , тушаал, тайлан төлөвлөгөө, ирсэн явсан бичиг зэрэг 15 ширхэг хадгаламжийн нэгжийг үдэж хавтаслан, хадгаламжийн нэгжид хаяг адресс, товъёог бичиж, архивыг бүрдүүлж хадгалав.

Тав. 2012 ОНД ДЭВШҮҮЛЭХ ЗОРИЛТУУД

1. ССАЖЯ-наас дэвшүүлсэн зорилтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, Соёлын үнэт өв сан – ном хэвлэлийг хамгаалах, үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залууст уламжлуулах , Зөв монгол хүүхэд, зөв монгол нийгэм төлөвшүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ
2. Хүүхэд залуус, олон нийтэд ном унших соёлыг сурталчилах, урамшуулах ажлыг зохион байгуулж, нийт иргэд уншигчдыг номын сангийн үйлчилгээнд өргөн хамруулна.
3. Номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагаа, өв санг хадгалж, хамгаалах стандарт шаардлагыг хэрэгжүүлнэ
4. Аймгийн эдийн засаг нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.
5. “Шинэ Дорноговь-2” хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд шинэлэг, бүтээлч ажлуудыг төлөвлөлтийн дагуу зохион байгуулна.

ДОРНОД АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2012 ОНД
ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2012.12.24

Зорилго: Мэдээллийг нээлттэй хүргэх түшиц газар болох

Зорилт: Номын сангийн үйлчилгээг нэгжид хүргэх, каталог ном зүйг сайжруулах

Соёлын үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах талаар

Зорилт: номын сангийн үйлчилгээг нэгжид хүргэх, каталоги ном зүйг сайжруулах.

Хэрэгжилт: Уншлага үйлчилгээ цахим үйлчилгээгээр түргэн шуурхай хүргэн, соёл олон түмний ажлыг нийтийн хүртээл болгон аж ахуй нэгжид хүрч "Номын хур" буулган, алслагдсан хүн амд явуулын үйлчилгээг хүргэн, хүүхдийг багаас нь номтой нөхөрлүүлэн анги хамт олноор уншигч болгон, номын сан хоорондын ном солилцоог өргөжүүлэх, зөөвөр, гэрээр хүргэх, лавлагаа ном зүй, мэдээлэл сурталчилгааны ажлуудыг удирдамж хөтөлбөрийн дагуу зохион явуулсан. Үүнд:

Уншлага үйлчилгээ: тайлангийн хугацаанд 2977 байнгын уншигч , / насанд хүрэгсэд 1301 хүүхэд 1676 , 73009 ирцэд 140481 ном олгож номын сангийн үйл ажиллагааг сурталчлах, алслагдсан иргэдэд ном хэвлэл хүргэх явуулын үйлчилгээг 9 ЕБС, 2 их дээд сургууль, Чойбалсан, Гурванзагал сум нийт 3547 хүнд 8791 номоор үйлчилгээ үзүүлсэн. 5 дугаар сарын 1-нээс Гэрээр ном авахыг үнэгүй болгосноор уншигчдын ирц ном олголт нэмэгдсэн. Уншигчид сэтгэл хангалуун байна

Уншигчдад электрон каталоги ашиглуулахаар 3 компьютер коридорт суурилуулж ашиглах заав
рыг бичиж тавьснаар уншигчид электрон каталогийг ашиглаж сурч байна.

Ном солилцоо, зөөвөр номыг өргөжүүлэн 1,2,5,6,8,11,12-р сургууль, Шинэ хөгжил, цогцолбор сургууль,Хан-Уул цогцолбор сургуулийн номын сангууд, ДДС, Политехник коллеж, ХЦ 0132-р анги, Баян-Уул, Баяндун, Сэргэлэн, Гурванзагал зэрэг нийт 17 байгууллагатай гэрээ байгуулж 9 байгууллага 398 ном уншуулсан.

1.Соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх арга зүйг сайжруулах:

Хэрэгжилт: Соёлын ажилтны сургалтыг жил бүр уламжлал болон зохиодог. Энэ жилийн анхны сургалтыг соёлын ажилтны сургалтаар эхлүүллээ.

Сургалт 2012-01-21-нд аймгийн төв номын сангийн уншлагын танхимд зохион байгууллаа. Сургалтанд Сумдын соёлын төвийн ажилтнууд, Хэрлэн сумын ЕБС-ийн болон Их дээд сургуулийн номын санчид, сумын нийтийн болон ЕБС-ийн номын санчид нийт 75 хүн оролцсон. Сургалтыг шинэлэг хэлбэрээр зохион нийтийн болон ЕБС-ын номын санчдын дунд "Номын сангийн хөгжил-Ирээдүй" сэдэвт илтгэлийг зарлаж Нийт 11 илтгэл тавигдаж номын сангийн өмнө тулгамдаж буй асуудал болон цаашдын хөгжлийн талаар олон сайхан илтгэл тавигдлаа. Илтгэлийг сонссон сумдын эрхлэгчид болон номын санчид талархаж байгаагаа илэрхийлэж цаашид сумдын

_номын санг цахим болгох талаар санал оруулсан. Соёлын ажилтны анхдугаар чуулга уулзалт Дашбалбар суманд 2012 оны 3 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд боллоо. Чуулганы нээлтэд БСШУЯ-ны дэд сайд Т. Ундармаа, УИХ-ын гишүүн Д. Одбаяр, Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга Н. Хүрэлбаатар Аймгийн ЗДТГ-ын нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Д. Жаргал, БСГ-ын дарга Р. Дуламсүрэн, Дашбалбар сумын засаг дарга М. Ёндонжамц, Дашбалбар сумын ИТХ- ын дарга Балжид нар чуулганд оролцогчдод амжилт хүсч мэндчилгээ дэвшүүллээ. Чуулганд соёл урлагийн байгууллагуудын удирдах ажилтан, уран бүтээлч нийт 61 хүн оролцож "Аймгийн соёлыг 2012-2016 онд хөгжүүлэх бодлого, төлөвлөлт, Аймгийн Биет бус соёлын өвийн өнөөгийн байдал, цаашдын хандлагын талаар хэлэлцэн чууллаа. Чуулганаар хөндсөн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл боловсруулж, ИТХ-ын тэргүүлэгчдэд танилцуулж батлах саналыг уриалга болгон дэвшүүллээ. Чуулганаас гаргасан уриалга шийдвэр, хэлэлцүүлгийн эмхтгэлийг хэвлүүлж соёлын байгууллагуудад хүргэхээр боллоо.

Соёл урлагийн хорооноос зохион байгуулсан "Номын сан мэдээллийн технологи" сэдэвт сургалтанд мэдээллийн технологич М.Баатарсүх, фондоч

Э.Учралмаа, Үндэсний номын сантай хамтран зохион байгуулсан сумдын нийтийн номын санчдын мэргэжил дээшлүүлэх сургалтанд төв номын сангийн 5 номын санч, Сэргэлэн, Чулуунхороот, Гурванзагал, Хөлөнбуйр, Дашбалбар, Чойбалсан, Баян-Уул сумын 7 номын санчид хамрагдаж номын сангийн үйл ажиллагаанд баримтлах эрх зүйн баримт бичиг, номын сангийн менежмент, анхан шатны бүртгэл хөтлөлт, каталоги, түүний зохион байгуулалт, номын сангийн фонд, түүний хадгалалт, үйлчилгээний соёл, ном тодорхойлох талаар мэргэжлээ дээшлүүлж сертификтат авсан.

Номын санчид мэдлэг мэдээллээр хангагдаж, ур чадвар сайжирч, мэргэжил арга зүйгээр хангагдаж байна.

Сумдын номын санг цахим хэлбэрт шилжүүлэх

Мэдээлэл сурталчилгаа:

Хүүхэд багачуудын уран унших авьяас чадварыг нээн илрүүлэх,хөхүүлэн дэмжих, уран уншлагын урлагийг хөгжүүлэх, тэдэнд монголын болон дэлхийн шилдэг утга зохиолыг сурталчилан таниулах зорилготой “Уран жиргээ 2012, Хүрэл тулга-2012” наадмыг 2 дугаар сарын 17-18 ны өдрүүдэд зохион байгуулж Хүүхдийн төлөө хэлтэстэй хамтран зохион байгууллаа. Уран жиргээ, хүрэл тулга наадамд нийт 152 хүүхэд оролцож насны ангиллаар зохион байгуулсан. Уран жиргээ наадамд Дашбалбар, Хөлөнбуйр, Хэрлэн сумын 7 цэцэрлэгийн 117 хүүхэд оролцож цэцэрлэгийн нас /4-5 нас/ 1-р байр Болормаа 2-р цэцэрлэг Өргөмжлөл медаль дурсгалын зүйл сургуулийн бага нас /1-5 анги/ Билгүүнтөгөлдөр 8-р сургууль Өргөмжлөл Медаль дурсгалын зүйл, сургуулийн дунд нас /6-9 анги/ С.Намхай Хөлөрбуйр сум өргөмжлөл медаль сургуулийн ахлах нас /9-11 анги/ Д.Мөнхчимэг 2-р сургууль Өргөмжөл медаль дурсгалын зүйлээр тус тус шагнууллаа.

Хүрэл тулга-2012 наадамд нийт 9 сум, ЕБС-ийн нийт 35 хүүхэд оролцож 2 ангиллаар 3 үе шаттай зохион байгуулагдлаа. Дунд насанд 2-р шатанд 10 хүүхэд шалгарч 3-р шатанд түлхүүр сэдвээр 8 мөрт шүлэг зохиож, Ахлах нас 2-р шатанд шалгарч үлдсэн 10 хүүхэд Өглөг сэдвээр 4 мөрт зохиож амжилттай зохион байгуулагдлаа. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигаар жил бүр уламжлал болгон явагддаг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын үйл ажиллагааг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан “Номтой нөхөрлөе” 1 сарын аян зарласан.

Баярын арга хэмжээ жил жилийнхээс онцлог болж өнгөрдөг бөгөөд энэ удаа ЕБС-ийн 1 дүгээр ангийн сурагчдын дунд “Сэтгэхүйн хурд-2012”, “Монгол бичгийн уралдаан, татлаган бичлэг, монгол бичгээр зөв унших , бүтээлийн үзэсгэлэн, шинэ номын үзэсгэлэн зэрэг олон шинэлэг ажлуудыг зохиосноор олон нийтийг хамарсан арга хэмжээболж өнгөрлөө.

“ Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг сурталчилах ажлын хүрээнд зохион байгуулагдсан ”Сэтгэхүйн хурд-2012” тэмцээнд Хэрлэн сумын ЕБС-ийн 6 сургуулийн 18 хүүхэд оролцож оюун ухаан, хурд хүч авхаалж самбаагаа өрсөлдөн оролцож 1 дүгээр байрыг Аймгийн тэргүүний 8 дугаар сургуулийн Наранцацрал багштай “Сэтгэмж баг”, 2-р байрыг Улсын тэргүүний 1 дүгээр сургуулийн “Гэгээ баг”, 3-р байр 11-р сургуулийн “Хөгжилтэй багачууд” багууд тус тус шалгарлаа.

Номтой нөхөрлөе сарын аян Лу "Алтан товч" судар Монгол бичгийн уралдааныг Боловсрол соёлын газар, Аймгийн төв номын сан, Ерөнхий ивээн тэтгэгч байгууллагаар АйСВН ХХКомпани болон бусад байгууллагууд хамтран зохион явууллаа.

Монгол бичгийн уралдаан сарын хугацаатай зарлагдаж " Л Алтан товч судар"-ыг Сумын нийтийн номын сан сургуулиудын номын сангаар хэвэлмэл номыг залж, Төвийн болон сумын айл өрхүүдэд судар хэлбэрийн номыг залахаар үйл ажиллагааг зохион байгуулсан нь ард иргэд талархалтайгаар хүлээн авсан. Дорнод аймгийн брэнд " Хос судар"- тай аймаг боллоо. Аймгийн төв номын сан нь "Алтан товч " судрын хуулбарыг 9 эрдэнээр чимэглэн залахаар төлөвлөсөн боловч хөрөнгийн асуудлаас шалтгаалан түр хүлээгдээд байна.

Монгол бичгийн уралдааныг багш, хувь хүн, баг, суралцагч гэр бүл гэсэн ангилалаар зохион байгуулж 1-р шатны шалгаруулалт аймаг болон сумдуудын харьяа номын сангуудад удирдамжийн дагуу зохион байгуулж 2-р шатны шалгаруулалтыг 2012 оны 05-р сарын 28-нд аймгийн төв номын санд шалгаруууллаа.

Аймгийн хэмжээнд 87 бүтээл оролцсноос 31 хүний бүтээл 3-р шатанд шалгарч үлдсэн байнаНомтой нөхөрлөе "Лу Алтан товч" судар Монгол бичгийн уралдааны 3-р шатны шалгаруулалт 5-р сарын 31-нд тусгаар тогтнолын талбайд

амжилттай зохион байгуулагдлаа. Нээлтийн арга хэмжээг хөтлөгч Ганзориг хөтлөн, ХДТ-ын морин хуурч Оюунбилэг морин хуурын аялгуугаар эхлэн, дараа нь МУ-ын төрийн соёрхолт гавьяат багш доктор профессор Ш.Чоймаа, АйСВН ХХК захирал н.Туяа,БСГ-ын дарга Р.Дуламсүрэн, Аймгийн төв номын сангийн захирал Ж.Цагаан нар нээн үг хэллээ.

Тус арга хэмжээнд Аймгийн нийгмийн бодлогын хэлтсийн дарга Д.Жаргал, БСГ-ын мэргэжилтэн Т.Оюунбат, Б.Эрдэнэтуяа, 1-р сургуулийн багш Ч.Эрхчөлөө,5-р сургуулийн багш Б.Эрдэнэтуяа,12-р сургуулийн багш Ө.Одмандах нар оролцлоо.Сүүлийн шатанд Аймгийн төв болон, Цагаан-овоо, Чойбалсан, Баянтүмэн сумдууд аймгийн төвийн багш, хувь хүн, гэр бүл, суралцагч, баг гэсэн 5 ангиллаар нийт 48 хүн оролцсоноос ангилал тус бүрээр 31 хүн шалгарч байр эзэлсэн байна.

Багш ангилал: 1-р байр 5-р сургуулийн багш Б.Эрдэнэтуяа Өргөмжлөл 1 000 000 төгрөг Лу “Алтан товч” судар, 2-р байр Ө.Одмандах өргөмжлөл 750.000 төгрөг, 3-р байр Б.Шагдаржав өргөмжлөл 500.000 төгрөг, Баг ангилал: 1-р байр Хан-уул цогцолбор сургуулийн багш суралцагчдын баг шалгарч Өргөмжлөл 1 000 000 төгрөг, Лу”Алтан товч” судар, 2-р байр 8-р сургууль өргөмжлөл 750.000 төгрөг, 3-р байр Дорнод дээд сургуулийн багш Шагдалжав өргөмжлөл 500.000 төгрөг, **Гэр бүл ангилалд:** 1-р байр “Сүлд” баг өргөмжлөл 1.000.000 төгрөг, “Алтантовч” судар, 2-р байр “Соёмбо” баг өргөмжлөл 750.000 төгрөг, 3-р байр Цагаан- овоо сум “Буриад зон” баг өргөмжлөл 500.000 төгрөг, **Хувь хүн ангилалд:** 1-р байр Д.Ундармаа Өргөмжлөл 1,000,000 төгрөг ,2-р байр Ж.Батжаргал Өргөмжлөл 750,000 төгрөг, 3-р байр Д.Туяа 500,000 төгрөг Суралцагч багт: 1-р байр Ариунболд Өргөмжлөл 1. 000. 000 төгрөг Лу “Алтан товч” судар, 2-р байр Юмжирдулам өргөмжлөл 750.000 төгрөг, 3-р байр Дэлгэрцэцэг өргөмжлөл 500,000 төгрөг, Шилдэг номын санчаар Цагаан-Овоо сумын номын санч Ө.Алтан-Үсэг, Гар бүтээлийн үзэсгэлэнд Политехник коллежийн багш Д.Дамдинсүрэнгийн бүтээл шалгарч мөнгөн шагналаар шагнагдсан.

“Үндэсний бичиг үсгийн баяр” –ын арга хэмжээ, үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар мэдээллийн хэрэгсэл телевиз, сонин хэвлэлүүд мэдээ, мэдээлэл реклам зар сурталчилгаагаар өргөн сурталчиллаа. Оюуны хамгийн том шагналтай анхны арга хэмжээ болсныг дурдахад таатай байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн “Номын баярын өдөр тэмдэглэх тухай” 2012 оны 158 дугаар зарлиг, аймгийн Засаг даргын 2012 оны А/273 тоот захирамжийг үндэслэн “Номын баярын өдөр”-ийг аймгийн хэмжээнд ЗДТГ, БСГ, Зохиолчдын эвлэлийн салбар байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

Номын баяр:

Баярын арга хэмжээ нь нийтийг хамарсан олон төрлийн уралдаан тэмцээнээр дүүрэн зохиогдсон ба “Номын хур” аяны хүрээнд шалгарсан “Оюунлаг байгууллага”-ыг шалгаруулж өргөмжлөл гардуулах, Түргэн уншлага”-ын уралдаан, цэцэрлэгийн насны ангилалд “Зохиолын баатрууд амилсан нь” дүрээр хувцаслах, хамгийн том, жижиг номын үзэсгэлэн, сум бүр өөрийн нутгаас төрсөн эрдэмтэн доктор зохиолч, яруу найрагчдын бүтээлээр үзэсгэлэн, сумдын хандивын хайрцаганд ном хандивлах зэрэг олон арга хэмжээ болж өнгөрлөө.

“Номын баярын өдөр”-ийн нээлтийн ажиллагаа 2012 оны 09 дүгээр сарын 22 –ний өдрийн 12 цагт Тусгаар тогтнолын талбайд ном уншигч идэвхтэн уншигч, зохиолчид, аж ахуйн дарга захирал нар уригдан ирсэн байлаа. Баярын нээлтийн ёслолын ажиллагааг аймгийн ХДТ-ын хөтлөгч СТА Одсүрэн хөтлөн, Аймгийн ЗДТГ-ын дарга П.Бат-Өлзий, БСГ-ын дарга Р.Дуламсүрэн нар нээж үг хэллээ. Номын баярын хүрээнд зохиогдсон “Хамгийн их ном уншигч” номинацад 2-р сургуулийн 9а ангийн сурагч Ч.Алтангэрэл шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар, Өндөр настан Б.Хоохойг СТА цол тэмдэгээр, фондоч Э.Учралмаа, үйлчлэгч Х.Гантөмөр нарыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр, “Оюунлаг байгууллага”-аар шалгарсан аймгийн ХДТ-ын хамт олныг шилжин явах цом, өргөмжлөлөөр шагнав.

Номын баярын өдөрт сумдын нийтийн болон ЕБС-ийн номын санчид, аймгийн төвийн 1,3,4,6-р цэцэрлэг, ЕБСургууль, их дээд сургуулийн номын сангууд, иргэд нийт 300 гаруй хүн оролцлоо.

Номын баярын хүрээнд зохиогдсон Түргэн уншлага”-ын уралдаан /18-аас дээш нас/ нийт 25 хүн оролцсоноос тэргүүн байр 5-р сургуулийн сурагч Х.Нандинцэцэг, дэд байр Баян-дун сумын ЕБС-ийн сурагч н.Гантогтох, гутгаар байр 2-р сургуулийн сурагч н. Мөнхтуул, цэцэрлэгүүдийн дунд “Зохиолын баатрууд амилсан нь” сэдэвт дүрээр нийт 4 цэцэрлэгийн 120 хүүхэд оролцож тэргүүн байранд 1-р цэцэрлэг, 2-р байр 6-р цэцэрлэг, 2012 онд Төв номын сангийн идэвхтэн уншигч 2-р сургуулийн 11 а ангийн сурагч Ч.Алтангэрэл 2012 онд 352 ш нэр төрлийн ном уншиж “Олон ном уншигч” номинацаар шалгарсан байна. Уншигч олондоо байнга оюуны их хөрөнгө оруулдаг зохиолч, Ш.Дугар. /хүний их эмч/, Зохиогч Г.Пүрэв-Очир /МУ-ын дасгалжуулагч/, Зохиогч Н.Дугарсүрэн нарт “ Гэрэгэ” гардуулав.

Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтнээр сумдын ЕБС-ийн 22 сурагч Хэрлэн сумын ЕБС-ийн 9 сурагч нийт 31 сурагч шалгарсан байна. Мөн идэвхтэн уншигчаар 1-р сургуулийн 10 а ангийн хамт олон, 1-р сургуулийн 10 б ангийн сурагч Г.Буд, 2-р сургуулийн 11^{а} ангийн сурагч С.мягмарсүрэн, Э.Ононмөрөн, Шинэхөгжил цогцолбор сургуулийн 11 ^{г} ангийн сурагч Х.Энхсолонго, өндөр настан Жүгдэр нар шалгарсныг танилцуулж зурагт самбар гаргаж алдаршууллаа. Номын баярын арга хэмжээг байгууллагын вэб сайтад болон орон нутгийн телевизүүдэд мэдээ өгсөн.

Ерөнхий боловсролын 9 сургууль,Политехник коллеж, Дорнод Дээд сургуульд “Номын элч” явуулын үйлчилгээг хүргэж шинэ номын үзэсгэлэн, сурагчдын дунд “Миний бүтээл” цуглуулгын үзэсгэлэн “АХА” асуулт хариултын тэмцээн, “ Та та тунгаа” танин мэдэхүйн тэмцээнүүдийг оюутан

сурагчдын дунд зохион явуулж, “Үлгэрийн баатрууд амилсан нь “ сэдэвт гар зургийн уралдаан зарлаж 5-р сургуулийн 3в ангийн сурагч Ж.Жавхлантөгс түрүүлсэн. явуулын үйлчилгээнд нийт 67 уншигчдад карт нээж, 15 ангийг анги хамт олон уншигч болгон нийт 1674ш ном олгож 1337 ирэгсдэд үйлчилсэн.

Номын хур аяныг ЗХ-ний 0327-р анги,0132-р анги,Онцгой байдлын хэлтэс,цаг уур орчны шинжилгээний алба, Мэргэжлийн хяналт, ХДТеатр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн Алба , номын хур аяныг удирдамж хөтөлбөрийн дагуу 5 хоног ажиллаж 52 карт нээж 685 хүнд 954 ш номоор үзэсгэлэн гарган захиалгаар 124 ном олгосон. Номын хур аянд хамгийн их хамт олноороо ном уншсан ХДТеатр “Оюунлаг байгууллага” шилжин явах цомоор шагнагдсан байна.

Номын сангийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, шинэ ном мэдээллийг хүргэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилготой “Номтой нөхөрлөе” 3 сарын аяныг Аймгийн ХДТ-тай хамтран зохион байгуулж 92 номоор үйлчилгээ үзүүлэн ажиллаа.

Зохиогчдын номын баяр:

Дорнод нутагтаа зохиол бүтээл туурвиж хэвлэн нийтэлж байгаа яруу найрагч сэтгүүлч судлаачдын оюуны бүтээлийг иргэдэд таниулах, сурталчилах цаашид олны хүртээл болгох зорилгоор Сэтгүүлч-судлаач МЗЭ-ийн гишүүн Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит “Оюуны ундрага” шагналт Л.Хэрээ, МЗЭ-ийн шагналт яруу найрагч Ц.Жамбалгарав нарын уран бүтээлээр хийсэн “Уншигчдын бага хурал- Уулзалт ” 2012 оны 04-р сарын 24-нд амжилттай зохион байгуулагдлаа

Яруу найрагч Ц.Жамбалгарав, сэтгүүлч судлаач Л.Хэрээ нарын бичсэн ном, сонин сэтгүүлд нийтэлсэн бүтээл гар бичмэлүүдээр үзэсгэлэн гаргасан нь олны сонирхолыг татлаа. Энэхүү үйл ажиллагааны нээлтэнд ХДТеатрын дуучин МУГЖ Дугар, МУСТА Энхтүвшин , МУСТА Март нар ирж ая дуугаа өргөн мэндчиллээ.

Сэтгүүлч-судлаач Л.Хэрээгийн уран бүтээл судлал шүүмжлэлийн талаар “Гярхай ажиглалт” илтгэлийг ДДС-ийн захирал Доктор /Ph.D/ М.Одмандах тавьж МЗЭ-ийн шагналт яруу найрагч Ц.Жамбалгаравын уран бүтээлийн шүүмж судлал “Этгээд захирал Архангай, Хүний их эмч клиникийн профессор Вандансүрэн, Монголын сэтгүүлчдын аймгийн салбарын тэргүүн Дорнод сонины захирал Туяа, нар дурсамж яриа өрнүүллээ.

Монголын ардчилсан холбооны дарга, УИХ-ын гишүүн асан С.Билэгсайханы

анхны уран бүтээл “Шинэтгэл, Шинэ Монгол” номын хуримыг гэр бүл, найз нөхдийн хамт зохион байгууллаа. Энэхүү номын хуримын нээлтийн үйл ажиллагаанд С.Билэгсайханы ээж Долгор, Аймгийн төв номын сангийн захирал Ж.Цагаан, МЗЭ-ийн шагналт, яруу найрагч Ц.Жамбалгарав, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга асан Г.Хүрэлбаатар, Аймгийн засаг дарга асан Лу.Сүхбаатар, иргэдийн төлөөлөл оролцож номын тухай дурсамж дуртгал, яриа өрнүүлэн, номоо уншигч олныхоо өмнө өргөн барилаа.

Түүх судлаач А. Гүрбямбаа, Хэл бичгийн ухааны доктор М.Одмандах нарын бичсэн “ Бандын зээ Баатар Цэрэндорж” номын хуримд Аймгийн Засаг даргын орлогч Л.Хишигтогтох, Цагаан-Овоо сумын нутгийн зөвлөл оролцсон. Номын хуримын онцлог нь Баатар Цэрэндоржийн гар бичмэл болон эдлэж хэрэглэж байсан эд өлгийн зүйлээр үзэсгэлэн гаргасан нь олны сонирхолыг татлаа.

Олон улсын харилцааны ажилтан Хятад хэлний багш, орчуулагч, судлаач Ц.Мөнхцацралын “ Монгол улсын зүүн бүсийн аялал жуулчлал”, Хятад хэлний анхан дунд шатны сурах бичиг номын хурим, Цэргийн түүхийн судлаач, доктор, профессор хурандаа Г.Мягмарсамбуугийн “ Монгол улсын цэрэг, цэргийн жанжид” цуврал номын баярыг хийж зохиол бүтээлүүдийг сурталчилж байна.

“ Нийгмийн салбарынхан хамтаа “ өдөр

Нийгмийн салбарууд хамтдаа нэг, өдөрт Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс,Музей Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн газар, Татвар, Халамж үйлчилгээний хэлтэс, ХДТ, Биеийн тамир спортыг газрууд хамтран зохион байгуулж 2012 онд шинээр ирсэн Шинэ ном хүүхдэд зориулсан цуврал үлгэрийн номоор үзэсгэлэн гаргаж 34 хүнд төлбөргүй карт нээж 375 хүнд үйлчилсэн байна.

Засгийн газрын чуулганаар хэлэлцэж БШУ-ны сайдын 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/85 тушаалын дагуу “Наадам зохион байгуулах тухай жил

бүрийн өвлийн эхэн сарын шинийн нэгэнд “Монгол бахархлын өдөр”-ийг аймгийн хэмжээнд зохион байгуулах Монгол хүн бүр “Монголын нууц товчоо” зохиолыг судлах, Үндэсний хэл бичиг, уламжлалт түүх, соёл, зан заншилаас суралцах,түүх шастираа уншин судлах сурталчлах, үндэсний бичгээ чадмаг эзэмших, эх оронч

сэтгэлгээг төлөвшүүлэх, үндэсний бахархлыг үр хүүхэддээ зааж өвлүүлэх зорилгоор энэхүү үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгууллаа.

Энэхүү үйл ажиллагаанд ЕБС-ийн багш, сурагчид оюутан ,насанд хүрэгчид 658 уншигч "Монголын нууц товчоо зохиолоор уншлага зохион байгуулагдаж 5-8-р ангийн сурагчдын дунд "Чингис хаан" комикс цуврал номоор АХА асуулт хариултын тэмцээн зохион байгуулагдаж нийт 65 сурагч оролцож 5-р сургуулийн 7б ангийн сурагч Б.Золзаяа тэргүүлж Дурсамж дурсгалын зүйлээр шагнагдлаа.

"Монголын нууц товчоо бидний амьдралд" эссэ бичлэгийн уралдаан 9-11-р

ангийн сурагчдын дунд зохион байгуулж нийт 10 сургуулийн 18 багийн 90 сурагчид оролцож Тэргүүн байр Хан-Уул цогцолбор сургуулийн "Хас-1" баг Өргөмжлөл дурсгалын зүйл, Дэд байр 2-р сургуулийн "Хөх тэнгэр" баг Өргөмжлөл дурсгалын зүйл, Гутгаар байр 6-р сургуулийн "Хөх толботон" баг Өргөмжлөл дурсгалын зүйлээр тус тус шагнагдлаа.

Хүүхдийн номын ордон, Монголын 4-Н Хүүхдийн байгууллага хамтран " Ном" хөтөлбөрийн хүрээнд 2-дахь удаагаа зохион байгуулж буй "Номын анд" уралдаан 2012 оны 11 дүгээр сараас 2013 оны 04 дүгээр сарын 1-ныг дуустал 4 насны ангилалаар Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 9-н сургуулийн 43 баг 287 сурагч, ганцаарчилсан бүртгэлд 3 сурагч оролцож, 7сумдаас 85 баг 467 сурагч, ганцаарчилсан 13 сурагч, 2 гэр бүл баг 7 сурагч тус тус оролцож байна.

Цагдаагийн Ерөнхий газар БШУЯам хамтарсан " Сургууль Аюулгүй Орчин-2" арга хэмжээний удирдамж төлөвлөгөөний дагуу их дээд сургуулийн оюутны дунд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цагдаагийн байгууллага албан хаагчийн тухай зохион бичлэгийн уралдааныг зарлаж нийт 35 бүтээл оролцож Тэргүүн байр Политехникийн коллежийн малын бага эмчийн 1-р курсийн оюутан Н.Энхзул Өргөмжлөл, дурсгалын зүйл, мөнгөн шагнал, Дэд байр Политехникийн коллежийн токарийн 1-р курсийн оюутан Ч.Хишигбат Өргөмжлөл дурсгалын зүйл мөнгөн шагнал, Гутгаар байр МСҮТөв барилгын өргөн мэргэжлийн 2а ангийн оюутан Түвшинжаргал Өргөмжлөл ,дурсгалын зүйл ,мөнгөн шагналаар тус тус шагнаж урамшууллаа.

Монгол улс тунхагласны 88 жилийн ойн баяраар “Монголын нууц товчоо” г хүндэтгэн залах үйл ажиллагааг Политехник коллежийн захиргаанаас зохион байгуулж аймгийн музей ховор олдвор бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж Аймгийн төв номын сан “Монголын нууц товчоо”,”Эзэн Чингис хаан”-ы холбогдолтой 35 номоор үзэсгэлэн гаргалаа.

Лавлагаа ном зүй :

Номын мэдээг мэдээллийн самбарт байрлуулж 74 хүнд электрон каталогоос ном хайж зааварчилгаа өгөхөөс гадна аман болон бичгээр 187 хүнд лавлагаа,цахим программаас 252 хүнд нийт 439 лавлагаа өгч сэдэвчилсэн үзэсгэлэн 21 удаа гаргасан. Орон нутгийн 6 телевизээр 25 удаа мэдээ өгсөн.

Номын баяжилт хадгалалт хамгаалалт:

Ойрын фондын урагдаж гэмтсэн 124 ном, үндсэн фондын 54ш ном, хүүхдийн тасгийн 87 ном нийт 265 номын хуудасыг нөхөж сэлбэн заслаа. Шинээр ирсэн 441 ном 5.077.500 төгрөгний номыг програмд оруулж бар код нааж танхимуудад хуваарилан уншлаганд гаргалаа.

Өдөр тутмын сонин сэтгүүлийг сараар нь дугаарлан үдэж хаяг хийж байрлуулсан байна.Энэ онд 678850 төгрөгний сонин сэтгүүл захиалан нийтэд үйлчилж байна. Нийтийн уншлагын танхим, Хүүхдийн уншлагын танхим,Тогтмол хэвлэлийн тасаг, коридор, фондонд хяналтын камер шинээр суурилуулж дэлгэцийг харуул хамгаалалтын дэргэд байрлууулж уншлагын заалны текийг шинээр хийлээ./ 2.507.650 төгрөг /

Гар утсанд үнэгүй интернэтэд орж болохоор “ Wireless Fi “ төхөөрөмжийг суурилуулсан нь уншигчдын талархалыг хүлээж байна.

Уншлагын танхимууд, фондонд дулаан чийгшилт хэмжигч багаж, чийгшүүлэгч аппарад авч өгсөн.

Үзэсгэлэн, ном солилцоо

Шинэ номын болон сэдэвчилсэн үзэсгэлэнг 21 удаа, С.Дашдэндэвийн 100 жилийн ой,С.Буяннэмэх 100 жил, Мэнд-Ооёо 60 жил, Хүүхдийн зохиолч Т.Жамьянсүрэнгийн 70 жилийн ой, Ж.Галийн 75 жилийн ой, З.Сандагийн 85 жилийн ой, С.Дашдэндэвийн 100 жилийн ойд зохиолчдын уран бүтээлийг уншигчдад сурталчилан нийт 358 номоор үзэсгэлэн гаргалаа.

Ном солилцоогоор Халгол сумын нийтийн номын сан 45, Музей 25, 0132-р анги 59, Поитехник коллеж 5 ном, ДДС-20, 2-р сургууль 8, 8-р сургууль 9 ном, 6-р сургууль 33 ном, 12-р сургуульд 3, Цагдаагийн газар 9, 5-р сургууль 6, ном Хөгжимт драмын театрт 42 ном, Онцгой байдлын хэлтэс 25 ном, Цаг уур орчны шинжилгээний алба 18 ном, мэргэжлийн хяналтын газар 15 ном, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба 24, ,Баян-Уул 35 ном, Матад сум 3 ном, Цагаан-овоо сум 35 ном, Сэргэлэн сум 8 ном, Гурван загал сум 50 ном нийт 477 номоор солилцоо хийж зөөврөөр Цагдаагийн газар 35 ном, 0132-р ангид 40 ном, 9-р багийн иргэн Октябрь 152 ном нийт 217 номыг зөөврөөр уншуулж үйлчилсэн байна.

Боловсролын зөвлөгөө мэдээлэл:

Англи хэлний Access тэтгэлэгт хөтөлбөрийн 2011-2012 оны хичээлийн жилд Access 4, 5, груп 30 хүүхэддтэй хичээллэж байна.

Сурагчидтай гэрээ байгуулан ажиллаа. Англи хэлний сургалтын ном, их дээд

сургуулийн танилцуулга, шинээр ирсэн, уншигчдын хэрэгцээт 130 номыг чөлөөт

сонголтоор 6 удаа үзэсгэлэн гаргасан. 10 сурагч материалаа явуулж, тэднээс

Дорнод аймагт TOEFL-н шалгалт авав. 1 оюутан TOEFL-н шалгалтад тэнцэн SAT

шалгалтыг өгсөн.

Тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хамрагдах, БЗМТөвийн үйл ажиллагаа сэдвээр орон нутгийн телевизид / TV6 / нэвтрүүлэг хийлгэж сурталчилсан..

Ганцаарчилсан зөвлөгөө авах хүсэлтэй 132 хүнд тэтгэлэгт хөтөлбөрийн талаар ШСТТСургууль, ЕБСургуулийн багш нар болон, сумын номын санчдад “АНУ-д суралцах боломж” сэдвээр нийт 85 хүнд бүлгээр зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Англи хэлний сонсох, ярих чадвараа дээшлүүлэх хүсэлтэй хүмүүсийн дунд зохион явуулдаг English club - ийг хувиарын дагуу 20 удаагийн хичээлд давтан тоогоор 359 хүн хамрагдан хичээллэж байна. 7 хоног бүрийн 5 дахь өдөр чөлөөт ярилцлагыг Англи хэлээр явуулж байна. Санхүүжилт 1.700. 000 төгрөг.

3. Үндэсний төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

Зорилт: Үндэсний хөтөлбөрүүдийг сурталчлах

Хэрэгжилт: Соёл урлагийнн салбарт хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийг иргэдэд хүргэх , монгол хөөмий, угийн бичиг хөтлөх тухай танхимуудаар мэдээлэл хийж " Угийн бичгийг хэрхэн хөтлөх", " Интернэт цахим мэдээллийн сан үүсэх" , " Гадаадад суралцах тэтгэлэгт хөтөлбөрүүдийн тухай" мэдээлэл өгсөн. Монгол бичгийн хөтөлбөрийн талаар иргэдэд сурталчилан "Монгол бичгийн уралдааныг зарласан. " Авъяас-Ном " хөтөлбөр,

Үр дүн: Хөтөлбөрүүдийн мэдээлэл уншигчдад хүрсэн.

4. Соёлын салбарын статистик мэдээний үнэн зөв байдал:

Номын сангийн жил бүрийн тайлан судалгааг төвлөрсөн СУ-3, СУ-5, төвлөрсөн бус СУ-10, СУ-14 маягтаар БСГ-т хугацаанд нь гаргаж хүргүүлсэн, тайлан мэдээг сар бүр гаргаж АЗДТГ-ын мэргэжилтэн Г.Одбилэгт мэйлээр хүргүүлж хэвшсэн. 7 хоног бүр гол хийх ажлын мэдээг гаргаж тамгын газрын мэргэжилтэнд хүргүүлэн 7 хоног бүрийн шуурхайд танилцуулагдан ажиллаж байна.

5. Соёл урлагийн байгууллагуудын тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалт номын хангалт

Зорилт:

Хэрэгжилт: Номын сангийн барилгын өргөтгөлийн хөрөнгө 465 сая төгрөгийг улсын төсөвт суулгуулж эхний 165 сая төгрөгийн барилгын гүйцэтгэлийн ажил хийгдээд байна. 2013 онд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.

Хандиваар ирсэн 291ш 2,541,350 төгрөгийн ном, БСШУЯ-наас олгосон 20 ширхэг 12,300,000 төгрөгийн компьютерийг сумдын нийтийн номын сан, Музей, ХДТ хүргүүллээ. Танхимуудад гэрэлтүүлэг, чийгшүүлэгч авч байрлуулсан. Соёл, спорт,

аялал жуулчлалын яамнаас олгосон канон, 20 номын тавиур, 80 ширээ, 160 сандал, Сэргэлэн, Дашбалбар, Баян-Уул сумын нийтийн номын санд тус бүр 12 ширээ, 24 сандал, сумдын нийтийн номын сангуудад 53 нэр төрлийн 731 ширхэг 13,808,580 төгрөгний номыг хуваарилан өгсөн.Цэцэрлэгүүдийн 20 төрлийн 413 ш 5.493.900 төгрөг, ЕБС-ийн 44 төрлийн 929ш 15.832.050 төгрөг, нийтийн номын сангийн 116 төрлийн 1444 ш 27.119.731 төгрөгний номыг хуваарилан хүргүүлсэн.

Үр дүн: Уншигчид шинэ ном, хэвлэл, хүүхдүүд үлгэрийн шинэ ном үзэх бололцоогоор хангагдаж байна.

6. Хяналт шалгалт үнэлгээг бодит болгох , иргэдийн санал хүсэлтийг барагдуулах

Зорилт: Хууль тогтоож, Засгийн газрын болон Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах , соёлын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах , зөвлөгөө өгөх.

Хэрэгжилт: Байгууллагын дотоод хяналтыг байгуулан ажиллах төлөвлөгөө журам гарган ажиллаа. Байгууллагын 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад татварын хэлтэст тооцооллын алдаа гаргаж 92255 төгрөг илүү шилжүүлж авлага үүсгэн, санхүүгийн тайланг хугацаа хоцроосон тухай менежментийн захидлын дагуу нягтлан бодогч Б.Майцэцэгт хариуцлага тооцон сануулах арга хэмжээ авч ажиллаа.

Аймгийн татварын хэлтсээс 2010, 2011 оны санхүүгийн баримтанд албан татвар ногдуулалт, төлөлтийн байдлыг анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт, татвар, санхүүгийн тайлан тэнцэл мэдээ зэрэгт үндэслэн шалгасан.

Үр дүн : Шалгалтаар татвар аваагүй 34000 төгрөгний зөрчил илэрснийг барагдуулан цаашид анхаарч ажиллахыг нягтлан бодогч Майцэцэгт анхааруууллаа.

Архив албан хэрэг хөтлөлт:

Байгууллагын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар 2012 онд хөтлөгдөн гарах хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, байнга түр хадгалах баримт бичгийн бүртгэл, хугацаа дууссан баримтыг устгах тухай хэлэлцэн аймгийн архивын газраар хянуулан батлууллаа. 2011 онд хөтлөгдөн гарсан 22 баримтын техник ажиллагаа хийж архивласан.

Баримт бичгийг стандартын дагуу хөтлөн боловсруулан гаргаж захирлын тушаалыг оны эхнээс боловсон хүчний холбогдолтой, албан ажлын гэж гаргаж байна. Хагас жилийн байдлаар ирсэн бичиг 35, явсан бичиг 55, хариутай 10 бичгийг цаг тухай бүрт нь гаргаж явуулсан. Санал хүсэлтийн хайрцагт ирсэн 5 хүсэлтийг хүлээн авч удирдлагад танилцуулан шаардлагатай арга хэмжээг цаг тухай бүрт нь авч шийдвэрлэсэн.

Боловсон хүчний холбогдолтой цалингийн судалгаа, орон байрны, судалгааг гаргасан.

Бусад ажлын талаар:

Сар шинийн баярыг тохиолдуулан тус байгууллагад ажиллаж байсан болон өндөр насны тэтгэвэрт гарсан Ахмад ажилтнуудын дунд “Гурван үеийн уулзалт” арга хэмжээг 2012 оны 02 –р сарын 20 нд зохион байгууллаа. Уулзалтын үеэр номын сан байгуулагдсан үеэс эхлэн одоог хүртэл ажиллаж байгаа үе үеийн ажилчид, номын санчид, эрхлэгчид нарын хийж бүтээсэн ажлын зургийн цомогийг түүхчилэн гаргаж, àæèëëàæ áàéñàí үеийн дурсамж яриа өрнүүлэн ажлын туршлага солилцон хүндэтгэл үзүүллээ.

Сар шинийн баярыг угтаж олон жил үр бүтээлтэй ажилласан арга зүйч Ж.Соняг Аймгийн засаг даргын “Жуух бичиг”-ээр, жижүүр Б.Чадраабалыг “ Хэрлэн сумын “Тэргүүний ажилтан цол тэмдэг”-ээр, номын санч Д.Энхчимэгийг аймгийн “ Тэргүүний ажилтан” цол тэмдэгээр тус тус шагнаж урамшуулсан.

Мэдээллийн цагийг тогтмолжуулан 7 хоног бүрийн мягмар гаригт ажилтан ажиллагсадын илтгэл бичих чадвар болон ярих чадвар сайжруулах зорилготой мэдээллийн цагт төрөл бүрийн сэдвээр илтгэл тавиулж хэвшүүлж эхлэж байна.

Сар бүрийн 25-нд гаднах талбай болон танхимуудын их цэвэрлэгээг зохион байгуулж хийж байна.

Хүний нөөцийн ажилтан, нягтлан бодогчийн өрөөг пракетэн шал хийх, коридорыг плеталж будах ажилд жижүүр Наранбаатар, Бат-Эрдэнэ нар бусдыгаа хошуучлан сайн ажилласныг дурдахад таатай байна.

Тэргүүний уншигч Нацагдорж тэмдэгийн шагналт 5 хүүхдэд Шинэ жилийн бэлэг гардууллаа.

Нийгмийн асуудал

Байгууллагын ҮЭХороо Хамтын гэрээг байгуулан, батлуулан ажиллаж байна. 3 буудлаас дээш хол гэртэй ажилчдад ажилдаа ирэх унааны зардлыг 2 сараас эхлэн олгож байна. Өрх толгойлсон эмэгтэй үйлчлэгч Х. Гантөмөр, жижүүр

С. Бат-эрдэнэ нарт түлээ нүүрсний тусламж тус бүр 45000 төгрөг, шинэ гэр бүл болсон нягтлан Майцэцэгт 100.000 төгрөг олголоо.

Улсад архивын алба үүссэний 85 жилийн ойгоор хүний нөөцийн ажилтан М.Ариунаа " Аймгийн тэргүүний ажилтан" цолоор, Улсад 37 жил ажилласан Чулуунхороот сумын номын санч Ж. Дэлгэр "Аймгийн тэргүүний ажилтан " цол, номын санч Амаржаргал, жижүүр С. Бат-Эрдэнэ нар " Үйлдвэрчний соёлын тэргүүний ажилтан" цол тэмдэгээр шагнагдлаа.

2012 оны ажлыг дүгнэж захиргаа арга зүйн зөвлөлөөр хэлэлцэн сайн ажилласан ажиллагсадад 15-40 хувийн ур чадварын нэмэгдэл урамшуулал олгосон.

С.БУЯННЭМЭХИЙН НЭРЭМЖИТ ДУНДГОВЬ АЙМГИЙНТӨВ НОМЫН САНГИЙН 2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ХУУЛЬ, ТОГТООМЖ ШИЙДВЭРҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР

Төсвийн байгууллагын Удирдлага санхүүжилтын хуулийн дагуу 2012 онд хийх ажил, нийлүүлэх бүтээгдэхүүний Үр дүнгийн гэрээг төсвийн Ерөнхий менежертэй хийлээ. Ажиллагсдын жилийн ажлын төлөвлөгөөг баталж, биелэлтийг хангуулах үүднээс хагас жилээр дүгнэж ажлын амжилтаар урамшуулал, нэмэгдэл зэргийг олгож байна. Сангийн сайд, БСШУЯ-ны сайдын хамтарсан 2006 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 357/406 дугаар тушаалаар батлагдсан "Ном, хэвлэл дахин үнэлэх журам"-ын дагуу номын фондын 82 хувь буюу 44280 ширхэг номыг дахин үнэллээ. БСШУхааны сайдын 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 441 дүгээр тушаалын "Номын сангийн данс, маягт шинэчлэн батлах тухай" журмыг үндэслэн 2006 оны 1 дүгээр сараас эхлэн дараах байдлаар:

- Номын нэг бүрчилсэн бүртгэл:
- Номын сангийн фондын нэгдсэн бүртгэл:
- Номын санчийн өдөр тутмын ажлын бүртгэлийг шинэчлэн хөтөлж байна.

БСШУ-ны сайдын 2007 оны 11 сарын 8-ны өдрийн 415 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт "Алдагдсан буюу гэмтээгдсэн ном, хэвлэлийг дахин төлүүлэх журам"-ын дагуу тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн урагдаж гэмтэж уншлагын шаардлага хангахгүй байгаа номыг актанд бүртгэж журмын дагуу удирдах дээд байгууллагын /МҮНСан/ зөвшөөрлийг авч ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулах бэлтгэл ажлуудыг хийж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дугаар тогтоол, Засаг даргын 2007 оны 228 дугаар захирамжийн дагуу "Нээлттэй мэдээллийн арга хэмжээ" зохион байгуулж Монгол Улсын Засгийн газрын болон Аймгийн Засаг даргын 4 жилийн үйл ажиллагааны тайланг аймгийн Засаг даргын багтай хамтран тавьж Шадар сайд М.Энхболд тэргүүтэй бүрэлдэхүүн төлөөлөгчдөд, мөн Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагууд, Мандалговь хотын иргэдэд танилцууллаа. Мөн явуулын номын санг сурталчиллаа.

Аймгийн Засаг Даргын 2009 оны 180 тоот захирамжаар баталсан “С.Буяннэмэх тэмдэгтэн”-г шалгаруулах журмын дагуу 52 хүүхэд шалгарсныг байгууллагын хүндэт самбарт алдаршууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн Газрын 2004 оны 163 дугаар тогтоолын дагуу үндэсний бичиг үсгийн баяр “Бичиг соёлын хишиг өдөр”-ийг 1 сарын аяны хүрээнд өргөн тэмдэглэж өнгөрүүллээ.

Сумдын номын санг арга зүй, бусад мэдээллээр хангаж байх үүргээ биелүүлж дараах арга хэмжээг зохион байгуулсан.

БСШУЯ-аас хандивласан шилдэг номууд, өндөр хүчин чадал бүхий 1 компьютерийг 14 суманд хуваарилан хүргэж сумдын номын хөмрөгийн баяжилтыг чанаржуулах, техник хэрэгслээр хангахад тодорхой хувь нэмрээ оруулсан.

Монгол улсын “Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний тухай” хуулийн дагуу Байгууллагаас чөлөөнд гарсан өндөр настангуудад хүндэтгэл үзүүллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн “Номын баярыг тэмдэглэх тухай” зарлигын дагуу номын баярыг тэмдэглэн өнгөрүүллээ.

Долоо хоногийн Даваа гарагийн 17-18 цагт хууль эрх зүйн болон бусад мэдээллийг холбогдох мэргэжилтнүүдийг урьж хийлгэж заншсан.

ХОЁР. МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА, СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААР

- Насанд хүрэгчдийн уншлагын танхим 2010 оны 1-р сараас эхлэн, хүүхдийн уншлагын танхим 2011 оны 3-р сараас эхлэн, 2012 оны 1-р сараас эхлэн гэрээр ном олгох танхимууд цахим үйлчилгээ явуулж байна.
- Фондын номыг 100 хувь электрон каталогт оруулж номуудыг цэгцлэх, номын формуляр хэвлэх, цаасан каталог гаргаж байрлуулах зэрэг ажлуудыг хийж байна.
- Гурвансайхан, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдаар нүүдлийн номын сангийн үйлчилгээг үзүүлж 80 гаруй төрлийн ном, 10 гаруй төрлийн сонин сэтгүүлээр үзэсгэлэн гаргаж, 200 гаруй уншигч иргэдэд үйлчиллээ.
- “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд: Буяннэмэхийн нэрэмжит болон Нацагдоржийн шагналт яруу найрагч, сэтгүүлч П.Нямлхагвыг урьж “Ургийн уран тангараг” лекцийг Мандалговийн хүүхэд, залуучууд, албан хаагчдад зориулан уншуулав. “Монгол бичгээр зөв сайхан, уран бичих” уралдаан, “Их хөлгөн судартнэвтрэхүй” эссэ бичлэгийн уралдааныг амжилттай зохион байгуулахад ЕБС-ийн 3 дугаар сургуулийн монгол хэл, бичгийн багш Д.Отгонсүрэн, МГСС-ийн 11[a] ангийн сурагч Б.Түвшинтөр нар уралдааны тэргүүн байруудыг тус тус эзэллээ. “Алт мөнгөн аргай” телевизийн танин мэдэхүйн уралдаант нэвтрүүлгийг 2 дахь

удаагаа үндэсний соёл, түүх, зан заншлаа сурталчлах зорилгын доор зохион байгуулж орон нутгийн Цоглог телевизээр нэвтрүүллээ.

- "Номын амт-2" хүүхдийн бага наадмыг зохион явуулж, монголын хүүхдийн зохиолчдын төлөөлөгчдийг урин уншигч зохиолчийн уулзалт хийлээ. Нацагдоржийн шагналт, хүүхдийн зохиолч С.Надмидын нэрэмжит энэхүү "Номын амт" анхдугаар бага наадамд Адаацаг, Дэрэн, Дэлгэрцогт, Эрдэнэдалай, Сайнцагаан сумын ЕБС, цэцэрлэгүүдийн 176 хүүхэд оролцон авьяас чадвараа сорьсон өргөн арга хэмжээ боллоо. Шилдэг оролцогч цэцэрлэгээр Сайнцагаан сумын 6 дугаар цэцэрлэг, сургуулиар Эрдэнэдалай сумын сургууль шалгарлаа.
-
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн "Номын баярыг тэмдэглэх тухай" зарлигын дагуу Монгол улсын соёлын гавъяат зүтгэлтэн, Нацагдоржийн нэрэмжит шагналт Ц.Чимиддоржийн нэрэмжит "Есөн намрын зээргэнэ" номын баярыг тэмдэглэн өнгөрүүллээ.
- Шинэ номын болон сэдэвчилсэн үзэсгэлэнг 36 удаа тус бүр 70-80 номоор гаргалаа. Үүнд: Х.Нямбуугийн 70 насны ойд зориулан "Монгол зан заншил", "Монгол ардын тоглоомууд", "Монгол ардын аман зохиол", "Гэрийн эзэгтэй танд", "Монгол бичиг мину", "Танд сонирхолтой", "Шилдэг, шинэ ном" г.м.
- ЕБС-ийн ЭДЦ сургуулийн 5^{а}, 4^{б} ангийн 20 эцэг эх, 36 сурагчдад хүүхдийн шилдэг 20 номоор тойм яриа хийлээ.
- БСШУЯамнаас хандивласан 2011 оны шилдэг номыг аймгийн 14 сум, 18 сургууль, 20 цэцэрлэгт хувиарлан хүргүүллээ.
- "Олуулаа уншъя" аяныг зохион байгуулж аймгийн засаг дарга Д.Чандмань, төв номын сангийн захирал А.Нансалмаа нар МГССургууль, ЭДЦСургуулиудын сурагчиддай уулзалт зохион байгууллаа.

ГУРАВ. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖЛЫН ТАЛААР

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө /жил/	Гүйцэтгэл	хувь
1	Уншигч	20000	21000	105%
3	Ном олголт	40000	40000	100%
4	Ном сэлбэн засалт	2600	2662	102%

Үйлчилгээний танхимууд каталогийн хаяг, ялгагчуудыг шинэчлэн байрлууллаа. Номын фондын баяжилтыг чанаржуулах зорилгоор уншигчдаас санал асуулгын хуудсаар захиалга авч байна.

21000 уншигчид 40000 ном хэвлэлийн бүтээгдэхүүн олгож үйлчилсэн нь урд оны мөн үеэс 2% хувиар нэмэгдсэн байна

Улсын төсвөөр 387 ширхэг ном худалдан авч, фондын баяжилт хийлээ. 18 нэрийн 557400 төгрөгийн тогтмол хэвлэл захиалан уншигчдад үйлчлэв. Үүнээс 2 нэр төрлийн хэвлэл нь хүүхдэд зориулсан тогтмол хэвлэл байна. Нийт номын 2% буюу 1055 номд сэлбэн засалт хийж уншигчдад үйлчиллээ.

ДӨРӨВ. ДОТООД АЖЛЫН ТАЛААР

- 2012 онд хийх жил, улирлын ажлын төлөвлөгөөг гарган аймгийн БСГазрын даргаар баталгаажуулж хэрэгжүүлж ирлээ.
- Үйлчилгээний тасгууд болон номын үндсэн фонд хоорондоо дотоод сүлжээгээр холбогдох, электрон каталогт номуудыг оруулах ажлууд хийгдэж байна.
- Номыг 100 хувь электрон каталогт оруууллаа.
- Үйлчилгээний бүх танхимууд цахим үйлчилгээг үзүүлж байна.
- Үндсэн фондын ээлжит тооллогыг тооллогын комиссын бүрэлдэхүүнтэйгээр 11247 нэр төрлийн, 28242 ширхэг монгол ном, 8810 ширхэг орос номыг дансаар, цахимаар тоолж дуусгалаа. Мөн насанд хүрэгчдийн уншлагын тахимын 2046 нэр төрлийн, 2376 ширхэг номыг дансаар, цахимаар тоолж дуусгалаа.
- Ажиллагсад үйл ажиллагаандаа мөрдлөг болговол зохих хуулиудын сорилго боловсруулж өөрсдийн хуулийн мэдлэгийг шалгах, дээшлүүлэх арга хэмжээ явагдаж байна.
- Байгууллагын тохижилтыг батлагдсан төсөвт багтаан чанартай хийж байна.

ТАВ. САНХҮҮГИЙН ТАЛААР

“Дундговь ном хэвлэлийн хуудаснаа” ном зүйн бүртгэлийг боловсруулсан нь орон нутгийн номын сангуудын хувьд анхдагч байгаа ч хэвлүүлэх санхүүгийн боломжгүйгээс хэвлэлтэнд өгч чадаагүй байна.

Дотоод томилолтын зардал хүрэлцэхгүй, соёл олон түмний ажлыг явуулах төсөв огт байдаггүй зэрэг санхүүгийн бэрхшээлүүд байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

2012 онд хийсэн ажил, арга хэмжээндээ дүгнэлт хийж. ажиллагсдыг хийсэн ажлын нь үр дүн, амжилт, ур чадвараар нь нэмэгдэл урамшил олгосон нь ажил эрчимтэй явах, шинээр төрөл бүрийн ажил, арга хэмжээ зохион байгуулагдах, бүтээлч ажлын өрсөлдөөн бий болох зэрэг ажлын ахиц, өөрчлөлт гарахад шууд нөлөөлж байгаа нь харагдаж байна. Нөгөө талаар БСШУЯ-аас номын санчдын ур чадварыг дүгнэх шалгуур журам боловсруулж, мэргэжлийн зэрэглэл тогтоож өгөх нь зүйтэй байна. /Энэ тухай мөн урд онуудад ч санал болгож байсан/

2008-2012 онуудад их, бага урсгал засварууд хийгдсэнээр уншигчдын үйлчлүүлэх тав тухтой орчин бүрдэж ирэгсдийн тоо, байнгын уншигчдын тоо өмнөх онуудтай харьцуулахад өссөөр байна. 2012 оны энэ үетэй харьцуулахад уншигчийн тоо 23%-аар нэмэгдсэн байна.

Санхүү төсвийн хүндрэл их байгаа ч дотоод хүчин чадлаа дайчлан ажиллаж, орон нутгийн мэдээллийн төв, цаашилбал сургалтын төв болох, үйлчилгээндээ орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж ажиллах боломж байна гэж дүгнэж байна.

Б.ЯВУУХУЛАНГИЙН НЭРЭМЖИТ ЗАВХАН АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2012 оны үйл ажиллагааны хэрэгжилт үр дүн

Монгол улсын засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ард иргэдийн оюун санааны хэрэгцээг хангах тэдний улс төр, ёс суртахуун, гоо зүй, хууль эрхийн хүмүүжил, оюуны чадавхийг дээшлүүлэхэд номын сангийн уламжлалт үйлчилгээг орчин үеийн шинжлэх ухаан техникийн ололттой хослуулж хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхитэй мэдлэгтэй иргэн төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг номын сан гол зорилгоо болгон ажиллалаа. Иймд номын сангийн үйлчилгээг өргөтгөх техник технологийг шинэчлэх ном сурталчлах ажлыг хүүхэд багачуудын нас сэтгэхүйн онцлогт тохируулан агуулга хэлбэрийг баяжуулахад бүх ажлаа чиглүүлэн ажиллалаа.

Нэг. Номын сангийн үндсэн үйл ажиллагаа Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг гарсантай холбогдуулан *Номын баяр*-ыг аймгийн хэмжээнд тэмдэглэж энэ ажлын хүрээнд бүх номын сангуудын дунд уралдаант уншлага зохион байгууллаа.

Мөн уншлага үйлчилгээгээ өргөтгөх , хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх авъяас чадварыг хөгжүүлэх зорилгоор хүүхдийн номын ордон, АНУ-н 4Н байгууллагатай хамтран “Номын анд” аяны хүрээнд зохион байгуулалттай уншлага зарлан 108 багийн 647 хүүхэд хамрагдсан бөгөөд уг ажлыг 2 үе шаттайгаар дүгнэх бөгөөд 1-р шатыг аймгийн төв номын сан дээр шалгаруулах бөгөөд багуудын болон ганцаарчилсан багийн тайланг хүлээн авч сар бүр нэгтгэж байна.

Жилдээ 5500 уншигч 43112 ирэгсдэд 64690 ном олгож үйлчиллээ. Алслагдсан албан байгууллага, сургууль, цэцэрлэгүүдэд англи болон монгол ном зөөвөрлөх ажлыг амжилттай зохион байгуулан зөөврөөр 2074 уншигч 28555 ирэгсдэд 30532 ном олгож үйлчиллээ.

Уралдаант уншлагад хамгийн олон хүүхэд хамрагдаж, хамгийн олон ном уншсан сургуулиар Жавхлант цогцолбор сургууль шалгарч Тэргүүний уншигчаар Дэвшил сургуулийн 8а ангийн сурагч Я.Бат-Амгалан, Жавхлант цогцолбор сургуулийн 7а ангийн сурагч Д.Бат-Эрдэнэ, Г.Мандах,7д ангийн сурагч Б.Сумъяа, Б.Даваажаргал, 5б ангийн сурагч Б.Уртнасан, ЧЭЦС-н 9б ангийн сурагч Б.Баясгалан, 11 жилийн 4-р сургуулийн 7а ангийн сурагч Д.Хажидмаа, 2а ангийн сурагч Д.Цэвэлмаа нар тус тус шалгарлаа.

- Дэвшилтэт шинэ үйлчилгээ, бүтээлч ажлын хүрээнд:
- Номын сангийн LIB4U программд үндсэн фондны 80% гаруй хувийг программд оруулж электрон каталоги зохион байгуулан уншигчдын эрэлт хэрэгцээг түргэн шуурхай хангаж ажиллаж байна.
- Аливаа мэдээллийг олон эх сурвалжаас авах , хэрэгцээт зүйлийг шууд хэвлэн өгөх , уншигчид өөрсдөө хэрэгцээт зүйлээ хэвлэж авах хувилах зэрэг мэдээллийн үйлчилгээний шинэлэг хэлбэрийг амжилттай зохион

байгуулж уг ажилд зориулан шинээр Keocera каноныг худалдан авч үйлчилгээнд ашиглаад байна.

- Завхан аймаг 2012 оныг мэдээлэл технологийн жил болгон зарласантай холбогдуулан номын сангийн компьютеруудыг шинэчилж дотоод сүлжээнд холбох ажлыг хийлээ.
- Bookbridge-н номын санд интернэтийн танхим байгуулан уншигчдад үйлчилж байна.
- Сумдын номын сангуудыг компьютержүүлэх ажлыг зохион байгуулж 23 сумын номын санд тус бүр нь 615,0 төгрөгийн нийт 14145,0 төгрөгийн үнэтэй компьютерүүдийг тараах ажлыг зохион байгууллаа.

- Завхан аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг угтаж номын сангийн гадна дотор засвар хийхээр мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулан холбогдох байгууллагад танилцуулж хөрөнгийг шийдвэрлүүлэх арга хэмжээ авлаа.

• Үйлчилгээний таатай орчин, хөнгөн шуурхай байдлыг хангах мэдээллийн орчин үеийн олон талт үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж уншлагын танхимуудын үйлчилгээний тохилог орчин гэрэлтүүлэг, дулаан, чийгшил,эрүүл ахуйн нөхцөл, ойрын болон үндсэн фондын номын хадгалалт хамгаалалт зэргийг стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулж байна.

• Номын сангийн үйлчилгээний орчинг сайжруулах дулаан тавлаг орчинд үйлчилгээ явуулах зорилгоор номын сангийн өргөтгөлийн барилгын цонхыг вакум цонхоор солих,гадна талыг тоосголох ажлыг хийлээ.

• Номын сангийн хэвийн үйл ажиллагааг явуулах нөхцөлийг хангах зорилгоор сантехникийн засвар хийлээ.

• Номын санд цэвэр ус оруулах ажлыг хийлээ.

Лавлагаа ном зүйн ажлын талаар

- Лавлагаа ном зүйн ажлыг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор ACCESS программаар хийсэн лавлагааны санг тасгуудын компьютерт суулгаж ашиглахад бэлэн болголоо.
- ТАК болон ҮДК-д редактор хийж 70 агруй урагдаж гэмтсэн болон хуучирсан картыг шинэчиллээ.
- 862 номонд техник ажиллагаа хийн бүх номоо каталогийн картанд тусганТАК болон ҮДК-т байрлуулан тасаг танхимуудад хуваарилан уншлаганд гаргалаа.
- Уншигчдын лавлагаанд амаар 241 удаа, бичгээр 42 удаа хариу өгсөн байна.
- Уншигч хэрэглэгчдэд мэдээ мэдээллийг тухай бүрт нь хүргэх зорилгоор * Байгаль экологи *, *Жижиг дунд үйлдвэрлэл*, * Эрүүл аж төрөх ёс* сэдвүүдээр картын санг сонин сэтгүүлээс түүвэрлэн зохион байгуулж байна.
- Нийтийн уншлагын танхимд уншигчдад зориулсан компьютер тавьж уншигчдын лавлагаанд интернэт, цахим, болон төрөл бүрийн CD-ний тусламжтайгаар лавлагаа өгч байна.
- Номын сангийн уншигчдын сүүлийн 3 жилийн судалгааг гаргаж дүн шинжилгээ хийлээ.

- Уншигчдын дунд судалгаа явуулж хэрэгцээ шаардлагатай байгаа номын жагсаалтыг гаргалаа.

- Фондын баяжилт бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, лавлагаа мэдээллийн санг өргөжүүлэх хүрээнд :
- Ном хэвлэлийн бүрдүүлэлтийг хийхдээ орон нутгийн онцлог, татгалзлын дэвтрийг үндэслэн худалдаагаар 591 ширхэг 5694800 төгрөгийн, хандиваар 271ширхэг 2716802 шинэ ном хэвлэлийг авч техник арга ажиллагаа хийж фондоо баяжууллаа.
- Хөдөөгийн номын сангуудын фондыг
- “Шилдэг ном 2010” 2084812 төгрөгийн 566 ширхэг номоор
- Бэлгийн 1501500 төгрөгийн 420 ширхэг номоор
- БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар
    - Сумын номын сангуудад 42388201 төгрөгийн
    - Аймгийн ЕБС-н болон сумдын сургуулийн номын сангуудад 19599650 төгрөгийн
    - Аймгийн болон сумуудын цэцэрлэгүүдэд 7252470 төгрөгийн номыг тус тус тараах ажлыг зохион байгууллаа.
- СУХСангийн улсын төсвөөр 23 сумдын номын сангуудын фондыг 1951481 төгрөгийн 14520 ширхэг номоор тус тус баяжууллаа.

- Уншигчдын эрэлт хэрэгцээг түргэн шуурхай барагдуулах зорилгоор монгол номын фондын бүх ялгагчуудыг шинэчиллээ.

Ном сурталчилах ажлын талаар

- Уншигч багачуудын дунд номтой зөв боловсон харьцах талаар яриа таниулга 10 удаа хийсэн байна.

- Цэцэрлэгийн хүүхдүүдийг номын сантай танилцуулах ажлын хүрээнд хүүхдүүдийг номын сантай номтой танилцуулахын зэрэгцээ бяцхан уншигчдын сонирхсон үлгэрийн номоор чанга уншлагыг 14 удаа хийлээ.

- Уралдаант уншлагын аяны хүрээнд зохион байгуулсан уралдаан тэмцээнд ашиглагдах шилдэг бүтээлүүдээр шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 42 удаа гаргаж уншигчдад чөлөөт сонголтоор ашиглуулж хэвшсэн.ЕБС-н 1-р ангийн сурагчдын дунд “Бид уншиж сурлаа” сэдэвт түргэн уншлагын уралдааныг зохион байгууллаа.

1-р байр Дэвшил сургуулийн Оюунчимэг багштай 1Б ангийн сурагч Г.Дэлгэрмөрөн 105 үг

2-р байр Дэвшил сургуулийн Оюунчимэг багштай 1Б ангийн сурагч О.Бумбаяр 71 үг

3-р байр Жавхлант цогцолбор сургуулийн 1Г ангийн сурагч Б.Энхжаргал 67 үг тус тус уншиж эхний 3 байр эзэллээ.

Эхний 3 байрт шалгарсан сурагчид

- 5-р ангийн сурагчдын дунд “Би монгол хүүхэд” сэдэвт ёс заншилын олимпиадыг Хас банктай хамтран 2 үе шаттайгаар зохион байгууллаа.

  1-р байранд ЧЭЦС-н 5а ангийн сурагч Батсайхан овогтой Оюунмөнх

  2-р байранд Жавхлант цогцолбор сургуулийн 5в ангийн сурагч Дамиранжав овогтой Бямбадорж

  3-р байранд Бүрэн дунд 3-р сургуулийн 5б ангийн сурагч Батсуурь овогтой Насанжаргал

  Тусгай байранд ЖЦС-н 5а ангийн сурагч Нямбуу овогтой Отгонцэцэг нар тус тус эзэллээ.

Уг олимпиадын үеэр номын сан шинэ болон уламжлалт ёс заншилын талаарх номын үзэсгэлэн гарган тойм хийж сурталчиллаа.Мөн аймгийн Air1 телевиз ирж мэдээлэл хийж олон нийтэд сурталчилллаа.

Олимпиадад оролцсон сурагчид

Air1 телевизийн сурвалжлагч нар байр эзэлсэн сурагчдын сэтгэгдлийг сонсов

- Бичиг үсгийн хишиг өдрийг тохиолдуулан ЕБС-н 8-р ангийн сурагчдын дунд “Үндэсний бичиг соёлоо хадгалцгаая” сэдэвт монгол бичгийн уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгууллаа.

  Уралдаанд сургууль тус бүрээс 2 сурагч оролцсон бөгөөд гэрийн даалгавар болох үндэсний бичиг үсгээ эрхэмлэн дээдлэсэн ишлэл,сургаал үг бичсэн үзүүлэн болон цэвэр алдаагүй сайхан бичих гэсэн 2 үзүүлэлээр явуулан дүнг гаргасан.

  1-р байр Бүрэн дунд IV сургуулийн 8б ангийн сурагч Б.Сувд-Эрдэнэ

  2-р байр Дэвшил сургуулийн 8б ангийн сурагч Г.Лундаа

  3-р байр Бүрэн дунд III сургуулийн 8в ангийн сурагч Г.Цэвээндулам нар тус тус эзэллээ.

Уралдаанд оролцсон сурагчид

- ❖ МБУГС-тай Дэвшил сургуультай хамтран “Хүүхдийн хүчирхийлэл”, ”Хүчирхийллийн эсрэг хамтдаа”,”Аливаа гамшигийн үед авах арга хэмжээ” сэдэвт сургалтуудыг тус тус хамтран зохион байгууллаа.

“Хүчирхийллийн эсрэг хамтдаа” Дэвшил сургууль 9б ангийн сурагч Хонгорзул

Номын баярыг тэмдэглэх тухай ерөнхийлөгчийн зарлиг гарсантай холбогдуулан аймгийн БСГ-тай хамтран “Номын баярын өдөр”-г зохион байгууллаа. Тус арга хэмжээний удирдамжийг боловсруулж оролцогчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн явууллаа

- ❖ Дэлхийн зөн монгол ОУБ-н Завханхангай ОНХХ-тэй хамтран “Хүүхдийн хүмүүжил ” сэдэвт онол практикийн бага хурал зохион байгууллаа.

Бага хуралд сургууль бүрээс 15 суралцагч, 5 эцэг эх, багш нарын төлөөлөл оролцсон бөгөөд уг хурлаар:

- ➢ Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо /**Дэвшил сургуулийн 10а ангийн сурагч Аниймаа/**
- ➢ Хүүхдийн хүмүүжил ба сургуулийн орчин/**ЧЭЦС-н 10г ангийн сурагч Амармэнд/**
- ➢ Өсвөр насны хүүхдийн хүмүүжил ба үе тэнгийнхний хоорондын үл ойлголцол /**ЖЦС-н 10а ангийн сурагч Дулам/** гэсэн сэдвүүдээр тус

тус илтгэл явагдаж түүн дээрээ тулгуурлан санал бодлоо солилцох, хэлэлцэх,гарах арга замуудыг тодорхойлох замаар явагдлаа.

/ЖЦС-н 10а ангийн сурагч Дулам/

Соёл олон түмний ажлын талаар

- Дэвшил сургуулийн багш Оюунцэцэгтэй хамтран Дэвшил сургуулийн 7,8,9-р ангийн сурагчдын дунд “Мэддэгт мэргэн цоохор “ танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгууллаа.

- Дэвшил сургуулийн багш Оюунцэцэгтэй хамтарч 6-р ангийн эцэг эхчүүд сурагчдын дунд * Боловсрол гэр бүлээс эхэлнэ* сэдвээр лекц зохион байгууллаа.
- Англи хэлний багш агсан Г.Гантөгсийн нэрэмжит * Бүхнийг мэдэхийг хүснэ* танин мэдэхүйн тэмцээнийг Дэвшил сургуулийн Оюунцэцэг багштай 8а ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.

- Идэвхтэн уншигч хүүхдүүдийн дунд номч клуб байгуулан ном сэлбэн засах ажлыг зохион байгууллаа.
- Отгонтэнгэр УТХГ-тай хамтран жил бүр уламжлал болгон зохион явуулдаг " Байгаль орчноо хайрлан хамгаалах зан заншил түүхтэй холбогдон холбогдуулан МСҮТ-ийн 1-р курсын 123 оюутнуудын дунд АХА тэмцээн зохион байгууллаа.
- Отгонтэнгэр УТХГ-тай хамтран МСҮТ-ийн 1-р курсын оюутнуудын дунд *Байгалийн нөөц баялагийг зүй зохистой хэрэглэх* сэдвээр илтгэлийн уралдаан зохион байгуулж 10 илтгэл тавигдлаа.
- Монгол ном сэдэвт УБХ зохион байгуулж Монголчуудын бүтээсэн ном хэвлэл сэдвээр мэдээлэл хийлээ.
- Ном сэлбэн засах өдөрлөгийг Дэвшил сургуулийн 8-р ангийн сурагчидтай хамтран зохион байгуулав.
- Жил бүр * Номын баяр*-г тэмдэглэх тухай Ерөнхийлөгчийн зарлиг гарсантай холбогдуулан номын баярыг төв талбайд зохион байгуулан нээлтийн үйл ажиллагаанд уншигчид болон нийт иргэдэд байгууллагын ажлын тайлан болон Завхан аймгаас төрсөн алдартнуудын мэдээлэл, шилдэг номын сангуудын танилцуулгыг тус тус бэлтгэн уншигчдад дэлгэцээр гарган танилцуулж сурталчиллаа.
- * Монголчуудын ном хэвлэлийн хөгжил ба өнөө үе* сэдэвт илтгэл тавилаа.
- Орон нутгийн AIR 1 телевизээр номын гүүрийн талаар мэдээлэл хийж үүнтэй холбогдуулан 6-р цэцэрлэгийн хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх тэдний сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх тоглоом тоглуулах хүүхэлдэйн кино үзүүлэх ном сурталчлах ажлыг зохион байгууллаа.
- Солонгос улсын иргэн Соломонтой хамтран ENGLISH CLUB –н үйл ажиллагааг насанд хүрэгчдийн дунд зохион байгуулан Солонгос үндэсний хоолыг хийж сурах англи хэлээр ярьж сурах зэрэг ажлуудыг зохион явууллаа.

- Нидарланд улын иргэн номын гүүрийн төлөөлөгч Роб номын сангийн үйл ажиллагаатай танилцаж арга зүйн зөвлөлгөө өгөхийн зэрэгцээ 3-р 11 жилийн англи хэлний багш Ууганцэцэг сайн дурын ажилтан Bianca нар клубын хүүхдүүдийн сургалт хичээллүүлж ХБК-н оюутнуудын урлагийн тоглолт уралдаан тэмцээн явуулж ном сурталчлав.
- Номын гүүр сургалтын номын сангаас ЕБС-н 9-р ангийн сурагчдын дунд Англи дууг хэн сайн дуулах вэ? Уралдааныг зохион байгуулж 3 сургуулийн 6 сурагч оролцож
  - 1-р байр Дэвшил сургуулийн 9б ангийн сурагч Билгүүн
  - 2-р байр Дэвшил сургуулийн 9а ангийн сурагч Баттөр
  - 3-р байрыг 3-р сургуулийн 9в ангийн сурагч Сайнзаяа тус тус эзэллээ.Тус уралдаанд нийт 30 хүүхэд хамрагдлаа.
- Завхан аймагт ажиллаж амьдарч буй сайн дурын ажилтан, англи хэлний багш нартай хамтарч зуны англи хэлний анхан болон ахисан шатны эрчимжүүлсэн төлбөртэй сургалтыг хичээллүүлж 18 хүүхэд хамрагдлаа.
- ЕБС-н сурагчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх , чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор MOVIE CLUB-н үйл ажиллагааг тогтмол явуулж байна.
- ЕБС-н сурагчдын амралтаар 5-7 ангийн сурагчдад америк монгол багштай 14 хоногийн англи хэлний төлбөртэй сургалт хичээллүүлж 15 хүүхэд хамрагдлаа.
- ЕБС-н 8-9 болон 10-11 ангийн сурагчдын дунд англи хэлний SPEAKING CLUB-г сайн дурын ажилчид Bill,Bianca, Brayn ,Caren нартай хамтран 7 хоног бүр ярианы хичээлийг явуулж нийт 40 хүүхэд хамрагдсан байна.
- ЕБС-н сурагчид оюутнууд хамарсан 2 сарын гүнзгий шатны эрчимжүүлсэн төлбөртэй сургалтыг англи монгол багш нартай хамтарч хичээллүүлж нийт 20 хүүхэд хамрагдаад байна.
- Насанд хүрэгчдийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилготой Америк багштай TOEFL class хичээллүүлж 17 хүн хамрагдлаа.

Арга зүйн ажлын талаар

- Сумдын номын сангуудыг 5 бүсэд хувааж соёлын ажилтнууд болон номын санчдыг 3 хоногийн сургалтанд хамруулж нийт 123 соёлын ажилтан хамрагдсан бөгөөд гарсан санал хүсэлтийг холбогдох дээд газруудад хүргүүлж асуудлыг шийдвэрлүүлээд байна.
- Сум сургуулийн мэдээ тайланг нэгтгэж БСГ, МҮНС-д хүргүүлээд байна.
- Ургамал сумын номын санчийг номын сан дээр дадлага хийлгэж мэргэжлийн зөвлөгөө өглөө.
- 23 сумын номын сангуудад номын сангийн Openbiblio программ бүхий тус бүр нь 712.158.7 төгрөгийн үнэтэй Dell 3010 компьютерийг тарааж программын сургалтыг хийхээр төлөвлөөд байна.
- ССАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар Эрдэнэхайрхан, Баянтэс, Завханмандал, Идэр, Сонгино сумын соёлын төвүүдэд 381150 төгрөгийн үнэтэй конторын ширээ сандал
- Төв номын сан,Эрдэнэхайрхан, Алдархаан, Идэр, Тэс, Завханмандал, Баянхайрхан сумуудад 8623333 төгрөгийн номын тавиур

- Тэс,Завханмандал,Эрдэнэхайрхан,Тосонцэнгэл,Идэр,Баянхайрхан сумуудад 6217200 төгрөгийн уншигчийн ширээ сандал
- Их-Уул, Баянхайрхан, Цэцэн-Уул, Нөмрөг,Цагаанчулуут сумуудад 2827500 төгрөгийн үзэгчийн сандлыг тус тус тараалаа.

Орхон аймгийн Номын төвийн 2012 оны үйл ажиллагааны тайлан

Эрхэм зорилго:

Илүү нээлттэй, чөлөөтэй, орчин үеийн үйлчилгээг ашиглаж, өргөжүүлэн хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхитэй, мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

Орхон аймгийн номын төв нь 2012 онд тав тухтай, таатай орчинд үйлчлэх зорилтыг тавьж ажиллаа.

Номын төв нь 2012 онд Нийтийн танхим, Хүүхдийн танхим, Гэр бүлийн танхим, Гэрээр ном олголтын танхим, Лавалгаа-мэдээллийн танхим, Виртуал-гадаад хэлний танхим, Интернет-номын худалдаа, Хүний хөгжил дэхь салбар номын сан, Дэнж баг дахь салбар номын сан гэсэн 7 танхим, 2 салбар номын сангаар 210 гаруй хүнд үйлчилгээ нэг дор үзүүлэх тохилог орчин бүрдүүлэн мэдээллийн үйлчилгээ үзүүлж байна.

Нэг. Уншлага үйлчилгээ

Номын төв нь 2012 онд 7260 уншигчдад буюу давхардсан тоогоор 63225 ирэгсэдэд 133592 ном олгосон байна. Уншлагын танхимаар нь задалвал:

№	Уншлагын танхим	Уншигч	Ирэгсэд	Олголт
1	Нийтийн уншлагын танхим	1597	20070	24933
2	Хүүхдийн уншлагын танхим	3850	25517	71422
3	Виртуаль-гадаад хэлний уншлагын танхим	515	4611	4872
4	Гэр бүл, гэрээр олголтын танхим	280	6192	23339
5	Хүний хөгжил дэх салбар номын сан	411	1458	3134
6	Дэнж баг дахь салбар номын сан	607	5263	5892
Нийт		7260	63225	133592

Номын сангаар үйлчлүүлж буй иргэдийн 43,5% нь ЕБС-ийн сурагчид 41,7 % оюутан, 14,8 % нь насан хүрсэн иргэд буюу ажилчин албан хаагчид байна. Дээрх судалгаанаас үндэслэн насанд хүрэгчид тэр дундаа үйлдвэрийн ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, номонд дуртай болгох зорилго бүхий “Дулааны

Цахилгаан Станц"-тай хамтарч ажиллаж, цехүүдийн дунд 2 сарын аян өрнүүлэн ажилласан нь чухал ажил болсон.

Хоёр. Номын фондын бүрдүүлэлт, фондын ажил

Номын төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, уншигч үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан ном хэвлэлийг татан авч фондын номын баяжилт хийж, номын сангийн стандарт шаардлагын дагуу номыг бүртгэж, номын бүрэн бүтэн байдлыг хангаж хянаж ажилладаг.

Номын фондыг 2012 онд төсвөөр 361 нэрийн 545 ширхэг 6798600 төгрөг, хандиваар 453 нэрийн 725 ширхэг 5952600 төгрөгийн нийт 814 нэрийн 1270 ширхэг 12751200 төгрөгийн шинэ авч, номонд техник ажиллагаа хийж номын сангийн программанд оруулсан байна. Номын сангийн баяжуулалтаар авч байгаа номонд агуулга хэрэглээнд чанарын шинжилгээ хийж уншигч хэрэглэгч нараас захиалга авахын зэрэгцээ танхимуудын номын санч нар өөрсдөө дэлгүүрээр явж ном сонгох ажлыг нэг удаа зохион байгуулан ажиллаа.

Номын төвийн даргын 2012 оны 06 сарын 14-ны өдрийн 17 тоот тушаалаар үндсэн фондын ээлжит тооллогыг ня-бо Д.Нэргүйгээр ахалсан фонд бүрдүүлэгч Н.Отгонцагаан, номын санч Ч. Чойжилсүрэн, мэдээллийн ажилтан А.Бахыт, үйлчлэгч П.Даарийжав нарын комиссын гишүүнтэй нэг сарын хугацаанд номын сангийн Libu4 программаар цахим хэлбэрээр тооллого явууллаа. Тооллогоор үндсэн фондын монгол 8920 ширхэг 15859000 төгрөг, орос 63606 ширхэг 5725000 төгрөгийн нийт 15226 ширхэг 21584000 төгрөгийн номыг тоолж монгол 50 ширхэг 119360 төгрөг, орос ном 8 ширхэг 10358 төгрөгийн ном дутсанаас хүний гар дээр 2 ном данс давхардсан, дутсан ном дахин гарсан 7 ширхэг ном байна.

Танхимуудад энэ онд ажил хүлээлцэх болон ээлжит бус тооллогыг нийтийн танхим 2 удаа, хүүхдийн танхим 1 удаа хийж энэхүү тооллогоор урагдаж гэмтсэн, ариун цэврийн шаардлага хангахгүй байгаа 549 ширхэг 353617 төгрөгийн номын жагсаалтыг гаргуулж аймгийн төрийн өмчийн албанд акт тогтоолгох арга хэмжээ авлаа.

Үндсэн фондын номноос зөөврөөр гадаад хэлний танхимд 70 ширхэг ном, дэнжийн салбарт 21 ширхэг , номзүйд 19 ширхэг , нийтийн танхимд 8 ширхэг нийт 118 номоор үйлчилсэн байна. Үндсэн фондын нэгбүрчилсэн бүртгэлд бичих асуудлын талаар ҮННС-ийн зарим хүмүүстэй санал солилцсон болно.

Гурав. Лавалгаа номзүй

- Уншигчдад 816 удаа лавлагаа өгсөн. Үүнээс: Сэдэвчилсэн 734 удаа, ном зүйн тодруулгын 21 Тоо баримтын 61 удаа тус тус өгсөн.
- Радио, телевизэд нийт 27 удаа мэдээ, мэдээлэл, уншлага үйлчилгээний талаар өгсөн байна.
- Маркетинг,, эдийн засаг, мөнгө санхүү, Соёл гэгээрэл, Ерөөл магтаал зэрэг 3 ш санамж өгөх ном зүйг хийхээс гадна Чингис хаан, Аман зохиол- утга зохиолын чиглэлээр 2 ш бүртгэн мэдээлэх номзүйг хийлээ.
- Эрдэнэтийн домог түүхийн лавлагааг болон хөшөө дурсгалуудын тайлбартай лавлагааг гаргасан.
- Интернэтийг ашиглаж онлайнаар лавлагаа өгөх үйлчилгээг тасралтгүй хийж нийтдээ 130 гаруй хүнд 260 гаруй мэдээллэлийг олж өгсөн байна.
- Номын төвийн нэгдсэн каталогийг уран зохиолын ангилал хүртэл хэвлэж гаргасан.
- Номын сангийн ном ашиглах талаарх зөвлөмжүүдийг бэлтгэж мэдээллийн самбараар сурталчлах болон номзүйн хавтсанд хийсэн
- Номын санг ашиглах талаарх зааварчлагааг уншигчдад хийж номын төвийн талаар байнга асуугддаг асуултуудыг гаргасан.

Дөрөв .Соёл олон түмний ажил

СОТА нь уншигчдыг номонд дуртай болгох, ном хэвлэл, мэдээллийн нөлөөг дээшлүүлэх, олсон мэдлэгээ бататгах, нийгэм олон нийтийн ажилд оролцох идэвхи санаачлагатай болгох, өөртөө итгэлтэй нээлттэй болгох ач холбогдолтой. Номын төвөөс 2012 онд 64 удаа 3000 гаран хүн хамруулсан СОТА зохион байгуулсан байна . Үүнээс томоохон уламжлалт ажлуудыг дурьдвал:

Номын баяр-2012

Монгол Улсын Ерөнхийлөгч 2012.08.24-ны өдөр “Номын баярын өдөр тэмдэглэх тухай” 158 дугаар зарлигийг соёрхон баталж, жил бүрийн 9-р сарын гурав дахь долоо хоногийн Бямба гарагийг “Номын баярын өдөр” болгон өргөнөөр ёслон тэмдэглэхээр болсонтой холбогдуулан Орхон аймгийн Номын төвөөс Номын баярыг 1 сарын хугацаатай өрнүүлэх болсон. Номын баяр-2012 нь өнгөрсөн жилүүдээс илүү өргөн хүрээтэй Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигийг дэмжсэн “Олуулаа уншъя” уриатай явагдсан. Үүнд: Номын баярын нээлтийн ажиллагааг 2012.09.21-ны өдрийн 11.00 цагт Найрамдал талбай дээр хийсэн. Энэ үеэр Зохиолч уншигчдын уулзалт, ярилцлага зохион байгуулж, тэдгээрийн бүтээлийг

нийтэд сурталчлах, зарах худалдах иргэд ном солилцох, бэлэглэх хандивлах ажлуудыг зохион байгуулж нийт 12 зохиолч оролцсон.

- Соёлын төвүүдийн номын сан номын үзэсгэлэн гаргаж өөрсдийнхөө үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан
- Номонд ээлтэй хамт олонг хөхүүлэн дэмжих ажиллагааг зохион явуулж Дулааны станц, Хүдрийн ил уурхай, Баян-Өндөр сум зэрэг газруудыг шагнаж урамшуулсан
- Ном хандивлах: /ЕБС-иуд, цэцэрлэг 62 нэрийн 801 ширхэг буюу 12.5 сая төгрөгийн ном,соёлын төвүүдэд 110 нэрийн 427 ширхэг буюу 7.9 сая төгрөгийн номыг хандивласан./
- Дотоодын цэргийн 816-р тусгай салбар өөрийн анги нэгтгэлдээ шинээр номын санг байгуулж Монголын нууц товчоог хүндэтгэн залсан
- Номын баярын хүрээнд: нийт 400 гаруй хүүхэд оролцсон
- Хүүхдүүдийг номонд дуртай болгох, ном унших сонирхолыг нь төрүүлэх, тэдгээрийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх
- Монголын үгэн урлагийн нэрт төлөөлөгч, өгүүллэгийн уран дархчуул болон монголын сонгодог зохиолч нарын зохиол бүтээлтэй танилцах,
- ЕБС-ийн сурагчдын уран зохиолын мэдлэгийн хүрээг тэлэх үзсэн хичээлийг нь бататгаж өгөх
- Номч анги, номонд ээлтэй багш, Д.Нацагдорж тэмдэгтэн 18 хүүхэд 3 багш 2 ангийг шалгаруулж урамшууллаа.
- Номын сан уншигчдын харилцаа холбоо хамтын ажиллагааг сайжруулах гэх зэрэг ажлуудыг хийж нийт 1800 гаруй хүүхдэд үйлчилсэн байна.
- Үндэсний бичиг үсгийн өдөр Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 тоот зарлигийг хэрэгжүүлэх, үндэсний хэл бичиг, түүнтэй холбогдолтой ёс заншил, уламжлал, өвийг судлах, сурталчлах, үндэсний бичгээ өвлүүлэх зорилгоор Бичиг үсгийн өдрийг тус аймгийн БСГазартай хамтран зохион байгууллаа. Нийт 500 гаруй хүүхэд оролцсон Үүнд:БСГ, Номын төв хамтран "Хурдан уншлагын " уралдааныг 8-9 анги, 10-11-р анги, насанд хүрэгчид гэсэн 3 ангиллаар зохион байгуулж, шалгаруулж урамшууллаа.
- Монгол бичгээр бичсэн бүтээлийн уралдааныг зарлаж нийт 69 бүтээл

ирсэнээс 2 ангилалаар шалгаруулж бүх нийтэд сурталчиллаа.

- Үндэсний бичиг үсгийн өдрийн ажиллагааã зохион байгуулж ЕБС-ийн сурагчид болон хэл уран зохиолын багш нар оролцлоо. Энэхүү арга хэмжээг орон нутгийн 5 телевиз болон шинэ мэдээ сонингоор сурталчилсан

• Номын үзэсгэлэнг 30 гаруй номоор зохион байгуулж, хүүхдийн зохиолчдын зохиол бүтээл болон бичиг үсгийн тухай ном сэтгүүлээр үзэсгэлэнг гаргахаас гадна багш Л.Чинбатын ховор хуучин номын үзэсгэлэнг гаргасан.

• Д.Нацагдорж тэмдэгтний болзолт уралдааныг дүгнэж улсын Монгол хэл бичгийн уралдаанд тэргүүн болон медальт байр эзэлсэн 12 хүүхдэд гардууллаа.

• Монголын нууц товчоог 1 өрх 1 байгууллагад залж өргөмжлөв.

"Монгол үгийн чуулган" наадмын хүрээнд: Нийт 600 гаруй хүүхэд оролцсонБоловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны 10-р сарын 23-ны өдрийн А/ 85 тоот тушаалыг хэрэгжүүлэх, ЕБС-ийн бүх сурагчдыг "Монголын нууц товчоо" зохиолын гайхам уран хэллэгээр үгийн сангаа баяжуулах, эх сайхан хэлээрээ зөв ярьж хэвших, Монгол улсынхаа түүх, соёл, зан заншлаас суралцах, өвөг дээдсийн үлгэр дууриаллаар хүмүүжих, үндэснийхээ бахархлыг сэргээх зорилгоор манай аймгийн Боловсрол соёлын газар, аймгийн номын төвтэй хамтран, "Монгол үгийн чуулган" наадмыг 11 сарын 1-нээс 14-ний хооронд зохион байгуулсан.

- ДЦС-ийн 25 жилийн ойг тохиолдуулан зөөврийн номын сан ажиллуулах 2 сарын аяныг эхлүүлэн удирдамж , ажлын төлөвлөгөөг батлуулан энэ хугацаанд танхимуудын номын үзэсгэлэн номын худалдаа, гэрээр олгохоор 3 удаа номын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 98 хүнд уншигчийн карт нээж 105 ширхэг номыг зөөврөөр уншуулан, 275000 төгрөгийн номын борлуулалт хийж, ажилчдын дунд танин мэдэхүйн чиглэлээр "АХА" тэмцээнийг ажилчдын дунд хийж шалгаруулан нийт 52 хүн оролцож "Тусгал" телевизээр шууд бичлэг хийлгэлээ. ЭДЦС-ийн мэргэжлийн номын сангийн нээлтэнд зориулж МСҮТ-ийн номын санч яруу найрагч Отгонбаяртай уулзалт ярилцлага хийж 2 хүн Монголын нууц товчоо залах ёслолын ажиллагаа боллоо. Энэ үеэр Номын төвөөс нийт 50 нэрийн уран зохиолын номын тус номын санд нь хандивлалаа.

Тав. Номын үзэсгэлэн:

- Номын төвөөс аж ахуй нэгж албан байгууллага болон өөрийн байгууллага дээрээ нийт 121 удаа 3093 номоор үзэсгэлэн гаргасан байна.
- Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Номын яармаг-үзэсгэлэн худалдаа"-г Найрамдал талбайд 2012 оны 9-р сарын 24-25-ны хооронд зохион байгуулсан.
- Жаргалант сумын "Ургацын баяр"-аар Номын үзэсгэлэн, худалдаа гаргасан.

Зургаа. Номын зөөвөр

- ССАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар "нүүдлийн номын сан"-гийн УАЗ ПУРГОН авто машинтай болж 09-р сараас хойш малчин багаар 2 удаа нүүдлийн номын санг ажиллуулсан нь малчдын талархлыг хүлээсэн ажлын нэг болсон.
- Номын төвөөс 120 аж ахуй нэгж, албан байгууллагад 1942 ширхэг номоор 2800 хүнд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 61 удаа 160 номоор зөөврөөр олгож үйлчилсэн байна.

Долоо. Мэдээ мэдээлэл

- "Эрдэнэт үйлдвэр"-ийн телвизтэй хамтаран 14 хоног тутам Номын хишиг нэвтрүүлэг тогтмол хийж хэвшсэн.Номын төв нь мэдээллийг нээлттэй байлгах үүднээс орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байнгын хамтарч ажиллаж ирсэн.
- Телезид-56
- Шинэ мэдээ -2
- Эрдэнэт таймс-2
- FM -2 удаа мэдээллийг тус тус өгсөн байна.

Найм. Тайлан мэдээ

- Аймгийн статистикийн албанд 12 удаа мэдээ гаргаж өгсөн.
- Танхимууд I,II,III,IV улирлын төлөвлөгөө тайланг цаг хугацаанд нь гаргаж өгсөн.
- 2010-2011 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтын шалгалт орж зөрчил дутагдалгүй гарсан.

Ёс. Сургалт

- Хүүхдийн зохиолч Ж.Дашдондог, хэвлэлийн компаниудтай хамтран " Сайн ном- хүүхэд таны ирээдүй" сэдэвт бүсийн сургалтыг манайхтай хамтран зохион байгуулсан. Мөн Хүүхдийн ордон, "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ны залуучуудын холбоо, Уурхайчин соёлын ордон зэрэг байгууллагуудтай хамтран эцэг эхчүүдтэй уулзалт зохион байгуулсан.
- Номын төвийн номын санчдын дунд онолын мэдлэгийг нь бататгаж өгөх чиглэлээр доорх сургалтуудыг явуулсан.

-Номын сангийн мэргэжлийн сэтгүүлээс номын санг ашиглах тухай, Номын сан гэж юу вэ? сэдэвт сургалт

Мөн номын сангаас зохион явуулах СОТА зохион явуулах

-Номын сангийн автоматжуулалт, номын сангийн каталоги зохион байгуулалт сэдвээр тус тус сургалтуудыг зохион явуулж номын санчдынхаа онолын мэдлэгийн хүрээг тэлж сургалтын материалуудыг тарааж өгсөн.

- Үндэсний номын сангаас зохион байгуулсан номзүйч, мэдээллийн ажилтан нарт зориулсан сургалтанд номзүйч Н.Болормаа, мэдээллийн ажилтан А.Бахыт нар хамрагдсан.

Арав**. Санхүү, материаллаг баазыг бэхжүүлэх талаар**

2012 оны төсвийн жилд 165.822.848 төгрөгийн төсөвтэй.50.000 төгрөгийн өөрийн орлого хийх төлөвлөгөөтөй, төсвийг хуваарийн дагуу зарцуулж ажиллаж байна. Өөрийн орлого багссантай холбогдуулан 2012 оны 4-р сарын 11-нээс хүүхдийн танхимын уншигчийн карт 500 төгрөг байсныг үнэгүй, насанд хүрэгчдийн уншигчийн карт 1500 байсныг 1000 төгрөг, тогтмол хэвлэл, захиалгын хуудас зэргийг үнэгүй болгосон. .

БСШУЯ-ны санхүүжилтаар дээвэрийн засварт 50.0 сая төгрөг батлуулж, дээвэр болон хүүхдийн уншлагын танхим, гэр бүл-гэрээр олголтын танхим, хэвлэлийн бага хурлын өрөө, ариун цэврийн өрөөнд засвар оруулсан.

БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 10 компьютер, 2 принтер, 20 номын тавиур, "Нүүдлийн номын сан"-гийн автомашин /УАЗ ПУРГАН/ зэргийг авч үйл ажиллагаагаа өргөтгөсөн.

"Тогтвортой амьжиргаа –II" төслөөс гэр бүлийн танхимыг тохижуулахад зориулан 5.000.000 сая төгрөгийн санхүүжилт авч тохижуулсан.

Японы элчин сайдын яамны дэргэдэх "Соёлын өвсний үндэс" төсөлд их засварын ажлын саналыг боловсруулж явуулсан.

БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар соёлын төвүүдэд 1 компьютер, 6 ширээ, 12 сандал, 141 нэрийн 595 ширхэг 7.9 сая төгрөгийн номыг хувиралан тус тус олгосон.

ЕБС,цэцэрлэгүүдэд 62 нэрийн 801 ширхэг 12.5 сая төгрөгийн номыг хувиарлан олгосон.

"Ёлт-Эрдэм" ХХК-тай гэрээ байгуулан галын дохиолол хийлгэсэн.

Арван нэг. Бусад

Сар шинийн баярыг тохиолдуулан ахмадуудаа хүндэтгэл үзүүлсэн.
Аймгийн ҮЭ-ийн холбооноос зохион байгуулсан волейболын тэмцээнд эмэгтэй баг тусгай байранд,

Засаг даргын нэрэмжит гар бөмбөгийн тэмцээнд эрэгтэй баг 3-р байрт тус тус шалгарсан.

Хавар, намар бүх нийтээрээ мод тарьдаг өдөр байгууллагын ар талдаа 50 ширхэг шар хуайс тарьж цэцгийн мандалаа будаж сэргээсэн.

Долоо хоног бүрийн Баасан гаригт бүх нийтээрээ цэвэрлэгээнд гарч байгууллагынхаа ойр орчимын хог шороо, цас мөсийг арилгаж хэвшсэн.

Орхон аймгийн Номын төвд 2012 онд хийгдсэн засварын ажлууд

Хэвлэлийн танхим /өмнө нь/ /Засварын дараах/

Хэвлэлийн танхим тасалгаа /өмнө нь/ /Засварын дараах/

Хүүхдийн танхим /өмнө нь/ /Засварын дараах/

Хүүхдийн танхим /өмнө нь/ /Засварын дараах/

Тогтмол хэвлэлийн танхим /өмнө нь/ /Засварын дараах/

Тогтмол хэвлэлийн танхим /өмнө нь/ /Засварын дараах/

Гэр бүлийн танхим /өмнө нь/ Гэр бүлийн танхим /өмнө нь/

/Засварын дараах/

Нийтийн 00 /өмнө нь / /Засварын дараах/

Шинэ УАЗ-2206 Микроавтобус машинтай болсон

2012онд хийгдсэн СОТ ажилууд

Номын баярын нээлт

Номын баярын хаалтын үйл ажиллагаа

Гэр бүлийн танхимаас зохион явуулсан “Ном бидний баяр” өглөөлөг

МУИС-ОС-ын гадаад хэлний танхимтай хамтран явуулсан СОТА

ЕБС-ийн сурагчдын дунд явуулсан илтгэлийн уралдаан

Үндэсний бичиг үсгийн баяр-2012

Номын үзэсгэлэн-2012

Бүх төрийн байгууллагуудын нээлттэй хаалгны өдөр

Номын төвөөс ДЦС –тай хамтран гаргасан нээттэй хаалганы өдөр

Алслагдсан багийн иргэдэд нүүдлийн номын сангаар үйлчилсэн

Сургалт

Хүүхэд цахим ном /Булган, Сэлэнгэ, Дархан Орхон аймгуудын хүүхдийн номын санч нар оролцсон/

Улаанбаатар хотын Үндэсний төв номын сангаас зохион байгуулсан бүх орон нутгийн номзүйч, мэдээллийн ажилтан нарт явуулсан сургалт

Өвөрхангай аймгийн Төв номын сангийн 2012 оны үйл ажиллагааны тайлан

Аймгийн төв номын сан нь 2012 онд Аймгийн Засаг даргатай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээг байгуулан ,уншигчдад ном хэвлэлээр үйлчлэн,тэдний боловсрол мэдлэгийг дээшлүүлж орчин үеийн мэдээллээр шуурхай хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа. 2012 онд Захирал 1, Номын санч мэдээллийн ажилтан 5,фондч 1, катологич номзүйч 1, үйлчлэгч нярав 1 гэсэн 9 орон тоотойгоор 79288.4 сая төгрөгний төсөвтэйгээр ,Боловсрол танхим,Хүүхдийн уншлагын танхим,Гэрээр ном олгох танхим, Гадаад мэдээллийн танхим,Интернет танхимуудаар дамжуулан уншлага үйлчилгээ явуулж ажиллалаа.

Аймгийн төв номын сан нь байгууллагын хэмжээнд мөрдөгдөх хууль эрх дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

Аймгийн төв номын сангийн үлгэрчилсэн дүрмийг мөрдөн ажиллаж байна. Аймгийн төв номын сангийн дотоод журманд нэмэлт өөрчлөлт оруулж мөрдлөгө болголоо.

Аймгийн төв номын сангийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан.

Ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг байгуулан ажиллаж байна.

Боловсрол танхим,Хүүхдийн уншлагын танхим,Гэрээр ном олгох танхим, Гадаад мэдээллийн танхим, Интернет танхимын үйл ажиллагааг сайжруулж уншигчийн картны үнийг шинэчлэн тогтоолоо. Ирсэн явуулсан баримт бичгийг цаг тухайд нь бүртгэж,холбогдох албан тушаалтанд өгч, албан бичгийн хариу өглөө.

Байгууллагын архивын бичиг баримтыг эмхлэн цэгцэлж,хадгаламжийн нэгж болгон хадгалж байна.

“Алдагдсан буюу гэмтээгдсэн номыг төлүүлэх журам”,буюу. “Аймаг нийслэлийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм”-ыг уншигчдад танилцуулан ажиллаж байна.

Уншлага үйлчилгээний талаар

Номын сан нь уншигчдын эрэлт хэрэгцээг хангах,номын фондын эргэлтийг нэмэгдүүлэх ,,мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор Боловсрол танхим, Гэрээр ном олгох танхим, Хүүхдийн уншлагын танхим,зөөврийн үйлчилгээний хэлбэрүүдээр 1634 уншигч 12633 ирэгсэд, 40973 ном олгож уншигчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэн 1329490 төгрөгийн өөрийн орлоготойгоор үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Фондын номын эргэлт 71 %-тай байна. Боловсрол танхим нь уншигч хэрэглэгчдэд үйлчилгээг шуурхай болгохын тулд

ойрын фондын номыг уншигчдын эрэлт хэрэгцээт номоор хангах талаар судалгаа хийж, судалгааны дагуу ойрын фондоо баяжуулж байна.

Аймгийн төв номын сан нь хандив буюу төсвөөр 5730.500 төгрөгний 456 ш ном хэвлэлээр фондоо баяжуулж уншигчдад үйлчилгээ үзүүлж байна.

Үндсэн фондноос Боловсрол танхимын ойрын фондонд 886ш, захиалгаар 99 ш ном, Гэрээр ном олгох танхимын ойрын фондонд 853ш ном, захиалгаар 233 ш ном, Ирээдүй танхимын ойрын фондонд 722 ш ном,захиалгаар 58 ш ном олгож үйлчилгээ явуулсан байна.

Мөн урагдаж гэмтсэн болон уншигчийн буруугаас ашиглах боломжгүй болсон 365 номонд сэлбэн засалт хийж үйлчилгээнд гаргалаа

Соёл олон түмний ажлын талаар

Монгол Улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн хорооноос санаачлан “Үндэсний бичиг үсгийн өдөр”-ийг Аймгийн төв номын сан тодорхой хөтөлбөр төлөвлөгөө гарган зохион байгууллаа. Төрийн албан хаагчид,мэргэжлийн багш нар, ЕБС-ийн сурагчид, иргэд, уншигчдын дунд зохион байгуулсан ба хаалтын үйл ажиллагаанд 320 уншигч оролцсон соёл олон түмний ажил боллоо. Үүнд:

Төрийн соёрхолт ардын уран зохиолч Д.Пүрэвдоржийн шүлгийг хэн сайн мэдэх вэ” уран уншлагын тэмцээн

Алдаагүй зөв бичигтний уралдаан

Цэвэр сайхан бичигтний уралдаан

Уралдаант цэнгээнт АХА тэмцээн

“Хувийн номын сан” шалгаруулах, үзэсгэлэн гаргах

“Би үндэснийхээ монгол бичгийг мэднэ”эссэ бичлэгийн уралдаан

Монгол бичгийн гайхамшиг” номын үзэсгэлэн

Аймгийн төв номын сангийн үнэт ховор номын үзэсгэлэн

“Төрийн соёрхолт ардын уран зохиолч Д.Пүрэвдоржийг хэн сайн мэдэх вэ” уран уншлагын тэмцээнийг зохион байгуулсан ба 16 сурагч оролцсоноос 4-р сургуулийн 9-р ангийн сурагч Цэрэннадмид 1-р байр, 2-р сургуулийн 8б ангийн сурагч Цогзолмаа 2-р байр, Уянга сумын ЕБ-ын сургуулийн 9а ангийн сурагч Равжаа 3-р байранд шалгарлаа. Энэ уралдааныг яруу найрагч Л.Байгальмаа номын санчдын хамт шүүн явууллаа. Мөн уралдаанд оролцсон сурагчдад яруу найрагч Л.Байгальмаа шүлгийг хэрхэн яруу унших, өөрийн болгож унших талаар зөвлөгөө зөвлөмж өгч,оролцсон сурагчдад баяр хүргэлээ.

“Алдаагүй зөв бичигтний уралдаан” “Цэвэр бичигтний уралдаан”-д нийт 74 уншигч оролцсоноос: Алдаагүй зөв бичсэн уншигчаар ЕБ-ын 4-р сургуулийн 10а ангийн сурагч Г.Лхагвасүрэн 1-р байр,4-р сургуулийн 9б ангийн сурагч Ш.Мөнхтулга 2-р байр, Мэргэд цогцолбор сургуулийн 10а ангийн сурагч Ц.Наранчимэг 3-р байр,”Цэвэр сайхан бичигтний уралдаанд” хамгийн цэвэр нямбай бичсэн уншигчаар 4-р сургуулийн 11а ангийн сурагч Ц.Майдарсүрэн 1-р байр,2-р сургуулийн 9а ангийн сурагч Б.Билэгмаа 2-р байр,Уянга сумаас оролцсон Ч.Долгорсүрэн нар шалгаран Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа. Мөн 4-р сургуулийн монгол хэлний багш Ц.Загарзүсэм уралдаанд оролцсон сурагчдад монгол бичгийг хэрхэн сайхан гаргацтай бичих,зөв бичих талаар зөвлөгөө өгч ярилцлага зохиолоо.

Мөн уншигчдын дунд танин мэдэхүйн уралдаан цэнгээнт АХА тэмцээнийг зохион нийт 86 уншигч оролцсон ба 4-р сургуулийн 11а ангийн сурагч П.Буянжаргал,Мэргэд цогцолбор сургуулийн сурагч Наранчимэг нар түрүүлж,идэвхтэй сайн оролцож,Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.

“Хувийн номын сан шалгаруулах” уралдаанд :

Яруу найрагч Н.Пүрэв –уран зохиол,монгол бичгийн /ховор/ 134 номоор,Мэргэд цогцолбор сургуулийн сурагч М. Хулан –уран зохиол, эрүүл мэнд

түүх,хэлний шинжлэлийн 98 номоор,уншигч Б.Батчимэг уран зохиол,шүлэг өгүүллэгийн 49 номоор, 4-р сургуулийн багш Ц.Лхагважав уран зохиол танин мэдэхүйн ховор 32 номоор, лам Р.Мэндбаяр шашин танин мэдэхүйн 120 номоор, яруу найрагч Л.Байгальмаа яруу найраг,шинэ 36 номоор үзэсгэлэн гаргаж уншигчдад номоо сурталчиллаа.

"Хувийн номын сан" шалгаруулах уралдаанд үнэт ховор,уншигчдын татгалзлын дагуу олддоггүй номтой, хувийн номын сантай уншигчийг шалгаруулж, 4-р багийн иргэн Р.Мэндбаяр 1-р байр, 6-р багийн иргэн Н.Пүрэв 2-р байр, Мэргэд цогцолбор сургуулийн 10а ангийн сурагч М.Хулан 3-р байранд шалгарч Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.

"Би үндэснийхээ монгол бичгийг мэднэ" эссэ бичлэгийн уралдааныг насанд хүрэгчид,уншигчдын дунд зарлан нийт 34 эссэ ирснээс 1-р байрт 2-р сургуулийн 11б ангийн сурагч С.Хорлоо, 1-р байр,Мэргэд цогцолбор сургуулийн 10а ангийн сурагч Ц.Наранчимэг, 2-р сургууль 7б ангийн сурагч Б.Оюунбилэг нар түрүүлж Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан байна.

"Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн" шалгаруулах болзол хангасан,хамгийн олон ном уншсан уншигчдаа шагнаж урамшууллаа.

Номын сангийн сан хөмрөгт байгаа хуучин монгол бичгийн 375 номнуудаас сонгон авч уншигчдын сонирхол татахуйц 74 номоор Боловсрол танхим болон фондонд "Монгол бичгийн гайхамшиг" үзэсгэлэн гаргаж хаяг тайлбарыг бичиж тавьсан нь уншигчид хуучин монгол бичгээ дээдлэх,сурахад нь ихээхэн дэмжлэг болсон ажил боллоо.

Үндэсний бичиг үсгийн баярын арга хэмжээнд зориулан захирлын тушаалаар 2910000 төгрөг гарч, идэвхтэй оролцсон түрүүлсэн уншигчдыг шагнаж урамшуулахад зарцуулагдсан байна.

Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтнээр Хүүхдийн уншлагын танхимын тэргүүний уншигч Оюуны –Ундраа бага сургуулийн 33 ангийн сурагч Ж.Ариунзул, Боловсрол танхимын тэргүүний уншигч ЕБ-ын 2-р сургуулийн 10г ангийн сурагч Шүр овогтой Эрдэнэсувд,Гэрээр ном олгох танхимын тэргүүний уншигчаар Я.Төмөр-Очир нар шалгарч Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтнээр шалгарсан байна.

Шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 13 удаа гаргаж 654 ш номыг уншигчдад сурталчилсан байна..Татгалзлын дэвтэр хөтлөлтийн дагуу уншигчдын эрэлт ихтэй уран зохиолын болон салбар шинжлэх ухааны номуудаар фонд баяжилтыг хийсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 8-р сарын 24 ны өдөр "Номын баярын өдөр тэмдэглэх тухай" 158 дугаар зарлигийг соёрхон баталж, жил бүрийн 9-р сарын 3 дахь долоо хоногийн Бямба гаригийг "Номын баярын өдөр" болгон өргөнөөр тэмдэглэхээр болсон. үүнтэй уялдуулан 09-р сарын 21 нд "Олуулаа ном уншия" номын баярыг тэмдэглэлээ. Уг баярын арга хэмжээнд:

-Өвөрхангай аймгаас төрөн гарсан зохиолчдын номоор үзэсгэлэн

-Шинэ номын үзэсгэлэн

- Уншигчдад үнэгүй карт нээх үйлчилгээ

-Гар зургийн уралдаан

-Иргэдийн дунд танин мэдэхүйн АХА тэмцээн

-ЕБС,Цэцэрлэгүүдийн мэндчилгээ, дүрийн тоглолт

-Сумын номын сан, сургууль,цэцэрлэгүүдэд ном хандивлах арга хэмжээнүүд зохион байгуулагдлаа. Энэ арга хэмжээг Аймгийн боловсрол соёлын газар, ЕБСургуулийн номын санчидтай хамтран зохион байгууллаа.

Ном зүйн ажлын талаар:

2012 онд шинээр худалдан авсан болон хандиваар ирсэн бүх номоор агуулгын тайлбартай шинэ номын мэдээг товхимол болгон гаргаж уншигчдад сурталчилж байна. Цаашид улиралд 1 удаа гаргах зорилт тавин ажиллаж байна.

2012 онд шинээр ирсэн 150 төрлийн 483 ширхэг номоор агуулгын талбайртай товхимол гаргаж уншигчдад сурталчилж байна.

Шинэ номын картын санг шинжлэх ухааны салбар ангиудын дагуу хийж байна. Энэ нь уншигчдад сүүлийн үеийн эрэлт хэрэгцээтэй номыг түргэн шуурхай олоход хялбар болж байгаагаараа онцлогтой.

Уншигчдад электрон катологи болон цаасан катологиос номоо хэрхэн хайх,хэрхэн захиалах талаар заавар зөвлөгөөг өгч байна.

2012 онд шинээр ирсэн 483 номонд техник ажиллагаа хийж,номыг ангилж,нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэж,танхимуудад хувиарлан олгосон байна.

Номын санч мэдээллийн ажилтан С.Энхтогтох нь “Ухаан далай номоос эхтэй” 1-12-р ботид орсон зохиол бүтээлийн ном зүйн лавлах, “Бүрэн дунд боловсролын түвшинд унших уран зохиол” 5 ботид орсон зохиол бүтээлийн ном зүйн лавлах,”Монголын хүүхэд залуучуудын уран зохиолын дээж” 3 ботид орсон зохиол бүтээлийн ном зүйн лавлахуудыг номын санчдад гарын авлага болгон гаргалаа.

Мэдээллийн сан” “Мэдэхэд илүүдэхгүй “ самбаруудад 25 сэдвээр мэдээлэл бичиж сурталчилсан.

Арга зүйн ажлын талаар:

Аймгийн төв номын сангаас сумын номын санчдад арга зүйн зөвлөгөөг өгөн өөрсдийн хариуцсан сумдын номын санч нарыг хариуцан ажиллаж байна. Сант,Тарагт,Өлзийт, Зүйл, Уянга сумын номын санчдад мэргэжлийн зөвлөгөө өгөн тусалсан байна. ЕБ-ын 1-р сургууль,4-р сургуулийн номын санд биеэр очин уншигчдад ном хэрхэн олгох,фонд зохион байгуулалт, номыг хэрхэн ангилах талаар зөвлөгөө өгсөн байна. Мөн ЕБ-ын 1-р сургуулийн номынсанч Сарантуяа номын сангийн программ болох LIB4U программд ном хэрхэн оруулах талаар зөвлөгөө авсан байна.

“Номын сангийн үйл ажиллагааны стандарт,технологийн шинэчлэл” сургалтыг 2012 оны 03-р сарын 09 нд 18 сумын номын санчид ЕБ-ын сургуулийн номын санчдыг хамруулан зохион байгууллаа.

Сургалтаар:

Сумын номын санг ном хэвлэлээр хангах аргачлал
Номын сангийн фондны стандарт
Ном сэлбэн засах
Катологи зохион байгуулалт
Лавлагаа ном зүйн мэдээллийн ажил
Ном зүйн бичилтээр ном тодорхойлох
Номын сангийн бүртгэл,хадгалалт хамгаалалтыг шалгах хяналтын хуудас
зэрэг сэдвүүдээр хичээл заан номын санчдад гарын авлага бэлтгэн өгсөн байна.

Соёлын дээд сургуулийн багш Т.Хайдавтай хамтран “Openbiblio” программын онлайн сургалтыг зохион байгууллаа.

Үндэсний номын сангаас зохион байгуулсан “Номын сан мэдээллийн технологи” сургалтанд Ахлах номын санч Д.Отгонболор,номзүйч Жаргал нар хамрагдан мэргэжил боловсролоо дээшлүүлсэн байна.

Номын сангийн автоматжуулалтын талаар.

Аймгийн Засаг даргад хүсэлт гаргасны үндсэн дээр “LIB4U” номын сангийн цогц программтай боллоо. “LIB4U” программын тусламжтайгаар электрон номын сан болон электрон катологит ном оруулан интернет болон дотоод сүлжээндээ байрлуулан уншигчдадаа ашиглуулах,зураасан зодын тусламжтайгаар номын

сангийнхаа өдөр тутмын үйлчилгээг явуулах, тооллого хийх,хэрэгтэй номоо түргэн шуурхай олох,үйл ажиллагааг автоматжуулах, номын сантай холбоотой төрөл бүрийн тайлан статистик мэдээгээр хангах өргөн боломжийг олгож байна. Одоогоор танхимуудын ойрын фондын бүх ном,фондын ном 26517 ш буюу 60%-ийг электрон катологит оруулаад байна.

Аймгийн төв номын сан нь 22 компьютерийг дотоод сүлжээнд холбон интенетэд холбогдож уншигчид шинэ мэдээллийг нэг дороос авах боломжийг бүрдүүлэн ажиллаж 417 уншигчдад интернетээр үйлчилсэн байна.

" Нүүдлийн болон зөөврийн номын сан"-г ажиллуулсан талаар

- Нүүдлийн номын ажиллуулах,уншигчдад шинэ мэдээ мэдээллийг хурдан хугацаанд уншигчдад хүргэх боломжоор хангаж БСШУЯ-наас Нүүдлийн номын сангаар иргэдэд үйлчлэх автомашинтай боллоо.
- Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба,Аймгийн төв номын сантай байгуулсан гэрээний үндсэн дээр тус албаны нийгмийн ажилтан ахмад Б.Мөнхцэцэгтэй хамтран ажиллаж хоригдож байгаа этгээд ялтнуудад нийгэмшүүлэх чиглэлээр зөөврийн номын сангаар үйлчилж, 11 хүнд карт нээн 28 ширхэг номоор үйлчилсэн байна
- Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн багш Төмөрдуламтай хамтран ажиллаж нийт 20 багш ажилчдад карт нээн,87 ширхэг номоор үйлчлэн зөөврийн номын сангаар үйлчилсэн байна.

Ажиллагсадын нийгмийн асуудлын талаар

Ажилчдын хоолны мөнгө 1920.0 төгрөг, өвлийн түлш авахад нь зориулж 450000 төгрөгний буцалтгүй тусламж,мөн байгууллагаас гарсан өндөр настангуудад сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлж 150.0 төгрөг зарцуулсан байна. Мөн Хүүхдийн баяр болон шинэ жилийн баяраар ажилчдын хүүхдүүдэд бэлэг гардуулсан.

Мөн биеэ эмчлүүлэх шаардлагатай ажилчдад цалинтай чөлөө олгож ажилласан байна.

Байгууллагын тохижилтын талаар

Байгууллагын гаднах цэцэрлэгт талбайд хайлаас, улиас зэрэг 18 ширхэг мод тарьж уншигч үйлчлүүлэгчдэд таатай орчин бүрдүүллээ.

Үндсэн фонд болон танхимуудын ариутгалыг мэргэжлийн байгууллагуудаар 2 удаа хийлгэж,цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийлгэж 98540 төгрөгний ариутгалын материал худалдан авсан байна.

Танхимуудад чөлөөт сонголтоор байрлуулахад тохиромжтой сүүлийн үеийн 10ш номын тавиурыг нэмж байрлууллаа.

Үндсэн фондын тавиурыг шинэчлэн 11 тавиурыг байрлуулж монгол номын фондын номыг зөөж байрлуулсан байна.

Үндсэн фондын хадгалалт хамгаалалт,чийгшил гэрэл зэрэг фондны стандарт хангахгүй байсан 2011 оны БСГ-ын стандарт шалгалтын дүгнэлт,МХГ-ын гэрэл,чийгшил зэрэгт анхаарах шаардлага/ -т байгууллагын зүгээс анхаарч халуун хүйтнийг хэмжигч төхөөрөмж тавин,стандартын шаардлага хانган ажиллаж байна.

Өмнөговь Аймгийн Төв Номын сангийн
2012 оны ажлын тайлан

Өмнөговь аймгийн Төв Номын сан нь 2012 онд үйлчүүлэгч уншигчиддаа чанартай , хэрэгцээ шаардлагад нь нийцсэн үйлчилгээг үзүүлэх, соёл танин мэдэхүйн ажлын чанарыг нэмэгдүүлэх зорилго тавин ажиллалаа.

1. Уншлага үйлчилгээний талаар

2012 онд нийт 1396 байнгын уншигч, 13585 иргэсэдэд нийт 38571 ном олгож үйлчилсэн байна.

¹	*Үзүүлэлт*	***Нийтийн уншлагын танхим***	***Хүүхдийн уншлагын танхим***	***Гэрээр ном олгох танхим***	***Интернет хөгжил мэдээллийн төв***	***Íèéò***
1	*Уншигч*	*521*	*633*	*212*	*30*	***1396***
2	*Ирц*	*3178*	*6183*	*4147*	*77*	***13585***
3	*Ном олголт*	*14101*	*13307*	*11037*	*126*	***38571***

1. ***Интернэт үйлчилгээ***

2012 онд тус төв нийт 405 хүнд интернэт компьютерийн үйлчилгээ үзүүлж 6 хүнийг интернэт болон компьютерийн сургалтанд хамруулсан байна. Дээрх үйлчилгээний төлбөр болох 404050 төгрөгийг номын сангийнхаа үйлчилгээний орлогод тушааж ажилласан.

2. Сан хөмрөгийн баяжилт, ном хэвлэлийн хадгалалт хамгаалалт

*Номын сангийнхаа сан хөмрөгийн баяжилтанд анхаарч уншигч үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, үйлчилгээний бүртгэлүүдийн үзүүлэлтэд үндэслэн 473 ширхэг номоор сан хөмрөгөө баяжууллаа.*Сан хөмрөгийн номнуудаас хуучирч элэгдсэн 259 ширхэг номонд сэлбэн засалт хийж тавиурт байрлуулав.

Сан хөмрөгийн номын тавиуруудыг стандартад тохирсон төмөр тавиураар сольж номнуудын тоосжилтыг цэвэрлэж тавиуруудыг будаж номоо байрлуулж, номын болон тавиурын ялгагчийг шинэчлэн хийлээ.

БСШУ-ны сайдын 2010 оны 56-дугаар тушаалаар батлагдсан “МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ” маягтын дагуу үнэт ховор түвд, монгол, модон бар, гар бичмэл номнуудыг бүртгэж, электрон каталогт оруулж, дахин үнэлж, шинээр нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэлээ. /номын тоо-45 ширхэг/



Боловсрол, Соёл, шинжлэх ухааны сайдын
2006 оны 56-дугаар тушаалаар батлав

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ

УНБМС-ийн дугаар:--------------------

Өмчлөгч: Монгол улс	РД:
Эзэмшигч:Өмнөговь Даланзадгад сум Аймгийн Төв номын сан	РД:9051325

Дурсгалт зүйлийн оршин байгаа хаяг: Өмнөговь аймгийн Төв номын сан

Ашиглалтын байдал: Номын сангийн Сан хөмрөг

Дурсгалын нэр: Рашааны зүрхний 8 гишүүд	Хувийн дугаар: 1

Орон нутаг, олон улс /шинжлэх ухаан/-ын нэр: Рашааны зүрхний 8 гишүүд

Төрөл зүйл: Ном судар

Бүтээсэн он цаг:XIX зуун

Бүтээлчийн нэр: /сургууль хийц/

Материал арга ажиллагаа: Цагаан цаасан дээр хуучин монголын дармал үсгээр улаан ба хар өнгийн бэхээр бичигдсэн.

Хэмжээ	өндөр	Өргөн зузаан	урт	диаметр	Жин /гр/
Ерөнхий	11см	7см	55см		800гр

Хадгалалтын байдал: сайн дунд + муу

Иж бүрдэл: /нэр материал, хэмжээ, тоо ширхэг/ Рашааны зүрхний 8 гишүүд, ногоон торгон баринтагтай, цагаан цаасан дээр улаан болон хар өнгийн бэхээр монгол бичгийн дармал үсгээр бичигдсэн. 1 ширхэг,

Тодорхойлолт:

Өнгө хэлбэр төрх, дүрслэл: Хийсэн арга техник: гараар үйлдвэр
ногоон торгон баринтагтай, цагаан цаасан дээр улаан болон хар өнгийн бэхээр монгол бичгийн дармал үсгээр бичигдсэн.

Онцлог шинж: /тэмдэг,бичээс сорьц/
Номын нүүр хуудсанд 2 бурханы зурагтай.

Гэмтэл өө сэв: Номын нүүр болон арын хуудаснууд уранхай.

Товч түүх:

Үнэт ховор бар бичмэл номнуудыг баринтагжуулах ажлыг зохион байгуулж бүх номуудыг баринтагтай болгон хаягжуулж үзэсгэлэнгийн тавиурт байрлуулсан.

- Номын сангийн номын ээлжит тооллого 2008-2011-онуудад хийигдсэн тооллогын нэгдсэн дүнг гаргаж 2012-онд бүх заал танхимуудын номын актыг тус бүрээр нь гаргаж номын сангийн сан хөмрөгийн ном хэвлэлийг нэг бүрчлэн тоолж тоог үнэн зөвөөр тодорхой гаргалаа. Үүнд: Нийт 29275 ширхэг ном сонин сэтгүүл 8637979 төгрөг 40 мөнгөний ном сонин сэтгүүлийн актыг үйлдэж жагсаалтыг гаргалаа.
- Дээрх актлах жагсаалт болон хүсэлтийг Аймгийн Өмчийн албанд шилжүүлээд байна. Эдгээр актлах номнуудын тушаал гарсаны дараа манай фондын ном хэвлэлийн тоо 35184 болоод байна.

1. Ном хэвлэлийг сурталчилах болон соёл танин мэдэхүйн ажлын чанар хүртээмж

- Номын сангийнхаа ном хэвлэлийг олон нийтэд танилцуулах, сурталчилах, уншигчдыг номтой нөхөрлүүлэх тал дээр явуулын номын сангийн үйлчилгээ, сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэнгүүдийг танхимаар гаргах, онлайнаар сурталчилах, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүллээ.
- Үүнд: Сэдэвчилсэн үзэсгэлэн:18 удаа 408 номоор
- Шинэ номын үзэсгэлэн: 14 удаа 766
- Үзэсгэлэнгүүд:Цагаан сарыг тохиолдуулан “ Монгол ардын уламжлал ёс заншил сэдвээр - 25 ширхэг номоор

- Олон улсын эх үрсийн баярын өдөрт зориулан гаргасан номын үзэсгэлэн 30 ширхэг номоор
- Төрийн соёрхолт зохиолч Ж.Пүрэвийн номын үзэсгэлэн - 25 номоор
- 70-80 оны шилдэг зохиолуудаас - 32 номоор
- Хүүхдийн уншлагын танхимд **<<Үлгэрийн баатрууд амилсан нь>>** сэдэвт үлгэрийн номуудаар үзэсгэлэн гаргав. Нийт 70 ширхэг номоор үзэсгэлэн гаргасан. Үзсэн хүүхдийн тоо 500
  /тогтмолжсон үзэсгэлэн/
- Хүүхдийн уншлагын танхимд **<<Монголын ээж хатад>>** нэртэй түүхэн сэдэвт үзэсгэлэн гаргав. Оролцсон номын тоо 24 Үзэсгэлэнг үзсэн хүүхдийн тоо125
- **<<Хөгжилтэй онигоо>>** сэдэвт үзэсгэлэн гаргав. Үзэсгэлэнд тавигдсан номын тоо15ширхэг сонирхсон хүүхдийн тоо154
    - Сан хөмрөгийн 64 ширхэг хүүхдийн хүмүүжил , багш эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх номнуудаар “Үлгэрч хүү ” уралдааныг угтаж үзэсгэлэн гаргав.
    - Сан хөмрөгт байдаг Номын сан соёлын ажилтнуудад гарын авлага лавлагаа өгөх 35 ширхэг номоор “Номын сангийн уламжлал шинэчлэл ” сэдэвт үзэсгэлэнг 12-р сард НУТанхимаас Монголын багш нарын баярт зориулан “Миний багшийн алдар” сэдэвчилсэн номын үзэсгэлэн, Эх орончдын өдөрт зориулсан “Монгол эх орноороо бахархая” , Монгол хүн сансарт ниссэн өдөрт зориулан “Сансарын уудамд” үзэсгэлэнг нийт 98 ширхэг номоор тус тус гаргав.
    - ГНОТахимаас нийт 7 удаа шинэ номын үзэсгэлэнг 224 ширхэг номоор
    - Нийтийн Уншлагын танхимаас 3 удаа шинэ номын үзэсгэлэнг 96 ширхэг номоор гаргаж сурталчиллаа.
    - ХУТанимаас 3 удаа шинэ номын үзэсгэлэнг 260 ном

оор тус тус гаргаж сурталчилсан.

- Уншигчдад гарын авлага болгох зорилгоор шинээр ирсэн номуудаар шинэ номын мэдээ гаргаж заал танхимуудаар болон мэдээллийн самбарт гаргаж уншигчдад сурталчиллаа.

- 2012-онд худалдаж авсан буюу хандив бэлгээр ирсэн бүх номыг түүвэрлэн авч оруулан ***Шинэ номын мэдээ*** нэртэй эмхтгэл хэвлэн гаргалаа.

- 2012 онд хэвлэгдэн гарсан Төрийн мэдээлэл сэтгүүлүүдээр бүртгэн мэдээлэх ном зүй хийж олны хүртээл болгосон.
- Зөөврийн номын сангийн үйлчилгээ1-р сард зөөврийн номын санг 4-р сургуулийн 4в ангид ажиллуулав.Оролцсон хүүхдийн тоо36 Уншсан номын тоо72 ширхэг
- ГНОТ –аас 2012 онд 24 цэцэрлэгт 12 удаа 239 ширхэг ном олгож , 9 уншигчдыг шинээр бүртгэн 2012-06-04 нд ЭМГ, СХЗХ-ийн хамт олонд байгууллага дээр нь очиж шинэ номын танилцуулга үзэсгэлэн гаргаж 25ш ном олгон шинээр 6 уншигчыг бүртгэлээ. Багш, ажилчид уншсан номын тэмдэглэл хөтөлж сурган хүмүүжүүлэх холбогдолтой сэдвүүдийг сонгон ярилцлага хийж сургалтын гарын авлага, материал бэлтгэхэд ашиглаж байна.

Онлайн сурталчилгаа, автоматжуулалт

- *Номын санд хийгдэж байгаа ажлууд болон үйл ажиллагаа үйлчилгээний талаар ном хэвлэл танин мэдэхүйн чиглэлийн мэдээ мэдээллээр номын сангийнхаа вэб блогийг баяжуулж , аймгийн төвийн байгууллагуудын и-мэйл хаягын жагсаалтанд бүртгэлтэй хүмүүст и-мэйл илгээх замаар мэдээлэл сургталчилгааны ажлыг зохион байгуулж ажиллав.*

Энэхүү вэб блогийг 2012 онд нийт 1415 хүн үзэж сонирхсон байна.

- *Номын сангийн автоматжуулалт ном хэвлэлийн лавлагааг уншигчдад ойртуулах тал дээр анхаарч номын сангийн электрон каталогиос ном хайхад зориулсан номын сангийн* каталогийн компьютерийг вистульд байрлуулж уншигчдад ашиглах боломжийг бүрдүүллээ.

- БЗМТөвөөр дамжуулан болон АНУ-ын ЭСЯ-аас зарлагдсан тэтгэлэгт хөтөлбөрүүдийн мэдээллийг төвийн мэдээллийн самбар, и-мэйл хаягийн жагсаалт, интернэт дэх вэб блог, орон нутгийн ТВ-ээр сурталчилж ажиллав.
- 2012 онд нийт 550 ширхэг номыг электрон каталогидоо нэмж оруулсан байна.
- Уралдаан тэмцээн, танилцуулга сурталчилгаа1-р сард 4-р сургуульд шинэ ба хуучин номын үзэсгэлэн гаргав.Оролцсон номын тоо 56ширхэг оролцсон хүүхдийн тоо136

Хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх зорилгоор 2012.3.12 нд 3-р бүрэн дунд сургуулийн Базармаа багштай 10б ангийн хамт олон, Сарантуяа багштай 8б ангийн хамт олон, 2012.3.23 нд тус сургуулийн Өнөрцэцэг багштай 5а ангийн сурагчид нийт 84 сурагчид номын сангийн үйл ажиллагааны талаар танилцууллаа. Сурагчид танхимуудыг үйл ажиллагаатай танилцаж үзэсгэлэн үзэж сонирхлоо.

Үлгэрч хүү уралдаан

Монгол ардын аман зохиолын баялаг өв сан , түүний дотроос үлгэрийн арвин сантай хүүхэд багачуудыг танилцуулж номтой нөхөрлүүлэх зорилгоор цэцэрлэгийн ахлах ангийн хүүхдүүдийн дунд "Үлгэрч хүү" уралдаан 2012.05.01-2012.05.21ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэхүү уралдааныг угтаж эцэг эх багш нарт зориулсан номын үзэсгэлэнг гаргаж онлайн хэлбэрээр танилцуулгыг олон нийтэд сурталчилсан. Мөн 9,11,2,24-р цэцэрлэгүүдийн ахлах бүлгүүдийн хүүхдүүдийг номын сантай танилцуулж номыг хэрхэн зөв ариг гамтай унших талаар яриа, үлгэрийн номоор чанга уншлага хийсэн. Энэхүү ажлын үеэр хүүхдүүдээ эцэг эхчүүд нь номын сангаас ирж авах явцдаа дээрх хүүхдийн хүмүүжил , сурган хүмүүжүүлэх арга зүйтэй холбоо бүхий номнуудын үзэсгэлэнг үзэж сонирхсон. Уг уралдааны шалгаруулалтын үеэр багш сурган хүмүүжүүлэгчдэд Дэлхийн банкны READ төслийн хүрээнд гарсан 247 ном бүхий DVD –г танилцуулж , уралдаанд хүүхдүүддээ оролцуулсан цэцэрлэгүүдэд уг DVD-г тараалаа.

Уралдаанд Уралдаанд 11, 2, 9, 24-р цэцэрлэгийн 12 баг оролцсонооос 11-р өэцэрлэгээс Давхарбаяр 1-р байр, Дүүрэнжаргал 2-р байр, Батцэцэг 3-р байр тус тус эзэлсэн.

*"Номын баяр" арга хэмжээ*МУ-ын

Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 2012 оны 08-р сарын 24-ний өдрийн "Номын баярын өдөр тэмдэглэх тухай" 158-р зарлигийн дагуу аймагтаа Номын баяр-ын арга хэмжээг 2012 оны 9-р сарын 21-ний өдрийн 11 цагаас Нутгийн удирдлагын ордны өмнөх талбайд хамт олны хүчээр өргөн дэлгэр тэмдэглэлээ.

Номын баярыг нээж аймгийн Төв номын сангийн дарга Батсаруул, НБХ-ийн дарга Жамъянхорол, СБ түшмэл Эрдэнэчимэг нар оролцож үг хэллээ.

Номын баярын нээлтийн үйл ажиллагааны олон нийтийг хамарсан жагсаалд байгууллагууд номын баатруудын дүрээр баг бэлтгэж, номын зураг плакат , туг дарцаг, цэцэг бөмбөлөг зэргийг барьж идэвхтэй жагсаж оролцлоо.

Театрын уран бүтээлчид оролцож урлагийн тоглолт үзүүлэв

Тэргүүний уншигчид номын санчдыг шагнаж урамшуулав.

Ном худалдах солилцох бэлэглэх үйл ажиллагаа өргөнөөр зохион байгуулагдаж хувийн номын сантай хүмүүс номоо танилцуулж үзэсгэлэн гаргав. Мөн номын худалдаа хийв.

Номын санчид шинэ номын үзэсгэлэн гаргаж сурталчлав. Сумын номын сангуудад шинэ номын дээжээс бэлэглэв.

Номын баярын арга хэмжээнд идэвхтэй оролцсон байгууллага хамт олныг шалгаруулан дүгнэж урамшууллаа.

- *Номын анд уралдаан*

2012.11.03 Эрдмийн гэгээ бүрэн дунд сургуулийн Ганбилэг багштай 3а ангийн 32 сурагчыг урилгаар ХУТ-д ирүүлж, мөн 3-р бүрэн дунд сургуулийн Амаржаргал багштай 4 а ангийн 35 хүүхдэд сургууль дээр нь очиж номын анд уралдаанд оролцох, номын тэмдэглэл хөтлөх талаар зөвөлгөө өгөв. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа " Номын анд" уралдаанд 51 сурагчыг бүртгэж ном унших хөдөлгөөнд оролцуулж эхэллээ.

2012 оны шилдэг уншигчид

- *2012 оны шилдэг уншигчдаа шалгаруулж өргөмжлөл, гарын бэлгээр урамшууллаа. Шилдэг уншигч хүүхдээр 1-р сургуулийн 5г ангийн сурагч Э.Наранбаатар, насанд хүрэсдээр 61 настай ахмад уншигч Б.Батчулуун гуай шалгарлаа.*

5. Сургалт, арга зүйн зөвлөгөө

Баруун бүсийн Баяндалай, Ноён, Гурван тэс, Сэврэй ,Хүрмэн сумдад 2012-оны 3-р сарын 10-наас 3-р сарын 17 ны хооронд 7 хоног БСГазрын мэргэжилтэнүүдтэй сумдын Соёлын төвийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, соёлын төвийн номын санчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажил үйлчилгээнд нь туслалцаа үзүүллээ.

11-р сарын 27 ны өдөр аймгийн ЕБС-дын номын санчидад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх нэг өдрийн сургалт зохион байгууллаа. Номын сангийн бүртгэлүүдийг хөтлөх арга зүй, номын сан ном зүйн ангилал, номын сангийн автоматжуулалтын талаар сургалтын үеэр зааж зөвлөгө, заавар өглөө. 12-р сарын 3-7 ны өдрүүдэд зохиогдсон "Номын сангийн шинэчлэл" сургалтанд хамрагдаж ирсэн номын санчид сургалтаас сурсан сонссон мэдлэг мэдээллээ хамт олныхоо дунд сургалт хэлбэрээр зохион байгуулж тус сургалтаар яригдсан зүйлс зарим туршлагаас санаа авч цаашид хийх ажилдаа зарим санааг тусгахаар зөвлөлдлөө. Мөн түүнчлэн энэхүү сургалтын дүнд тус номын сангийн фондод байдаг Номын

санчидад зориулсан онол арга зүйн номнуудаар үзэсгэлэн гаргах ажлыг санаачиллаа.

6. Ажилтан ажилагсадын мэргэжил арга зүйг дээшлүүлэх тал дээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Улаанбаатар хотод Монголын Үндэсний номын сангаас 2012.04-09-нөөс 11-ний хооронд зохион байгуулсан "Номын сан-мэдээллийн технологи" сэдэвт 24 цагийн сургалтанд каталогич номзүйч, мэдээллийн ажилтан 2-оо хамрууллаа.

- 4-р сард Малайзын Куалалампур хотноо зохиогдсон Education USA төвүүдийн Зүүн ази номхон далайн орнуудын бүсийн уулзалт хуралд Мэдээллийн ажилтан А.Одончимэг оролцож гадны орнуудын туршлагаас сонсож, түвшин тогтоох шалгалтуудад гарсан өөрчлөлт шинэчлэлт, Америкийн боловсролын байгууллагуудын төлөөллүүдтэй танилцлаа.
- Өмнөговь аймгийн Соёл урлагийн ажилтны сургалт семинарт 2012- оны 4-р сарын 28-наас-30 ны хооронд сургалт семинарт номын санчидаа хамрууллаа.
- 2012 оны 9-р сарын 8-9ний өдрүүдэд Өмнөговь аймгийн бүх соёл урлагийн ажилтнуудын уулзалт Ноён суманд болж үйл ажиллагаанд оролцлоо.
- 2012-09-15-нд Улаанбаатар хотноо болсон “Номын баярын” үйл ажилгаанд оролцсон.

- 12-р сарын 3-7 ны өдрүүдэд зохиогдсон “Номын сангийн шинэчлэл” сургалтанд 2 номын санч хамрагдаж ССАЖЯамнаас авч хэрэгжүүлж байгаа номын сангийн шинэчлэлийн хүрээнд хийгдэж байгаа ажлууд, дэвшүүлж буй хөтөлбөр, зорилтын талаар болон Номын сангийн автоматжуулалтын

Openbiblio програìм дээр ажиллах дадлага, орчин цагийн соёл танин мэдэхүйн ажлыг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах арга барил, номзүйн талаар шинэ зүйлс сурч мэдлээ.

- 12-р сарын 12-15 нд УБ хотноо зохион байгуулагдсан “Соёл урлагийн салбарын шинэчлэл” чуулганд дарга Б.Батсаруул оролцов.

6. Давуу тал ба боломж

- Номын сангийн фондын баяжилт болон номын сангийн танхимуудын үйлчилгээ төлбөргүй болсонтой холбоотой уншигчдын тоо, ном олголт өссөн.
- Номын санчидаа сургалт семинарт хамруулснаар тэдний мэдлэг , ур чадвар зохих шатаар дээшилсэн.
- Нүүдлийн номын сангийн пургон автомашинтай болсон нь соёл танин мэдэхүйн ажил явуулах, албан байгууллалуудад хүрч үйлчлэх, УБ-аас шинэ ном авчрах , сум, сургууль цэцэрлэгт шинэ ном түгээх , сумын номын сангуудад арга зүй мэргэжлийн туслалцааг газар дээр нь очиж өгөх зэрэг үйл ажиллагаанд хялбар болж, үр нөлөөгөө үзүүлж байна.

7. Сул тал

- Номын сангийн шинэчлэлийн асуудал ярьж байгаа энэ цаг үед номын сангийнхаа өрөө танхимуудыг камержуулан ном хэвлэлийн бүрэн бүтэн байдлыг анхаарахгүй бол ном хэвлэл алдагдах , урагдаж гэмтэх асуудлууд их гарч байна.
- Интернэт сүлжээний хурдыг нэмэгдүүлж сүүлийн 2-3 сард туршиж үзсэн ч энэ нэмэгдсэн хурд нь орчин үеийн өндөр агуулга бүхий онлайн мэдээлэлд хандахад тийм ч хангалттай биш байна.
- Тус байгууллагыг тойрон өндөр байшингууд баригдаж байгаа нь номын сангийн танхимуудын гэрэлтүүлэгт сөргөөр нөлөөлж байна.

8. Санал

- Номын сангийн үйл ажиллагааг хэвийн чанартай явуулахад номын сангийн байрны өргөтгөл буюу шинэ байрны асуудлыг яаралтай шийдвэрлэх.
- Номын сангийн автоматжуулалтыг бүрэн шийдэхэд интернэт сүлжээний хурдыг нэмэгдүүлэх буюу шилэн кабелд холбох асуудлыг шийдвэрлэх.

Сүхбаатар аймгийн Нийтийн номын сангийн 2012 оны үйл ажиллагааны тайлан

Сүхбаатар аймаг байгуулагдсаны 70 жил, Баруун – Урт хот байгуулагдсаны 55 жилийн ойн хүрээнд цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлэх, иргэдэд сурталчлах, техник хэрэгслийг нэмэгдүүлэх, номын фондыг баяжуулах, мэдээлэл сурталчилгааг олон нийтэд хүртээмжтэй болгох, үйлчилгээний хүрээ хүртээмжийг өргөжүүлэх, уншигчдад үйлчлэх таатай орчинг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирсэн.
Уншлага үйлчилгээ:
3240 байнгын уншигчдад 26526 ирэгсдэд 39210 ном, хэвлэл олгож үйлчиллээ.

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Уншигч	2900	2950101	
Ирэгсэд	24500	26526	108
Ном олголт	3800039210	103	

Шинээр 20072836 төгрөгний 320 нэр төрлийн 1716 ш ном авч фондоо баяжуулсан. Үүнээс: Төсвөөр 6505720төгрөгний 613 ш ном, Хандиваар12901216 төгрөгний 1103 ном, Тогтмол хэвлэл : 665900 төгрөгний 15 нэр төрлийн тогтмол хэвлэл захиалан уншлага үйлчилгээнд гаргасан.
Соёл олон түмний ажил:
Шинэ номын үзэсгэлэнг 1716 номоор 10 гаруй удаа гарган сурталчилжСүхбаатар аймгийн 70 жилд аймгийн түүх, соёлын дээж буланг Сүхбаатар аймгийн яруу найрагч, шүлэгчдийн бүтээлийн дээж “ Шаргын ай”
1. Г. Мэнд – Ооёо “ Алтан овооны шаштир
2. Анагаах ухааны доктор, профессор, орчуулагч М. Шагдарсүрэнгийн Бурхан багшийн амьдрал, шагжамуни бурхны хөрөг оршвой
3. Тал нутгийн өв соёл
4. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал: Сүхбаатар аймаг II
5. Монголын эртний түүхч эрдэмтэн
1. Ч. Жамъяанжавын “ Зүрхний дуулал”
2. Ц. Оюундэлгэрийн “ Дотно аяз” гэх мэт 100 гаруй номоор өргөжүүлэн сурталчлахад 6000 гаруй хүн хамрагдсан.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн: Д. Сүхбаатарын 119 жилийн ойд24 ном
- Эрүүл амьдрал – Бидний сонголт 48
- Эх хэл эрдэм 30
- Тал нутгийн зохиолчдын уран бүтээл60
- Хууль эрх зүй 24
- Статистикийн мэдээлэл30
- Уйгаржин монгол бичиг 40
- Азийн хөгжлийн сан / Англи ном/ 120
- Гэр бүлийн ном 30
-Д. Нацагдоржийн намтар уран бүтээл 47
-Ардын аман зохиол 60
-Эзэн богд Чингис хааны мэндэлсний 850 жилийн ойд гэх мэт сэдвээр30 гаруй удаа 2000 гаруй номоор гаргаж сурталчлахад 8000 гаруй хүн хамрагдсан.

“Сүхбаатар аймаг – 70” аяны хүрээнд Баруун – Урт сумын ЗДТГ, БСГ – тай хамтарч “ Бичиг үсгийн баяр - ыг зохион байгуулж, хосгүй үнэт болон ховор номын үзэсгэлэн, шинэ номын, уйгаржин бичгийн, хэлшинжлэлийн, эрүүл мэнд, амьдрах ухааны, хүүхдийн номын үзэсгэлэнг 400 гаруй номоор гаргаж сурталчлахад 1000 гаруй хүн хамрагдсан. Мөн энэ үеэр Угийн бичгийн хөтлөлтийн талаар телевизийн нэвтрүүлэгт гавъяат багш Ш. Чулуунбор, Баруун – Урт сумын Тамгын газрын дарга Г. Алтаннавч, номын санч В. Энхтуяа нар оролцсоноос гадна Тэмүүлэл цогцолбор сургуулийн багш С. Мандахтуяа, 10 жилийн 1 сургуулийн багш Д. Жавзмаа, Ш. Чулуунбор нар хувийн номын сангийн дээжээс үзэсгэлэн гаргасан.
Хүүхдүүдийг номонд хэрхэн дуртай болгох талаар дунд бүлгийн хүүхдүүдийн дунд МУ-ын гавъяат багш Ш. Чулуунбортой уулзалт ярилцлага, Баруун-Урт сумын 7-р цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийнхний дунд “Үлгэр уншихын ач холбогдол”, “Н. Доржцэрэнгийн шүлгийг хэн уран унших вэ?” уран уншлагийн тэмцээнийг зохион байгуулсан. Улс тунхагласны 88 жилийн ойг тохиолдуулан цэцэрлэгийн ба бага ангийнхны дунд сүлд, соёмбо, төрийн далбааны утга учрыг танилцуулж сурталчилсан.
“Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн” шалгаруулах журмын дагуу “ Олуулаа уншъя” ном унших 1 сарын аян зохион байгуулж,Д.Нацагдоржийн амьдрал, уран бүтээлийнномын үзэсгэлэн, ном зүйн бүртгэлийг гарган сурталчилж, сурагчдыг анги бүлгээр нь номын санд хамруулах ажлыг зохион байгуулж, уг уралдаанд нийт 20сурагчид бүтээлээ ирүүлснээс бага насны ангилалд Тэмүүлэл цогцолбор сургуулийн 7а ангийн сурагч Э. Аззаяа, 5г ангийн сурагч Н. Мөнгөнсор, өсвөр насны ангилалд Бүрэн дунд сургуулийн 11д ангийн сурагч А. Анар, 11б ангийн сурагч Х. Чаминчимэг нар шалгарч, “ Тэргүүний уншигч - Д. Нацагдорж тэмдэгтэн болзлыг хангасан.Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 8-р сарын 24-ны өдрийн 158-р зарлигийн дагуу Д. Сүхбаатарын нэрэмжит бүрэн дунд сургуультай хамтарч “Номын баяр” тэмдэглэж шинэ номын мэдээлэл хийн гом, хэвлэлээ сурталчилсан.
Зөөврийн номын сан:Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба – 8 удаа, Барилгын цэргийн 338-р ангид 11 удаа, 1 - 7 цэцэрлэгт 12 удаа нийт 600 гаруй уншигчдад1000 гаруй номоор үйлчилсэн.
Нүүдлийн номын сан: Сүхбаатар аймгийн засаг даргын засаг даргын 2012 оны 03 сарын 14 – ний “Соёл, урлагийн арга хэмжээг зохион байгуулах тухай” ¹ 116 тоот захирамжийн дагуу “Сүхбаатар соёл урлаг – 70” арга хэмжээнд захирал М. Дэнсмаа, номын санч Т. Чандмань оролцож, 2012 оны 4 сарын 9 – нөөс 5 сарын 4 хүртэл аймгийн нийт сумдуудаар явж, сумын соёлын төв болон сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцан, мэргэжил заах арга зүйн зөвлөгөө өгч ажилласан ба номын сангийн фондонд дахь номын дээж болох үнэт болон ховор ном, Сүхбаатар аймгийн холбогдолтой түүх, соёлын номууд, эрүүл мэнд, амьдрах ухаан, хүүхдийн номууд мөн төрөл бүрийн гарын авлага, тогтмол хэвлэл гэх мэт 180 гаруй номоор “ Нүүдлийн номын сан” ажиллуулж давхардсан тоогоор нийт 3000 гаруй хүн хамрагдсан. Мөн Онгон суманд нүүдлийн номын сан 3 удаа ажиллуулж, 130 гаруй мянган төгрөгний 50 гаруй номоор үйлчилж, 300 гаруй хүн хамрагдсан.
Лавлагаа, мэдээлэл, ном зүйн ажлын хүрээнд:
Шинэ номын мэдээлллийг нийт 10 удаа гаргаж, тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан ном зүй,гарын авлага, лавлагааны материал тогтмол бэлтгэн сурталчилж ирсэн. Үүнд: “Монгол дээлээрээ гоёцгооё”, Сүхбаатар нутгаас төрсөн эрдэмтэн зохиолчдын ном зүйн бүртгэл, Д. Нацагдоржийн амьдрал, уран бүтээл, “Болор цом”-ын тэргүүн байрын шагналтнуудын материалыг 2011 хүртэл баяжуулан сурталчлахад нийт 3260 гаруй уншигчид хамрагдсан.

Сүхбаатар аймаг байгуулагдсаны 70 жил, Баруун – Урт хот байгуулагдсаны 55 жилийн ойн хүрээнд "Хүндэтгэлийн самбар" - ыг "Жавхлант шарга" аймгийн түүхэн замнал, хүн ам, газарзүйн байршил, байгалийн тогтоц, Манай алдартнууд, Дарьганга дархны урлал, хурдан хүлгүүд, Тал нутгийн уран бүтээлчдийн ном зүй болон өөрийн байгууллагын тухай гэх зэрэг сэдвүүдээр бэлтгэн хийж, сурталчилж байна.
Номын санг автоматжуулах ажлын хүрээнд:
Аймаг, нийслэлийн Нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийн 3.2.3-д заасны дагуу номын сан, ном зүйн мэдээллийг автоматжуулах ажлын хүрээнд цахим каталогит ном оруулах ажлын төлөвлөгөөг шинэчлэн гаргаж, нийт 9770 нэр төрлийн нийтдээ 22175 ном цахим каталогт ороод байна. Эдгээр номуудыг CD дээр буулган архивлаад байна.Бүртгэл мэдээллээс мэдээллийн баазад байгаа2010-2012 онуудын цахим каталогит орсон номуудын нарийвчилсан судалгааг диаграммаар гаргаж, хувийн үзүүлэлтийг хүн нэг бүрээр гарган дүгнэлт хийн ажиллаж ирсэн.
Уншигчдын хэрэгцээт мэдээллийг цахим хэлбэрээр өгч, Амьдралд хөл тавих нэгэн гүүр буюу таны оюуны чадамж, Харилцааны саятан, Патент, Хөх судрын үлгэрийн хураангуй, Монгол ардын ерөөл магтаал, Үндсэн хууль, Зян Рун " Чонон сүлд, Лондон Ж. Саран хөндий, Виктор Гюго " Инээмтгий хүн" гэх мэт 100 гаруй нэр төрлийн цахим номоор үйлчилж 100 гаруй хүн хамрагдсан.
Байгууллагын дотоод сүлжээ болон компьютерууд, тэдгээрийн дагалдах төхөөрөмжүүдийн найдвартай ажиллагааг хангаж ажиллаж, нийт 8 удаагийн эвдрэл гэмтлээс засвар үйлчилгээг 5 удаа, шинэчлэн сайжруулалт 2 удаа хийж гүйцэтгэв. Мөн компьютеруудад гарсан программ хангамжийн шинэчлэлтүүдийг хэрэгцээт програмуудаар нь 5 удаа шинэчлэн сэлбэж сайжруулж ажиллав.
Байгууллагын хэмжээнд дотоод сүлжээний диаграмм болон бүх компьютеруудын нэгдсэн гарын авлага зэрэг баримт бичгүүдийг бий болгож ажилдаа нэвтрүүлсэн.
Байгууллага сурталчлах:

2012 онд ирсэн номуудаар "Шинэ номын мэдээлэл" өнгөтөөр бэлтгэн гаргаж , байгууллагаа сурталчлах зорилгоор "Ил тод"–ын самбарт номын сангийн холбогдолтой мэдээ, тайлан, төсөв, санхүүгийн болон бараа ажил үйлчилгээ, ажиллагсдын хүний нөөц, шинэ номын мэдээ, номын сангийн дүрэм, байгууллагын дотоод журам, төсвийн зарцуулалт,Miniih.com дээр" librarysan" блогт байгууллагын түүхэн замнал, номын түүх, хамгийн хамгийн номын түүхийн тухай сонирхолтой мэдээлэл, үнэт ховор ном, хүүхдийг номонд хэрхэн дуртай болгох тухай,Д.Нацагдорж тэмдэгтэний болзол, номын сангийн автоматжуулалтын тухай, номын санчийн зөвлөгөөгэх мэт мэдээллийг тавьж сурталчилж, блокт нийтдээ 1280 зочилж үзэж сонирхсон байна. Мөн байгууллагынзорилт, ажиллагсдын талаарх товч мэдээллийг танхимуудын үүдэнд хийж байрлуулсан.

Сургалт, арга зүйн ажлын талаар:

Үндэсний номын сангаас зохион явуулсан "Мэдээллийн технологи Номын сан" 3 хоногийн сургалтанд бүртгэл мэдээллийн ажилтан М. Нарангэрэл хамрагдсанаас гадна Барилгын цэргийн 338 – р ангийн номын санд нь очиж ажиллан номын сангийн ажлын талаар заавар зөвлөгөө өгч, номын сангийн бүртгэл хөтлөлт, ном ангилах, ном данслах талаар зааж сургаснаас гадна Наран сумын сургуулийн номын санч болон СУИС – ийн Соёлын боловсролын сургуулийн 330 – р ангийн Э. Энхнаран, ШУТИС – ийн компьтерийн ангийн оюутан Ч. Оюундалайг өөрийн номын сан дээр ажиллуулан дадлагажуулсан.
Сүхбаатар аймгийн засаг даргын засаг даргын 2012 оны 03 сарын 14 – ний "Соёл, урлагийн арга хэмжээг зохион байгуулах тухай" [1] 116 тоот захирамжийн дагуу

Жаахахн шарга" ХЖТ, БСГ, Угсаатны зүйн музейтэй хамтран "Сүхбаатар соёл урлаг – 70" арга хэмжээнд захирал М. Дэнсмаа, номын сан, арга зүйч Т. Чандмань нар оролцон 2012 оны 4 сарын 9 – нөөс 5 сарын 4 хүртэл аймгийн нийт сумдуудаар явж, сумын соёлын төв болон сургуулийн номын сангийн үйл ажиллагаатайтанилцан, мэргэжил заах арга зүйн зөвлөгөө өгч ажиллан, номын санд холбогдох гарын авлага, материалыг өгч ажиллаа. Нийт 12 сум, сургуулийн 24 номын санч, мэдээллийн ажилтан хамрагдсан.
Аймгийн Нийтийн номын сан, Үндэсний номын сантай хамтран 2012 оны 10 сарын 22–24-ний өдрүүдэд сум, сургуулийн номын санчдад зориулсан "Номын сангийн салбарын эрх зүйн шинэчлэл" сэдэвт сургалтыг зохион явуулж, сургалтанд аймгийн нийт сум, сургуулийн 28 номын санч хамрагдсанаас гадна Үндэсний номын сангийн ахлах арга зүйч Б. Энхжаргал, арга зүйч Б. Сарандэлгэр нар ирж оролцсон. Мөн уг сургалтанд Аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б. Буянтогтох, нийгмийн бодлогын хэлтсийн соёл хариуцсан мэргэжилтэн Л. Нарангарав нар оролцож, номын санчид номын сангийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар санал бодлоо солилцсоноос гадна сум, сургуулийн номын сангуудад аймгийн нийтийн номын сангаас мэргэжил заах арга зүйн зөвлөгөө өгч ажилласан ба номын сан дахь ном зүйн бүртгэл, шинэ номын тойм, ханын самбар, лавлагаа мэдээлэл зэргээр үзэсгэлэн гаргаж, орон нутгийн SB

телевизээр сурталчилсан.
Номын фондын баяжилт, хадгалалт хамгаалалтын ажлын талаар:
Шинээр 20072836төгрөгний 320 нэр төрлийн 1716 ш ном авч фондоо баяжуулан 73301938 төгрөгийн 44468 ш номын фондтой болоод байна.
2012 онд төсвөөр6505720төгрөгний 613 ш ном, хандиваар12901216 төгрөгний 1103 ном / Үндэсний номын сан, Азийн хөгжлийн сан, Ерөнхийлөгчийн тамгын газар, Нээлттэй Нийгэм Хүрээлэн, аймгийн Статистикийн хэлтэс зэрэг байгууллагууд болон хувь хүмүүс/Тогтмол хэвлэл : 665900 төгрөгний 15 нэр төрлийн тогтмол хэвлэл захиалан уншлага үйлчилгээнд гаргасан.

БСШУЯамнаас Ш. Лувсанвандангийн бүтээлийн чуулган хэмээх 12 боть зохиол, Монгол бэлчээрийн мал аж ахуй 4 боть, CD, Ж. Дашдондогийн Хотын үлгэр, Дүрслэх урлагийн боловсрол хэмээх нийт 2314000 төгрөгний 231 ш номыг бүх сумын соёлын төвийн номын санд, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 8 дугаар сарын 24 - ний өдрийн "Номын баяр тэмдэглэх тухай" 158 дугаар зарлигийн дагууЕБС-ийн 15 сургууль, 17 цэцэрлэг, 12 сумын соёлын төвийн номын санд 36314054 төгрөгний 3941 ширхэг номыг хуваарилан өгсөн.Мөн Нээлттэй Нийгэм Форумаас 304000 төгрөгний ирсэн 60 ширхэг номыг сумдад хувиарласан.
Шинэ ирсэн 1716 ш номонд техник ажиллагаа хийж, танхимуудад хувиарлан өгч уншлага үйлчилгээнд гаргаснаас гадна хуучин оны тогтмол хэвлэлийг үдэж

цэгцлэн архивт шилжүүлсэн ба үнэт ховор ном 15 ш номыг торгоор баринтагласан. Номын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, дотоод хяналтыг сайжруулах тал дээр анхаарч, үйлчилгээний танхимуудад тооллого хийж, хүүхдийн уншлагын танхимын номын санч Р. Цолмонтуяад 3.652.420 төгрөгний 345 ш номыг хүлээлгэн өгсөн ба үйлчилгээний танхимуудын тооллогоор дутагдсан 158356 төгрөгний 55 ш номын тооцоог хийж дуусгасан.

Гадаад харилцаа:

Монгол Улсын Бичигт, Хятад Улсын Зүүн хатавч боомтуудын 20 жилийн ойг хоёр
орны найрамдалт хамтын ажиллагааны хүрээнд хамтран тэмдэглэхээр тохиролцсоны дагуу аймгийн Засаг даргын захирамж, ИТХ – ын тогтоолын дагуу уг баярын арга хэмжээнд 2012 оны 8 сарын 20 - 23 – ны өдрүүдэд аймгийн нийтийн номын сангийн хамт олон оролцож, Зүүн үзэмчин хошууны Улиастай балгасын номын сантай туршлага солилцож, уйгаржин бичгийн номын үзэсгэлэнг 100 гаруй номоор гаргаж сурталчилж нийт 2000 гаруй хүн үзэж сонирхсон.

Төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтарч ажилласан талаар:
Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан“ Архигүй монголын төлөө хамтдаа” 1 сарын аяны хүрээнд АЗДТГ- аас зохион байгуулсан сургалт, Мянганы хөгжлийн сангаас зохион байгуулагдсан “ Архи - бидний сонголт биш” лекц, Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “ Тамхигүй аймаг” аян, Бүх нийтийн кросс гүйлтэнд хамт олноороо оролцож,уншигчдадаа сэтгэлийн бэлэг болгон эрүүл мэндийн талаарх онч мэргэн үгс, “ Номын сан – Архи, тамхигүй орчин” уриаг бичиж сурталчилсанаас гадна Тамхи татахыг хориглосон наалтуудыг өрөө танхимууд, явган хүний шат болгонд нааж сурталчилсан.

Байгууллагын дотоод ажил, хяналт шинжилгээний ажлын талаар:
Байгууллагын үндсэн хөрөнгийн бүх бүртгэлийг шинэчлэн дансалсанаас гадна үндсэн хөрөнгийн тооллогыг 2012 оны 4 сарын 9 - нөөс 2012 оны 4 сарын 13 – ны хооронд хийж, тооллогын комиссын даргаар Т.Чандмань, гишүүдээр В.Энхтуяа, Р.Хүрэлтогоо нар ажиллаж, уг тооллогод үйлчилгээний бүх танхим, коридорын эд хөрөнгүүд нийт 96272. 0 төгрөгний эд хөрөнгө тоологдож, хангалттай сайн үнэлгээ авсан.

Монгол Улсын ЗГ – ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор “ Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан тусгай төлөвлөгөө, журам гарган, сар бүр тайланг “ Ил тод” – ын самбарт байрлуулан сурталчилж, аймгийн МХГ – т тайланг гарган өгч ирсэн.
Номын сангийн сар бүрийн ажлын тайланг статистикийн газар болон НБХ – т гаргаж өгч хэвшсэн. Аймгийн хяналт шинжилгээ үнэлгээний тасгаас номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллан, заавар зөвлөгөө өгсний дагуу хяналт шинжилгээний материалыг номын санчдад хувиарлан өгч, тус тасгийн мэргэжилтэн нараар хянуулан биелэлтийг нь гаргасан.
Байгууллагын 2011 оны бичиг хэргийг үдэж цэгцлэн, 2003 – 2007 оны санхүүгийн баримтыг нягтлангаас авч хадгаламжийн нэгж үүсгэсэн ба тушаал бүртгэх болон ирсэн, явсан дэвтрийг шинэчилсэнээс гадна албан бланкийг стандартын дагуу хийлгэсэн.

Байгууллагын тохижилт:

Аймаг байгуулагдсаны 70 жилийн ойг угтаж Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигаар / 2010. 63 – р зарлиг / жил бүрийн Y, X дугаар сарын 2 дахь долоо хоногийн Бямба гаригийг бүх нийтээр “Мод тарих үндэсний өдөр” болгон зарласантай холбогдуулан байгууллагынхаа гадна тохижилтонд анхаарч өөрийн эзэмшлийн гаднах талбайд 10 ш мод нэмж тарьж, хөрс шороог сийрэгжүүлэн цэцгийн мандлыг шинээр хийж тохижуулан зүлэгжүүлсэнээс гадна МУЗГ – ын 2011 оны 19 – р хуралдаанаар жил бүрийн 5 сарын эхний 7 хоногийн Бямба гаригийн амралтын өдрийг “ Хөгжлийн төлөө хамтдаа” уриан дор “Бүх нийтийн хөдөлмөрийн өдөр” болгосонтой холбогдуулж, 5/ IY – ний өдөр “ Оргих” зоогийн газраас “ Хүүхдийн төлөө хэлтэс” хүртэлх газрыг цэвэрлэсэн.

ХЖТ – ын зүүн талд “ Номын сан” гэрлэн хаяг, сурталчилгааны самбар хийж байрлуулсанаас гадна байгууллагын лого бүхий туг, ажилчдын танилцуулгыг шинээр хийж, танхимуудын гадна талд байрлуулж, ажилчдад энгэрийн тэмдэг, ижил формоор жигдэлж, нийт 1200.0 гаруй төгрөг зарцуулсан.

Сэлэнгэ аймгийн нийтийн номын сангийн 2012 оны жилийн эцсийн тайлан

2012 .11.22 **Сүхбаатар сум**

Номын сангийн удирдлага зохион байгуулалтын талаар

Номын сангийн ажиллагсадттай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж , хөдөлмөрийн гэрээг шинээр боловсруулан боловсронгуй болгов.

Номын сангийн дотоод хяналтын журмыг баталж өдөр тутмын ажилдаа тусган хэрэгжүүллээ.

Ажилчдын эрүүл ахуйн байдалд анхааран урьдчилан сэргийлэх дархлаажуулах, витаминжуулах аяныг зохион байгуулж , шинээр хүүхэдтэй болсон ,гэр бүл болсон ажиллагсдад номын сангийн дотоод журмын дагуу зохих хөнгөлөлт дэмжлэгүүдийг үзүүллээ.

Номын сангийн ажиллагсадын мэргэжил боловсролыг дээшлүүлэх, талаар анхааран ажиллаж номын санчдыг Улаанбаатар хотын номын сангуудын үйл ажиллагаатай танилцах тэднээс туршлага судлах ажлыг зохион байгуулав.

Байгууллагын архивын ORG-AMS программыг суулгуулан бичиг хэрэг архивын хадгалалт хамгаалалтын сайжруулах боловсронгуй болгох талаар анхааран ажиллаа.

Нэг. Уншлага үйлчилгээ

2012 онд шинээр 1235 уншигч 4219 ирцэд 8603 ном олголоо.

д/д	Шинэ уншигч	Ирц	Ном олголт
1.	2235	6219	10603

ГНОТ-ийн нийт 972 ном олголтоос 4 байгалийн шинжлэл, 8 техник,10 хөдөө аж ахуй, 3 анагаах ухаан, 39 түүх, 20 эдийн засаг, 5 хууль, 1 хэл шинжлэл ,2 шашины номнууд тус тус олгогдсоноос 880 нь уран зохиолын ном үйлчилгээнд гарлаа.Ойрын фондын эргэлт 20 хувьтай байна.

Үлгэрчилсэн дүрмийн 3.2.8-д заасны дагуу алслагдсан цэг, дүүрэгт нүүдлийн болон хөдөлгөөнт номоор үйлчлэж, мөн СБ сумын 2,4-р цэцэрлэг, төмөр замын “Бүжигхэн” цэцрлэгийн багш нар, 12-н жилийн 1-р сургуулийн номын сантай хамтран нийт 534 хүүхдүүдэд 170 ш номоор үйлчилж, “Гуталт муур “,”Хэрэмний

хүүхэд “,”Миний бие” хүүхдийн зохиолоор үлгэрийн уншлага хийж, хүүхэд багачуудын дунд “Маша баавгай хоёр”, хүүхэлдэйн киног гаргаж 56 хүүхэд үзэж сонирхоллоо.

Бага насны хүүхдүүдийг номонд хайртай болгох , ном уншсанаар номын ач тусыг мэдрэх, хичээл сурлагандаа ашиглах, зөв төлөвшихөд тус болгох зорилгоор,урилгат уншлагыг зохион байгуулж, нийт 108 сурагчдыг номын сандаа урьж, номын сангаа танилцуулж, шинэ номын үзэсгэлэн гаргаж, Таши, Багачуудын нэвтэрхий толь цуврал номоор номын тойм яриа хийлээ.

Үндсэн фондонд байгаа сүүлийн үеийн шинэ ном зохиолыг иргэдэд хүргэхийн тулд хөдөлгөөнт ба зөөврийн номын сангийн үйлчилгээгээр Аймгийн шүүх, ХААНгазар,Стандарт барилгын дэлгүүр, Зурагчин, ЕБ1-р сургуулийн ахлах ангийн сурагчид зэрэг нийт 21 уншигчдад шинээр карт нээж номын сангийн уншигч болгон 45 ш номоор үйлчиллээ.

Явуулын номын сангийн үйлчилгээ

№	Уншигч	Ном олголт
	897	12311

Шинээр ирсэн номоор цаг тухай бүрт нь үзэсгэлэн гаргаж,мэдээлэл хийн гэрээр олгон уншигчдын талархалыг хүлээж байна.

Мөн уншигчдын хэрэгцээнд зориулж тогтмол хэвлэлээр байнга үйлчилж байна.

Номын сангийн өдөр тутмын болон, татгалзлын дэвтрийг стандартын дагуу хөтөлж,14 номын санал уншигчдаас авсанаас 10 номын хүсэлтийг биелүүллээ.

Хоёр. Арга зүйн ажлын талаар

А.Номын санчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх

Сум, сургуулийн номын санч нарт мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж Сүхбаатар, Хушаат, Дулаанхаан, Сант, Түнхэл, Цагаан нуур, Шаамар, Баруунбүрэн, Ерөө, Түнхэл гэх мэт сум, тосгоны нийт 40 гаруй номын санч нарт биечлэн болон утас, цахим шуудан ашиглан давхардсан тоогоор нийт 80 гаруй удаа аргазүйн зөвлөгөө өглөө. Үүнд: Номын сангийн анхан шатны бүртгэл хөтлөлт, номын сангийн номын фондын нөхөн бүрдүүлэлт, номын санд мөрдөгдөж байгаа хууль, эрх зүй, стандартын талаар гэх мэт.

2012 оны 05 сарын 18-19-нд аймгийн БСГ, Аймгийн Нийтийн номын сангаас хамтран Баянгол суманд зохион байгуулсан “Сум, сургуулийн номын санчдын ур чадварын уралдаан”-ыг зохион байгуулах ажилд оролцож, БСГ-ын Соёл, урлаг, хөгжмийн боловсрол хариуцсан мэргэжилтэн Г.Эрдэнэчимэгийн хамт ажиллалаа.

Сум, сургуулийн нийт 37 номын санч оролцсоноос Тэргүүн байранд Шаамар сумын соёлын төвийн номын санч Д.Батмөнх, Хоёрдугаар байранд Сайхан сумын сургуулийн номын санч М.Оюунгэрэл, Гуравдугаар байранд Сүхбаатар сумын 2-р сургуулийн номын санч Ч.Оюунцэцэг, Тусгай байранд Сүхбаатар сумын 6-р сургуулийн номын санч Б.Долгорсүрэн, Ерөө сумын номын санч Ш.Оюунчимэг нар шалгарлаа.

Б. Хууль, стандарын хэрэгжилт

Аймгийн Нийтийн номын сан БСГ-тай хамтран 2012.02.10-ны өдөр зохион байгуулсан “Сум, сургуулийн номын санч нарын сургалт семинар”-т оролцсон нийт 27 номын санч нарын “Номонд техник ажиллагаа хийх, ном зүйн бичилт хийх” талаарх ерөнхий мэдлэгийг шалган зөвлөгөө өглөө.

2012.04.16-нд МХГ-ын соёлын хяналтын бүсийн байцаагч Алтанзаяагийн хамт 1,2,3,4,6-р сургуулийн номын санч нараас тестээр шалгалт авч,МСҮТ-ийн номын санч нарын Номын сангийн анхан шатны бүртгэл хөтлөлтийн ажлыг үзэж зөвлөгөө өглөө.

Сумдын номын сангуудад нөхөн бүрдүүлэх шаардлагатай байгаа номын судалгаа болон уншигчийн ширээ сандал хэрэгцээтэй байгаа номын сангуудын судалгааг гаргалаа.

В. Номын санч нарын хамтын ажиллагааг бэхжүүлэх

2012.09.20-нд Сүхбаатар сумын сургуулийн номын санч нарын дунд туршлага солилцох, ярилцах, аргазүйн зөвлөгөө авах цагийг зохион байгуулж, шинэ номын санч нарыг танилцуулсан нь номын санч нарын ажлын идэвхийг сайжруулах, харилцан туршлага солилцох, хамтарч ажиллах, хамт олонч уур амьсгал бүрдүүлэхэд ач холбогдолтой ажил болсон тул “Бид хамтдаа” уриатай туршлага солилцох, ярилцлага зохион байгуулах өдрийг улирал бүр зохион байгуулж байхаар тогтлоо.

“Соёлын ажилтны өдөр”-өөр зохион байгуулсан гар бөмбөгийн тэмцээнд бэлдэх ажилд оролцож Сүхбаатар сумын 2,6-р сургуулийн номын сангийн номын санч нарыг хамруулан идэвхитэй оролцууллаа.

Сум сургуулийн номын санч нарыг цахим шуудан ашиглан мэргэжлийн зөвлөгөө авах, туршлага солилцох ажлыг хэвшүүлэхээр ажиллаж байна.

Г. Номын санч нарт зориулсан аргазүйн гарын авлага, мэдээлэл бэлтгэх

Номын санч нарт зориулан мэргэжлийн туслалцаа үзүүлэх гарын авлага болгон “Номын санд мөрдөгдөж байгаа хууль, стандарт”, “Номын фонд, хадгалалт хамгаалалт” гарын авлага боловсруулаа.

“Аргазүйн ажлын мэдээлэл”-ийн самбарт номын сангийн талаарх хууль эрхзүй, шинэ мэдээ, туршлагын талаарх мэдээллийг гаргаж байна.
Сум сургуулийн номын санч нарын судлагаа, бүртгэлийг шинэчлэв. Номын санч нарын мэдлэгийг шалгах 3 төрлийн тест бэлтгэлээ.

“Аргазүйн ажлын мэдээлэл самбар”-т номын сангийн талаарх хууль эрхзүй, номын сангийн талаарх шинэ мэдээлэл, туршлагын талаарх мэдээллийг тавилаа.

Номын санч нарт зориулан “Номын фонд, хадгалалт хамгаалалт” гарын авлага боловсруулаа.

№	Арга зүйн ажил	Тоо хэмжээ
1.	Арга зүйн зөвөлгөө	82
2.	Гарын авлага зөвлөмж	18
3.	Сургалт семинар	3
4.	Зохион байгуулсан ажил	5

Гурав . Ном зүйч фондын ажил

Номын фондын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, номын мэдээ мэдээллийг олон нийтэд сурталчлах, уншигчдийн тоог нэмэгдүүлэх зорилготой ажиллалаа.

6-р сард номын фонд ном зүйн ажлыг журмын дагуу тооллого хийн хүлээж авлаа. Тооллогын дараа фондыг эмхэлж цэгцлэх холилдсон эмх замбараагүй номыг тавиур дээр ангиллын дагуу байрлууллаа.

Үндэсний номын сангаас ирсэн 2011 оны сонгон шалгаруулалтанд шалгарсан 603 ш номыг хүлээн авч Сумын номын сангуудад хувиарлан өглөө. Засаг даргын тамгын газраас хандиваар ирсэн 20 ш ном, Хүүхдийн номын ордноос хандивласан 46 ш ном, Худалдаанаас авсан 242 ш 2,010,950 төг-ийн шинэ номыг хүлээн авч нийт 514 ш 4.879.670 төгрөгний номоор фондоо баяжууллаа.

9-р сарын 01 нд ”Эрдмийн баяраар”- аар Уншлагын танхим, Хүүхдийн уншлагын танхимтай хамтран шинэ номын үзэсгэлэн 35 номоор гарган “Хүнсний ногоо, жимс жимсгэнэ нөөцлөн хадгалах” мөн шинэ номоор санамж өгөх ном зүйн бүртгэл гарган сурталчлав.

“Номын хур” удирдамжийн дагуу МСҮТөвтэй хамтран 7 хоногийн ном сурталчлах өдөрлөг” Ном бидний найз” аяны хүрээнд зохион явуулав. Үүнд: МСҮТөвийн багш сурагчдыг аймгийн нийтийн номын сангийн уншигч хамт олон болгон уншигчийн карт нээх, асуулт хариултын уралдаан, олон уншигчтай хамт олныг шалгаруулах ажлыг зохион байгуулж нийт 40 багш сурагчдад шинээр карт нээн 40000 төг-ийн орлого, 6-р сургуулийн 5 багш сурагчдад карт нээн 5000 төг, 5-р сугуулийн 5 сурагчдад карт нээн нийт 50000 төг-ийн орлого оруулав.

Ном хэвлэлийг данснаас хасах журмын дагуу 750 ш номын жагсаалт хийлээ.

Номын баярын арга хэмжээнд шинэ номын үзэсгэлэнд фондноос 30ш номоор үзэсгэлэн гаргалаа. Соёлын ажилтны баярыг угтсан уралдаан тэмцээнүүдэд удирдамжийн дагуу бэлтгэл хийж оролцлоо.

Их Эзэн Чингис хааны мэндэлсний 850 жилийн ойд зориулан” Их хаад”-ын 11 ботиор “Тэмүүжин- Чингис бол монголчууд бидний хаан бахархал юм” санамж өгөх ном зүйн бүртгэл хийлээ.Ном зүйн өгөдсөн лавлагааны бүртгэл, нэгдсэн бүртгэлээ зохих журмын дагуу хөтлөн ажиллаж байна. Номын фондын 200 гаруй номонд ариутгал хийж, фондын өрөөний агаар, чийгийг хянан ажиллалаа.

№	Фонд бүрдүүлэлт	Тоо ширхэг, нэр төрөл	Үнэ
1.	Шинэ ном	514	4,879,670₮
2.	Сонин	6-10	408,000₮
3.	Сэтгүүл	2-4	168,000₮
4.	**нийт**		**5,455,670₮**

Номзүй, лавлагаа-мэдээлэл

А. Номын техник ажиллагаа

71ш ном нь хандиваар ирсэн ном хэвлэл үнэлэх журмын дагуу үнийг нь тогтоолоо.

Б. Лавлагаа

Нийтийн номын санд хадгалагдаж байгаа ховор номын бүртгэлийг шинэчлэн “Алтангэрэл”, “Бээжинбуяндалай”, “Галын судар”, “ Дэмбэрэл” гэх зэрэг нийт 13ш судрыг бүртгэн, судар тус бүрийн зургийг хавсаргалаа.Дээрх 13ш судрыг бүртгэл мэдээллийн сангийн хуудсанд бүртгэж, судар тус бүрийн видео бичлэгийг хийлгэн CD-нд буулгуулан хадгаллаа.

Өгөгдсөн лавлагааны санг нэмэгдүүлж, уншигчдад ном хэвлэлийн талаарх мэдээллийг хүргэн, эрэлт хүсэлтэнд нь хариулт өгч нийт 270ш лавлагаа өглөө.

В. Номын мэдээлэл-сурталчилгаа

Нийтийн номын санд шинээр бүрдүүлсэн 118 ш номоор шинэ номын мэдээ 3 удаа гарган “Мэдээллийн самбар” болон уншлагын танхимд байрлуулж

уншигчдад танилцуулав. Мөн Нийтийн уншлагын танхимд “Шинэ номын үзэсгэлэн” 3 удаа гаргалаа.

Уншигчдад зориулан номыг зөв уншиж сурах талаарх зөвөлгөөнүүдийг оруулсан “Ном яаж унших вэ” зөвлөмжийг “Түргэн уншиж сурах”, “Сонгодог бүтээл унших”, “Уншигчдын мөрдлөг болговол зохих 12 алтан дүрэм” гэсэн 3 төрлөөр бэлтгэж, нийтийн номын санд уншигч бүртгэх журам, үйлчилгээний тариф, цагийн хуваарь, ажилтнуудын утасны жагсаалт, номын сангийн хаяг, утас зэрэг мэдээллүүдийг багтаан боловсруулж уншигчдын хүртээл болголоо.

Номын санд 2011 онд шинээр бүрдүүлсэн номыг иргэдэд сурталчлах, нийтийн хүртээл болгох, номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор уншигчдын сонирхол, талархалыг хүлээсэн номуудаар “Шилдэг ном” ном сурталчилгааны ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд, уншигчдын сонирхолыг ихээр татаж байгаа “Дэлхийн түүх” , “Ертөнцийн түүхийн тайлагдашгүй нууцууд”, “Монголын түүхийн алтан нууц”, “Дэлхийн түүхийн нууц” зэрэг номууд болон бусад шинэ номуудыг олон нийтэд сурталчлах зорилгоор Дэлхийн түүхийн сэдэвт “Алтан хонх” асуулт, хариултын уралдааныг Сүхбаатар сумын ЕБС-иудын 7-р ангийн сурагчдын дунд 2012 оны 01 дүгээр сарын 30-нд зохион байгууллаа.

Уралдаанд Сүхбаатар сумын 1,2,4,5-р сургуулийн нийт 20 хүүхэд оролцсоноос 1-р сургуулийн 7в ангийн сурагч Г.Амаржаргал мэдлэгээрээ шалгарч Тэргүүн байр эзэллээ.

Уралдаанд оролцогчдод зориулан шинэ болон түүхийн сэдэвт номын үзэсгэлэн гаргах, номын сан, ном хэвлэлийн талаарх мэдээллийг хүргэх, “Ном яаж унших вэ” зөвлөмжийг тараах, Боловсрол суваг, Миний монгол телевизээр “Алтан хонх” асуулт, хариултын уралдааны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх зэрэг ажлуудыг зохион байгууллаа.

Аймгийн Нийтийн номын сан, Боловсрол соёлын газар, Номын садан сангаас хамтран зохион байгуулсан “Сэлэнгийн зохиолчдыг хэн сайн мэдэх вэ” асуулт хариултын уралдааныг зохион байгуулж, Нийт уншигчидын ангилалд Сүхбаатар сумын иргэн Н.Түмэнжаргал, сургуулийн дунд ахлах ангийнхний ангилалд Сүхбаатар сумын 10б ангийн сурагч М.Мөнхжаргал түрүүллээ.

Аймгийн нийтийн номын сангийн аргазүйч, номзүйч, номын санч нарын дунд зохион байгуулсан номын сангийн уншигчдын тоог нэмэгдүүлэх “Номын хур” аяны хүрээнд 2012,09,19-09,24-ний өдрүүдэд номын сангийн уншигчдын тоог нэмэгдүүлэх, номын сангийн үйлчилгээ, хөмрөгийн ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах, иргэдэд ном унших, номын сангаар үйлчлүүлэх сонирхол төрүүлэх зорилгоор уншигчдын дунд номын тойм яриа, мэдээлэл хийж, номыг зөв уншиж сурах талаар болон номын сангийн үйлчилгээний талаар мэдээллийг багтаасан “Ном яаж унших вэ” зөвлөмжийг уншигчдад тараан, 50ш номоор номын үзэсгэлэн гаргаж зөөврийн номын сангаар үйлчлэн нийт 31 хүнд карт нээж, 33ш ном олгон номын сангийн уншигч болголоо. Үүнд: 2-р сургуулийн сурагчид, Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн даатгал, Стандарт хэмжилзүй, ХААН газрын ажиллагсад, 6-р багийн иргэдийг хамруууллаа.

Номын сангаа сурталчлах, сурагчдыг ном унших сонирхолтой болгох зорилгоор Сүхбаатар сумын ЕБС-ийн сурагчдын дунд “Ном бидний амьдралд ямар хэрэгтэй вэ” зохион бичлэгийн уралдаан зарлалаа.

№	Номын ашиглалт хамгаалалт	Тоо хэмжээ
1.	Номын солилцоо	120
2.	Ном сэлбэн засалт	2200
3.	Шинэ номын үзэсгэлэн	18

Сум, сургуулийн номын санч нарт мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж Хушаат, Дулаанхаан, Сант, Түнхэл, Цагаан нуур гэх мэт сумдын нийт 18 номын санч нарт биечлэн болон утас, цахим шуудан ашиглан зөвлөгөө өглөө. Үүнд: Номын сангийн анхан шатны бүртгэл хөтлөлт, номын сангийн номын фондын нөхөн бүрдүүлэлт, номын санд мөрдөгдөж байгаа хууль, эрх зүй, стандартын талаар номын санч нарт зориулан мэргэжлийн туслалцаа үзүүлэх гарын авлага болгон "Номын санд мөрдөгдөж байгаа хууль, стандарт" – аар гарын авлага бэлдлээ.

"Аргазүйн ажлын мэдээлэл"-ийн самбарт номын сангийн талаарх хууль эрхзүй, шинэ мэдээ, туршлагын талаарх мэдээллийг гаргаж байна.

Сант сумын соёлын төвийн номын сан нь алслагдсан сум, багийн иргэдэд нүүдэл, зөөврийн номын сангаар үйлчлэх, уншигчдын дунд төрөл бүрийн соёл олон нийтийн ажлыг зохион байгуулах, ном унших, номын сангаар үйлчлүүлэх сонирхол төрүүлэх тал дээр шинийг санаачлан идэвхи чармайлттай ажиллаж байгаа тул тухайн номын сангийн туршлагын талаарх мэдээллийг аргазүйн танхимын "Аргазүйн мэдээлэл" самбарт байрлуулж, номын санч нарт танилцуулж байна.

Сумдын номын сангуудад нөхөн бүрдүүлэх шаардлагатай байгаа номын судалгаа болон уншигчийн ширээ сандал хэрэгцээтэй байгаа номын сангуудын судалгааг гаргалаа.

Номын сангаа сурталчлах, сурагчдыг ном унших сонирхолтой болгох зорилгоор Сүхбаатар сумын ЕБС-ийн сурагчдын дунд "Ном бидний амьдралд ямар хэрэгтэй вэ" зохион бичлэгийн уралдаан зарлалаа.

Фонд бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт: Номын санд шинээр худалдан авсан болон Хүүхдийн номын ордон, Тэнгэр баатар хэвлэх үйлдвэр болон бусад газраас хандиваар ирсэн ном хэвлэлээр фонд бүрдүүлэлт хийлээ.

"Номын фондын өрөөнд цэвэрлэгээ, ариутгал хийх, агаарын чийг дулааныг хэмжих, тохируулах ажлын хуваарь" гарган номын сангийн захирлаар батлуулан ажиллаж, фондын ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтанд анхаарч, фондын өрөөнд чийгтэй цэвэрлэгээ тогтмол хийлгэлээ.

Фондоос уншлагын танхим, гэрээр ном олгох тасагт уншигчдын хэрэгцээт ном, тогтмол хэвлэлийг олгож үйлчиллээ.

Үндсэн фондтой харилцах дэвтрээр байнга уншигчдад үйлчиллээ. Ойрын фондын номыг цэгцэлж,ялган уншигчдын хэрэгцээ,шаардлага хангахгүй болсон номыг журмын дагуу данснаас хасах ажлыг хийж гүйцэтгэн,ойрын фондын болон уншигчын картны ялгагчыг шинээр солилоо.

Номын сангийн өдөр тутмын бүртгэлийг стандартын дагуу хөтөлж, татгалзалын дэвтрийг байнга ажиллуулж байна.

Lib4U номын сангийн цогц програм хангамжтай танилцаж электрон номын сан болон электрон каталог байгуулан интернэт болон дотоод сүлжээндээ байрлуулж уншигчдадаа ашиглуулах, Цахим номын сан болгох зорилт тавин ажиллаж,сар болгон төлөвлөгөөний дагуу 50 ширхэг ном бүртгэн байршуулж байна.

Lib4U програмдаа байршуулан зураасан код хэвлэхэд бэлэн болгов. 2012 оны 4-р улирлын хэвлэлийг 8 төрлийн сонин 3 төрлийн сэтгүүлээр нийт 134400 төгрөгний хэвлэлийг захиалан 1,2,3-р улирлын 4 төрлийн хэвлэлийг үдэж хавтаслан фондод хүлээлгэн өглөө.

Ном сэлбэн засалт:

Уншигчдын гар дээр уншигдаж байх явцад урагдаж гэмтсэн болон, ярлык , уут, промляр нь алга болсон 725 ш номонд сэлбэн засалт хийлээ.

Мөн хортон шавьж үүрлэхээс сэргийлж жилд хоёр удаа фондод их цэвэрлэгээ хийж, ном хэвлэлдээ 2%-ийн хлорамины уусмалаар ариутгал хийлээ.

Шинээр бүрдүүлсэн 118 ш номыг нэгдсэн бүртгэл болон нэг бүрчилсэн бүртгэлд зохих журмын дагуу данслан, ангилж, зохиогчийн тэмдэгт, уут нааж, формуляр бичин техник ажиллагаа хийлээ

Фондын номын ялгагчууд хуучирч ашиглалтын шаардлага хангахгүй болсон байсан тул шинэчлэн нийт 210ш ялгагч шинээр хийж ашиглалаа.

Урагдаж гэмтсэн 125 номонд сэлбэн засалт хийлээ.

Тооллого хиив:

Нийтийн номын сангийн захирлын тушаалын дагуу тооллогын комиссоор томилогдон ном зүйч Ч.Үзмээ ахлах номын санч Т.Нарандалай арга зүйч А.Оюунсүрэн нартай хамтран 2012 оны 06-04-ний өдрөөс тооллогын ажил эхлэн 2012 оны 07-01-ний өдөр дуусч ,тооллогын үеэр тоологдоогүй үлдсэн номыг шүүх ажлыг хийн ойрын фондын номыг цэгцэлж,фондноос гнот-ын номыг ялган авч тавиурт байрлуулав.

Албан хаагчдын ашиглаж байгаа эд хөрөнгийн тооллого"- д хамрагдан өөрсдийнх нь ашиглаж буй эд хөрөнгө, техник хэрэгсэлийг тоолууллаа.

Каталог:Номын санд шинээр бүрдүүлсэн 118ш номонд карт бичин каталогт байрлуулаа.

Каталогийн шүүгээг цэвэрлэж, төрөл ангийн болон үсэг дараалльн каталогийн картын байрлалд хяналт хийлээ.

Дөрөв. Мэргэжил дээшлүүлэлт

2012.04.09-11-ний хооронд Үндэсний номын санд зохион байгуулагдсан "Номын сан-мэдээллийн технологи" сэдэвт 24 цагийн сургалтанд оролцож, "Коха" программ, блог хийх зэрэг шинэлэг мэдээллүүдээс суралцан, Улаанбаатар хотын Нийтийн номын сангаас туршлага судлалаа. 2012.04.16,17,18-нд МХГ-ын шалгалтанд ажлаа шалгууллаа.

Монголын үндэсний номын сангаас 2012 оны 04 дүгээр сарын 09-өөс 11-ний хооронд зохион байгуусан "НОМЫН САН –МЭДЭЭЛЭЛИЙН ТЕХНОЛОГИ" сэдэвт 3 өдрийн сургалтанд хамрагдаж номын сангийн шинэ программ хангамжтай танилцаж, суралцан шинэ мэдээ мэдээлэл олж авлаа.

Мөн интернетээр дамжуулан fecbook сайтад орон Монголын номын санчид хуудсанд нэгдэн СУИС-ын номын сан хариуцсан тэнхимийн эрхлэгч Т.Хайдав болон бусад аймгийн номын санчидтай санал бодлоо солилцож байна

Тав .Соёл олон нийтийн ажил, номын сурталчилгаа

Номын сангийн хүүхэд үйлчилгээг, хүүхэд багачуудад олон төрлийн сонирхолтой арга хэлбэрээр үзүүлэх зорилгоор, тэдний үзэх дуртай хүүхэлдэйн киноны сидигээр үзэсгэлэн гаргаж,"Үнсгэлжин " кино, шүлэг, найраглалыг проектроор үзүүллээ.

Соёл урлагын ажилтны баяраар "Номын баяр "номын нээлтийн үйл ажилгаанаар хандивийн 40 ширхэг номыг иргэдэд тараан номын сангаа суртчилан таниулав .

"Номын хур"10 хоногийн аяны удирдамжийн дагуу 9,10-р сарыг номын сангийн уншигдын тоог нэмэх зорилгоор 3-р сургуулийн багш сурагчдыг анги хамт олноор нь нийтийн номын сангийн уншигч болгон нийт 49 карт нээн амжилттай ажиллаж шинэ номын мэдээлэл хийлээ. Мөн шинээр ирсэн номын үзэсгэлэнг танхимдаа цаг тухайд нь гаргаж уншигчдад танилцуулж ирлээ.

Хичээлийн шинэ жилд зориулж "Нээлттэй хаалганы"өдрийг зохион байгуулж ахлах ангийн сурагчдын дунд "та та тунгаа" асуулт хариултын тэмцээн зохиосноор 1-р байранд 2-р сургуулийн сурагч Ц.Дэлгэрмаа 2-р

байранд Б.Номин эрдэнэ 3-р байранд Ж.Дөлгөөн тусгай байранд М.Мөнхжин нар тус тус орж шагнал гардууллаа.

Шинэ номын болон Сэлэнгэ аймгийн орон нутгийн талаар номын үзэсгэлэн гаргаж нийт уншигчдад суртчилан таниулж гэрээр олгож үйлчиллээ.

Сүхбаатар сумын 2-р сургуулийн номын сан нь 2011-2012 оны хичээлийн жилд ажлаа жил, улирал, сараар төлөвлөн ажиллаж, давхардсан тоогоор 2998 уншигчид 6289 ном хэвлэлээр үйлчилжээ. Номын сангийн анхан шатны бүртгэлүүдийг зохих журмын дагуу хөтөлж, жилд 29 төрлийн 296100 төг-ийн ном хэвлэл захиалан ажиллажээ. Хүүхэд багачуудын оюун ухааныг хөгжүүлэх, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх зорилгоор СОТА-ыг олон хэлбэрээр хийлээ.

Нийтийн номын сангийн уншлагийн танхимд 2012 оны 01 дугаар сарын 27 өдөр уншигчдын хүрээг тэлэх,тоог нэмэгдүүлэх,номын санд хадгалагдаж байгаа ном хэвлэлийг танилцуулах зорилгоор төрөл бүрийн ажил зохион байгууллаа. Үүнд:

“Өөдрөг үзэл ба амжилт Нийгмийн сэтгэл зүй” сэдэвт урилгат кофет уншилгад 11-н байгууллагын 11 хүнд карт нээн өөрийн уншигч болгон шинэ мэдээ,мэдээлэл хийн ажиллаа.

Уншигчдын хүрээг тэлэх,алслагдсан сумын иргэдэд хүрч үйлчлэх зорилгоор аймгийн музей,Шаамар сумын соёлын төвийн номын санчтай хамтарч тус сумын иргэдэд “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж номын сангаа танилцуулж шинэ болон шилдэг номын үзэсгэлэн гаргаж нийт 98 хүн хамрагдлаа.

“Номын баярын өдөр”-ыг зохион байгуулав.

Жил бүр уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлдэг “Соёлын ажилтны өдөр”-ийг тохиолдуулан 2012.09.27-нд "Номын баярын өдөр”-ийг зохион байгуулах ажилд оролцлоо. “Номын баярын өдөр”-өөр номын солилцоо, хуучин номын худалдаа, номын баярын өдрийн хөтөлбөр, хөтлөгчийн үгийг бэлдэх болон “Тэргүүний уншигч- Нацагдорж тэмдэг”-ээр шагнуулах сурагчдын шагналыг бэлдэх ажлыг хариуцан ажиллаа.

Номын солилцоо, хуучин номын худалдаанд Сүхбаатар сумын 1,2,4,6-р сургуулийн номын санч нар болон нийт 60 гаруй сурагчийг хамруулан сурагчид өөрсдийн номыг хоорондоо солилцон унших болон хуучин номоо худалдлаа.

“ Тэргүүний уншигч Нацагдорж тэмдэг”-ээр 1-р сургуулийн 4г ангийн сурагч Алтансүхийн Тэлмэн, 2-р сургуулийн 6а ангийн сурагч Амарсайханы Оюунсайхан , 2-р сургуулийн 4а ангийн сурагч Жаргалсайханы Оргил, 2-р сургуулийн 5б ангийн сурагч Б. Халиун, 2-р сургуулийн 6а ангийн сурагч Ганхүүгийн Баянхангай, 4-р сургуулийн 5в ангийн сурагч Дүгэр сайханы Тэлмэн, 4-р сургуулийн 5в ангийн сурагч Дүгэр сайханы Тэргэл, 6-р сургуулийн 9б ангийн сурагч Мягмарын Мандахнар, 6-р сургуулийн 9а ангийн сурагч Б. Энхтөр, 6-р сургуулийн 11б ангийн сурагч Ганхуягийн Оч-эрдэнэ нар нийт 10 сурагч шагнагдлаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдрийг тохиолдуулан СБ сумын 4-р цэцэрлэгийн ахлах ангийн хүүхдүүдийн дунд “Миний сайхан ээж” сэдэвт шүлгийн уралдааныг явуулж нийт 28 хүүхэд оролцноос Э.Зэлмэн түрүүллээ.

Хүүхдийн зохиолч З.Түмэнжаргалын Гэмшил номоор “зохиолч хүүхдүүд” сэдэвт зохион бичлэгийн уралдааныг 12-н жилийн 2-р сургуулийн 7/б/анги, 1-р сургуулийн 7/а/ангид зохион явуулж нийт 48 хүүхдэд оролцсоноос Ж.Уранжаргал,Б.Бадамгарав нар түрүүллээ.

Сэлэнгэ аймгийн сум, сургуулийн номын санч нараас 2012 оны ажлаараа шалгарч Аймгийн номын сангийн “Номын гэгээ” шагналаар Сант сумын Соёлын төвийн номын санч М.Жаргалсайхан шагнагдлаа.

Номын баярын өдрөөр “Сэлэнгийн долгио” чуулгын байранд 80 номын үзэсгэлэн гаргаж 200-аад иргэдэд үйлчиллээ.

№	Соёл олон нийтийн ажил	Тоо хэмжээ	Хамрагдсан тоо
1.	Хүүхэд	14	108
2.	Насанд хүрэгчид	8	198
3.	Нийт	22	398

Зургаа . Байгууллагын тохижилт, хөрөнгө оруулалтын талаар

Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар Тендерт шалгарсан Улаанбаатар хотын “Экструд Констракшн” компанитай хамтран 20.000.000 тагрөгийн тохижилтийн ажлыг хийж, уншлагын танхим арга зүйн танхим, номзүйчийн өрөө, захиралын өрөөний тавилга хэрэгсэлийг шинэчлэн тохижуулж, номын худалдааны шилэн павилоныг бариулав.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулсан “Олуулаа уншъя” уриатай номын баярт оролцож, БСШУ-ны яамны хөрөнгө оруулалтаар олгосон явуулын номын сангийн үйлчилгээнд зориулсан 20.400.000 төгрөгийн үнэлгээтэй пургон авто машиныг хүлээн авч, “Олуулаа уншъя”сэдэвт номын баярыг өөрийн аймагтаа зохион байгуулж 600 гаруй иргэдийг хамруулан нийт шинэ номын үзэсгэлэн гарган номын өглөг хандивыг зохион байгуулан, мөн шинэ номын худалдаа зохион байгуулав.

Сэлэнгэ аймгийн засаг даргын шийдвэрээр номын сангийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах,фонд баяжилтыг нэмэгдүүлэхээр олгосон 10.000.000 төгрөгөөр номын сангийн стандарт шаардлага болон мэргэжлийн хяналтын газрын хяналтын хуудсаны дагуу хамгийн өндөр үзүүлэлттэй шаардлага болох номын сангийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор номын сангийн гадна дотор нийт 10 ширхэг 7.393.050 төгрөгийн камер бусад дагалдах хэрэгсэлийн хамт суурилуулах ажлыг зохион байгуулж, нийт 110 нэр төрлийн нийт 2.010.950 төгрөгийн ном худалдан авалтыг зохион байгуулан, номын сангийн гэрэлтүүлэг хангалтгүй стандарт шаардлагыг хангахгүй байсан тул нийт 22 ширхэг сайн чанарын гэрэлтүүлэгийг уншлагын танхим болон өрөөнүүдэд суурилуулан гэрэлтүүлгийн стандартыг хангах ажлыг нийт 596.000 төгрөгөнд багтаан хийлээ.

Өвөлжилтын бэлтгэл болон номын сангийн сантехникийн гэмтэж хагарсан секц трубануудыг солих гагнах ажлыг хийлээ.

№	Хөрөнгө оруулалт	Үнэ	Хаанаас санхүүжсэн
1.	Тохижилт	20.000.000₮	Аймаг хөгжүүлэх сан
2.	Камер	7.393.050₮	Аймаг хөгжүүлэх сан
3.	Пургон	20.400.000₮	БСШУЯ
4.	Канон	1.300.000₮	ССАЖЯ
5.	принтр	350.000₮	БСШУЯ
6.	Номын тавиур	5.000.000₮	ССАЖЯ
	нийт	**35,183,050₮**	

Бичиг хэрэг, архивын ажил:Номын сангийн даргын тушаал болон албан бичиг бусад бичиг баримтыг бичиж боловсруулаа.

Номын сангийн 2011 оны баримт бичиг болох “Ирүүлсэн бичиг”, “Явуулсан бичиг”, “Захирлын тушаал”, “Ажлын тайлан”, “Хөдөлмөрийн гэрээ”, “Ажлын байрны тодорхойлолт” нийт 6 төрлийн баримтыг үдэж хавтаслав.

Архивын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, байнга хадгалах, түр хадгалах баримтын жагсаалт гарган “Архивын үзлэг шалгалт”-нд хамрагдлаа.

2012.04.16,17,18-нд хамрагдсан МХГ-ын үзлэг шалгалтын “Хяналт-шалгалтын хуудас”-нд заагдсаны дагуу Нийтийн номын сантай холбоотой материалыг бүрдүүлж хавтсанд хийж, товъёог хийлээ.

Нийтийн номын сангийн “Ажилтан, албан хаагчдын судалгаа” гаргалаа.

Тайлан мэдээ гаргалт:Номын сангийн 2011 оны СУ-3, СУ-10, СУ-15 мэдээнүүдийг боловсруулж БСШУЯ, Үндэсний номын сан, БСГ-т, номын сангийн 2011 оны тайланг боловсруулж Үндэсний номын санд хүргүүлж, номын сангийн 1-р улирлын ажлын тайланг боловсрууллаа.

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн 2011 оны онцлох үйл явдлын тухай мэдээг гарган АЗДТГ-т хүргүүллээ.

Төв аймгийн Нийтийн номын сангийн 2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайлан.

2013-01-03

Зуунмод

2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 9-н зорилт, 38 хэрэгжүүлэх арга хэмжээг тусган, хэрэгжилтэд нь хяналт тавин ажилласны үр дүнд хэрэгжилт 100% байна.

Нэг: Аймгийн нийтийн номын сан нь үйлчлүүлэгчдэд цаг тухай бүр мэдээллийг тасралтгүй чөлөөтэй олж авах боломжийг нэмэгдүүлнэ.

1. Нийтийн номын сан нь 2012 оны байдлаар үйлчилгээндээ 2775 байнгын уншигч, 14481 ирэгсэд, нийт-17761 уншигчдад 33698 ном, хэвлэл, мэдээллийн материал олгож уншуулсан нь 2011 оны мөн үеэс уншигчдын тоо 3,8%-иар өссөн байна.
2. Нийтийн номын сангийн үйл ажиллагааны талаар 6 санал асуулга бүхий судалгааг улирал бүр 14 хоногийн хугацаатай явууллаа. Уг судалгаанд янз бүрийн насны төрөл бүрийн мэргэжлийн нийт 200 хүн хамрагдсан. Үүнд:
    1. Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийг номын сангаар үйлчлүүлдэг-62%, хааяа үйлчлүүлдэг- 35%, үйлчлүүлдэггүй- 3% тус тус эзэлж байна.
    2. Манай сан хөмрөгт байгаа ном, хэвлэл таны мэдээлэл авах хэрэгцээг хангаж чадаж байна уу гэсэн асуултан иргэд: Хангаж чаддаг-92%, Дунд зэрэг-8%, хангаж чаддаггүй-0% гэсэн хариултыг өгчээ.
    3. Номын сангийн тохижилт үйлчилгээ болон тав тух, заалны ном сонголт хэр байна вэ? гэсэн асуултанд: 75%- сайн, 16%- боломжийн, 9%- муу гэж хариулсан
    4. Харилцааны соёл, зан төлөвийн талаарх асуултанд: Маш сайн-91%, боломжийн-9%, тааруу-0% гэсэн хариултын өгсөн.
    5. Номын сангаас уншигчдын дунд зохион явуулдаг соёл чөлөөт цагийн ажилд оролцож байсан уу? Цаашид ямар ажил зохион явуулбал хэрэгцээтэй вэ? гэсэн асуултанд: 36% - оролцож байсан, 64% - оролцдоггүй гэж хариулсан ба цаашид сонирхолтой оюун ухаан сорьсон тэмцээн, зохион бичлэгийн уралдаан, бага ангийн сурагчдын

дунд хурдан уншлагын тэмцээн зэргийг зохион явуулах гэсэн саналуудыг гаргасан.

6. Уншигчдын ном уншилтын сонирхол ямар чиглэлийн ном, гарын авлага унших хүсэлтэй байна гэсэн судалгаанд:

   - Хүүхдэд зориулсан ном зохиол гарын авлагад: Танин мэдэхүй, сэтгэхүй хөгжүүлэх- 19%, Монголын болон дэлхийн шилдэг уран зохиол- 25%, Гадаад хэл- 16%, Түүх ёс заншил- 15%, Байгаль, нийгэм, мэдээлэл харилцаа холбоо, техник технологи- 16%, Толь бичиг, нэвтэрхий толь, лавлагааны материал- 9%-г эзэлж байхад

   - Нийтийн уншигчдад зориулсан ном зохиол гарын авлагад Уран зохиол- 26%, Менежмент, маркетинг- 11%, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, мэдээлэл харилцаа холбоо, техник технологи- 17%, Амьдрах ухаан, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх- 23%, Эдийн засаг, санхүү, эрхзүй- 7%, Гоозүй, ёсзүй, эрүүл мэнд-10%, Нийгэм улс төр- 5%, Бусад салбарын зайлшгүй хэрэгцээтэй ном, зохиол гарын авлага- 1% -г тус тус эзэлж байлаа.

   Судалгаанд үндэслэн байгууллагынхаа үйл ажиллагаандаа дүгнэлт хийхэд:

   - ЕБС-н сурагчдын дунд сонирхолтой тэмцээн зохиохоор гадна түүний хажуугаар төрөл бүрийн уралдаануудыг зарлах

   - Уншигч үйлчилүүлэгчдын номын сонирхол, хэрэгцээ шаарлагага, судалгаан дээр тургуурлан ном худалдан авах, захиалах, фонд бүрдүүлэлт хийх

   - Номын сангийн тохижилт, тав тухтай орчинг бүрдүүлэх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Хоёр: Мэдээлэл, лавлагаа, ном зүйн үйлчилгээ

1. Төв аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг угтаж өөрийн номын санд захиалдаг өдөр тутмын сонин “Зууны мэдээ”, “Өдрийн сонин” сонинд нийтлэгдсэн төв аймгийн тухай материал болон орон нутгийн сонингоос Төв аймгийн талаар нийтлэгдсэн онцлог үйл явдлын талаархи 93-н мэдээллийн материалаар “Төв аймаг хэвлэлийн хуудаснаа” цуврал №1, №2 ном зүйн гарын авлагыг гаргалаа.
2. Лавлагаа мэдээллийг электрон каталоги, картын сан, лавлагааны материал ашиглан 652 хүнд лавлагааг амаар, бичгээр, цахим хэлбэрээр өгч лавлагааны дэвтэрийг хөтөлж, электрон каталоги ашиглах номын захиалга хуудас бичих талаар зөвлөгөө өгч, номын санд байхгүй номын татгалзалын дэвтэрийг хөтөлнө.
3. Номын санд зайлшгүй хөтлөгддөг БСШУЯамны 441 тоот тушаалын дагуу нэгдсэн, нэг бүрчилсэн, өдөр тутмын бүртгэл, өгөгдсөн лавлагаа номзүй бүртгэл, татгалзлын дэвтэр, уншигчын карт, Номын сан хоорондын ном солилцооны бүртгэл, Фондын ном тоолсон тухай акт, Үрэгдүүлсэн номын оронд авсан номын бүртгэл, захиалга хуудас, Номын формуляр зэрэг анхан шатны 17 бүртгэлийг стандартын дагуу бүртгэж үйл ажиллагаагаа явуулж байна.

4. 2012 онд үндсэн фондын 22750 ш, гэрээр ном олгох танхимын 1474ш номыг тоолж данс болон ангилал зөрсөн 655ш номыг нэг бүрчилсэн бүртгэлтэй тулгаж зөрүүг арилгаж стандартын болгож урагдаж гэмтсэн 66 ш номонд сэлбэн засалт хийсэн.

Гурав: Үйл ажиллагааны чанарыг сайжруулж, үйлчилгээг өргөжүүлэх.

1. Аймгийн Нийтийн номын сангаас соёл олон түмний 6-н ажил зохион байгууллаа. Үүнд:
   I. Аймгийн Нийтийн номын сан, ахмадын хороо, аймгийн зохиолч сэтгүүлчдийн салбар хамтран Зуунмод хотын 70 жилийн ойг угтаж “Эрдэм номоо дээдлэе” арга хэмжээг 2 төрлөөр зохион явууллаа.
      a. Зуунмод суманд ажиллаж амьдарч буй зохиолч яруу найрагчдын 2011 онд гаргасан шинэ бүтээл болон албан газар аж ахуйн нэгжүүдийн өөрийн байгууллагын тухай танилцуулга, олон нийтэд мэдээлэл хүргэхээр гаргасанном, товхимол, сэтгүүлийн үзэсгэлэн гаргаж олон нийтэд сурталчлан таниулсан шилдэг бүтээл шалгаруууллаа. 2011 оны шилдэг бүтээлээр Ш.Цэрэндоогийн “Их Монголын хөлгөлсөн их шар тууж” шалгарч удаах байранд С.Баярсайханы “Есүүлээ”, ТЗХУХэлтэсээс гарсан “Та үүнийг мэдэхүү” цахим эмхэтгэл тус тус орлоо.
      b. Аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг угтан “Найргийн хур” яруу найрагчдын уралдаан зохион байгуулж байгаатай уялдан Зуунмод сумын яруу найрагчдын “Найргын хур 2012” шүлгийн уралдаан зохион явуулж 1-р байранд С.Ариунзул, 2-р байранд Б.Бадамжав, 3-р байранд Самдан нар орлоо.
   II. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны196 дугаар тогтоол “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-II”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Монгол Улсын ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, аймгийн Засаг даргын 2012 оны 01/513 тоот албан даалгаврын дагуу Зуунмод сумын “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг 2012.05.04-ний өдөр Зуунмод сумын ЗДТГ, БСГ, Нийтийн номын сан хамтран, монгол бичгийн сургалтын чанарыг сайжруулах, суралцагч, төрийн албан хаагч, иргэдийн сурах сонирхлыг өрнүүлэх, монгол бичгийг түгээн дэлгэрүүлж сурталчлах, хэрэглээ болгоход чиглүүлэн ЕБС-ийн суралцагч, багш нарын дунд Монгол Улсын гавьяат багш Т.Гаваагийн нэрэмжит монгол бичгийн бүсийн VII олимпиад, Зуунмод сумын төрийн албан хаагч, иргэдийн дунд “Монгол бичигтэн баг” тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа.“Монгол бичигтэн баг” тэмцээнд 3М сумын төрийн албан хаагч, иргэдудирдамжийн дагуу урьдчилж сайтар бэлтгэн оролцож, хурдан зөв унших, хичээнгүй сайхан бичих, компьютерт монгол бичгийн фонд ашигдан бичих зэрэг төрлүүдээр мэдлэг чадвараа сорьж оролцсоноос Зуунмод сумын “Ланс хайрхан” 2-р баг 2 дахь жилдээ тэргүүлж, III, VI багууд удаах байруудыг эзэллээ. 7 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулагдаж буй Монгол Улсын гавьяат багш Т.Гаваагийн нэрэмжит монгол бичгийн олимпиадад Хүмүүн цогцолбор

ахлах сургууль 1-р байр, Хүмүүн цогцолбор дунд сургууль 2-р байр, ЗМ сумын 5-р сургуулийн багш, суралцагчид 3-р байр тус тус эзэллээ.

III. Аймгийн Хүүхдийн төлөө төвтэй хамтран "Хүрэлтулга" наадмыг зохион явуулсан.

IV. Аймгийн Нийтийн номын сан нь Музейтэй хамтран Батсүмбэр, Баян-Өнжүүл, Баянцагаан сумдын ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, багууд болон ТББ-ын дунд "Центавр", "АХА" танин мэдэхүйн тэмцээнийг зохиож Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

V. Сургуулийн өмнөх насныхны хэл яриа, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх зорилгоор Зуунмод сумын цэцэрлэгүүдийн дунд "Үлгэрийн баатрууд амилсан" нь тэмцээнийг нийт 7 цэцэрлэгийн 7 багийн 35 хүүхэд, 7 багш оролцлоо. Багийн нийлбэр дүнгээр ХСЧТөвийн "Алтансудар" баг 1-р байр, Бүжинхэн цогцолбор "А" байрны "Эрдэмийн бүлэг" баг 2-р байр, Дэгдээхэй "А" байрны "Монголын үр сад" 3-р байрыг тус тус эзэллээ.

VI. БСГазартай хамтран "Номын сайн нөхөр– сургууль – анги хамт олон - сурагч" – ийг шалгаруулах уралдааныг 2012.01.01-ээс 2012 оны 10-р сарын 30-ны өдөр хүртэл зохион явуулсан.

2. Сургуулийн өмнөх насныханд багаас нь номтой нөхөрлүүлэх, танин мэдэхүйг нь хөгжүүлэх зорилгоор чанга уншлагыг цэцэрлэгүүдээр хүүхдийн уншлагын танхимын номын санч Г.Балжнинням очиж хийдэг. 2012 онд ХЦС-ийн бэлтгэл ангид "Монгол ёс заншилын товчоон", "Оготны уршиг олондоо", "Зааны тугал", "Яагаад зарим загас шаар шиг хөөрдөг вэ" номоор чанга уншлага, ХСЧТөвийн хүүхдүүдэд "Монгол туургатны үлгэр" 1, 2 дэвтэр, "Монголын нууц товчоо", "Жанжин гуай баатар гуай", "Дудрангийн чих" номуудаас чанга уншлага хийлээ 4-р сургуулийн бага анги, цэцэрлэгийн насныханд "Туулай", "Түлээчин могой хоёр", "Яагаад усны үхэр усанд байдаг вэ", "Яагаад зарим загас шаар шиг байдаг вэ", "Цондоолой, Цүндээлэй хоёр" 1-16 цувралыг авч очиж уншуулав. Бүжинхэн цогцолбор "Б" байр "Чингис хаан" 1, 2, "Цондоолой дүүтэй болсон нь", "Цондоолой найзтайгаа эвлэрсэн нь", Ирээдүй цогцолбор "Б" байр "Өөхөн хүү, тосон хүү, дэрсэн хүү", "Аньс хуш мөнх ногоон болсны учир", "үнэг арслан хоёр", "үнэг чоно хоёр" Ирээдүй цэцэрлэг "Эрдмын далай "Тоншуул яагаад мод тоншдог вэ", Гогог гургалдай", "Эвтэй 4 амьтан", "Долоон өндөгтэй доголон шаазгай" зэрэг үлгэрүүдийг нийт 8-н цэцэрлэгийн болон сургуулийн бэлтгэл бүлгийн 566 хүүхдэд уншиж өгөв.

3. Уншигчдынхаа идэвхийг өрнүүлэх урамшуулах үүднээс 2012 оны "Тэргүүний уншигч"-дыг уншлагын танхим бүрээр шалгаруулаж шагнаж урамшууллаа.

Дөрөв: Шинэлэг арга хэмжээг санаачилж зохион байгуулах

1. Хүүхэд өсвөр үеийнхэнийг номтой нөхөрлүүлэх номын орчинг илүү өргөн хүрээнд хөхүүлэн дэмжиж, хөгжүүлэх болон номын сайн нөхөр сургууль, анги, хамт олон, сурагчыг шалгаруулан урамшуулах зорилгоор БСГазартай хамтран "Номын сайн нөхөр– сургууль – анги хамт олон - сурагч" – ийг шалгаруулах уралдааны болзол гарган 2012.01.01-ээс 2012 оны 10-р сарын 30-ны өдөр хүртэл зохион явууллаа. 2012 онд нийт сурагчдын 59.6% нь номтой нөхөрлөж, уншсан номын тэмдэглэлийг 51.8% нь хөтөлж, сурагчдын

уран яруу унших, ярих, илтгэх, дүр бүтээх чадваруудыг нээн хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулагдсан уралдаан тэмцээнүүдэд 71.36% нь хамрагдан, ангийн номын булантай болж, эцэг эх, багш нартайгаа хамтран төрөл бүрийн ном бүтээж, үзэсгэлэн гарган сурталчилж, нийт сургуулиуд багш, сурагчдынхаа бүтээлч чадварыг хөгжүүлэх чиглэлийн олон хэлбэрийн ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллалаа. Баяндэлгэр, Алтанбулаг, Эрдэнэ, Баян, Жаргалант сумдын сургуулийн багш сурагчид номын ертөнцөөр аялах, номын амт шимтийг мэдрэх, номтой нөхөрлөх энэхүү аяны түүчээ нь болж идэвх зүтгэлтэй, бүтээлчээр ажиллалаа. Тус уралдааны "Номын сайн нөхөр-Сургууль"-иар Баяндэлгэр, Алтанбулаг, Эрдэнэ сумдын ЕБС-иуд, "Номын сайн нөхөр-Анги хамт олон"-оор Баяндэлгэр сумын ЕБС-ийн 3а, 8а, 9а Зуунмод сумын ЕБС-ийн 4а, Баян сумын ЕБС-ийн 5а, Жаргалант сумын ЕБС-ийн 7а ангиуд шалгарлаа. Цаашид энэхүү уралдааныг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, аймгийн нийт сурагчдыг номтой нөхөрлүүлэх зорилго тавин ажиллаж байна.

2. Аймгийн Нийтийн номын сангийн сан хөмрөгийг 100% электрон каталогит оруулсан бөгөөд "Монголын цахилгаан холбоо" ХК-ны шилэн кабельд холбогдон өндөр хурдны интернэттэй болж байгууллагын www.library.tuv.mn вэб сайтад электрон каталогоо байрлуулснаар иргэд орон зай харгалзахгүй номын санд байгаа мэдээллийг авах боломжтой болсон. Мөн нийгмийн салбарын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх жилийн хүрээнд уншигчдад мэдээллийн нээлттэй чөлөөтэй байлгах, ая тухтай орчин бүрдүүлэх зорилгоор номын сангийн хамт олны санаачилсан төслийг ИНХурлаар дэмжин "Тогтвортой амжиргаа II" төслийг хэрэгжүүлж насанд хүрэгчдийн уншлагын танхимыг чөлөөт сонголтонд оруулж 4,000,000 төгрөгний тоног төхөөрөмжийг шинэчилсэн.
3. Зуунмод сумын 70 –н жилийн ойг угтаж зуунмод сумын хэмжээнд "Лондон - 2012" олимпийн бамбар цом аялуулах ажлын хүрээнд Зуунмод сумын ЕБСургуулуудын сурагчид , хүүхэд багачуудын дунд шатрын спортыг хөгжүүлэх, түүгээр хичээллэгсэд, сонирхогчдын цар хүрээг, өргөтгөх, өсвөр залуу тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, аймаг болон улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд өрсөлдөхүйц тамирчдыг төрүүлэн гаргах зорилгоор Зуунмод хотын "Өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээн"-ийг 2012 оны 1-р сарын 28 нд Аймгийн нийтийн номын сан, Зуунмод сумын ЗДТГ, Төв чандмань ДЭХГазартай хамтран Аймгийн нийтийн номын сангийн байранд амжилттай зохион явууллаа. Уг тэмцээн шатар сонирхогч хүүхэд багачууд идвэхтэй оролцож бага, дунд ахлах гэсэн 3 насны эрэгтэй эмэгтэй 5 ангиллаар нийт 60 гаруй тамирчид орсоноос, ХЦС-иас 49 сурагч 5-р сургуулиас 6 сурагч, 4-р сургуулиас 8 сурагч тус тус орж оюун ухаан ур чадвараа сорьлоо.

Тав: Сан хөмрөгөө шинэ ном хэвлэлээр баяжуулан, үндсэн болон ойрын фондын бүх номыг электрон каталогид оруулах

1. Аймгийн Нийтийн номын сан нь 2012 онд: Улсын төсвөөс: 4.762.700 төгрөгний 366 ш 14 төрлийн ном,аймгийн Засаг даргын эрх шилжүүлснээр 1.484.400 төгрөгний ном, Хандиваар 3.486.350 төгрөгний 237 ширхэг ном,

219800 төгрөгний 5 нэрийн тогтмол хэвлэл захиалж нийт 8.486.850 төгрөгний 653 ширхэг 14 төрлийн ном хэвлэл худалдан авч нэгдсэн болон нэг бүрчлэн бүртгэлд авч уншлагын танхимуудад хувиарлан үйлчилгээнд гаргалаа. Мөн "Шилдэг ном-2011"-т шалгарсан 39 нэрийн 6 төрлийн 696 ш 2,727,550 төгрөгний ном мөн БСШУЯамны хөрөнгө оруулалтаар ирсэн 147 нэрийн 10 төрлийн 73.518.320 төгрөгний номыг 26 сумын номын санд хувиарлаж нэг суманд дунджаар 10 төрлийн 147 ш 2.500.000 гаруй мянган төгрөгний ном өгсөн.

2. 2012 онд шинээр авсан 653 ширхэг номыг электрон каталогит оруулж, хүүхэд, насанд хүрэгч болон гэрээр олгох танхим, үндсэн фондны нийт 30156 ш ном хэвлэлийг электрон каталогит оруулсан нь номыг төрөл анги, зохиогч, хэвлэсэн он, түлхүүр үг зэргээр хайж олох боломжтой болгож зураасан коджуулж 100% электрон каталогит оруулсан.
3. Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 12 удаа гаргасан. Үүнд: Шатар сонирхогчдод-15ш, Үлгэрийн баатрууд амилсан нь-22ш, бичиг үсгийн баярт-22ш, нутгийн зохиолчдын бүтээл-18ш, Сургууль төгсөгчдөд-26ш, Батсүмбэр суманд нээлттэй хаалганы өдөрт-36ш номоор тус тус шинэ номоор 5, сэдэвчилсэн номын үзэсгэлэн 7удаа нийт 187 ширхэг номоор 12 удаа гаргасан.
4. Урагдаж гэмтсэн нийт 113 номыг сэлбэн засварлаж, уншигчдийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй болсон 57 ш номыг актлахаар ИТХурал оруулах саналтай байна.

Зургаа: Сумын соёлын төвийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг баяжуулж тогтмолжуулж, хүүхэд, залуучууд, хүн амд хүргэх соёлын үйлчилгээний үр өгөөжийг дээшлүүлнэ.

1. Аймгийн Нийтийн номын сан нь зөөврийн номын сангийн үйлчилгээгээр аймгийн НХХ-ийн харьяа Музей, "Хүүхдийн төлөө" төв, Нийтийн номын сан, Хүүхдийн сувилгаа чийрэгжүүлэлтийн төв зэрэг байгууллагуудад үйлчилж үйл ажиллагаагаа сурталчилсан.
2. Явуулын номын сангийн үйлчилгээг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Баянжаргалан, Баян, Цээл, Угтаалцайдам, Батсүмбэр, Алтанбулаг, Зуунмод, Лүн, Эрдэнэсант, Баян-Өнжүүл, Баянцагаан суманд зохион байгуулж 2012 оны байдлаар 11-н сумын 21-н баг, 51 байгууллагад хүрч үйлчлэн нийт 1966 уншигчдад 3062 ширхэг ном хэвлэл мэдээллийн материал хүргэж үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс олгож уншуулсан ном 5,4%-иар, уншигч 25,7%-р өссөн үзүүлэлттэй байна.
3. Аймгийн НХХэлтэсийн харъяа байгууллагуудтай хамтран үйл ажиллагаагаа сурталчилах зорилгоор Батсүмбэр, Баянцагаан, Баян-Өнжүүл сум болон Батсүмбэр сумын "Үдлэг" багт "Нээлттэй хаалганы өдөр"-ийг зохион байгуулаж, арга хэмжээндээ 350 хүн хамруулсан.

Долоо: Аймгийн номын сан нь "Мэдээллийн нээлттэй төв" болно.

1. Интернэт мэдээллийн өрөөний үйл ажиллагааг тогтмолжуулан үйлчилгээндээ 2011 оны байдлаар 1060 хүнд үйлчилж нь урьд оны мөн үеэс 0,8 % -р өссөн үзүүлэлттэй байна.
2. Хувилан олшруулах, компьютерийн үйлчилгээг 375 хүнд үзүүллээ.

3. Боловсрол соёлын газар, Аймгийн нийтийн номын сан хамтран ЕБС, Соёлын төв, МСҮТ, аймгийн номын сангийн номын санчдад **“Номын сангийн салбарын бодлого, түүний хэрэгжилт, үйлчилгээний соёл”** сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 66 номын санч хамрагдахаас 62 номын санч буюу 93% нь хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1,5%-иар өссөн үзүүлэлттэй байна. Номын санчдад мэргэжлийн чиглэлээр 15 төрлийн нийт 16 цагийн сургалтыг явууллаа.
4. Цээл, Алтанбулаг, Батсүмбэр, Баян, Баянцагаан, Баян-Өнжүүл сумын сум, сургуулийн номын санд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ангилал, номзүйн бичилт, техник ажиллагаа хийж данс бүртгэлийг шинэчлэн номын сангийн үйл ажиллагааг сайжруулж стандартын түвшинд хүргэсэн.
5. Аймгийн Нийтийн номын сан нь БСШУЯ-нд жил болгон гаргаж өгч үнэлгээ хийлгэдэг СУ-3, СУ-10, СУ-15 мэдээнээс гадна үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор фонд эргэлт, фонд баяжилт, олгож уншуулсан номын судалгааг жил бүр гарган үр дүнг тооцон үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж хэвшээд байна.

Найм: Байгууллагын нээлттэй ил тод байдлыг сайжруулах.

1. Аймгийн Нийтийн номын сан нь Байгууллагын танилцуулга, танхимуудийн танилцуулга, эрхэм зорилго, зорилт, иргэдэд хүргэж буй үйлчилгээ, шинээр ирсэн номын болон үйл явдлын мэдээ, санхүүгийн тайлангийн мэдээ, статистик мэдээллүүдийг иргэд уншигчдад ойлгомжтой байлаар өөрийн байгууллагын вэб сайт болох www.library.tuv.mn болон байгууллагын “Мэдээ, мэдээлэл”, “Бид танд ил тод үйлчилж байна”, “Санхүүгийн ил тод байдал” зэрэг 3- мэдээллийн самбарыг шинээр хийн байрлуулж иргэд уншигчдад мэдээлэл хүргэж байна.
2. Нийтийн номын сангийн мэргэжлийн 7-н албан хаагч дотоод удирдлагын системд холбогдож үр дүнгийн гэрээг суулгаж, улирал, сар, долоо хоногоор ажлаа төлөвлөн ажиллаж байгаа ба захидал харилцааны программыг ашиглан сум, албан байгууллагуудад мэдээ мэдээллээ тогтмол хүргэн ажиллаж байна. Мэдээлэл технологийн ажилтан нь 2 удаа төвлөрсөн сургалтанд хамрагдсан ба ажлын байран дахь сургалтыг өөрийн байгууллагын албан хаагчдад 6 удаа зохион байгуулсан.
3. Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай” хууль, МУЗГазрын 2011 оны 11 дүгээр сарын 09 ны 311 тоот тогтоолоор батлагдсан “Аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах тухай нийтлэг журам” зэргийг үндэслэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтанг томилон, журам боловсруулж батлуулан, төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хугацаанд өгч ажиллаа.

Ес: Стандартад нийцсэн тав тухтай орчноор уншигч үйлчлүүлэх боломж бүрдэж, номыг хадгалах, хамгаалах нөхцлийг сайжируулна.

1. 2011 онд УМХГазраас ирсэн удирдамжийн дагуу аймгийн МХГазраас томилогдсон комисс “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага” MNS 5742:2007, олон улсын стандарт ISO 17799: 2003 олон улсын стандарт ISO 17799: 2003 “Архив, номын сангийн өв санг хадгалж

хамгаалахад тавигдах шаардлага стандарт"-ын шаардлагын түвшинг шалгаж, шаардлага хангаж ажиллаж байгаа гэсэн дүгнэлтийг авсан. Дутагдалтай байсан заалтад тавьсан шаардлагын дагуу 2012 оны төлөвлөгөөнд тусган 1, 2-р давхарын гал түймэр, ослын үед аврах гарцын схемыг шинэчлэн байрлуулж, галын буланг шинээр байрлуулж, Номын сангийн үндсэн фондын хэсэгт 900.000 төгрөгний урсгал засвар хийж орчин нөхцлийг сайжруулсан. Мөн 2012 онд БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар үндсэн фондонд стандартын шаардлага хангасан 20ш 5,389,583 төгрөгний шинэ тавиурыг байрлуулсан ба 5ш шинэ компьютертэй болж интернэтийн үйлчилгээг өргөжүүлсэн.

2. Байгууллагын урд талын 270м^2 газарт олон настын согооворын үр суулгаж шинээр зүлэгжүүлсэн. Мөн гадна талаа гэрэлтүүлэгтэй болгож 1,300,000 төгрөг зарцуулсан. 910,000 төгрөгний урсгал засвар хийсэн. Мөн
3. Номын сангийн ажилтан албан хаагчдын нийгмийн асуудалд анхаарал тавьж 2011 оны төсвийн хэмнэлтээс түлээ нүүрсний хөнгөлөлтөнд 1,700,000 төгрөг, үр дүнгийн урамшуулал 1,500,000 төгрөг зарцуулж албан хаагчдад олгосон.

Арав: Биет болон мөнгөн хөрөнгийн нөөцийг зохистой ашиглах ба боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх

1. Харилцагч байгууллагуудтай өр авлагагүй хамтран ажиллаа.
2. Эд хөрөнгийн хамгаалалтыг сайжруулах үүднээс "Дотоодын хяналтын комисс"-ыг шинэчлэн байгуулж 2012 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн бүх албан хаагчидтай эд хөрөнгийн хариуцлагын гэрээг байгуулж үүрэгжүүлэн ажиллаж байна.
3. Иргэд, уншигчид болон сум сургуулийн номын сангуудад үйл ажиллагаагаа сурталчилах мэдээлэл хүргэх зөвлөгөө өгөх зорилгоор онол арга зүй гарын авлага болгож улирал бүр "Номын санч" сонинг бэлтгэн гаргаж өөрийн байгууллагын веб сайт дээр байрлуулан олон нийтийн хүртээл болгож байна.
4. Хүүхдийн баяр, ахмадын баяр болон соёл урлагийн ажилчдын өдөр, шинэ жилийг байгууллагын хүрээнд тэмдэглэн өнгөрүүлж албан хаагчдад шагнал урамшил олгосон.
5. Байгууллагын мэргэжлийн албан хаагчдын үр дүнгийн гэргээг ТАЗ-с гаргасан журмын дагуу дүгнэж тэргүүлсэн албан хаагчдыг байгууллагын хөдөлмөрийн аваргаар шалгаруулж шагнаж урамшуулсан.
6. Номын сангийн захирал нь Улаанбаатар хотод Соёл урлагын хорооноос зохион байгуулсан "Номын сангийн салбарын бодлого хэрэгжилт болон менежмент технологийн шинэчлэл" сэдэвт сургалтанд хамрагдсан ба 12-р сарын 12-14-нд зохион байгуулагдсан "Соёл ба хөгжил" олон улсын чуулганд оролцсон, Номзүйч-фондоч Л.Долгор, Мэдээлэл технологийн ажилтан Г.Батхолбоо нар нь МУ-ын Үндэсний номын сангаас зохион байгуулсан "Номын сан – Мэдээлэл технологи" сэдэвт 3 хоногийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн. Мөн Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж харилцан туршлага солилцож ирлээ. Тус аймгийн номын сангийн үйл

ажиллагаа, санаачилсан ажлууд, үйлчилгээний арга барил зэрэгтэй танилцсаны үндсэн дээр фондын ялгагч, ардын зан заншилыг сурталчилах, мэдээллийг хүртээмжтэй болгох, зарим тохижилтын ажил гэх мэт тодорхой ажлуудыг өөрийн номын сандаа хийж гүйцэтгэсэн.

7. Нийтийн номын сангийн мэргэжлийн 6-н албан хаагч нь ажлын байран дахь сургалтыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж мэдлэг боловсролоо тасралгүй дээшлүүлсэн.
   - Номын санч С.Бадамханд нь “Ном хэвлэлийн байгуулагад мөрдөх үндэстний стандартаас”,“Уншигчдад үйлчлэх байрны орчин”
   - Номын санч Г.Балжинням “ Уншигчдад үйлчлэх байрны орчин”
   - Номын санч Д.Бадамцэцэг “Мэдээллийн тухай”, “Номын сангийн ёс зүйн тухай”
   - Номзүйч Л.Долгор “Ном хэвлэлийн байгуулагад мөрдөх үндэсний стандартаас”, “Номын сангийн орчны нөхцөл”
   - E-Office дотоод удирдлагын системийн талаар аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан сургалтанд 2 удаа хамрагдаж байгууллагын албан хаагчдад e-office системд хэрхэн ажиллах талаар 5-н удаагийн сургалтын зохион байгуулсан.
   - Байгууллагын албан хаагчдад E-Office, MS-Word, Excel программууд болон E-mail дээр хэрхэн ажиллах талаар 24 цагийн ажлын байрны сургалт, дадлагыг зохион явууллаа. Нийт 54 цагийн ажлын байран дахь сургалтыг зохион байгуулсан.
   - Мөн аймгийн хэмжээнд хууль сурталчлах аяны хүрээнд 2012 онд “Монгол улсын үндсэн хууль,хүний эрх,эрх чөлөөг хангах”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай”, “Тамхины хяналтын тухай”, “Хөдөлмөрийн холбогдолтой хууль тогтоомж”, “Гэр бүлийн тухай”, “Сонгуулийн хууль”, “Авлагын болон ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль”, “Аймаг, сум,дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай”, “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”, “Төрийн албаны тухай” зэрэг хуулиудаар удирдамжийн дагуу төлөвлөгөө гаргаж, мэдээлэл хийж, тайлан мэдээг хугацаанд нь явууллаа.

УВС АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН
2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2012.12.20 **Улаангом**

Манай хамт олон " Соёлын талаар төрөөс баримтлах бодлого, МУ-ын Соёлын тухай хууль, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт Номын сантай холбогдож гарсан заалтуудыг хэрэгжүүлэх, номын санг "Нээлттэй мэдээллийн төв" болгон ажиллах зорилт тавин ажиллаж байна. Үйл ажиллагаагаа төрөөс баримтлах соёлын бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг Даргын үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын Соёлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон түүнийг хэрэгжүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

Нэг: Дотоод ажлын талаар:

1.1. 2012 оны жил эцсийн мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж аймгийн БСГ, БСШУ-ны яам, МҮНС-д хүргүүллээ.
1.2. 2012 онд ажилтнуудтай байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэж байгууллагын оны аварга тэргүүнийг тодруулан шагнаж урамшуулав.
1.3. Ажилтнуудад 2012 оны ажлын тайлан тавьж санал бодлыг нь авч дараагийн ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаа.
1.4. Ажилтнуудтай 2012 онд ажиллах хөдөлмөрийн гэрээ , бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж байна.
1.5. Номын сангийн 2012 онд батлагдсан төсвийн тухай хамт олонд танилцуулж сар, улирлын хувиарыг мэдээлэв.
1.6. Номын сангийн 2012 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан аймгийн БСГ-ын даргаар батлуулан мөрдөн ажиллаж байна.
1.7. Ажилтнуудад хариуцсан эд хөрөнгийн картыг шинэчлэн бүртгэж хүлээлгэн өглөө.
1.8. 2012 оны санхүүгийн тайланг хамт олны хурлаар хэлэлцүүлэв.
1.9 2011 оны баримт бичгийг эмхлэн үдэж архивлав.
1.10 Номын сангийн 2009-2015 он хүртэл ажиллах стратеги төлөвлөгөөнөөс 2012 онд мөрдөн ажиллах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.
1.11 2012 онд явуулах Соёл олон түмний ажлын графикийг гаргаж номын санч бүрээр байрлууллаа.
1.12 2012 онд ажиллах уншигчийн карт хэвлүүлэн орлогод авлаа.
1.13 Байгууллагын 2012 оны бичиг баримтын тайланг ажилчдад танилцуулж санал хүсэлтийг нь тусган ажиллаж байна.

1.14 “Монгол бичгээр сайхан бичигтэн” шалгаруулах уралдааныг зохион байгуулж дүгнэн бүтээлүүдээр нь үзэсгэлэн гаргаж сурталчилан уралдаанд шалгарсан оролцогчдыг шагнаж урамшууллаа.

1.15 Номын фондтой холбоотой хууль тогтоомжийн заавар зөвлөмжийг эмхэтгэн үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.

Хоёр: Гэрээний биелэлтийн талаар:

№	Шалгуур үзүүлэлт	Нэгж	хүрэх түвшин	Биелэлт
1	Уншигч	тоо	36800 хүнд хүрч үйлчилнэ	Нийт 4031 уншигчдад, 40647 ш номоор үйлчиллээ.
2.	Орлого	Мян төг	Өөрийн үйл ажиллага анаас орлого оруулж ажиллана.	Өөрийн үйл ажилллагаанаас 100 хувь орлого оруулж ажиллаа.
				-2012 оны Эхний хагас жилд хамгийн их эрэлттэй байж үйлчилгээнд гарсан “ Ертөнцийн тайлагдашгүй нууцууд” ном

				рекорд номоор,
3.	жилийн тэргүүний уншигч шалгаруулж хэвлэл мэдээллээр сурталчилах	Чанар	Уншигчийг идэвхжүүлж тоог нэмэгдүүлэх	Тэргүүний уншигчаар ахлах 1-р сургуулийн сурагч Эрдэнэбилэгийн Тамжид шалгарлаа. -2011 оны Уншлагын танхимын Тэргүүний уншигч цогцолбор 2-р сургуулийн сурагч Д.Батболд, рекорд номоор "Шилдэг илтгэлүүд" ном шалгарлаа. -2011 оны Хүүхдийн танхимын Тэргүүний уншигчаар цогцолбор 1-р сургуулийн 9-р ангийн сурагч Г.Чинзориг, рекорд номоор "Хүүхэд багачуудын зурагт толь" ном шалгарлаа. 2. Тэргүүний уншигч Нацагдорж тэмдэгтэн" –ээр насанд хүрэгчдээс Батжаргал , ахлах 3-р сургуулийн 11

				ангийн сурагч Алтансувд шалгарлаа. • Аймгийн захиргаан дээр шинжлэх ухааны салбаруудаар шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 2 удаа гаргаж байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчиллаа. • 2012 оны Уншлагын заалны тэргүүний уншигчаарХДС-ийн багш Ч. Ганзориг , • 2012 оны рекорд номоор Ц.Оюунгэрэлийн **“Ногоон нүдэн лам”** шалгарлаа • 2012 оны Хүүхдийн танхимын тэргүүний уншигчаар Цогцолбор 2-р сургуулийн 5-д ангийн сурагч Энхээ овогтой Зулзаяа, • Рекорд номоор “**Ах дүү Гриммийн үлгэрүүд**” шалгарлаа. Шалгарсан сурагч, анги хамт олныг захиргааны зүгээс шагнаж урамшуулан алдаршуулав.

4.	Номын фондыг ном хэвлэлээр баяжуулах Төсөл хандивын журмаар фондын баяжилт хийх	Тоо ширхэг	Номын фондын баяжилт хийх	2012онд 375 нэр төрлийн 972 ширхэг 10249950 төгрөгийн номоор фондоо баяжууллаа. Үүнээс хандив бэлгийн журмаар төгрөгний 134 нэр төрлийн 706 ширхэг ном хэвлэл, өөрийн хөрөнгөөр 237 нэр төрлийн 465 ширхэг 5639500 төгрөгийн ном хэвлэлээр фондоо баяжуулсан байна.
5.	Номын сангийн үйлчилгээний чанар, уншигчдын эрэлт хангасан эсэх/ үйлчилгээний шинэлэг хэлбэр нэвтрүүлсэн эсэх/		• Шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэн 60 удаа гаргана. • Номын сангийн үйл ажиллагааны талаар болон шинэ номын мэдээ, мэдээллийг орон нутгийн телевизээр сурталчилах	• “Өрхийн хөгжлийг дэмжье”, ЕБС-ийн төгсөгчдөд зориулсан сэдэвчилсэн үзэсгэлэн , Гэр бүлийн өдөр , гэх мэт шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 60 удаа гаргалаа. • Номын сангийн үйл ажиллагааны талаар болон шинэ номын мэдээ мэдээллийг нийтэд сурталчилж байна. • Номын санчдад

		Тоо чанар	• Зөөврийн номоор үйлчлэх үйлчилгээг идэвхжүүлнэ. • Аргазүй мэдээллийн самбар гаргаж ажиллуулах • Сумдын номын санчдад ажлын аргачлал өгч семинар зохион байгуулах • 2011 оны тэргүүний уншигч, рекорд номыг шалгаруулан, урамшуулах алдаршуулах ажлыг зохион байгуулах • 2011 оны Хүүхдийн танхимын "Тэргүүний уншигч, рекорд ном"-ыг шалгаруулан, урамшуулах	зориулсан арга зүй мэдээллийн самбар гаргаж ажиллуулаж байна. • БСГ-тай хамтран сум болон сургуулийн номын санчдад ажлын аргачлал өгч семинар зохион байгууллаа. • БОАЖГ, болон Увс–эрдэм ахлах сургууль, зарим нэг албан байгууллагуудад зөөврийн номоор үйлчилж байна. • 2011 оны Уншлагын танхимын Тэргүүний уншигч цогцолбор 2-р сургуулийн сурагч Д.Батболд, рекорд номоор "Шилдэг илтгэлүүд" ном шалгарлаа. • 2011 оны Хүүхдийн танхимын Тэргүүний уншигчаар цогцолбор 1-р сургуулийн 9-р ангийн сурагч Г.Чинзориг, рекорд номоор "Хүүхэд багачуудын

			алдаршуулах ажлыг зохион байгуулах • “Монгол бичгээр сайхан бичигтэн” уралдааныг зохион байгуулна.	зурагт толь” ном шалгарлаа. • Уншигчдын эрэлт хэрэгцээтэй 10 гаруй номыг цахим хэлбэрээр бэлтгэж үйлчилгээнд ашиглуулж байна. • Хэвлэлийн Интерпресс ХХК-ны танилцуулсан I nom-буюу компьютер дээрээс шууд уншигддаг 60 ш ном сэтгүүлийг электрон катологийн хайлтын компьютерт суулгаж үйлчилгээнд ашиглуулж байна. • Бичиг соёлын хишиг өдрийг тохиолдуулан “Монгол бичгээр сайхан бичигтэн “шалгаруулах ээлжит уралдааныг зохион явуулж дүгнэлээ. УГК-ийн оюутан Нямцэнгэл тэргүүн байр, Музейн ажилтан Цэнд-аюуш 2-р байр ,УГК-ийн савхины 2-р анги оюутан Цогзолмаа 3-р

				байрыг тус тус эзэллээ. • "Номын баярыг" аймгийн цогцолбор сургуулиудын дунд зохион явууллаа. Тус арга хэмжээний үеэр илтгэлийн уралдаан, шүлгийн уралдаан, аха тэмцээнүүдийг явууллаа. • Аха тэмцээнд цогцолбор 1-р сургуулийн 11 ангийн сурагч Ганболд түрүүлсэн • Шүлгийн уралдаанд Шинэ ирээдүй цогцолбор сургуулийн 8-р ангийн сурагч Батхишиг түрүүллээ. • -Илтгэлийн уралдаанд Шинэ ирээдүй цогцолбор сургуулийн 10-р ангийн сурагч Мөнхцэлмэг түрүүллээ. • Мөн "Тэргүүний уншигч Нацагдорж тэмдэгтэн" –ээр насанд

				хүрэгчдээс Батжаргал , ахлах 3-р сургуулийн 11 ангийн сурагч Алтансувд шалгарлаа. • Аймгийн захиргаан дээр шинжлэх ухааны салбаруудаар шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 2 удаа гаргаж байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчиллаа.
6.	Номын фондын хадгалалт хамгаалалт /хуучин ном хэвлэлийг сэргээн засварлах/	чанар	3000 ш номонд варкод наана. 6500 ш номонд сэлбэн засалт хийнэ. Хэрэгцээгүй ном зохиолыг актлаж устгах, шаардлагатай газар өгч ашиглуулах	• 3000 ш номонд варкод наалаа. • 6500 ш номонд сэлбэн засалт хийлээ. • Данс шинэчлэн бичих, хэрэгцээгүй ном зохиолыг актлаж устгах ажлуудыг хийж байна.
7.	Статистик мэдээ мэдээлэл болон албан хэрэг хөтлөлтийг стандартын	Тоо чанар	СУ-3, СУ-15, СУ-10 мэдээнүүдийг хуулийн хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох газруудад хүргүүлэх Албан хэрэг хөтлөлтийг заавар журмын дагуу хөтлөж	• СУ-3, СУ-15, СУ-10 мэдээнүүдийг хуулийн хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох газруудад нь хүргүүллээ. • Албан хэрэг хөтлөлтийн заавар журмын дагуу өмнөх оны бичиг баримтуудыг нэгж

	дагуу гүйцэтгэх		ажиллах	болгон ангилж архивллаа.
8.	Боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх талаар	чанар	1 -2 номын санчийг сургалтанд хамруулах	1-2 номын санчийг сургалтанд хамруулах зорилт тавин ажилласнаас Ном зүйч ахлах номын санч М.Лхагважав, Мэдээллийн ажилтан Д.Нямбилэг нар УБ хотод МҮНС-с зохион байгуулсан программын сургалтанд хамрагдлаа. Оросын холбооны Тува улстай хамтран ажиллах гэрээний дагуу Тува улсын 15 муж оролцсон олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцож " Ойрдуудын дээр мөргөх ёсон "сэдвээр илтгэл тавьж оролцлоо Номын санч Д.Мөнхцэцэг нь СУИС-ийн магистарт үргэлжлүүлэн суралцаж байна. • Үйлчилгээний ажилтан Б.Биньеэ СУИС-ийн номын сан мэдээллийн

				ажилтаны ангид эчнээ суралцаж байна • Захирал Б. Булган СУИС-ийн Соёл урлагийн удирдлагаар магистр төгслөө.
9.	Байгууллага, орчны тохижилтын талаар	чанар	Байгууллагын өнгө төрхийг сайжруулах зарим тохижилтыг хийх	• Байгууллагын ажилчдын ажлын өрөө байрны тохижилт хэвийн. • Шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан. • Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт ,хадгалалт хамгаалалтыг сайжруулахын тулд ажилтан бүрт эд хөрөнгө эзэмшигчийн карт хариуцуулан бүрэн бүтэн байлгах ашиглах үүрэг хариуцлагыг хүлээлгэн ажиллаж байна. • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам гарцыг шинээр хийсэн. • Фондын өрөө,

				Уншлагын танхим, Хүүхдийн уншлагын танхимуудын гэрэлтүүлгийг шинээр сольж шинэчиллээ. • Байгууллагын хашаа, хайс будах, өнгө үзэмжийг сайжруулах ажлуудыг хийж байна. • Фондын өрөөний номын тавиуруудыг бүрэн шинэчиллээ. • Интернет танхимын ширээ сандалыг шинэчиллээ. . • Хүүхдийн танхим, лавлах фондын өрөөний номын тавиуруудыг будлаа • Ня-бо-гийн өрөөг шинээр тохижуулж , лавлах фондын өрөөний хулдаас сольж, хүүхдийн танхим, лавлах фондын өрөөний номын тавиуруудыг будлаа • Бичиг хэргийн болон харуул, үйлчлэгч нарын компьютерүүдийг сольж шинээр компьютерүүд тавьж өглөө. • Зөөврийн номын сангаар үйлчлэх фургон автомашинтай

				болсон
10.	Стандарт хангалт	Чанар	Номын санд мөрдөгдөх стандартуудыг мөрдөж ажиллах	Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS5742:2007 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гурав. Хууль тогтоомж , шийдвэрийн хэрэгжилт түүний үр дүн:
3.1. Номын сан нь үйл ажиллагаандаа Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль , Засгийн газрын болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль эрх зүйн актыг мөрдлөг болгон ажиллаж байна.
3.2. Номын сангийн хамт олон нь МУ-ын хууль тогтоомжийг нийтэд сурталчилах зорилгоор төрийн мэдээлэл, хууль зүйн мэдээлэл сэтгүүл, хууль зүйн мэдээ сонинг улирал тутам захиалж уншигч үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд гаргаж байна.
3.3.УИХ-с гарсан хуулиуд ,Засгийн Газраас гарсан тогтоол шийдвэрүүдээр сүүлийн 5 жилд ном зүйн бүртгэл хийж иргэдэд сурталчилан ашиглуулж байна.
3.4. Хууль эрх зүйн чиглэлээр гарсан шинэ ном хэвлэлүүдээр фондоо баяжуулж байна.
3.5. 40 гаруй хуулиар хувийн хэрэг бүрдүүлэн нийтэд сурталчилан ажиллаж байна.
3.6. Аймгийн засаг даргын үйл ажиллагааны 2009-2012 онд хэрэгжүүлэх хөтөлбөрөөс номын сангийн талаар тусгагдсан заалтанд хувийн хэрэг нээн ажиллаж байна.
3.7. Монгол Улсын ЗГ-с хэрэгжүүлж байгаа “Монгол бичиг”-ийг хөгжүүлэх, дээдлэх үндэсний бичгээ сэргээх, хүүхэд залууст эзэмшүүлэх , өвөг дээдсээс уламжлан ирсэн өв соёлоо хадгалж хамгаалах зорилготой үндэсний томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор жил бүр “Монгол бичгээр сайхан бичигтэн” уралдаан зарлаж бүтээлүүдээр нь үзэсгэлэн гаргаж байр эзлүүлэн тодорсон эзнийг нь шагнан урамшууллаа.

Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгжилт,

Монгол Улсын Засгийн Газрын 2008-2012 оны мөрийн хөтөлбөрт номын сантай холбоотой 1.2.22-р заалт гарсан. Үүнийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Төв номын сангаас 2011-2012 он хүртэл уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаа.
Аймгийн Засаг даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт номын сантай холбоотой заалтаар хэрэгжих ажлын төлөвлөгөө гарган ажиллаа.

Тав: Хяналт шинжилгээ, тайлан мэдээний байдал:

Номын сан нь статистикийн СУ-3, СУ-10, СУ-15 гэсэн 3 төрлийн мэдээг гаргаж өгдөг. Үүнээс СУ-3 мэдээг улирал тутам, СУ-10 СУ-15 мэдээг жил эцсээр гаргаж аймгийн БСГ, Статистикийн хэлтэс, ҮНС-д хүргүүлж хэвшсэн.

Номын сангийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах стандарт, дүрэм, журам хөтлөгдөх бүртгэл тооцооны хөтлөлтийг улирал тутам шалган дүгнэжзааварчлагаа өгөн ажиллаа.

Сайн ажилласан ажилтанг алдаршуулах, жилийн эцэст ажлаа дүгнэж байгууллагын аварга, тэргүүнийг шалгаруулах, аймгийн болон яамны ,ЗГ-ын шагналд тодорхойлох зэрэг урамшууллын дэмжлэг үзүүллээ.

Зургаа: Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал:

Ажилчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч цалинтай чөлөө олгож байлаа.

МУ-ын хөдөлмөрийн хуулинд заагдсан тэмдэглэлт баяр ёслолын үеэр ажилчдад хүндэтгэл үзүүлж гарын бэлэг, дурсгалын зүйл өгөхөөс гадна байгууллагын зардлаар аялал зугаалганд оролцууллаа.

Эмч нарын зөвлөгөөний шийдвэрийн дагуу эмчилгээнд явах ,рашаан сувилалд амарсан ажилчдад тэтгэмж олгож байлаа.

Ажилчдын амьдралд тулгамдсан асуудалд /найр хурим хийх, өвчтэй байх гэх мэт / дэмжлэг үзүүлэн тодорхой хэмжээний цалинтай чөлөө олгож байлаа.

Сайн ажилласан ажилчдыг урамшуулах, шагнах, аварга тэргүүнээр шалгаруулах зэрэг арга хэмжээ авлаа

Долоо: Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар :

Ном зүйч М.Лхагважав, мэдээллийн ажилтан Д.Нямбилэг нарыг МҮНС-с зохион байгуулсан номын сангийн автоматжуулалт, программын сургалтанд хамруулсан .

Оросын холбооны Тува улстай хамтран ажиллах гэрээний дагуу Тува улсын 15 муж оролцсон олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцож “ Ойрдуудын дээр мөргөх ёсон ”сэдэвээр илтгэл тавьж оролцлоо.

Найм: Сахилга хариуцлагын талаар:

Ажилтан бүр бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ,хариуцлага сахилгын гэрээ байгуулан гэрээнд тусгагдсан үүрэг хариуцлагыг хүлээлгэн ажиллаж байна.

Байгууллагын дотоод журам, хамтын гэрээг шинэчлэн боловсруулж нийт ажилчдын хурлаар хэлэлцүүлэн батлан ажилласан бөгөөд дотоод журмыг зөрчсөн тохиолдолд хөдөлмөрийн хуулийн дагуу хариуцлага тооцон ажиллаж байна.

МУ-ын төрөөс баримтлах соёлын бодлого, МУ-ын Соёлын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг нийт ажилтануудаар судлууллаа.

Байгууллагад ГХУС ажилтан болон байгууллагын ёс зүйн хороо байгуулан төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Манай байгууллага 2012 онд 148182.5 төгрөгний төсөв батлагдаж үйл ажиллагаа явуулсанаас 148182.5 төгрөгний гүйцэтгэлтэй гарлаа.

Арав: Байгууллага, орчны тохижилтын талаар:

Байгууллагын ажилчдын ажлын өрөө байрны тохижилт хэвийн.

Шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан.

Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт ,хадгалалт хамгаалалтыг сайжруулахын тулд ажилтан бүрт эд хөрөнгө эзэмшигчийн карт хариуцуулан бүрэн бүтэн байлгах ашиглах үүрэг хариуцлагыг хүлээлгэн ажиллаж байна.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам гарцыг шинээр хийсэн.

Фондын өрөө, Уншлагын танхим, Хүүхдийн уншлагын танхимуудын гэрэлтүүлгийг шинээр сольж шинэчиллээ.

Байгууллагын хашаа, хайс будах, өнгө үзэмжийг сайжруулах ажлуудыг хийж байна.

Фондын өрөөний номын тавиуруудыг бүрэн шинэчиллээ.
Интернет танхимын ширээ сандалыг шинэчиллээ. .
Хүүхдийн танхим, лавлах фондын өрөөний номын тавиуруудыг будлаа
Ня-бо-гийн өрөөг шинээр тохижуулж , лавлах фондын өрөөний хулдаас сольж, хүүхдийн танхим, лавлах фондын өрөөний номын тавиуруудыг будлаа
Бичиг хэргийн болон харуул, үйлчлэгч нарын компьютерүүдийг сольж шинээр компьютерүүд тавьж өглөө.

ШИНЭ БОЛОН СЭДЭВЧИЛСЭН НОМЫН ҮЗЭСГЭЛЭНГҮҮД

НОГООЧДЫН
НОМЫН САНД

ШИНЭ НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

ШИНЭ НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

Номын баярыг өргөн тэмдэглэв.

Бичиг соёлын хишиг өдрийг тохиолдуулан жил бүр уламжлан болгон зохиогддог "Монгол бичгээр хэн сайхан бичих вэ?" уралдаанд шалгарсан оюутан сурагчид шагналаа гардаж байгаа нь

Тэргүүний уншигч, Рекорд номыг хагас бүтэн жилээр шалгаруулан шагнаж урамшуулан сурталчилдаг

ҮЙЛЧИЛГЭЭНД АШИГЛУУЛСАН ГАРЫН АВЛАГА, ХЭРЭГЦЭЭТ МАТЕРИАЛУУД:

10 гаруй нэр төрлийн тогтмол хэвлэл захиалан хэрэгцээт уншигчдад үйлчилж байна.

уншигчид электрон катологоос Номоо хайж үйлчлүүлдэг.

Байгууллагын бичиг хэ



Зохиолч М. Уянсүхын" Ойрад "номын нээлт хийж уншигчид болон зохиолч, зочидтой уулзалт хийлээ.

Байгууллагын тохижилт үйлчилгээний талаар :

Гадна хашааг будаж , сайжруулсан.

Үүдний коридорт толь байрлуулав.

фондын өрөөний тавиур шинэчилсэн

Цэвэр усны сантехник шинэчлэв.

Интернет өрөөг таслаж шинээр ня-бо –ийн өрөө гаргав.

Уншигч /сүүлийн 3 жилээр/



Олгосон ном /3 жилээр/



Фондын номын тоо /3 жилээр/



ФОНДЫН БАЯЖИЛТ /СҮҮЛИЙН 3 ЖИЛЭЭР/



ХОВД АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2012 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2012.12.10

Ховд аймгийн Нийтийн номын сан нь 74 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Тэрээр Монгол Улсын засгийн газраас Соёлын байгууллагын талаар дэвшүүлсэн зорилт, төрийн бодлого, шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гол анхаарлаа хандуулан ажилалаа.

Тайлант хугацаанд манай байгууллага үйлчилгээний чанарт ахиц гаргаж, төлөвлөгөөт үзүүлэлтээ биелүүлэх, номын фондыг баяжуулан, техник тоног төхөөрөмжөөр хангах, материаллаг баазаа бэхжүүлэх зэрэг олон зорилтот ажил дэвшүүлэн ажилласан.

Удирдлагын үйлчилгээ:

- 2011 оны ажлаа аймгийн БСГ болон Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсээр дүгнүүлж” А” үнэлгээтэй шалгагдаж 2012 оны ажлын төлөвлөгөө болон Үр дүнгийн гурвалсан гэрээ байгуулж ажиллаа.
- Байгууллагын мэргэжлийн номын санчидтай үр дүнгийн гэрээ бусад үйлчилгээний туслах ажилчидтай үйл ажиллагааны төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээ байгууллаа.
- Ажилчид ажил үйлчилгээгээ сар улирал жилээр төлөвлөн захирлаар батлуулан ажилласан ба жилийн эцэст захиралтай байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг үндэслэн дүгнэж үр дүнгийн болон ур чадварын нэмэгдэл олгож ажиллаа.
- Ардын хувьсгалын 91, Ховд хотыг Манжаас чөлөөлсний100 жилийн ойг угтаж бүтээн байгуулалтын ажлын аян зарлаж байгууллагын үзэмж сайжруулах, тохижуулах ажлыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн.
- АНУ-ын Элчин Сайдын Яамтай хамтран ажиллах гэрээг 5 жилээр үргэлжлүүлэн байгуулж, цаашид ажиллах ажлын төлөвлөгөөг гарган үйл ажиллагааг өргөтгөхөөр тохиролцлоо.
- Автоматжуулалтын ажилд анхаарлаа хандуулж электрон каталогт номын сангийн цогц программ хангамж “LIB4U” –г ашиглан нийт номын 80%-ийг орууллаа.
- Тайлант хугацаанд байгууллагын хурал 6 удаа хийж асуудлыг хамт олноороо хэлэлцэн шийдвэрлэж байсан ба нийт 55 тушаал гаргаж 32 бичиг боловсруулан явуулж, ирсэн 48 бичигтэй танилцаж, үүрэг даалгаврыг биелүүлж хамтран ажиллаа.
- Байгууллагын тоног төхөөрөмж сайжруулах зорилгоор яамны хөрөнгө оруулалтаар 8,0 сая төгрөгийн 10 компьютер, 2 принтер авч ашиглаж байна.

- Засгийн газраас Нүүдлийн номын сангийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор УАЗ-фургон машин олгосныг авч ажиллуулж байна.
- Спорт, Соёл, Аялал жуулчлалын Яамнаас 1350000 төгөгийн үнэ бүхий хувилагч машин1 ширхэгийг хөрөнгө оруулалтаар олгов.

Уншлага үйлчилгээний талаар

Бид ажлаа сар улирал жилээр төлөвлөж, гүйцэтгэлийг нь шалгаж тухай бүрд нь дүгнэж ажлын хариуцлага тооцон ажиллахаас гадна, Аймгийн Боловсрол, Соёлын газар, Нийгмийн бодлогын хэлтэстэй бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гурвалсан гэрээ байгуулан ажиллаа.

2012 онд манай байгууллага Мэдээлэл, ном зүйн тасаг, номын сангийн фондын тасаг, Эрдэм шинжилгээ, чөлөөт уншлагын танхим, Уншлагын их танхим, Хүүхдийн Үл мэдэх танхим, Америкийн соёл мэдээллийн төв зэрэг тасаг танхимуудын жигд ажиллагааг бүрэн хангаан ажиллаа.

Уншлага үйлчилгээний хувьд өмнөх жилийнхээ ажлын амжилтыг бататган ахиулсан жил байлаа. Энэ үйлчилгээнд Уншлагын их танхимын номын санч Л.Даваахүү М.Чимэгээ, Үл мэдэх танхимын номын санч М.Эрдэнэ, Насанд хүрэгчдийн уншлагын танхимын номын санч Г.Баяраа, Гадаад уншлагын танхимын номын санч В.Алтанцэцэг, Гэрээр ном олгох тасгийн номын санч Д.Мягмарсүрэн нар ажиллаа.

Номын санчид ажлаа сар улирал жилээр төлөвлөгөө гаргаж захирлаар батлуулан төлөвлөгөөнийхөө дагуу уншлага үйлчилгээгээ явуулж оны эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөө нормоо 100 хувь давуулан биелүүлсэн сайхан амжилт үзүүллээ. Тэдний дотроос номын санч М.Эрдэнэ, М.Чимэгээ, В.Алтанцэцэг Г. Баяраа нар бусдыгаа хошуучлан ажиллаа.

Тус үйлжилгааний ажлын амжилтын үндэс нь байгууллагуудын удирдлагуудтай ажлын холбоо тогтоож хамтран ажиллсан, уншлагын танхимаас гадна тухайн байгууллагууд дээр номоор үйлчилж, олон удаагийн номын аян, нээлттэй хаалганы өдөр зохион байгуулсан, уншигчдад татгалзлын дагуу ном бүрдүүлж үйлчилж, хүрэлцэхгүй байгаа номыг хувилан олшруулж бяцхан ном хийсэн, номын үзэсгэлэн гаргаж ном хэвлэлээ сурталчилсан зэрэг олон ажлуудын үр дүнгийн нэгдэл байлаа.

Уншигчдын хэрэгцээ шаардлага хангах, иргэдэд мэдээлэл түгээх, тэднийг номын сангийн үйлчилгээнд татан оролцуулах олон 510, 3850 уншигчдад карт нээхээс 3900, 40000 ирцэд 60000 ном хэвлэл олгож үйлчлэхээс 40560 ирцэд 60100 ном олгон уншуулж уншлага үйлчилгээний төлөвлөгөөг 101-150% -иар биелүүлэн ажиллаа.

Мэдээлэл, ном зүйн тасаг нь Номын тооллогын ажлыг цэгцлэх, номоо ДДС-ийн ангилалд оруулах, данс бүртгэлийг шинэчлэх ажлыг бүрэн хийж дууссан бөгөөд нийт номыг төрөл анги, үсэг дарааллын каталог шинээр байршуулж 80%-ийг электрон каталогт оруулаа. Энэхүү үйлчилгээний хүрээнд Ахлах номын санч Д. Саранцэцэгээр удирдуулсан

ажилчид баг болон ажиллаа. Үүнд: Номзүйч Ц.Мөнхжаргал, Фондч Б.Алимаа, мэдээлэл сүлжээний ажилтан Д.Дөмөгтүшиг каталогч Д.Оюунчимэг нар мэргэжлийн хувьд голлон ажилласан бол үйлчлэгч Оюунбилэг Б.Цогтчимэг, Д.Отгонжаргал нар бар код наах, ном хэвлэл хайж олох, каталогийн уут хийж наах, ном сэлбэн засварлах зэрэг туслах ажилтнаар ажиллаа. Энэхүү тасгийн 2012 онд хийх гол ажил нь Номын фондны ном хэвлэлийг электрон каталогт оруулах, шинээр ирсэн ном хэвлэл техник ажиллагаанд оруулж богино хугацаанд уншлаганд оруулах номын үзэсгэлэн гарган сурталчилах байгууллагаас зохиосон СОНА зохион явуулах, туслах явдал байлаа.

Тэд үүргээ амжилттай биелүүлж 2012 оны байдлаар шинээр ирсэн 889 номонд ном зүйн ажиллагаа хийж уншлага үйлчилгээнд оруулав. Оюутан сурагчдыг номтой нөхөрлүүлэх, шинэ ном сурталчилах зорилгоор Ховд Их сургуулийн номын санчидтай хамтран номын үзэсгэлэн сургууль дээр нь 3 удаа гаргав.

Ном зүйн тасгийхан өмнө нь " Нээлттэй хаалганы өдөр"-ийг өөрийн номын сан дээр зохион байгуулдаг байсан бол энэ жилээс тухайн байгууллага дээр очиж хамтран зохион байгуулах болсон нь үр дүнтэй ажил боллоо хэмээн үзэж байна.

Америкийн соёл мэдээллийн төв нь Энэ төв нь байгуулагдаад 6 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Гадаад хэл суралцагчдад зориулсан сурах бичиг техник хэрэгсэлээр бүрэн хангагдсан уг танхимаар нас харгалзахгүйгээр, хэн бүхэн хамрагдах боломжтой бөгөөд энэ оны хагас жилийн байдлаар 240 уншигчид карт нээж, 3100 ирцэд 3401 ном хэвлэл олгон үйлчилсэн байна. Байгуулагдсан цагаас хамрагсдын хүрээ улам өргөжсөн ба энэ онд 6800 минутын үнэгүй интернет ашигласан байна. Тэрээр хагас жилийн хугацаанд Англи хэлний ярианы клубаар 112, сургалтанд 140, ганцаарчилсан зөвлөгөөг 102 хүнд өгч, Англи хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт 3 удаа явуулж түүнд 150 багш нар оролцсон бол Америкийн боловсролын талаар лекц хийж 580 оюутан сурагчид хамрагдав.

Боловсролын зөвлөгөө мэдээллийн төвийн ажлын хүрээнд Болгар дахь Америкийн их сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг танилцуулж өргөдлийн маягт тарааж сурталчилаа.

2012 оны 6 сарын 13-14 нд АНУ ЭСЯ-ны мэргэжилтэн Отгон, Англи хэлний хөтөлбөрийн ажилтан АлисМуре нар ирж Америкийн Соёл мэдээллийн Төвд ажиллаж "Access" 4 хөтөлбөрийн сурагчдын төгсөлтийн Сертификат гардууллаа.

Америкийн тэмдэглэлт өдрүүд болох Аймшгуудын байр, Мартин Лүтер Кингийн тэмдэглэлт өдөр, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Мөн оюутан сурагчдын англи хэлний мэдлэг дээшлүүлэх зорилгоор "Хэлтэй бол хөлтэй", "Пирамид", "АХА" тэмцээнүүдийг Англи хэл дээр "Оюуны оньс", "Монгол зан үйлээс суралцъя", "Уншигчдын бага хурал" зэргийг монгол хэл дээр бусад номын санчидтай хамтран зохион байгууллаа.

Америкийн соёл мэдээллийн төвөөс сурагчдын англи хэлний мэдлэг боловсрол дээшлүүлэх зорилгоор "Access" хөтөлбөр 5 дахь удаагаа сурагчдаа шалгаруулж нийт 20 сурагч хамрагдаад байна. Эдгээр хүүхдүүд англи хэлийг 2 жилийн хугацаанд Америкийн Элчин Сайдын Яамны зардалаар үнэ төлбөргүй суралцах бөгөөд тэд орон нутагт явагдах Англи хэлний шалгалтанд тогтмол дээгүүр байранд шалгарч байна. Тус төвийн үйлчлүүлэгч оюутан сурагчид, уншигч иргэдийн дунд Англи хэлний мэргэжилтэн нар байнга сургалт семинар явуулдаг бөгөөд Гадаад мэргэжилтэн Англи хэл заах болсоноор англи хэл сонирхогчдын тоо нэмэгдэж, сургалтын чанар сайжрах боллоо.

Соёл олон нийтийн ажил

Дээрх жилүүдэд номын сангийн тасаг танхимуудаас иргэдийг гэгээрүүлэх, тэдний оюун, танин мэдэхүйг хөгжүүлэх зорилгоор сургалт сурталчилгааны олон талт арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

2012 онд танин мэдэхүйн уралдаан тэмцээн 38 удаа явуулж түүнд 3200, тойм яриа 24 удаа зохион байгуулж 1026, Урилгат уншлага 6 удаа зохион байгуулж 98 уншигч оролцож, 18 удаагийн номын өдөрлөг 2334, үйлчлүүлэгч, дүрийн тоглолт 4 удаа явуулж 126 уншигч тус тус оролцож 88 удаагийн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.

СОНА нь Монголын багш нарын баярыг угтаж явуулсан “Багшдаа барих миний бэлэг” сэдэвт номын аян уралдаан тэмцээнээр эхэллээ. Уг арга хэмжээг Поргресс сургууль дээр зохион байгуулсан бөгөөд тус багш сурагчид идэвхтэй оролцсон.
2012 оны 2 дугаар сард Ховд аймагт амьдардаг гадаад иргэдэд Монгол ёс заншилд суралцуулах сурталчилах, зорилгоор “Монгол ёс заншил” сэдэвт танин мэдэхүйн уралдаан тэмцээн явуулсан. Уг тэмцээнийг АСМТөв, Насанд хүрэгчдийн уншлагын тасаг танхимаас хамтран зохион байгуулсан бөгөөд Ховдод амьдарч байгаа гадаадын 12 иргэн оролцсон байна. Мөн Үл мэдэх танхимаас Монголын цагаан сарыг тохиодуулан “Монгол ёс заншлаас суралцъя” сэдэвт 21 хоногийн уншлага үйлчилгээний аян зохион байгууллаа. Энэ үеэр “Уламжлалт ёс заншлаа хэн сайн мэдэх вэ” танин мэдэхүйн АХА, “Дөрвөн бэрх” тэмцээн тус тус явуулсан. Үүнд 12 жилийн 3-р сургуулийн 3-5 дугаар ангиуд идэвхтэй оролцлоо.
ЕБС-ийн анги хамт олны дунд Монголын багш нарын баярыг тохиолдуулан “Багшдаа барих миний бэлэг”, Олон улсын эмэгтэйчүүдийн баяраар “Ээждээ барих миний бэлэг”, сэдэвт уншлага үйлчилгээний аян зохиохоос гадна уран зураг, зохион бичлэгийн уралдаан зарлаж явууллаа. Мөн Казак иргэдийн дунд тэдний ёс заншилаас суралцах сурталчилах зорилгоор 2012 оны 03 сар Наурызийн баярыг тохиолдуулан 12 жилийн 2-р дунд сургууль дээр казак хэлээр зохиогдсон номын үзэсгэлэн гаргаж, 14 хоногийн аян зохион байгуулж дүгнэлээ.
Манай байгууллага Ховд аймгийн залуучуудын холбоотой хамтран “Өнгөрсөн дөрвөн сарын нэгэн” шилдэг онигоочдын баярыг жил бүр зохион байгуулдаг. Энэ удаад нийтдээ 12 онигоочид оролцсоноос Мөнххайрхан сумын иргэн яруу найрагч Бүрнээ тэргүүллээ.
2012 оны 05 сард “Монгол бичиг үсгийн баярыг аймгийн Боловсрол, соёлын газартай хамтран зохион байгууллаа. Энэ үеэр сурагчдын дунд “Цэвэр гоё бичигтэн” “Уран бичлэгийн уралдаан” зэргийг зохион явууллаа. Мөн угийн бичгийг сэргээх зорилгоор сургалт семинар зохион байгууллаа. Угийн бичиг хөтлөх сургалтан одоогоор 22 байгууллагын 28 сургагч багш бэлтгэгдээд байгууллага дээрээ сургалт явуулж байгаа бөгөөд 204 өрхийн 638 хүн хамрагдаад байна.
“Нээлттэй хаалганы өдөр” Байгууллага сар бүр нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж иргэд, уншигчдад үйл ажиллагаагаа илүү нээлтэй хүртээмжтэй хүргэхийн тулд байгууллагууд дээр зохион байгуулж эхэлсэн 2012 оны эхний хагас жилд 7 байгууллага дээр тус тус зохион байгуулсан бөгөөд энэ үеэр тухайн байгууллагын онцлогт тохирсон мэргэжлийн номуудаар үзэсгэлэн гаргаж сурталчилах, уншигчдад карт нээж ном уншуулах номын сангийн үйлчилгээг электрон хэлбэрээр танилцуулах, зэрэг ажлуудыг цогцоор нь хүргэлээ.

“Нацаг дорж тэмдэгтэн” болзолын тухайд

Мөн БСШУЯ-ны сайдын 211 дүгээр тушаалыг үндэслэн сурагчдыг ном хэвлэлтэй нөхөрлүүлэх үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих зорилгоор Д.Нацагдоржийн тэмдгийн болзол, журмыг бүх сургуулиудад хүргэн танилцууллаа. Нийт 40сурагч уг болзлыг хангаж тэмдэг үнэмлэх гардаж авлаа.
“Ган үзэг” яруу найргийн наадам. Манай номын сан жил бүр “Ган үзэг” яруу найргийн наадам зохион байгуулдаг. Уг тэмцээнээр сурагчид өөрсдийн бичсэн шүлэг, найраглалаа уншиж танилцуулдаг уламжлалтай. Энэ удаагийн “Ган үзэг” яруу найргийн тэмцээнийг 2012 оны 10-р сарын 18 нд зохион байгууллаа 4 насны ангиллаар явагдсан уг тэмцээнд 203 хүүхэд залуучууд оролцож амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээний шүүгчээр Монголын зохиолчдын эвлийн гишүүн 2010 оны Болор цом” яруу найргийн тэмцээний эзэн Хөөдөөгийн Эрдэнэбаатар тэргүүтэй хүмүүс шүүн явууллаа.
Монголын нууц товчоо залах үйл ажиллагаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 2дугаар сарын 18-ны өдрийн 23 тоот зарлигын дагуу Монголын ард түмний олон зууныг өртөөлсөн үндэсний соёлын гайхамшигт өв сан Монголын нууц товчоог эрхэмлэн дээдлэн залах ажиллагааг 2012 онд шинээр байгуулагдсан “Прогресс” сургууль дээр явууллаа. Уг үйл ажиллагаанд Номын санчдаас гадна тус аймгийн Засаг даргын Тамгын газрын удирлагууд Сургуулийн багш ажилчид оролцлоо. Хүрэн ширэн хавтсаар хайрцагласан крил хэл дээр бичигдсэн эртний бүтээлийг дээдлэн залахад тус сургуулийн багш, ажилтан, сурагчид хүндэтгэлтээгээр хүлээн авч хойморьтой заллаа.
“Шувуун саарал” уран уншлага, богино өгүүллэгийн наадам. “Шувуун саарал” богино өгүүллэгийн наадамд 2012 оны 11 сарын 25 нд зохион байгуулагдлаа. Уг наадамд 4

насны ангиллаар явагдсанаас бага насны ангилалд 18, 7-9 дүгээр ангийн сурагчдын дунд явагдсан богино өгүүлэгийн наадамд 17 хүүхэд л 10-11-р ангийн ангилалд 8 нийт 43 сурагч оролцлоо

Ажилчдын нийгмийн асуудал, шагнал урамшил, мэдлэг чадвар дээшлүүлэх талаар
Манай байгууллага ажилчдыхаа мэдлэг чадвар дээшлүүлэх талаар байнга анхааран ажилдаг. Номын санч каталогч Д.Оюунчимэг Соёлын дээд сургуулийн номын сангийн эчнээ сургуульд хамрагдан амжилттай суралцаж төгслөө.
Гадаад хэлний уншлагын тасгийн ажилтан В.Алтанцэцэг 2012 оны 03 сарын 23-28- ны өдрүүдэд мэргэжлийн зөвлөгч нарын болон Англи хэлний гүнзгийрүүлсэн сургалтанд хамрагдаж мэргэжил дээшлүүллээ. Тэрээр 2012 оны 04 дүгээр сард Малайз улсад олон улсын бага хуралд оролцоод илтгэл хэлэлцүүлээд ирлээ.
Ажилчдын ажлыг сар улирлаар төлөвлөн ажил үүргээ сайн гүйцэлдүүлэн ажилчдыг улиралд нэг удаа ур чадварын нэмэгдэл өгч, захиралтай байгуулсан үр дүн, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэн ажиллаж байна.
Ажилчдын мэдлэг мэргэжил дээшлүлэх, ажлын туршлага солилцох зорилгоор Завхан аймгийн номын сантай танилцах ажлыг зохион байгууллаа. 2012 оны 06сарын 30- 07 сарын 02 нд явагдсан уг үйл ажиллагаанд нийт 11 номын санч оролцож мэдлэг чадвараа дээшлүүллээ.
Номын санд олон жил үр бүтээлтэй ажиллаж байсан ахмад буурлуудаа Монголын цагаан сар угтаж байгууллага дээрээ хүлээн авч санаа бодлыг нь хуваалцаж 5 ахмад ажилтан тус бүрийг 20.000 төгрөгөөр шагнаж урамшууллаа.

Олон нийтийн ажил , гадна орчны тохижилт

2012 он Ховдчуудын хувьд Ховд аймгийг Манжаас чөлөөлсний 100 жилийн ой угтаж тус байгуулагаас 14 бүтээлч ажил зохион байгуулахаар төлөвлөн ажиллаа.
Юуны өмнө аймгийн Засаг даргын Тамгын газар, Жаргалант сумын Тамгын газар, хот тохижуулах албанаас зохион байгуулсан хаврын ажилд идэвхтэй оролцож, ойр орчныхоо хог цэвэрлэх хайс хамгаалалтай сайжруулах, мод бут тарих ажлуудыг удирдамж зааврын дагуу хийж гүйцэтгэлээ. Энэ хүрээнд байгууллагад 20м газар саад татах, барилгын гадна дотно шохой будаг хийх, номын өргөөний гадна дотно засварлах ажилд1.5 сая төгрөгний ажил хийж гүйцэтгэлээ.

Цаашид:
1.Номын сангийн фондын бүх ном хэвлэлийг 2013 оны 06 сарын 30 гэхэд электрон каталогт оруулж дуусгах
2. Номын сангийн техник хэрэгсэл шинэчлэн солих
3. Номын сангийн шинэ барилгын зураг дизиан холбогдох зардал гаргаж удирдалгуудаар батлуулах.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2012 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2012.03.19

Аймгийн нийтийн номын сан нь 2012 онд аймгийн соёлыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, түүнийг сурталчлан уншигчдад хүргэх, номын сангийн үйлчилгээнд шинэ техник, технологи нэвтрүүлэх, уншигчдад үйлчлэх таатай орчин бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаа.

Нэг. Удирдлага, бүтэц зохион байгуулалтын талаар

Тайлангийн хугацаанд тус номын сан нь 15 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж ажилтан бүртээ бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээ хийж хагас бүтэн жилээр дүгнэн ажиллаж байна.

Долоо хоног бүрт номын сангаас зохиох ажлын төлөвлөгөө, ажлын явц, тулгамдаж байгаа асуудлуудыг нийт ажиллагсдын хурлаар хэлэлцэн шийдвэрлэж ажиллаа.

Монгол болон гадаад хэлний төрөлжсөн 2 үндсэн фонд, 140 суудалтай үйлчилгээний 3 танхим ажиллаж танхим тус бүр нь өргөн хэрэглээний ном хэвлэлийн ойрын фондоо чөлөөт сонголттойгоор зохион байгуулж уншигчдад ном хэвлэлээр үйлчлэх ажил үйлчилгээг явуулж байна.

Хоёр. Уншлага үйлчилгээний талаар

Тайлангийн хугацаанд танхимууд 3263 уншигч шинээр бүртгэж 29930 ирэгсдэд 38856 ш ном хэвлэл олгож үйлчиллээ. Үүнээс нүүдэл, зөөврийн номын сангаар 115 уншигч шинээр бүртгэж 475 ирэгсдэд 1070 ш ном хэвлэлээр үйлчилсэн нь уншигч, ирц, ном олголтын төлөвлөгөөг 101,8-133% -иар биелүүлсэн. Уншигч хэрэглэгчдэд үнэгүй интернетээр үйлчилж 88 уншигч хүссэн мэдээллээ авсан байна.

Гурав. Фонд баяжилт, ном хэвлэлийн захиалга, бүрдүүлэлт

Хэвлэлийн газруудын каталог, интернет, уншигчдын захиалга, татгалзлын дэвтэр зэргийг үндэслэн 515 нэрийн номын захиалга хийж өгөгдсөн төсвийн дагуу 4927112 төгрөгийн 367 ш ном хэвлэл авч бүрдүүлэлт хийв.

Хандив, тэслөөр 283 ширхэг 3468020 төгрөгийн ном тохимол авч 488511 төгрөгийн тогтмол хэвлэл захиалан нийт 8395132 төгрөгийн 650 ш ном хэвлэлээр фондоо баяжуулав.

Уншлагын танхимд байдаг ч гэсэн хүрэлцээгүй байгаа номнуудыг скайнердан оруулаад түүний PDF өргөтгөлтэй файл руу хөрвүүлээд CD or DVD дээр буулган компьютер дээр үзэх боломжтой болгон өгсөн.

Дөрөв. Ном хэвлэлд хийх техник үйл ажиллагаа

ННА-ын дагуу 3950 ном ангилахаас 4697 нэрийн 6450 ш ном ангилж шинээр авсан номуудад стандартын дагуу техник ажиллагааг хийж анхан шатны данс бүртгэлүүдэд тусган электрон болон уламжлалт каталогийн санд оруулж уншлага үйлчилгээнд гаргаж байна.

Уншлагын танхимуудын ойрын фондонд 183 ш ном хуваарилж данс бүртгэлүүдэд тэмдэглэж хүлээлгэн өгөв.

Тав. Фондын ажил, хадгалалт хамгаалалт, тооллого

Номын тавиурт ном хэвлэлийг төрөл ангийн байрлалтаар 50129 ш ном / Электрон каталогт оруулсан **4200** ш ном, танхимаар олгоод буцааж авсан 538 ш, бар кодыг нь зассан 6029 ш, үзэсгэлэнд гаргасан 506 ш ном, ойрын фондын уншлаганд гаргасан 38856/
Үзэсгэлэнд гаргасан 506 ш номыг буцааж байрлуулав.

Фондын номонд төрөл анги, үсэг дараалалын байрлалтанд зориулсан ялгагч 77 ш-ийг хийж байрлуулсан.

Ахуйн чийгшүүлэгч болон савтай ус ашиглан фондын өрөөний агаарын чийгшлийн хэмжээг хэвийн байлгах арга хэмжээ авч чийгшлийн хэмжээг боломцооны хэрээр дээшлүүлж байсан.
Фондоос уншлагын танхимуудад уншигчдын захиалгаар 817 ш ном хэвлэл уншлаганд гаргаж захиалгаар гарсан 538 ш ном хэвлэлийг уншлагын танхимуудаас шалгаж буцааж авлаа.

2011 оны Зууны мэдээ, Өдрийн сонинуудыг /24 нэгж болгон хавтасласан/хүлээн авч тавиурт хаяг хийн байрлуулсан.

Шилдэг ном-2011 болон бусад хандив, төслөөр ирсэн номуудыг сумын номын сан болон сургуулиудад хуваарилж тараах ажлыг зохион байгуулж нийт 5707 ш ном хуваарилж тараав. Үүнд:Сумын номын сангуудад Шилдэг ном-2011 656 ш, 23 сумын номын санд 2344 ш ном, ЕБС-ийн 34 сургуульд 1261 ш ном, 37 цэцэрлэгт 637ш ном тус тус хуваарилж тараалаа. Мөн эхний хагас жилд сургуулийн н/с-уудад 809 ш ном хуваарийн дагуу хүргүүлэв.
Фонд 1-ын номын 18 тавиурын хажуу талыг ислэг хавтангаар битүүлж, тавиурын заалтуудыг бичиж хадав.

501 ш номонд сэлбэн засалт хийж номын эдэлгээг уртасгалаа. Үндсэн фондын номын тавиуруудыг будаж өнгө үзэмжийг нь сэргээв.

Ойрын фондуудын ээлжит тооллогыг 1 удаа хийж 7142 ш ном тоолон тооллогын тэмдэг тавин нэгбүрчилсэн бүртгэлтэй тулгаж тэмдэглэв.
Гэрийн тасгийн агуулгаар хуучирсан 3000 ширхэг номыг тоолж тооллогын тэмдэг тавин үндсэн фонд руу буцаан авч зөөж байрлуулав.

Зургаа. Каталогийн ажил
Электрон каталогт оруулах ном хэвлэлийг каталогтой тулгаж электрон каталогийн санд оруулах 9550 ш ном оруулахаас 9466 ш ном орууллаа. 3240 ш карт хэвлэж уламжлалт каталогт байрлуулав. 9466 ш бар код хэвлэж хайчлан наав. Үсэг дараалалын уламжлалт каталогийн 8285 картанд редакц хийж ангилал байрлалын засвар хийв. 4000 картыг скочоор бүрж каталогийн картны эдэлгээг сайжруулав.

Мэдээллийн электрон каталогийн санд редактор хийж 4154ш /ангилал, түлхүүр үг, гарчиг, товч агуулгад/ номыг нэг бүрчлэн тулгалт хийж алдааг засаж орхигдсон мэдээллүүдийг нэмж оруулан баазыг цоожлов. 1084нэрийн 2278 номын ангиллыг өөрчлөв.
Номын сангийн програмд 29802ш үсэг дараалалын зохиогчийн 3 тэмдэгтийг оруулж каталогийн үйл ажиллагаанд хэрэглэж байна.

Долоо. Лавлагаа номзүйн ажил

Лавлагааны фондоо тогтмол шинэчлэн баяжуулж танхим бүр өөрийн онцлогт тохируулан лавлагааны буланг ажиллуулж байна.

Уншигчдын асуусан төрөл бүрийн лавлагаанд тухай бүрд нь хариулт өгч аман лавлагаа 237 удаа өгч аман лавлагааны дэвтэрт бүртгэсэн.

Бичгийн лавлагааг Академич Базарын Ширэндэвийн намтар уран бүтээлээр хийсэн номзүй, уран бүтээлийн жагсаалт, намтар уран бүтээлтэй холбогдол бүхий интернет мэдээлэл зэрэг сэдвээр академичийн 100 жилийн ойд зориулан зохион байгуулж байгаа зохион бичлэг, илтгэл, эссэ бичвэрийн уралдаанд оролцогчдод зориулсан гарын авлага бэлтгэж Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ганболд, мэргэжилтэн Нарангэрэл, сумдын соёлын төвийн захирлуудад Далай ван сургуулийн бага ангийн Мааньгүмбэн багш зэрэг 24 хүнд бичгээр болон файлаар өгсөн.

Мөн сэтгүүлч Д.Сүрэнжав, Б.Бат-Эрдэнэ нарт номын санд хадгалагдаж байгаа өөрийнх нь уран бүтээлийн лавлагааг бичгээр өгөв.

“Шинэ ном”, “Монгол ардын аман зохиол”, “Далантайн Сүрэнжавын уран бүтээлүүд”, “Базарын Ширэндэвийн уран бүтээлээс”, “Шилдэг ном-2011”, “Чингис хааны 850 жилийн ойд”, “Д.Нацагдоржийн намтар уран бүтээл”, “Үндсэн хуулийн өдөр”, “Балдангийн Бат-Эрдэнийн намтар уран бүтээл”, “Дэлхийн сонгодог утга зохиолоос”, “Хүүхдийн эрхийн өдөрт” зэрэг сэдвүүдээр 327 нэрийн номонд санамж өгөх номзүй хийж, “Байгаль хамгаалах өдөрт”, “Мэргэжил бүхэн сайхан”, “Эх түүх соёлоо уншья, мэдье”, “Ардын аман зохиолоос” зэрэг сэдвүүдээр 306 нэрийн номонд бүртгэн мэдээлэх номзүй хийж, “Шинэ ном”, “Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр”, “Монголын зэвсэгт хүчний өдөрт”, “Эрүүл мэндийн өдөрт”, “Дэлхийн номын өдөр”, “Монголчуудын үсэг бичгийн түүх соёлоос”, “Эх үрсийн баяр”, “Академич Базарын Ширэндэвийн 100 жилийн ойд”, “Монгол бахархал”, Их жанжин Сүхбаатар, “Байгаль орчныг хамгаалах өдөрт”, “Элсэлтийн ерөнхий шалгалт-2012”, “Д.Намдагийн намтар уран бүтээл”, “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт”, “Хүний эрхийн өдөрт” зэрэг сэдвүүдээр 679 номын жагсаалт, Академич Б.Ширэндэвийн мэндэлсний 100 жилийн ойд зориулж намтар номзүй гаргаж ном хэвлэлийн сурталчилгаа хийсэн.

Мэдээлэл сурталчилгааны самбарт 45 сэдвүүдээр 50 гаруй удаа мэдээлэл гаргаж уншигч хэрэглэгчдэд хүргэлээ.

Найм. Соёл олон нийтийн ажил

Номын сангийн сан хөмрөгт байгаа ном хэвлэлийг уншигчдад хүргэх, тэдэнд хэрэгцээ шаардлагатай мэдээллийг хүргэхийн тулд төрөл бүрийн хэлбэрээр СОНА-ыг зохион явууллаа.

Шинэ номын үзэсгэлэн 25 удаа 363 ш номоор, сэдэвчилсэн номын үзэсгэлэн 45 удаа 807 ш ном хэвлэлээр гаргаж уншигч хэрэглэгчдэд танилцуулсан.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг цаг үеийн онцгой байдал, тэмдэглэлт үйл явдлуудтай холбогдуулан гаргаж байлаа. Монголын зохиолчдын эвлэл байгуулагдсан өдрийг тохиолдуулан “Зохиолч уншигчдын уулзалт”,

Яруу найрагч Б.Сарантуяатай хийсэн уулзалт **Уулзалтанд оролцогчид**

“Нийгмийн амьдрал хүүхдийн эрх” сэдэвт АХА тэмцээн /9 сургуулийн 250 гаруй сурагчид оролцов/, Монголын багш нарын өдрийг тохиолдуулан Монголын сурагчдын холбоотой хамтран “Багш-шавийн уулзалт” зохион байгуулж гавьяат багш Доржжүгдэрийг урьж оролцууллаа. Уулзалтанд 40 гаруй уншигчид оролцож сонирхолтой асуулт, хариулт явагдаж ахмад багшийн зөвлөгөө сургаалийг сонсов.

МУГБ 8-р сургуулийн сургалтын менежер Доржжүгдэр багштай хийсэн уулзалт

Монгол улсын соёлын тэргүүний ажилтан, МУ-ын билэг авьяастан, цуурч залуу, хүннү цуурын холбооны тэргүүн цуур хөгжмийг анх ЮНЕСКО-д бүртгүүлсэн Б.Наранбаатарыг урьж уншигч нарт цуур хөгжмийн талаар мэдээлэл, тойм яриа

хийлгэв. Уг мэдээллээр цуур хөгжимийг анх хэдэн онд дэлгэрсэн ЮНЕСКО-д анх яаж бүртгүүлж байсан гээд олон сонирхолтой мэдээллийг уншигчдад хүргэлээ.

Цуур хөгжмийн тухай уншигчдын Сонирхсон асуултанд хариулт өгөв. **цуур хөгжим тоглож сонирхуулав.**

Үндэсний бичиг соёлын өдөрт зориулав. **Байгаль хамгаалах өдрөөр**

Шүлгийн уралдаанд оролцогчид
Төгсөх ангийнханд

НҮБ-ийн Соёл, урлагийн хорооноос жил бүрийн 4-р сарын 23-ыг "Дэлхийн номын өдөр" болгохоор 1995 онд албан ёсоор зарласан билээ. Энэ гэгээлэг өдрийг угтаж Аймгийн төв номын сангаас нийт уншигчиддаа зориулан "Номын анд" 20 хоногийн аяны үйл ажиллагааг зохион явууллаа.

Уг аяны хүрээнд "Дэлхийн сонгодог утга зохиолын сангаас" сэдэвчилсэн номын үзэсгэлэн зохион байгуулж, хүүхдийн уншлагын танхимаас "Ардын аман зохиолоо судалъя, суралцъя" өдөрлөг, Бага ангийн сурагчдын дунд 10 минутын идэвхтэй уншлага, Гэрээр ном олгох уншлагын танхимаас төгсөх ангийн сурагчдад зориулсан "Амьдралын анхны гишгүүр" сэдэвт теле хэлэлцүүлэг, Орон нутгийн номын санчдад "Номын сан- мэдээллийн технологи" сэдэвт сургалт зэрэг ажлуудыг удирдамж, төлөвлөгөө, хөтөлбөр гарган зохион байгууллаа.

"Дэлхийн сонгодог утга зохиолын сангаас" сэдэвчилсэн номын үзэсгэлэнг өөрийн номын сангийн фондонд байгаа дэлхийн сонгодог бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж үзэсгэлэнгийн номуудад товч тайлбар бичиж сурталчлав. Дэлхийн сонгодог утга зохиолоор танхим болгон үзэсгэлэн гаргаж уншигчдын хүртээл болголоо. Мөн дэлхийн номын өдрийн тухай ном хэвлэл, интернет зэрэг мэдээллийн олон эх сурвалжуудаас авсан мэдээнүүдээр мэдээлэл сурталчилгаа хийв. Үзэсгэлэнд гаргасан номуудаар сэдэвчилсэн жагсаалт гаргасан.

"Ардын аман зохиолоо судалъя, суралцъя" сэдэвт өдөрлөгийг ЕБС-ийн сурагчдын дунд зохион явуулав. Уг өдөрлөгөөр ардын аман зохиолын сэдэвт уралдаант тэмцээнүүдийг зохион явууллаа. "Ардын аман зохиолоо судалъя, суралцъя" сэдэвт үзэсгэлэнг хүүхдийн уншлагын танхимд Ардын дуу, Оньсого таавар, Зүйр цэцэн үгс, Ерөөл магтаал, Домог, хууч яриа, Үлгэр, туульс, Ардын аман зохиолын тухай гэсэн төрөлжсөн хэлбэрээр гаргаж уралдаан тэмцээнд оролцох уншигчдад мэдлэг, мэдээлэл өгч байв. Үзэсгэлэнд гаргасан номуудад товч тайлбар бичиж гаргах, мэдээллийн олон сувгаас хайлт хийн аман зохиолын төрөл бүрээр мэдээлэл гаргаж сурталчилгаа хийв. Өөрийн номын сангийн фондонд байгаа аман зохиолын номуудаар санамж өгөх номзүйг 23 ш номоор, бүртгэн мэдээлэх ном зүйг 59 номоор хийж аман зохиолын ном хэвлэлийн сурталчилгаа хийлээ..

Тэмцээн наадам явуулах өрөө тасалгааг сэдэвт ажлын орчныг бүрдүүлж тухайн сэдвүүдээр ишлэл, төрөл бүрийн мэдээлэл, зураг байрлуулж чимэглэл хийв. Тэмцээний хөтөлбөрийг гаргаж оролцогч нарт танилцуулан бэлтгэлийг хангуулав. Өдөрлөгөөр:

- домогт дууны тэмцээн
- бэлэг дэмбэрэлийн үгээр уралдах
- Оньсого таалцах
- Дайралцаа үгээр тэмцэлдэх
- Түргэн хэллэгийн тэмцээн
- Хошин шог яриа
- Ертөнцийн гурваар уралдъя зэрэг тэмцээнүүдийг зохион явуулж аваргыг шалгаруулан дүгнэв.

Уг уралдаан тэмцээнүүдэд Далай ван, ДМЦС, 2р сургуулиудын багш сурагчид идэвхтэй оролцлоо. Тэргүүн байранд Далай ван сургуулийн Мааньгүмбэн багштай 5[а] анги, ДМЦС-ийн Цулаа багштай 7[и] ангийн багууд орж тэргүүллээ.

Дэлхийн номын өдөртэй холбогдуулан номын сангаа сурталчлах таниулах, номын сангаас мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх, хүүхдийн санал бодлоо хэлэх, өөрийгөө илэрхийлэх нээлттэй байхыг дэмжих, ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход нь туслах, нөлөөлөх, сонгох гэж буй мэргэжлийн нь талаар тодорхой мэдээлэлтэй зорилгоор уламжлал болгон 2 дох жилдээ явуулж байгаа “Амьдралын анхны гишгүүр” телевизийн хэлэлцүүлэг нэвтрүүлгийг явууллаа.

Уг хэлэлцүүлэгт Мөрөн сумын нийт ЕБС-ийн 11-р ангийн сурагчдын төлөөлөл 50 гаруй сурагчид оролцож санал бодлоо солилцон зөвлөгөө авав.

Нэвтрүүлэгт БСГ-ын өв соёл хариуцсан мэргэжилтэн Баасансүрэн, Номын гүүр боловсрол төвийн зохицуулагч Баасандулам, Газрын харилцаа барилга хот байгуулалтын мэргэжилтэн Цолмон, Хөвсгөл аймгийн эрх зүйн боловсрол мэдээллийн төвийн тэргүүн Мягмарсүрэн, Хөвсгөл аймгийн Хас банкны борлуулалтын менежер Батнягт нар урилгаар оролцож Соёл, боловсрол, гадаад хэлний мэргэжил, гадаадад суралцах боломжуудын тухай, барилгын инженер, архитектор, бусад инженер, нийгэм, хууль эрх зүй, эдийн засгийн мэргэжлүүдийн талаар мэдээлэл зөвлөгөө зөвлөмжүүдийг оролцогчдод өгч тэдний асуусан асуултанд хариулт өгөв.

“Амьдралын анхны гишгүүр” нэвтрүүлэг явагдах танхимд их, дээд сургуулиудын танилцуулга, болон төрөл бүрийн мэргэжилтэй холбогдол бүхий мэдээ матерталуудаар үзэсгэлэн гаргав. Мөн “Мэргэжил бүхэн сайхан” номын сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж сурталчилгаа хийв.

Дэлхийн номын өдрийн тухай танилцуулга хийж 4-р сарын Бестселлер номуудаар мэдээлэл гаргаж сурталчилсан.

Телевизээр цацагдах нэвтрүүлгээр манай аймгийн төгсөх ангийн сурагчдын мэргэжил сонголт, болон төгсөгчид ажлын байраар хэрхэн хангагдаж байгаа зэрэг статистик мэдээг бэлтгэж мэдээлсэн.

Уг теле нэвтрүүлэгийн Хөвсгөл аймаг дахь сурагчдын холбоотой хамтран явуулав.

Дэлхийн номын өдрийг угтаж Монголын сурагчдын холбооны хөвсгөл аймаг дахь салбар Монголын залуучуудын холбооны Хөвсгөл аймаг дахь салбар Хөвсгөл аймгийн Далай ван коллежийн оюутны зөвлөл, Чандмань телевизтэй хамтран Далай ван коллежийн 1-3 курсын нийт 15 ангийн 60 хүүхдийн дунд алтан хонх тэмцээнийг зохион явуулсан. Уг тэмцээний үеэр монголын сурагчдын холбооны тэргүүн Ж.Болдбаяр **“Нийгмийн амьдрал дахь залуучуудийн оролцоо”** сэдэвт лекц уншсан. Мөн Монголын залуучуудын холбооны Хөвсгөл аймаг дахь салбарын гишүүн ÓÒÁÀ-èéí áààø Á.Ìºíãºí-Ýðäýíý **“Номтой хэрхэн ажиллах вэ”** сэдэвт лекцийг уншиж уншигч, залуучуудад сурталчилгаа хийв. “Алтан хонх” тэмцээнд тэргүүлэгчдийг 1-3-р байр эзлүүлэн шагнаж урамшуулсан.

Төгсөх ангийн сурагчдад зориулан гаргасан “Мэргэжил бүхэн сайхан” номын үзэсгэлэн

Теле нэвтрүүлэгт урилгаар оролцсон мэргэжилтэнгүүд

“Амьдралын анхны гишгүүр” теле нэвтрүүлэгт оролцогчид

Теле нэвтрүүлгийн үйл ажиллагаанаас....

Орон нутгийн “Чандмань” телевизэд Аймгийн Нийтийн номын сангаас Дэлхийн номын өдөрт зориулан зохион байгуулсан “Номын анд” 20 хоногийн аяны хүрээнд явуулсан ажлуудын тухай товч мэдээлэл өгөв.

“Монгол ардын аман зохиолоо судалъя, суралцъя” сэдэвт уралдаант тэмцээн

2р

Домогт дууны тэмцээнд

2р сургуулийн сурагч Тэгшжаргал охин” “Сэндэр охин” 1,5 оноо

ДМЦС-ийн сурагчид “Сэндэр 2,5 оноо авлаа

Бэлэг дэмбэрэлийн үг хэн олныг мэдэх вэ тэмцээнд:

/зүүн гараас/ 2р сургуулийн $7^{б}$ ангийн Долгор, ДМЦ сургуулийн $7^{и}$ ангийн сурагч Өлзий бүрэн нар өрсөлдөж багтаа оноо авцгаалаа.

Оньсого таалцах тэмцээн

Дайралцаа үгийн тэмцээнд багууд харилцан тэмцэлдэв.

ДМЦС-ийн 7р ангийн баг 3 оноогоор 2р сургуулийн

7р ангийн баг 2 оноо- гоор удаалав.

Түргэн хэллэгийн тэмцээн. ДМЦС-ийн Түвшин, 2р сургуулийн Бавуудорж нар өрсөлдөж сурагч Түвшин түрүүлэв.

ДМЦС-ийн багийн “Хөгжилтэй гэр бүл” хошин шог яриа

Багуудын дунд болсон “Ертөнцийн гурвыг хэн олныг мэдэх вэ?” тэмцээн ДМЦС-ийн 7р ангийн баг 1 оноо

2р сургуулийн баг 3 оноогоор тэргүүлэв.

“Номын анд” аяны хүрээнд зохиогдсон Ажлуудад сурагчдаа идэвхтэй хамруулсан Багш Цулаа

Тэмцээнд идэвхтэй оролцсон 2р сургуулийн багийн ахлагч

ДМЦС-ийн багийн Өлзийбуян хамгийн 2р сургуулийн багийн хамгийн идэвхтэй идэвхтэй оролцогчоор шалгарав.

Тэргүүний уншигчдыг шагнаж урамшуулав

Уулзалтанд оролцсон зохиолчдоос дурсгалын гарын үсэг авч байна.

Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан Хөвсгөл аймгийн асрамж үйлчилгээний төвд амьдарч байгаа ахмадуудын дунд өдөрлөг зохион байгууллаа. Уг өдөрлөгөөр Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн сурагчдыг урьж урлагийн тоглолт үзүүлж сэтгэл зүйн дэм үзүүлэн мөн хөвсгөл аймгийн соёлын салбарын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцуулж, ОНСМузей үзүүлэн түүх соёлын үнэт

үзмэрүүдийг үзүүлж сонирхуулав. Энэ өдөрлөгийн бас нэг үйл ажиллагаа болох тус төвийн үйлчлүүлэгчдийг нийтийн номын сангийн уншигч болгож номын сангийн карт хүн бүрт үнэгүй нээсэн. Тус төвийн номын санд номын хандив өргөв.

Мөн дэлхийн яруу найргийн өдрийг тохиолдуулан яруу найрагч Пүрэвжалын Майнбаяртай “Зохиолч, уншигчдын уулзалт”-ыг 2-р сургуулийн 10 дугаар анги болон Далай ван сургуулийн 10 ангийн сурагчтай хамтран зохион байгуулав. П.Майнбаярын намтар уран бүтээлээр хүүхдийн уншлагын зааланд үзэсгэлэн гаргаж ном хэвлэлийн сурталчилгаа хийв.

Хилийн цэргийн 0257 ангийн номын сангийн нээлтэнд оролцож номын хандив өргөж тус ангийн бие бүрэлдэхүүнд өөрийн номын сангийн үйл ажиллагааг танилцуулж ном унших ач холбогдол, ном унших арга, ном унших соёлын талаар номын санч Г.Оюунбилэг лекц уншив.

Б. Ширэндэвийн 100 жилийн ойд Далай ван сургууль дээр намтар уран бүтээлээр нь үзэсгэлэн гаргаж хүмүүст сурталчилгаа хийв. Ц. Дамдинсүрэнгийн 104 жилийн ой Ч. Лхамсүрэнгийн 95 жилийн ой, Д.Намдаг, С.Пүрэв, Д.Нацагдорж, Чингис хааны мэндэлсэний 850 жилийн ойд түүний тухай зурагт альбом хийж намтар уран бүтээлээр уншлагын танхимд сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж номын тухай зурагт хуудас хийв. Эх үрсийн баярыг угтаж нээлттэй хаалганы өдөрт оролцож номын сангийнхаа үйл ажиллагааг харуулсан үзэсгэлэн гаргаж сурталчилгаа хийв.

Номын анд өдөрлөгийг угтаж заавал унших 10 шүлэг, үлгэрүүдийг уншуулж, зургийн уралдаан зарлан уншигч хүүхдүүдийн бүтээлийн үзэсгэлэн гаргаж байр эзлүүлэн шалгаруулж урамшуулав. Үүнд 48 сурагч идэвхтэй оролцсон.

Урилгат уншлага 2 удаа / II сургуулийн 7^{г}, 7^{д} ангиудыг хамт олноор нь урьж, карт нээж, номын сангийн үйл ажилгаатай танилцуулж, хамтран ажилсаны үр дүнд сурагч Батсуурь тэргүүний уншигчаар шалгарсан.
Бүтээлч уншлага 3 удаа Далайван сургуулийн 5^{а} ДМЦ сургуулийн 8^{г} II сургуулийн 3^{б} ангийн сурагчдад хамрагдсан.
Чанга яриа 20 удаа, шинэ номын мэдээлэл тойм яриа 26 удаа хийж ном хэвлэлийн сурталчилгаа хийв.

Ес. Мэргэжил арга зүйн ажил

Монголын үндэсний номын сангаас 2012 оны 4-р сарын 09-өөс 11-ний хооронд зохион байгуулсан "Номын сан-мэдээллийн технологи" сэдэвтэй 24 цагийн сургалтанд Аймгийн ННС-ийн 2 номын санч хамрагдан суралцав.

Орон нутгийн номын санчдын дунд зохион явуулах сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг гаргаж сургалт явуулах бэлтгэл үйл ажиллагааг хангав. "Номын сан-мэдээллийн технологи" сэдэвт 24 цагийн сургалт семинари явууллаа./Танхимуудыг бэлтгэхэд номын санчдад заавар зөвлөгөөг өгөв. МУҮНС-аас зохиосон сургалтанд хамрагдсан номын санч нар хичээл заав./



2012 онд ННС-аас зохион явуулах СОНА-ын төлөвлөгөө гаргаж төлөвлөгөөний дагуу удирдамж, хийгдэх ажлын төлөвлөгөөг гаргаж батлуулан зохиогдож байгаа ажлуудад хяналт хийж тухай бүрд нь заавар зөвлөгөөг өгч байлаа. Зохиогдсон ажлын нэгдсэн тайланг гаргаж байв.

Түнэл, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Эрдэнэбулган, Тариалан сумдын номын сангийн ажилтай танилцаж урьд өмнө өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үзэж арга зүйн зөвлөмжүүдийг өгөв.

Орон нутгийн номын санчдыг сургалтанд ирэхэд нь анхан шатны бүртгэлүүдийг нь

үзэж Рашаант, Цэцэрлэг, Галт, Хатгал, Баянзүрх, Ханх, Алаг-Эрдэнэ, Бүрэнтогтох, Цагаан-Уул, Шинэ-Идэр сумдын номын санчдад бүртгэл хөтлөлтийн талаар гаргасан алдаа дутагдлуудыг хэрхэн засах заавар зөвлөмжүүдийг өгөв.

БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар ирсэн компьютеруудыг бүх сумын номын сангуудад хүлээлгэн өгч компьютерийн анхан шатны

мэдлэг олгох хичээлийг технологийн ажилтан Батцоож номын санч нарт зааж сургалт явууллаа.

Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал, Номын сангийн үйл ажиллагааг автоматжуулахад баримтлах зөвлөмж, ННС гэж юу вэ, Хүүхдийг яаж ном уншихад дуртай болгох вэ, Ном хэрхэн унших вэ, Шинэ номын мэдээ гаргах, Номын сангийн төсөв хархан зохиох, Тэргүүний уншигч-Нацагдорж тэмдэгтэн шагнал олгох журам, Номын аяны удирдамж зохиох тухай, Мэдээ мэдээлэл гаргах тухай, Шинэ ном-2011 санамж өгөх номзүй /150 номоор/, Б.Ширэндэв-100 санамж өгөх номзүй зурагтай, Номын санчийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөний загвар /стандарт нэгжийн нормын дагуу хийсэн/, Ажлын байрны тодорхойлолтын загвар, Болор цомтой шүлгүүд, Хүүхдийн эрх зүй санамж өгөх номзүй, Академич Базарын Ширэндэвийн

намтар номзүй, Б.Ширэндэвийн уран бүтээлийн номзүй жагсаалт, Б.Ширэндэвийн тухай интернэт мэдээллүүд, Ардын аман зохиолын тухай мэдээлэл, Монголын нууц товчоо, Гэсэр, Жангарын тууж номуудын тухай зурагт хуудас, Янз бүрийн үзэсгэлэнгүүдийн хаяг реклам чимэглэл, Номын тухай санамжууд, Дэлхийн сонгодог утга зохиол санамж өгөх номзүй, Тэмдэглэлт өдрүүд, Сумын номын санг ном хэвлэлээр хангах журам, Хүүхдийн хүмүүжилд зөвлөмж, СОНА-ын төлөвлөгөөний загвар, Номын баяр тэмдэглэх тухай, Номын тухай мэргэдийн хэлсэн үг, Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл, Номын тухай санамжууд, Унших номоо хэрхэн сонгох талаар зөвлөмж, Шинэ ном-2012 санамж өгөх номзүй зэрэг 52 сэдвүүдээр арга зүйн зөвлөмжүүдийг 27 номын санчид бичгээр өгөв.

“Аймгийн шилдэг номын санч” шалгаруулах уралдааны болзол гарган хянуулахаар номын сангийн удирдлагад өгсөн.

Номын сангийн ном хэвлэлийг хэрхэн ашиглах, номын санд суух санамж зөвлөмжүүдийг гаргаж мэдээлэл технологийн ажилтнаар бичүүлэн танхимуудад тараалган байрлуулав.

Номын сангийн фонд бүрдүүлэлт, шинээр ирсэн ном хэвлэл, цаг үеийн сэдвээр зохиогдож байгаа ажлуудын талаар орон нутгийн телевизээр **22** удаа мэдээлэл хийв.

10. Санхүү аж ахуйн үйлчилгээ

Монгол Улсын төсвийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулийн дагуу 157 301.1 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулснаас ажилтнуундтай холбоотой зардал 83964.3 төгрөг, бараа үйлчилгээний зардалд 73336.8 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан. Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг мөрдлөг болгон Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу тайлан мэдээг гарган, холбогдох газруудад хугацаанд нь өгч ажилласнаар 2012 онд Аймгийн Төрийн Аудитийн дүгнэлтээр санхүүгийн онц сайн үзүүлэлттэй дүгнэгдлээ. Үндсан хөрөнгийн ашиглалтыг сайжруулахад анхааран ажиллаж Төрийн өмчийн хуулийн дагуу эд хөрөнгийн тооллогыг хийж тайланг Орон нутгийн өмчийн алба болон бусад холбогдох газруудад тайлагнаж ирлээ.

Ажилтнуудын нийгмийн асуудалд анхаарч Нэг удаагийн тэтгэмж болон урамшуулалд нийт 4907.0 төгрөг, урлаг соёл, спортын арга хэмжээнд 506.0 төгрөгийг зарцууллаа.

Тайлангийн хугацаанд ажил үйлсээрээ салбар, хамт олноо манлайлан ажилласан нягтлан бодогч Т.Мягмар, Ахлах номын санч Г.Энхтайван нар Төрийн одон "Алтан гадас" одонгоор, захирал Н.Оюунтуяа "Соёлын тэргүүний ажилтан" цол тэмдгээр Фончин Д.Туул "Аймгийн тэргүүний ажилтан" цол тэмдгээр тус тус шагнагдлаа.

Манай хамт олон Номын сангийн үйлчилгээг иргэдэд нээлттэй, ил тод, шуурхай хүргэх ажилд хичээнгүйлэн ажиллаж Аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын 2012 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээгээр амжилттай дүгнэгдэж "Хоёрдугаар байр" эзэлсэн амжилттайгаар ажиллав.

ТӨРИЙН ШАГНАЛТ ЯРУУ НАЙРАГЧ Р.ЧОЙНОМЫН НЭРЭМЖИТ ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2012 ОНЫ ТАЙЛАН

2012.12.10

Үр дүнгийн гэрээнд тусгагдсан ажил, үйлчилгээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл	Тухайн ажил, үйлчилгээний биелэлтэд менежерийн өгсөн үнэлгээ
1	2	3
А. НИЙТ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БИЕЛЭЛТ		
Бүтээгдэхүүн 1.1 2012 онд байнгын 1200, ирцээр 13300 бүгд 14500 уншигчдад 29700 ном олгож үйлчлэх	2012 онд байнгын 1247, ирцээр 15883 бүгд 17130 уншигчдад 36480 ном олгож үйлчилсэн байна. 993.5 мянган төгрөгний өөрийн орлоготой ажилласан байна. Уншигчдын тоо өмнөх оныхтой харьцуулахад 103.8-108.7%-иар, олгосон ном 112,6%-иар өссөн үзүүлэлттэй байна.	
Бүтээгдэхүүн 1.2 Шинэ номын үзэсгэлэн, мэдээлэл гаргаж, сурталчлах	2012 онд шинээр ирсэн 748 номонд тайлбарт танилцуулга хийж, khentii.mn сайт, Хэнтийн мэдээ сонинд номын сангийн танилцуулга, номын сангаас зохион байгуулсан ажлын тайлан, Ц. Оюунгэрэл “Гэрт болсон яриа”, Б. Сарантуяа “Яг л ээж эгч найз шиг”, “Ярьж эхлээд”, “Эмэгтэй хүний амьдрал 20 наснаас эхэлдэг” зэрэг 25 номуудыг тайлбарын хамт сурталчилж ажилласан. “Нээлттэй хаалганы өдөр”, “Номын баярын өдөр”-өөр, Аймгийн цагдаагийн газар, ЕБ-ын 1,4-р сургууль, Хан Хэнтий цогцолбор, Тэмүүжин цогцолбор сургууль, Цэцэрлэгүүдэд шинэ номын үзэсгэлэн 589 номоор гаргаж, Шинэ номын үзэсгэлэнг танхимуудад 10 удаа гаргаж сурталчилсан.	

Бүтээгдэхүүн 1.3 Мэдээллийн сан ажиллуулах	Сонгосон буюу хандсан хүмүүст зориулсан мэдээллийн сангаар 1.Сумын соёлын төвийн эрхлэгчдэд зориулж “Номын сангийн арга зүйн ажлын зохион байгуулалт” сэдвээр presentation бэлдэж 22 хүнд мэдээлэл хүргэсэн. 2. “Миний монголын ирээдүй” эссэ бичлэгийн уралдааны шилдэг 20 эссэг сурагчдад зориулж бичмэл сэтгүүлээр гаргаж, эссэ бичих гарын авлага болгон ашиглаж байна. 3.Монгол Улсын Их Хурлын 2012 оны 05-р сарын 22-ны өдрийн 52 тоот тогтоолоор баталсан “Төрөөс баримтлах соёлын бодлого”-ыг мэдээллээр бүх сумын соёлын төвийн эрхлэгч ажилчид, номын санчдад нийт 120 гаруй хүнд сурталчилсан. 4. Мод бут сөөг таригчдад туслах зорилгоор “Чацаргана” тарих тухай гарын авлага гаргасан	

Дотоод мэдээллийн сангаар

1.”Хожмын лаатай уншигдах ном”, “Өөртөө сэтгэл санааны амин дэм өгөх арга”, “ Төсөл бичих аргачлал”, “Интерном ХХК-ны борлуулалтаараа тэргүүлж байгаа 10 зохиол”, “Сэтгэлийн нүд” сургамжит өгүүллэгээс, “Архи тамхи шинэ үеийнхний сонголт биш”, “Хүннү”, “Сяньби” зэрэг мэдээлэлийг гаргаж мэдээлэлийн самбараар сурталчилж байна.

2.”Олон улсын хүүхдийн цахим номын санд”-нд “Хөдөөгийн боловсролыг дэмжих төсөл”-өөр бүтээгдсэн монгол хувилбарын хүүхдийн уран зохиолын DVD-г ашиглах зааврыг хүүхдийн уншлагын танхимын 100 гаруй уншигчдад танилцуулсан.

3. ЕБ-ын сургуулийн сурагчдын түүх нийгмийн хичээлд зориулж “Галын учир ба гал тахих ёс” сэдвээр мэдээлэлийг 25 уншигчдад гаргасан

4.Номын баярын өдрийг тохиолдуулан “Ном унших соёл” сэдвээр мэдээлэлийг номын баярт ирсэн нийт 150 гаруй уншигчдад мэдээлсэн

Хууль эрхзүйн мэдээллийн сангаар

1 Уншигчдад хууль эрхзүйн мэдээллээр хангах зорилгоор Аймгийн ЗДТГ-ын Хуульзүйн хэлтэстэй хамтран 80 гаруй хууль тогтоол, ном товхимол, гарын авлагаар “Хуулийн булан” ажиллуулсан.

2.Сумын номын санг ном хэвлэлээр хангах аргачлал, Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэгтэн шалгаруулах журам зэрэг тушаал шийдвэрийг сумын соёлын төвийн эрхлэгч нарт танилцуулж мэдээлэл хийсэн.

3. Номын санд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, тушаалаар хавтас үүсгэн ашиглуулж байна.

4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн дугаар 158 зарлиг болох “Номын баярын өдрийг тэмдэглэх тухай” зарлигийг бүх ард иргэд, уншигчид, номын санчдад мэдээлэл гаргаж сурталчилсан

Орон нутгийн онцлог мэдээллийн сангаар

1.Хэнтий аймгаас төрсөн уран бүтээлч зохиолчдын намтар, уран бүтээлээр ном зүйн бүртгэл хийсэн.

2. khentii.mn сайтад номын сангийн танилцуулгыг шинэчлэн тавьсан мөн орон нутгийн зохиолч яруу найрагч Л. Энхбаатар, Л.Баавай, Ш. Одонтуяа, Ш. Батцэцэг, С. Ган-Эрдэнэ, Н. Цогтбаяр нартай уран бүтээлийн уулзалт, ярилцлага зохион байгуулж, 80 гаруй уншигч оролцлоо.

2. “Нээлттэй хаалганы өдөр”-өөр аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан заалтын биелэлтийн танилцуулга боршуурыг нийт 326 иргэдэд тарааж сурталчилсан.

3. Уншигчид, номын санч нарт зориулж номын сангийн тухай мэдээлэлийг цахим хэлбэрээр түгээх зорилгоор өөрийн байгууллагын вэб сайт http://www.hentii-lavlagaa.blogspot.com/ блогийг ажиллуулж, шинээр 10 мэдээлэл, шинэ номын талаар мэдээлэл блогтоо оруулж, нийт 371 хүн

Бүтээгдэхүүн 1.4 Номын санч, уншигч иргэдэд зориулж бичмэл сэтгүүл гаргаж гарын авлага болгох	Номын санчдад зориулж “Каталог зохион байгуулах аргачлал” сэдвийг сонгож номзүйн бичилтийн стандарт, үсэг дараалал, төрөл ангийн каталог зохион байгуулах талаар бичмэл сэтгүүл гаргаж, аргачлал болгон сумын болон сургуулий номын сангуудад хүргүүлсэн. Уншигч хүүхэд багачууд сурган хүмүүжүүлэгчдэд зориулж “Миний монголын ирээдүй” сэдэвт шилдэг 20 эссэг бичмэл сэтгүүлээр гаргаж, уншлагын танхим болон Хэрлэн сумын ЕБ 1, 4-р сургуулийн номын сангуудад ашиглуулж байна.	
Бүтээгдэхүүн 1.5 Мэдээлэл- лавлагаа номзүйн үйлчилгээ	Орон нутгаас төрж гарсан 50-иад зохиолч, яруу найрагчдын намтар, 239 уран бүтээлээр, хүүхдийн зохиолч Д. Гармаа, Ж. Дашдондог, О. Сундуй нарын намтар болон 47 уран бүтээлээр, С. Буяннэмэхийн мэндэлсний 110 жилийн ойд зориулж 118 бүтээлээр мэдээлэмж тодорхойломжийн аргаар санамж өгөх номзүйн бүртгэл хийж уншигчдад ашиглуулж байна.	
Бүтээгдэхүүн 1.6 Сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж сурталчлах	Монголын уламжлалт баяр цагаан сарыг угтаж “Мэндлэх хүндлэх ёс”, багш нарын баярт зориулан сурган хүмүүжүүлэх сэдвээр, дэлхийн яруу найргийн өдрөөр яруу найргийн номоор, бичиг соёлын хишиг өдрөөр уйгаржин монгол хэл дээр хэвлэгдсэн уран зохиолын номоор, инээдмийн баярт зориулж шог зохиолч Цэнд-Аюуш, Ц. Доржготов, Ж. Барамсайн зохиол бүтээлээр, их дээд сургуульд элсэгчдэд зориулж сэдэвчилсэн номоор, мөн номын баяраар, Р. Чойном, С. Буяннэмэх, О. Сундуй, Д. Гармаагийн амьдрал уран бүтээл зэрэг тэмдэглэлт өдрүүдэд сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 15 удаа 851 номоор гаргаж, 3039 уншигчид үзэж сонирхсон байна.	

Бүтээгдэхүүн 1.7 “Бичиг соёлын хишиг өдөр” – ийг зохион байгуулах	Хэл уранзохиолын багш нарын дунд сургалтын орчинг бүрдүүлэх, хичээлийн хэрэглэгдэхүү-нийг нэмэгдүүлэх зорилгоор хичээлийн программд орсон ардын аман зохиол, яруу найраг, үргэлжилсэн үгийн зохиолоор монгол бичгээр 2-оос доошгүй судар бүтээх уралдаан зарлаж явуулсанаас ЕБ-ын I сургуулийн багш нар 3 судар, Хан Хэнтий цогцолбор сургуулийн багш нар 3 судар, Тэмүүжин цогцолбор сургуулийн багш нар 6 судар, ЕБ-ын IV сургуулийн багш нар 2 судар тус тус бүтээж ирүүлсэнээс ЕБ-ын I сургуулийн багш Өнөрцэцэг 1-р байр, 2-р байрыг Тэмүүжин цогцолбор сургуулийн багш Уранчимэг, Нэргүй нар эзэллээ. Уран бичлэгийн уралдаанд нийт 57 бүтээл ирсэнээс 1-р байрыг Хан Хэнтий цогцолбор сургуулийн сурагч Ууганбаяр, 2-р байрыг 1-р сургуулийн сурагч Наранзул, 3-р байрыг Цогзолтуяа нар эзэлсэн. Монгол бичгээр алдаагүй зөв цэвэр бичлэгийн үзэсгэлэнд 20 гаруй бүтээл ирж шалгаруулсан.	
Бүтээгдэхүүн 1.8 “Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолтын уралдаан зохион байгуулах	Хэрлэн сумын цэцэрлэгүүдийн дунд “Үлгэрийн баатрууд -2012” дүрийн тоглолтын уралдааныг зохион байгуулж, шүүгчээр Хүүхдийн төлөө хэлтсийн мэргэжилтэн н.Уртнасан, БСГазрын мэргэжилтан н.Байгалмаа, хүүхдийн номын санч Э. Цэрэн-Од нар ажиллаа. Нийт 8 цэцэрлэгт удирдамж хүргүүлсэнээс 6 цэцэрлэгийн 7 баг оролцож, тэргүүн байрын шагналд Хэрлэн сумын 5-р цэцэрлэгийн “Тариан түрүүхэн” баг, дэд байрт 7-р цэцэрлэгийн “Чоно ба долоон ишиг” үлгэрүүд эзэллээ. Шилдэг дүр бүтээгчээр 5-р цэцэрлэгийн “Тариан түрүүхэн” үлгэрийн тахианд тоглосон Цэрэнтөгөлдөр, 3-р цэцэрлэгийн “Эрх гөлчгий” үлгэрийн гөлчгийнд тоглосон Алтан-Өлзий нар шалгарлаа. Мөн Хэрлэн сумын 4-р цэцэрлэгийн эцэг эхчүүдийн дунд жүжигчилсэн тоглолт зохион явуулж, нийт 7 бүлгийн эцэг эхчүүд оролцсоноос “Бэлтгэл А” бүлгийн “Манжин” үлгэр тэргүүн байр, 2-р байрт “Дунд А” бүлгийн “Эрхий мэргэн” тоглолт эзэллээ.	

Бүтээгдэхүүн 1.9 Хүүхдийн зохиолч Д. Гармаагийн 75 жилийн ойг тохиолдуулан уран бүтээлээр уншигчдын бага хурал зохион байгуулах	Хүүхдийн зохиолч Д. Гармаагийн намтар уран бүтээлээр presentation бэлдэж, 50 гаруй уншигч хүүхдүүдийг хамарснаас гадна 29 номоор нь үзэсгэлэн гаргасан	
Бүтээгдэхүүн 1.10 Төрийн шагналт зохиолч С. Буяннэмэхийн 110 жилийн ойд зориулан уран бүтээлээр уншигчдын бага хурал зохион байгуулах	Төрийн шагналт уран зохиолч С. Буяннэмэхийн 110 жилийн ойд зориулж 56 номоор үзэсгэлэн гаргаж нийт 100 гаруй уншигчид уншиж судлан, ЕБ-ын 8-11-р ангийн сурагчдын дунд намтар уран бүтээлээр уншигчдын бага хурал хийж 60 гаруй уншигчдыг хамарлаа. Мөн 128 уран бүтээлээр нь санамж өгөх номзүйн бүртгэл хийсэн.	
Бүтээгдэхүүн 1.11 АХА тэмцээнийг ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах	Хэрлэн сумын ЕБ-ын сургуулиудын ахлах ангийн 78 сурагчид "АХА" тэмцээнд өөрийн оюун ухаан, сэтгэхүйн цар хүрээгээ уралдуулж, Тэмүүжин цогцолбор сургуулийн сурагч тэргүүн байрыг эзэлж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.	
Бүтээгдэхүүн 1.12 БСШУЯамны 316-р тушаалын хэрэгжилт	Номын санд зайлшгүй бүртгэх нэгдсэн бүртгэлийг шинэчлэх ажил явагдаж байна. Хүүхдийн танхим 12000 Уншлага гэрээр ном олгох танхим 5000 Фонд 14000 нийт 31000 номыг нэгдсэн бүртгэлд бүртгээд байна.	
Бүтээгдэхүүн 1.13 Соёлын ажилтаны өдрөөр "Ахмад номын санчдын нэг өдөр" зохион байгуулах	Соёлын ажилтаны өдрөөр ахмад номын санчийг шагнал урамшилд тодорхойлох, хүлээж авах ажлыг зохион байгуулсанаас гадна Р. Чойномын амьдрал уран бүтээлээр уншигчдын бага хурал зохион байгуулж, аймгийн зохиолч Л. Энхбаатар ахмад номын санч болон уншигчдад илтгэл тавьлаа. Ахмад номын санч нар Р. Чойномын "Залуу нас" найраглалаар жүжигчилсэн тоглолт хийж, нийт 100 гаруй уншигчдад сонирхууллаа. Мөн идэвхтэн уншигч Дархиа Р. Чойномын "Залуу нас" шүлгийг уншсанаас гадна ахмад багш Таравжав Чойномын тухай дурсан ярисан нь уншигчдын талархалыг хүлээлээ.	

Бүтээгдэхүүн 1.14 Өнгөрсөн онуудын баримт бичгийг үдэж архивлах	Номын сангийн 2011 онд хөтлөгдөж дууссан байнга хадгалах баримт материалууд болох 1.Захирлын тушаал 2.Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ, биелэлт 3.Номын сангийн ажилчдын шагналын холбогдолтой баримт бичиг 4.Ажилчдын ажлын байрны тодорхойлолт 5. Хөдөлмөрийн гэрээ 6.Ирсэн бичиг 3.Явуулсан бичиг 4.Ажилтан албан хаагчдын үр дүнгийн гэрээ түүний биелэлт 5. Ажилчдын сар улирлын тайлан 6.Хамт олны хурлын тэмдэглэл- 7.Хөдөө сумдын номын сангуудын үйл ажиллагаатай томилолтоор ажилласан баримт бичиг зэрэг материалуудад товьёог хийж архивт хадгалсан.	
Бүтээгдэхүүн 1.15 Байгууллагын архивын ажлын онол, арга зүй сургалтанд хамрагдах	Архивын Ерөнхий газраас “Байгууллагын архивын ажлын онол арга зүй” сургалтанд бичиг хэргийн ажилтан Ц. Одонтуяа суралцаж ирлээ. Байгууллагын архивын баримтанд товьёог үйлдэж архивлах, архивын стандарын шаардлага ханган ажиллаж байна.	
Бүтээгдэхүүн 1.16 Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан, хөтлөгдөж байгаа хэргүүдийн бүрдэлд хяналт тавьж, бүрдүүлэн хүлээн авах	1. Аймгийн нийтийн номын сангийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, 49 хадгаламжийн нэгжийг бүрдүүлж, хадгалах хугацааг тогтоосон. 2. 2011- онд хөтлөгдөж дууссан менежерийн үр дүнгийн гэрээ, түүний биелэлт, ажилтан албан хаагчдын үр дүнгийн гэрээ, биелэлт, ирсэн явуулсан бичиг, захирлын тушаал, хөдөө сумдын номын сангуудын үйл ажиллагаатай томилолтоор ажилласан баримт бичиг, Статистикийн тайлан, Арга зүйн зөвлөмж аргачлал зэргээр хадгаламжийн нэгж бүрдүүлэн архивын зааврын дагуу үдэж хавтаслан архивласан.	

Бүтээгдэхүүн 1.17 Фондын 3000 номонд сэргээн засварлалт хийх	1.Их танхим гэрээр ном олгох танхим 774 номонд 2.Хүүхдийн танхим 1012 3.Фонд 2000 Нийт 3786 номонд сэлбэн засалт хийсэн.	
Бүтээгдэхүүн 1.18 2011 оны ажлын тайлан хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгөх	1. 2011 оны ажлын тайланг бүх ажилтан албан хаагчдаар хэлэлцүүлэн дүгнэж, "Байгууллагын аварга" ажилтанаар сахиул Ч. Оюунбаярыг шалгаруулж цалингийн 30%-иар урамшууллаа.	
Бүтээгдэхүүн 1.19 Менежертэй үр дүнгийн гэрээ байгуулж ажиллах	1. Хамт олны хурлаар 2012 оны үр дүнгийн гэрээнд тусгах санал асуулгыг авч, ажилтан албан хаагчидтай зөвшилцсөний үндсэн дээр үр дүнгийн гэрээг боловсрууллаа. 2.Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2012 онд ажиллах үр дүнгийн гэрээ байгуулж, нийт 47 бүтээгдэхүүнийг ханган нийлүүлж ажиллана	
Бүтээгдэхүүн 1.20 2012 оны хамтын гэрээг шинэчлэн байгуулах	2012 оны хамтын гэрээг шинэчлэн байгуулж Хэрлэн сумын ЗДТГ-ын даргаар батлуулан ажиллаж байна	
Бүтээгдэхүүн 1.21 2012 оны хөдөлмөрийн гэрээг шинээр байгуулах	Бүх ажилтан албан хаагчилтай хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулсан	
Бүтээгдэхүүн 1.22 Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх	Ажлын байрны тодорхойлолтыг зохих журмын дагуу шинэчлэн мөрдлөгө болгон ажиллаж байна.	
Бүтээгдэхүүн 1.23 Улирал тутамд ажлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж аймгийн ЗДТГ, БСШУ Яаманд явуулах	СУ-17, СУ-11, СУ-10, СУ-5 мэдээнүүд болон менежерийн үр дүнгийн гэрээний илтгэх хуудас, үр дүнгийн гэрээний биелэлтийг СУХороо, Аймгийн ЗДТГ, БСГазарт явуулж ажилласан.	
Бүтээгдэхүүн 1.24 Ирсэн явсан бичгийн бүртгэл хөтлөж, хариутай бичигт картаар хяналт тавьж, ажиллах	Ирсэн, явсан баримт бичгийн бүртгэлийн дэвтэр, захирлын тушаалыг бүртгэх дэвтрийг шинээр хийж, ирсэн - 23 , явуулсан бичиг-13, захирлын тушаал-10-г бүртгэж , хариутай бичгийн хариуг тухай бүр гаргаж ирсэн.	

<u>Бүтээгдэхүүн 1.25</u> <u>Албан хаагчдын ажлыг дүгнэж урамшил шагналд тодорхойлох</u>	Ажиллагсадын үр дүнгийн гэрээг дүгнэж, “Байгууллагын аварга ажилтан” сахиул Ч. Оюунбая-рыг цалингийн 30%-иар 3 сар, үр дүнгийн гэрээг хагас жилээр дүгнэж Ц. Одонтуяа нарыг цалингийн 30%-иар 1 сар шагнаж урамшуулсан. Ахмад номын санч Л. Цэрэндулам, С.Цэвээндорж нарыг Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнасан.	
Тусгай захиалгат ажил үйлчилгээ *2. “Номын сангийн үйл ажиллагаанд шинэлэг арга барилыг нэвтрүүлж, орчин үеийн мэдээллийн төв болох” стратегийн зорилтын хүрээнд:*		

Бүтээгдэхүүн 2.1 ЗД-ын мөрийн хөтөлбөрийн 2.18 заалт Аймгийн төв номын санг цахим мэдээллийн сүлжээнд холбон, сумын номын сангийн фондыг жил бүр баяжуулж, уншигчдын тоог нэмэгдүүлэх	Гэрээр ном олгох танхимыг интернэт мэдээллийн танхим болгон засварлаж, интернэтэд 5 компьютерийг холбож номын сангийн уншигчдад үнэ төлбөргүй интернэт ашиглуулж байна. “Шилдэг ном-2011” шалгарсан 39 нэр төрлийн 575 ширхэг 2287750 төгрөгний ном, БСШУЯамнаас 335 ширхэг 244200 төгрөгний ном, 237 ном багтаасан 118 ширхэг DVD, Монгол Улсын төсвөөс Засгийн газрын санаачилгаар манай аймгийн хэмжээнд сумын соёлын төвийн номын сангуудад нийт 22 суманд 3213 ширхэг 40,1 сая төгрөгийн, сургуулийн номын санд, нийт 25 сургуульд 1725 ширхэг 15,8 сая төгрөгийн, нийт 28 цэцэрлэгт 943 ширхэг 651,7 мянган төгрөгийн номуудыг хандиваар хувиарлан өглөө. Аймгийн хэмжээнд нийт 6839 ширхэг 68617644 төгрөгний номоор фонд баяжуулсан. БСШУЯ-аас Хэнтий аймгийн соёлын байгууллагуудын хэмжээнд 22 сумын номын сан, аймгийн төв номын санд 5, чуулга, музейд тус тус 1- компьютер, ССАЖЯамнаас Галшар, Мөрөн, Цэнхэрмандал, Хурх, Дэлгэрхаан сумын номын санд уншлагын танхимын ширээ 30, сандал 60 ширхэг 4230,0 мянган төгрөгийн, номын тавиур 20 ширхэг 5389,6 мянган төгрөгийн эд хогшилыг хандивласан.	